

Улсын бүртгэлийн

Нууцлалын зэрэглэл: Б

Дугаар.....

Аравтын бүрэн

ангилалын код

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

**“ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ”**

Сэдэвт суурь судалгааны төслийн тайлан

2019-2021 (эцсийн тайлан)

Төслийн удирдагч:

А.Даваасүрэн доктор (Sc.D), проф,
ОУСХ-ийн салбарын эрхлэгч

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Улаанбаатар хот

2022 он

Улсын бүртгэлийн
Дугаар.....
Аравтын бүрэн
ангилалын код

Нууцлалын зэрэглэл: Б
Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар:
ШУСс -2019/72

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

**“ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ”**

Сэдэвт суурь судалгааны төслийн тайлан

2019-2021 (эцсийн тайлан)

Төслийн удирдагч:	А.Даваасүрэн доктор (Sc.D), проф, ОУСХ-ийн салбарын эрхлэгч
Захиалагч байгууллага:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан технологийн сан
Тайлан өмчлөгч:	ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Р.О.В.-187, Улаанбаатар-211238, Утас: 976-11-317138

**Улаанбаатар хот
2022 он**

СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАНГИЙН

ЕРӨНХИЙ АГУУЛГА

1. ТОВЧ АГУУЛГА.....	3
2. ТҮЛХҮҮР ҮГС.....	4
3. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	4
4. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТУУД.....	5
5. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ.....	6
6. СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	6
7. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЛОГИК УЯЛДАА.....	7
8. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ.....	7
9. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	9
10. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭЦСИЙН ҮР ДҮН.....	22
10.1. Суурь судалгааны ажлын үр дүнгээр бий болсон бүтээлүүд.....	23
10.1.2. Гадаадад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлүүд.....	24
10.1.3. Дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлүүд.....	25
10.1.4. Эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүд.....	27
11. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР.....	27
11.1. Гүйцэтгэгчдийн ажлын туршлага.....	27
11.1.1. Суурь судалгааны ажлын удирдагч, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор А.ДАВААСҮРЭН.....	27
11.1.2. Нэг сэдэв бүтээл ба ном.....	28
11.1.3. Хамтын бүтээл.....	28
11.2. Суурь судалгааны ажлын багийн гишүүд, Доктор (Ph.D) Б.САНЖМЯТАВ.....	31
11.2.1. Ном, нэгэн сэдэвт бүтээл.....	31
11.2.2. Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	31
11.3. Доктор (Ph.D) Н.ОТГОНСАЙХАН.....	33
11.3.1. Ном, нэгэн сэдэвт бүтээл.....	33
11.3.2. Хамтын бүтээл.....	33
11.3.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	35
11.4. Доктор (Ph.D) Д.ЦЭНДСҮРЭН.....	35
11.4.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	35
11.5. Доктор (Ph.D) И.ЭНХБОЛД.....	37
11.5.1. Нэгэн сэдэвт бүтээл ба ном.....	38
11.5.2. Хамтын бүтээл.....	38
11.5.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	38
11.6. Магистр (МВА) Р.ШАРБАНДИ.....	41
11.6.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл ба илтгэл.....	42
11.7. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ.....	42

1. ТОВЧ АГУУЛГА

Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ хүлээсэн орны үүрэг, амлалт, хэрэгжилтийн байдал, худалдааны олон талт тогтолцооны хүрээнд гишүүн орнуудад олгодог боломж, давуу талуудыг ашиглах асуудлыг судлаж үзэхэд ДХБ-д 1997 онд Монгол Улс элссэн боловч өнөөдрийг хүртэл гадаад худалдааны эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлж чадаагүй төдийгүй Худалдааны олон талт тогтолцоогоор гишүүн орнуудад олгодог боломж, давуу талуудыг ашиглаж чадахгүй байна.

Гэтэл өнөөдөр Монгол Улсын импортын урсгал эрс нэмэгдэж, түүхий эдийн экспорт нэмэгдсэнээр дотоодын үйлдвэрлэл уналтад орсон, уул уурхайн бүтээгдэхүүнээс хэт хамааралтай улс болж хувирчээ. Энэхүү ажлын хүрээнд Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс өнөөг хүртэл импортын гаалийн тарифын бодлогын шинэчлэл, дэлхийн улс орнууд барааны гарал үүслийн орон, барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас хамааруулан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтыг ялгавартай хэрэгжүүлж байгаа талаар судаллаа.

Дэлхийн бараг бүх улс орнууд тарифын бус арга хэрэгслэлийг гадаад худалдааг зохицуулах чухал арга хэрэгсэл гэж үзэж тэдгээрийг гадаад худалдаандаа түлхүү ашиглаж байгаа туршлагыг судаллаа. Үүнд Дэлхийн улс орнууд гадаад худалдаандаа эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага болон техникийн зохицуулалтыг түлгээмэл ашиглаж байна.

Монгол Улс зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний экспорт, импортод хориг, хязгаарлалт тогтоодгийг эс тооцвол гадаад худалдааг тарифаар голчлон зохицуулж байна. Монгол Улсын хэрэгжүүлж буй тарифын бус зохицуулалтын тоо, хамрах хүрээг дэлхийн бусад улс орны туршлагатай харьцуулахад асар бага байна.

Тарифын бус зохицуулалтын олон улсын туршлагаас харахад тарифын бус арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд холбогдох эрх зүйн зохицуулалт, стандарт, дүрэм журмыг баталж, мөрдүүлэх, тухайн зохицуулалтад тусгагдсан шаардлага, шалгуур хангагдсан эсэхийг баталгаажуулах, хянах чанарын дэд бүтцийг бий болгох, худалдаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдааг хангах зэрэг 3 механизмыг ашиглаж байгаа байдалд үнэлэлт дүгнэлт хийж санал, зөвлөмж дэвшүүлээ.

Европын Холбооны зүгээс ядуурлаас бууруулах, ажлын байр бий болгох, түүний дотор хөдөлмөр, хүний эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор эмзэг эдийн засагтай хөгжиж буй орнуудын гарал үүсэлтэй бараанд гаалийн татвар ногдуулаагүй байхаар шийдсэн. Ингэхдээ гаалийн тарифын хөнгөлөлт олгох систем буюу “Хөнгөлөлтийн ерөнхий систем” (Generalized Scheme of Preferences (GSP))-ийг 3 жил тутам гаалийн тарифын хувь хэмжээг тууштай бууруулж, шинэчлэх бодлого баримталж ирсэн. Монгол Улс хөгжиж буй орны хувьд 1991 оноос энэ системд хамрагдаж, импортын гаалийн тарифын

хөнгөлөлт эдэлж байгаа ч гэсэн манай улсаас экспортолсон ихэнхи бараа нь гаалийн татвараас чөлөөлөгдөж чадахгүй байна. Учир нь бидэнд барааг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, сав баглаа боодолын талаарх ойлголт мэдлэг дутмаг учир манай экспортын бараа бүтээгдэхүүн Европын Холбооноос тавьж буй стандартын шаардлагыг хангаж чадахгүй байна. Иймд бид Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем, түүний онцлог, Монгол Улсын ашиглалтыг сайжруулах боломжийн талаар судлан үзлээ.

Монгол Улсын импортын барааны бүтцэд өргөн хэрэглээний бэлэн бараа дийлэнх хувийг эзлэж, экспортын бүтцэд уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүн давамгайлж байна. Хэдийгээр Монгол Улс гадаад худалдаа, тээвэртэй холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон боловч тэдгээрийн үндсэн зарчмыг бүрэн дүүрэн ашиглахгүй байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, чиглэл, импортын гаалийн тарифын дээд хувь хэмжээнд харьцуулсан судалгаа хийж Монгол Улсын импортын гаалийн тарифын дээд хэмжээг өсгөх боломжийг тогтоосон.

Түүнчлэн дэлхийн худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа, бодлого, чиглэлийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэх Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ), Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-аас гаргасан бодлогын баримт бичгийн хүрээнд хөрш орнуудтай хэрхэн хамтран ажиллах боломжийг өнөөгийн байдлыг харьцуулан судлаж үзлээ.

Дэлхийн улс орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар БНСУ нь өөрийн үйлдвэрлэлд хэрэгтэй түүхий эдийг хямд үнээр авч, оронд нь эцсийн бөгөөд бэлэн бүтээгдэхүүн экспортлож улс орныхоо эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахж байгаа туршлагыг судлаж, Монгол Улсын гадаад худалдааны хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон.

2. ТҮЛХҮҮР ҮГС:

Дэлхийн Худалдааны Байгууллага, Монгол, Улс, ОХУ, БНХАУ, Худалдааны олон талт тогтолцоо, Хөнгөлөлтийн Ерөнхий Систем, гадаад худалдаа, Чөлөөт худалдааны хэлэлцээр, үүрэг, амлалт, гишүүн улсууд, давуу талууд, барааны боловсруулалтын түвшин, гарал үүсэл, гаалийн тариф, экспорт, импорт, тарифын болон тарифын бус арга хэмжээ, гадаад худалдааны бодлого гэх мэт.

3. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улс 1997 онд ДХБ-д гишүүнээр элссэн цагаас хойш дэлхийн зах зээл дээр бусад орнуудын зүгээс манай экспортлогчид гадаад худалдааны ялгаварлан гадуурхах зорилго бүхий тарифын болон тарифын бус хориг саадад өртөхгүйгээр өөрийн экспортын бараагаа чөлөөтэй худалдаалах эрхтэй

болж, гадаадын олон харилцагч, түншүүдтэй болж, дэлхийн зах зээлийн нөхцөл байдлын талаархи бодитой мэдээллээр хангагдах боломжтой болж, ингэснээр тэдний экспортын барааны өрсөлдөх чадвар сайжирсан зэрэг эерэг талууд гарч байлаа. Гэвч уг байгууллагын гишүүнээр элсэхдээ авсан амлалтууд нь манай улсын эдийн засаг, түүний дотор боловсруулах салбарын хөгжлийн бодит нөөц, чадамжаас давсан хэтэрхий үндэслэлгүй байсан болох нь өнөөдөр тодорхой болж байна. Тухайлбал, ДХБ-ын олон талт зохицуулалтын хүрээнд Монгол Улс гаалийн тарифын бодлогыг зөөлөрүүлэх, гишүүн орнуудын бараанд нэн тааламжтай хувь хэмжээг тогтоох шаардлагын үүднээс гаалийн тарифын тухай хуульд 1998, 1999, 2000, 2001, 2004, 2005 онуудад нэмэлт, өөрчлөлтүүд оруулсны үр дүнд Монгол Улсын импортын гаалийн татварын хэмжээ 7-5 хувь болж буурсан байдаг. Үүний үр дүнд 1990 онд боловсруулах салбар ДНБ-ий 36,5 хувийг дангаараа үйлдвэрлэж байсан бол одоо дөнгөж 5 хувь болж буурсаныг манай улс гадаад худалдааны бодлого, зохицуулалт байхгүй явж ирсэнтэй холбон тайлбарлаж болно. Ингэснээр үндэсний боловсруулах үйлдвэрүүд гадны хямд бараатай өрсөлдөж чадахгүй импортын хамгаалалтгүй болж, улс орон даяар ажилгүйдэл ядуурлыг улам бүр нэмэгдүүлж, нийгмийн эмзэг байдлыг хурцатгаж улмаар төрийн хямралыг бий болгох үндэс суурь болж байна гэж үзэж байна. Хэдийгээр АНУ дэлхий аж үйлдвэржсэн, дотооддоо чөлөөт эдийн засагтай хамгийн хүчирхэг гүрэн боловч өөрийн боловсруулах аж үйлдвэрүүдийг хямд импортын бараанаас хамгаалах протекционист бодлогын бүх арга хэрэгслэлийг авч хэрэгжүүлэхээ ил тод зарлаж хэрэгжүүлж эхлээд байна.

Иймд Монгол Улсын гаалийн худалдааны бодлогыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, гадаад худалдааны зохицуулалтын өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт гаргах, гаалийн тарифын хувь хэмжээний үндэслэлийг тогтоох, тарифийн бус хориг саадын үндэслэл болон гааль, хилийн хорио цээрийн стандартуудыг судлах замаар бодлогын зөвлөмжийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх шаардлага гарч байна. Ингэснээр Монгол Улс гадаад худалдааны бодлого, зохицуулалт боловсронгуй болж, үндэсний боловсруулах үйлдвэрийг сэргээн хөгжүүлэх, улмаар ажилгүйдэл, ядуурал үгүй болох үндэс тавигдах бөгөөд ард иргэд хэрэглэгч буюу бэлэнчлэх сэтгэлгээнээс ангижирч баялаг бүтээгч сэтгэлгээтэй болж улс орон маань хөгжлийн өндөр түвшинд хүрэх үүр хаалга нээгдэнэ гэж үзэж байна.

4. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТУУД

Гишүүн орнуудын гаалийн импортын тарифын хэмжээ нь ДХБ-ын худалдааны нэн тааламжтай нөхцлийн хүрээнд хянагдаж байдаг боловч гишүүн орнууд өөрийн дотоод зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих

зорилгоор гаалийн импортын тарифын болон тарифын бус хориг саадыг илүүд үзэж маш олон төрлийн хориг саадыг ашиглаж ирсэн байдаг. Монгол Улсын гадаад худалдааны бодлогыг шинээр томъёолох, гадаад худалдааны зохицуулалтад шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, импортын гаалийн албан татварын хувь хэмжээний зохистой түвшинг нэмэгдүүлэх боломжийг олох, импортын гаалийн тарифийн бус хориг саадыг ашиглах боломжийг судлах, судалгааны үр дүнгээр төрийн байгууллагад бодлогын зөвлөмж боловсруулахад оршиж байна. Бид зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтуудыг тавьж ажиллаа. Үүнд:

- ДХБ-д элсэхдээ Монгол Улсын авсан амлалт, хүлээсэн үүргийн хэрэгжилтэд шинжилгээ хийх;
- Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;
- ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд тарифын бус зохицуулалтыг ашиглаж буй олон улсын туршлагыг судлах;
- Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий (GSP+) системийн Монгол Улс дахь хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Монгол улс, БНХАУ, ОХУ-ын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
- БНСУ-ын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын талаар судалгаа хийх;
- ДХБ-ын гишүүн хөгжиж байгаа зарим орнуудын гадаад худалдааны (экспорт, импорт) бодлого зохицуулалтын туршлага, онцлогыг (тарифын болон тарифын бус хориг хязгаарлалт) судлах;
- ДХБ-ын гишүүнээр элсэхдээ Монгол Улсын амлалт, үүрэг болон хэлэлцээрүүдийн материалд шинжилгээ хийх,
- Монгол Улсын гадаад худалдааны бодлогыг шинээр боловсруулах, судалгааны үр дүнгээр төрийн байгууллагад бодлогын зөвлөмж боловсруулах гэх мэт.

5. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ОБЪЕКТ:

Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнээр элсэх үед Монгол Улсын авсан амлалт, хүлээсэн үүргийн биелэлт, тэдгээрийн тус улсын үндэсний эрх ашигт нийцүүлэх санал, зөвлөмж болно.

6. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ОБЪЕКТ:

Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнээр элсэх үед Монгол Улсын авсан амлалт, хүлээсэн үүргийн биелэлт, тэдгээрийн тус улсын үндэсний эрх ашигт нийцүүлэх санал, зөвлөмж болно.

7. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ:

ДХБ-ын үндсэн зарчмуудын хэрэгжилт болон Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалтуудад шинжилгээ хийсэн, дүгнэлт, практик санал гаргах, ялангуяа олон улсын түвшинд гадаад худалдаанд түгээмэл ашиглаж байгаа тарифын бус зохицуулалтыг ашиглах өргөн боломжуудыг нээж өгч, дэлхийн аж үйлдвэржсэн орнуудын гадаад худалдаагаа ялангуяа импортын зохицуулалтын хийж байгаа туршлага дээр үндэслэн Монгол Улс төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлогын арга зүйн үндэсийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлсон болно.

8. СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:

Аливаа судалгааны ажлыг гүйцэтгэхэд түгээмэл ашиглагддаг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, шинжлэх ухааны хийсвэрлэл ба нягтлал, системийн анализ, шинжээч, экспертийн үнэлгээ, загварчлал зэрэг аргууд нь бидний хийсэн судалгааны ажлын онол практикийн уялдаа, шинжилгээ, дүгнэлт, практик саналын шинжлэх ухааны үндэслэлийг бататгах болно.

9. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЛОГИК УЯЛДАА:

ДХБ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, үндсэн зарчмуудын хэрэгжилт, түүний гишүүн орнууд хоорондын худалдаагаа зохицуулж байгаа хоёр талт болон олон талт хэлэлцээрүүдэд гарч байгаа ололт, туршлагыг судлахаас эхлэн Монгол Улс гадаад худалдааны зохицуулалтад үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах, ялангуяа импортын тарифын бус зохицуулалтыг ашиглах боломжийг илэрүүлэх, төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлогын үндэсийг тодорхойлох хүртлэх асуудлыг судаллаа.

10. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ:

ДХБ-д элсэхдээ Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжилтийн байдал, худалдааны олон талт тогтолцооны боломж, давуу талуудыг ашиглах асуудлыг судлаж, Монгол улс импортын гаалийн тарифын бодлогын шинэчлэлийг хийхдээ дэлхийн улс орнууд барааны гарал үүслийн орон, барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас хамааруулан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтыг ялгавартай тогтоох, дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил тарифын бус арга хэрэгслэлийг гадаад худалдаандаа түүн дотор эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага болон техникийн зохицуулалтыг ашиглах, тарифын бус арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд эрх зүйн зохицуулалт, стандарт, дүрэм журмыг баталж, мөрдүүлэх, тэдгээрийн техникийн болон бусад шаардлага, шалгуурыг тогтоон

баталгаажуулах, чанарын дэд бүтцийг бий болгох талаар санал, зөвлөмж боловсруулсан.

Монгол Улсад Европын Холбооны зүгээс олгож буй гаалийн тарифын хөнгөлөлтийн систем буюу “Хөнгөлөлтийн ерөнхий систем” (Generalized Scheme of Preferences (GSP))-ийг Монгол Улс ашиглах талаар санал боловсруулсан, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, чиглэл, импортын гаалийн тарифын дээд хувь хэмжээнд харьцуулсан судалгаа хийж Монгол Улсын импортын гаалийн тарифын дээд хэмжээг өсгөх боломжийг тогтоосон, Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар БНСУ нь өөрийн үйлдвэрлэлд хэрэгтэй түүхий эдийг хямд үнээр авч, оронд нь эцсийн бөгөөд бэлэн бүтээгдэхүүн экспортлож улс орныхоо эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахж байгаа туршлагыг судласан нь Монгол Улсын гадаад худалдааны хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тус дөхөм болох зорилгоор төрийн бодлогын зөвлөмж боловсруулж өгсөн нь ач холбогдолтой болсон.

11. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Төслийн хүрээнд гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын нэр	Биелэлт	Гүйцэтгэгчийн овог, нэр,	Үр дүн ба Сэдэв
2019 он				
1	Дэлхийн худалдааны байгууллагын дүрэм, журам, гишүүн орнуудын эрх, амлалтыг хянаж, зохицуулж байгаа механизмын талаархи материалыг цуглуулж, цэгцлэн боловсруулалт хийж, үр дүнгээр нь ЭШИ бичих	ДХБ-ын дүрэм, журамын хүрээнд Монгол Улсын авсан амлалт, үүрэг, гаалийн тарифийг нэмэгдүүлэх боломжийн талаархи материалууд цуглуулж, эмхлэж цэгцлэн боловсруулалт хийсний дараа Монгол Улсыг ДХБ-д элсэх хэлэлцээрийг явуулсан монголын төлөөлөгчдийн үйл ажиллаганы үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч ХАА, хүнсний бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, зах зээлээ хамгаалах талаар хангалтгүй гэж үзсэн байна. ингэснээр Монгол Улс хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортоор авч байгаа нь бусад орнуудын ХАА, хүнсний бүтээгдэхүүнд ногдуулдаг тариф хэтэрхий бага байгааг нотолсон.	Доктор (Ph.D) С.Санжмятав	“Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалт” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон ЭШХ дээр илтгэл тавьсан.
2	ДХБ-ын гишүүн хөгжингүй орнуудын гадаад худалдааг зохицуулж байгаа туршлага, онцлогийн талаар баримт материал цуглуулж, цэгцлэн боловсруулалт хийж, үр дүнгээр нь ЭШИ	Европын Холбооны гадаад худалдааны бодлого, зохицуулалтын туршлага, тухайлбал, гадаад худалдааны зохистой ухаалаг, уян хатан бодлого нь тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход чухал хувь нэмэр оруулдаг, бараа болон үйлчилгээ худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт, худалдаатай	Доктор (Ph.D) Н.Отгонсайхан	“ДХБ-ын гишүүн орнуудын гадаад худалдааг зохицуулж байгаа туршлага, онцлог” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон ЭШХ дээр илтгэл тавьсан.

	бичих	холбоотой оюуны өмчийн асуудал, засгийн газрын худалдан авах үйл ажиллагаагаар дамжуулан гадаад худалдааг дэмждэг тухай, аж ахуйн нэгжүүдэд худалдааны тэгш боломжийг олгох, шинэ зах зээл нээх зорилгоор дэлхийн бусад орнуудтай худалдааны хэлэлцээр байгуулах, худалдааны саад бэрхшээлийг арилгах, хөрөнгө оруулалт татахад чиглэгддэг тухай, олон талт худалдааны системд үндэслэх, онцгой чадамж, дэлхийн зах зээл дээр нэгдсэн бодлоготой байх, худалдааны хэлэлцээр байгуулах, шударга үнээр худалдах зэрэг зарчмуудыг бичсэн байна.		
3	ДХБ-ын гишүүн хөгжиж байгаа орнуудын гадаад худалдааг зохицуулж байгаа туршлага, онцлогийн талаар баримт материал цуглуулж, цэгцлэн боловсруулалт хийж, үр дүнгээр нь ОУХХ дээр семинар зохион байгуулна.	БНСУ-ын гадаад худалдаанд байгал цаг агаар, эдийн засаг, нийгмийн, улс төрийн хүчин зүйлсээс гадна экспорт, хөрөнгө оруулалт, импорт, хэрэглээ, үйлдвэрлэлийн түүхий эд зэрэг эрэлтийн хүчин зүйлс, хөдөлмөр, капитал, техникийн дэвшил зэрэг нийлүүлэлтийн хүчин зүйлс, тэдгээрийн эсрэг нөлөө, харилцан хамаарал, тус улсын аж үйлдвэрийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд үзүүлж байгаа байдлын талаар бичсэн.	Доктор (Ph.D) И.Энхболд	“ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцаа”, /илтгэл /Бусан хотын олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2019.12.13.
4	Гадаад худалдааны бараа, бүтээгдэхүүнд тавьж буй стандартуудыг зохицуулж байгаа	Дэлхийн улс орнууд аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх, хүн, амьтны эрүүл ахуй, хорио цээр, хүрээлэн буй орчныг хамгаалах бодлого хэрэгжүүлж нийтийн эрх ашгийг	Магистр Р.Шарбанди	“Гадаад худалдаанд тавигдаж буй тарифын бус хориг, арга хэмжээ” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон ЭШХ дээр илтгэл тавьсан.

	<p>олон улсын туршлагын талаар баримт материал цуглуулж, цэгцлэн боловсруулалт хийж, үр дүнгээр нь ЭШИ</p>	<p>хамгаалах зорилгоор импортын бүтээгдэхүүнд тодорхой хатуу шаардлага, шалгуур тогтоож, тарифын бус арга хэмжээ (NTM), зөвхөн тэрхүү шалгуурыг хангасан бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нэвтрүүлдэг бодлогын тухай бичиж, энэхүү арга хэмжээний (Non-tariff measures) талаарх ойлголт ба түүний ангилалыг бичиж, эдгээр арга хэмжээ нь хөгжиж буй болон ядуу буурай улс орнуудын үйлдвэрлэгчдэд хүндрэл, бэрхшээл үүсгэдэг тухай, түүний ашиглалт, ач холбогдол, үр нөлөө, шалгуур үзүүлэлтүүдийн төрөл, ангилал, түүнийг тооцох аргачлал, түүнийг дэлхийн улс орнуудыг ашиглаж байгаа байдал, туршлагыг бичсэн байна.</p>		
5	<p>Гадаад худалдаа дахь бараа, бүтээгдэхүүний сертификатжуулалтын байдлын талаар баримт материал цуглуулж, цэгцлэн боловсруулалт хийж, үр дүнгээр нь ЭШИ бичих</p>	<p>Дэлхийн гаалийн байгууллагын чиг үүрэг, тухайлбал, тус байгууллага нь гаалийн олон улсын стандартыг хөгжүүлэх, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах, бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг хангах, олон улсын худалдааг хөнгөвчлөх, гаалийн хууль дүрмийг сайн дураараа дагаж мөрдөх, эсхүл албадан сахиулах ажиллагааг боловсронгуй болгох, хуурамч бараа, оюуны өмчийн хулгайтай тэмцэх, төрийн байгууллага, хувийн секторын түншлэлийг хөгжүүлэх, шударга ёсыг</p>	<p>Доктор (Ph.D) Д.Цэндсүрэн</p>	<p>“ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааг хөнгөвчлөх боломж” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон эрдэм шинжилгээний хурал дээр илтгэл тавьсан.</p>

		сахиулах, гаалийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх тогтвортой хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зорилгыг бичиж, уг байгууллагын Барааг тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенцид нэгдэн орсноор гадаад худалдаанд худалдаалж барааг олон улсын түвшинд 6 орноор тодорхойлох боломжтой тухай, уг конвенцийн дагуу Монгол Улсын үндэсний задаргаа 8 орон, БНХАУ, ОХУ үндэсний задаргааг 10 орны түвшинд хийж барааг тодорхойлж, кодолдог тухай, Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн (БТКУС) конвенцийн зорилго, уялдуулсан системийг гаалийн тариф тогтоох, мөн гадаад худалдааны статистик мэдээлэл гаргах зорилгоор ашигладаг тухай бичсэн байна.		
6	ДХБ-ын гишүүн ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны зохицуулалтын туршлага, онцлогын талаар баримт материал цуглуулж, цэгцлэн боловсруулалт хийж, үр дүнгээр нь ОУХХ дээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион	Судлаачдын ажлын үр дүнгээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж судлаач бүр илтгэл хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан.	Бүх судлаачид	Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан

	байгуулна.			
д/д	Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлын нэр	Биелэлт	Гүйцэтгэгчдийн овог, нэр,	Үр дүн ба Сэдэв
2020 он				
1	Дэлхийн улс орнуудын зүгээс хөнгөн, хүнсний бараанд тавьж буй хорио цээрийн стандартын шаардлагуудыг судлаж, дүгнэлт гаргаж, үр дүнгээр нь ЭШӨ бичиж ОХУ-д хэвлүүлэх	Дэлхийн улс орнуудын импортын бараанд үзүүлж байгаа тарифын бус хориг саад, арга хэмжээнүүдийг ашиглаж байгаа туршлагыг судлаж, манай улсад шинээр тарифын бус хориг саадыг ашиглахын ач холбогдолыг тодорхойлсон.	Магистр Р.Шарбанди	1. Р.Шарбанди, Б.Даваасүрэн. “Экспортын үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, экспортыг дэмжих бодлого” илтгэл. Экспорт Монгол 2020 бизнес форум. 2020 оны 12 сарын 25-ны өдөр.
2	Монгол Улс ДХБ-д гишүүнээр элсэх үед авсан амлалтын хэрэгжилтийг судлаж, дүгнэлт гаргаж, үр дүнгээр нь ЭШӨ бичиж ОУХХ-ийн “Олон улс судлал” сэтгүүлд хэвлүүлэх	ДХБ-ын тогтолцоо, дүрэм, хэлэлцээрүүд, маргаан үүсгэх, мөрдөн шалгах, шийдвэрлэх процедур, техникийн туслалцаа, үндсэн зарчмуудыг судлаж ДХБ дахь Монгол Улсын элссэн нөхцөл, үүрэг амлалтын биелэлт, давуу ба сул талуудын талаар дүн шинжилгээ хийсэн	Доктор (Ph.D), С.Санжмятав	1. С.Санжмятав, Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд /хамтын бүтээл/ “Бэмби сан ХХК” хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2020, 2. С.Санжмятав, Монгол Улсын ШУА-аас санхүүжүүлсэн “Монгол, Хятадын хамтын ажиллагааны тулгамдаж буй асуудлууд” /төслийн ажил/ Улаанбаатар, 2020
3	Монгол Улс ДХБ-д гишүүн хөгжингүй орнуудтай хийсэн хэлэлцээрийн үр дүн, тэдгээрээс манай улсад үзүүлж байгаа хөнгөлөлтийг ашиглаж	БНХАУ, ОХУ-ын гадаад худалдааны бодлого, зохицуулалттай Монгол Улсын гадаад бодлого, зохицуулалттай харьцуулсан судалгаа, Европын холбооноос манай улсад үзүүлж байгаа GSP+ системийн	Доктор (Ph.D) Д.Цэндсүрэн	<ul style="list-style-type: none"> Н.Отгонсайхан, Д.Цэндсүрэн, Хятад-Монгол-Оросын Эдийн засгийн коридор байгуулах явц дахь гадаад худалдааг хөнгөвчлөх: Практик үнэлгээ, судалгаа (ШУА), Улаанбаатар хот, 2020 он. Д.Цэндсүрэн, Д.Чулуунцэцэг, Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн

	байгаа байдалд дүгнэлт гаргаж, үр дүнгээр нь ЭШӨ бичиж МУИС-ийн ОУХНУС-ийн “Олон улсын харилцаа” сэтгүүлд хэвлүүлэх	онцлог, Монгол Улсын Япон улстай байгуулсан ЧХХ-ийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.		мэргэшлийн стандарт”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он. <ul style="list-style-type: none"> • Д.Цэндсүрэн, Х.Мөнзхул, Дэлхийн гаалийн байгууллагын “Транзит гарын авлага”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он. • Д.Баярсайхан, Д.Цэндсүрэн, Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх зарчим ба суурь стандарт”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
4	ДХБ-ын гишүүн хөгжиж байгаа зарим орнуудын гадаад худалдааны (экспорт, импорт) бодлого зохицуулалтын туршлага, онцлогыг судлах, үр дүнгээр нь ЭШӨ бичиж МУИС-ийн ОУХНУС-ийн “Олон улсын харилцаа” сэтгүүлд хэвлүүлэх	БНСолонгос улсын экспортын тарифийн бодлого, зохицуулалтын туршлага, дотоодын үйлдвэрлэлд шаардлагатай бараа, түүхий эдийн экспорт болон дотоодын түүхий эдийг үйлдвэрлэлд ашиглах шаардлагыг судалж тус улсын аж үйлдвэрлэлээ хамгаалах бодлого, зохицуулалтыг судлаж манай улс БНСолонгос улстай хийж байгаа гадаад худалдаандаа анхаарах асуудлыг тодорхойлсон.	Доктор (Ph.D) И.Энхболд	1. И.Энхболд, “БНСУ-ын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын асуудал” сэдэвт өгүүлэл бичиж, Олон улс судлал сэтгүүлийн редакцад хүргүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан сэдвийг “Монгол Улс, БНСУ-ын улс төрийн харилцаа” болгон өөрчилж, БНСУ-ын Гадаад хэлний дээд сургуулийн Евроази, Монгол судлалын төвийн эмхэтгэлд 2020 онд хэвлүүлэв. 2. И.Энхболд, Дэлхийн хэмжээнд дэгдээд буй цар тахал КОВИД-19-ийн талаар БНСУ-ын хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаг үеийн асуудлаар судалгаа мэдээ бэлтгэв. 3. И.Энхболд, “ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцаа” сэдэвт өгүүлэл бичиж “Монгол Улс, БНСУ-ын харилцаа 30 жил” эмхэтгэлд хэвлүүлэв.
5	Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн	Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс	Доктор (Ph.D), профессор	Н.Отгонсайхан, Л.Баярхүү Монгол улсад

	зохицуулалтад үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах, үр дүнгээр нь ЭШӨ бичиж ОУХХ-ийн “Олон улс судлал” сэтгүүлд хэвлүүлэх	өнөөг хүртэл импортын гаалийн тарифын шинэчлэлийн бодлогыг хэрхэн явуулсан, дэлхийн улс орнууд барааны гарал үүслийн орон, барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтыг хэрхэн хийж байгаа талаар судалж, дотоодын зах зээлийг импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтаар хэрхэн хамгаалж болох талаар судалсан болно.	Н.Отгонсайхан	цаасгүй худалдааг хэрэгжүүлэх зарим асуудал. МХНММХ, Хүний нөөцийн удирдлага сэтгүүл, (ISSN 2410-7174), –УБ 2020. – № 02 (53) – Х.69-111
6	Хөгжингүй орнуудын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын (тарифын ба тарифын бус) шинжилгээ хийж, үр дүнгээр нь ЭШӨ бичиж Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн “Худалдаачин” сэтгүүлд хэвлүүлэх	Барааны гарал үүсэл, барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас шалтгаалан ДХБ-ын гишүүн орнуудын импортын тарифийн бодлого, зохицуулалтын хүрээнд ялагавартай тогтоож байгаа туршлагыг судлаж Монгол Улсын зах зээлээ хамгаалах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон.	Доктор (Ph.D), профессор Н.Отгонсайхан	Н.Отгонсайхан, Ш.Энхбаяр, Монгол улсын импортын гаалийн тарифын шинэчлэл. МУ-ын ШУА-ийн олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл, (ISSN 2312-4512 eISSN 2663-7871), 2020. – № 02 (111). – Х.101-117 https://doi.org/10.5564/jis.v2i111.1448
7	“Гадаад худалдааны тарифын ба тарифын бус зохицуулалт” сэдвээр ОУХХ дээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	2020 онд судалгааны ажлын үр дүнгээр гадаад, дотоодын судлаач, эрдэмтэдийн оролцоотой олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч КОВИД-19 цар тахалаас болж зохион байгуулж чадаагүй	Бүх судлаачид	Олон улсын эрдэм шинжилгээний хурал -0
8	“Гадаад худалдааг зохицуулж байгаа	2020 онд судалгааны ажлын тайланг, үйл ажиллаганы тайлангын	Бүх судлаачид	206 хуудас бүхий явцын тайлан болон 5 хуудас бүхий үйл ажиллагааны тайлан

	олон улсны туршлага” сэдэвтэй явцын тайлан	хамт бичиж ШУТС-д цахимаар хүргүүлсэн.		
д/д	Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлын нэр	Биелэлт	Гүйцэтгэгчдийн овог, нэр,	Үр дүн ба Сэдэв
2021 он				
1	Экспортлогч-орны эрх ашигт хохирол учруулсан байж болзошгүй гомдол, маргааныг зохицуулж байгаа ДХБ-ын дүрэм, журам, гишүүн болсны давуу талаа ашиглаж байгаа зарим орны туршлагыг судлаж үр дүнгээр нь ЭШӨ бичиж МУИС-ийн ОУХНУС-ийн “Олон улсын харилцаа” сэтгүүлд хэвлүүлэх	Монгол Улс 1991 онд Дэлхийн Гаалийн байгууллагын, 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүнээр элсэн орсон цагаас эдгээр байгууллагын дүрэм, журам, заавар, конвенцүүдтэй (ДГБ-ын Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцид 2006 онд Монгол Улс нэгдэн орж, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2008 онд батлан гаргаж) өөрийн гадаад худалдаа, гаалийн бодлого, зохицуулалтуудын бичиг баримтыг уялдуулан боловсруулж батлан гадаад худалдаа, гаалийн горимыг хялбаршуулах, уялдуулах, стандартчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгаа байдалд үнэлэлт дүгнэлт өгч, Монгол Улс хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэлт хийж, түнш орнуудын холбогдох байгууллагатай хамтран ажиллах замаар хил дамнасан худалдаа эрхлэн, түүнийг аюулгүй байлгах, хөнгөвчлөх арга хэмжээний үр дүнг шинжлэж дүгнэлт гаргасан.	Доктор (Ph.D) Д.Цэндсүрэн	“Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал”, /илтгэл/ ШУА-ийн ОУХХ-ийн лхагва гаригын семинар, 2021 оны 3 сарын 10-ий өдөр, Улаанбаатар,

2	<p>Монгол Улсын гадаад худалдаанд ялангуяа импортын бараанд ногдуулж байгаа татварыг (нөхөн төлбөр, тэнцвэржүүлэх татвар, демпингийн эсрэг татвар) ялгавартай тогтоох талаар санал боловсруулах, үр дүнгээр нь ЭШӨ бичиж Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн “Худалдаачин” сэргүүлд хэвлүүлэх</p>	<p>Монгол Улс импортын тарифын дундаж хэмжээ 17,5 хувь, түүний дотор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд 18,5 хувь, хөдөө аж ахуйн бүс бүтээгдэхүүнд 17,3 хувь байхаар тохиролцож ДХБ-ын өмнө авсан үүрэг, амлалт нь харьцангуй бага хувь хэмжээ гэж үзэхээр байгаа ба одоо мөрдөж байгаа импортын 5 хувийн тариф нь үндэсний үйлдвэрийг гадаадын хямд, чанар муутай бүтээгдэхүүнээс хамгаалж чадахгүйгээр барахгүй, түүнийг сүйрүүлэх нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Ялангуяа Засгийн газраас 1997-1999 онд тарифыг “0” болгосон нь үндэсний үйлдвэрүүдэд маш том цохилт болж, манай улс зах зээлийн харилцааны шилжилтийн эхний цөөхөн жилүүдэд өмнөх тогтолцооны үед байгуулсан үндэсний боловсруулах үйлдвэрүүд үндсэндээ устаж үгүй болжээ гэж, одоо хүртэл шинээр үйлдвэрүүд баригдаагүй гэсэн дүгнэлтийг хийсэн.</p>	<p>Доктор (Ph.D), профессор Н.Отгонсайхан</p>	<ol style="list-style-type: none"> 1.Н.Отгонсайхан, Дэлхийн худалдааны байгууллага ба гаалийн тариф. ГЕГ-ийн Гааль сэтгүүл. –УБ 2021. – № 018/01. – Х.65-67 2.Н.Отгонсайхан Монгол Улсын гадаад худалдааны онцлог. Худалдаачин сэтгүүл. –УБ 2021. – № 10. – Х.16-23 3.Н.Отгонсайхан. Эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын зохицуулалт. ГЕГ-ийн Гааль сэтгүүл. –УБ 2021. – № 019/01. – Х.68-71 4.Отгонсайхан Н. Монгол, хятадын нүүрсний худалдааны өнөөгийн байдал. CitScience сэтгүүл. –УБ 2021. – Х.40-48
3	<p>Бараа, бүтээгдэхүүний сертификатжуулалт, чанарын болон стандартчлалын тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх талаар санал боловсруулах, үр дүнгээр нь ЭШӨ бичиж</p>	<p>Гадаад худалдаанд оролцож байгаа бараа, бүтээгдэхүүний сертификатжуулалт, чанарын стандартчлалын тогтолцоо нь Монгол Улсад хараахан бүрэлдээгүй, чиг үүргийн давхардал, хийдэл их байдаг ба манай улсын Стандартчлал, хэмжил зүйн үндэсний төв нь энэхүү чиг үүргийг</p>	<p>Магистр Р.Шарбанди,</p>	<p>Эрдэм шинжилгээний өгүүлэл - 0</p>

	<p>ОУХХ-ийн “Олон улс судлал” сэтгүүлд хэвлүүлэх</p>	<p>хангалтгүй гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ экспорт, импортын бараа, бүтээгдэхүүний сертификатжуулалт, чанарын стандартчлалын талаар судалгааны хийх ур чадвартай, мэдлэгтэй судлаач эрдэмтэн олдоогүй болно.</p> <p>Гэсэн хэдий ч дэлхийн ихэнхи улс орнуудын гадаад худалдааны зохицуулалтад ашиглаж байгаа тарифын бус зохицуулалтын хэрэгсэлүүд болсон квот, лиценз, татаас, хориг арга хэмжээ, эрүүл ахуй хорио цээрийн шаардлага, техникийн зохицуулалт, төрийн худалдан авалт, дотоод зах зээлээ хамгаалах, шударга бус өрсөлдөөний эсрэг арга хэмжээг ашиглаж байгаа олон улсын туршлагыг судалсан.</p>		
4	<p>ДХБ-ын гишүүнчлэлийн давуу талыг Монгол орны эрх ашигт ашиглах, нийцүүлэх боломжийг талаар санал боловсруулах, Үр дүнгээр нь ЭШӨ бичиж ОХУ-д хэвлүүлэх</p>	<p>Монгол Улс ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоходоо ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг зөрчихгүй, хөгжиж буй орнуудад олгодог бусад хөнгөлөлтэй нөхцөлийг ашиглах, тарифын дээд хязгаарын энгийн дундаж тарифыг өсгөх боломжтой болохыг тодорхойлсон.</p>	<p>Доктор (Sc.D) А.Даваасүрэн</p>	<p>1. А.Даваасүрэн, А.П.Суходолов, Ю.В.Кузьмин, Я.А.Суходолов “Торгово-экономические связи Монголии и России: история и современное состояние, вызовы и перспективы” /научная статья/ подготовлена в рамках проекта Российского фонда фундаментальных исследований 18-514-94002 МОН_а «Национальные интересы России и Монголии в треугольнике отношений Россия – Монголия – Китай: проблемы, противоречия, сценарии», Российский экономический вестник, 2021, Том 4, №4, с 318-329, 1,1 п.л.</p>

				<p>2. А.Даваасурен, А.П.Суходолов, А.В.Колесникова, Я.А.Суходолов “Международно--правовые аспекты Российско-Монгольского сотрудничества в сфере охраны и использования трансграничных вод бассейна р. Селенги” /научная статья/ юридическая наука, №9, 2021, Москва, с 65-71, 1,3 п.л.</p> <p>3. Авирмэд Даваасурэн, В.И.Самаруха, “Взаимоотношения России и Монголии: история, настоящее и будущее” / научная статья, опубликованная в сборнике докладов Международной научной конференции, посвящённой 100-летию установления Российско-Монгольских дипломатических отношений (Монголия XX века и российско-монгольские отношения: история и экономика): (Россия, г. Иркутск, 28 мая 2021 г.). – Иркутск : Изд. дом БГУ, 2021. – 258 с. с 20-29, 0,75 п.л.</p>
5	<p>Монгол Улсад тарифын болон тарифын бус зохицуулалтыг хийх арга, аргачлалыг талаар санал боловсруулж үр дүнгээр нь ЭШӨ бичиж ОУХХ-ийн “Олон улс судлал” сэтгүүлд хэвлүүлэх</p>	<p>Тарифын бус арга хэмжээг ашиглаж буй олон улсын туршлага, практикийг судалж, түүнд үндэслэн Монгол Улсын тарифын бус зохицуулалтыг боловсронгуй болгох, тарифын бус зохицуулалтаар импортыг хязгаарлах боломж, тэдгээрийн онцлог, хэлбэр төрөл, олон улсын байгууллагуудаас гаргасан ангилал, тарифын бус зохицуулалтад хамгийн их өртөж буй барааны нэр төрлийн талаар судаллаа.</p> <p>Тарифын бус арга хэмжээг БНХАУ,</p>	<p>Магистр Р.Шарбанди,</p>	<p>Р.Шарбанди, Ж.Тунгалаг. “Монгол Улсын импортын тарифын бус зохицуулалтын өнөөгийн байдал, сайжруулах боломж”. Бизнес инноваци сэтгүүл. УБ 2021 (хэвлэлтэд хүлээгдэж байгаа)</p>

		ОХУ-ын хэрэгжүүлж буй онцлогийг судаллаа. Импортыг тарифын бус арга замаар зохицуулах нөхцөл, боломжийн талаар судлаж тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх 3 тулгуур нөхцөлийг тодорхойлж, тэрхүү нөхцөл байдал манай улсад бүрдсэн эсэхэд дүгнэлт хийж, цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохих талаар санал, зөвлөмж боловсрууллаа.		
6	ДХБ ба Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалт” сэдвээр ОУХХ дээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	2021 онд судалгааны ажлын эцсийн үр дүнгээр гадаад, дотоодын судлаач, эрдэмтэдийн оролцоотой олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч КОВИД-19 цар тахалаас болж зохион байгуулж чадаагүй болно.	Бүх судлаачид	Олон улсын эрдэм шинжилгээний хурал - 0
7	Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах	Гадаад худалдааны талаар баримтлах төрийн бодлогын зөвлөмж боловсруулж БШУЯ, ГХЯ, УИХ-ын МАН болон АН-ын бүлгүүдэд, УИХ-ын Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, ГЕГ, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар зэрэг төрийн байгууллагуудад хүргүүлсэн	Доктор (Sc.D) А.Даваасүрэн	Монгол Улсын гадаад худалдааны бодлогын зөвлөмж 33 хуудас (2,43 х.х.)
8	«Дэлхийн худалдааны байгууллага ба Монгол Улсын гадаад худалдааны бодлого,	Судалгааны багийн гишүүн бүр өөрт оногдсон ажлуудыг улам сайжруулах талаар 3 удаа уулзаж зөвлөлдөж, судалгааны ажлын		242 хуудас буюу 15,12 хэвлэлийн хуудас бүхий эцсийн тайлан

	<p>зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал» эцсийн тайлан бичиж тушаах</p>	<p>тайланд зарим нэг засвар, тодруулга хийсэн. Судалгааны ажлын тайланг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 27-ий өдрийн хурлаар хэлэлцүүлж, доктор (Sc.D) Ц.Баатар, доктор (Ph.D) Б.Цэнгэллхам нараар уншуулах шийдвэрийн дагуу уг судалгааны ажлын тайланг эдгээр эрдэмтэдэд хэвлэн өгч уншуулсаны дараа тэдний зүгээс гарсан санал, шүүмжийг судалгааны ажлын багийн гишүүдээр дахин засаж сайжруулсаны дараа дахин ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 03-ий өдрийн хурлаар хэлэлцүүлж, уг хурлаас тайланг эцэслэн засаж сайжруулаад ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухааны бага чуулганы хуралдаанд бэлтгэж байна. Энэ хугацаанд хүрээлэнгийн эрдэмтэн, доктор (Ph.D) А.Нямдолжингоор тайланд редакцийг хийлгэж, холбогдох засваруудыг хийж дуусгаад байна.</p>		
--	--	--	--	--

10. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭЦСИЙН ҮР ДҮН

1. Монгол Улс 1997 онд ДХБ-ын гишүүнээр элсэхдээ авсан амлалт, хүлээсэн үүргийн биелэлтэнд шинжилгээ хийсний үр дүнд уг байгууллагын зүгээс гишүүн орнуудад олгодог боломж давуу талуудыг Монгол Улс төдийлөн ашиглаж чадахгүй байна. Тухайлбал, Монгол Улс өнөөг хүртэл гадаад худалдааны эрх зүйн орчныг (хуулийг) бүрдүүлж чадаагүй, хариуцсан төрийн бүтэц ч байхгүй, одоо хэрэгжиж байгаа бодлого нь гишүүн оронд олгодог хөнгөлөлт, давуу талыг ашиглаж чадахгүй байгаа тул дотоод зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжихэд чиглэгдээгүй учир үндэсний үйлдвэрүүд хөгжихгүй, ажилгүйдэл, ядуурал их, гадаад зах зээлээс хамаарал өндөр байна.

2. Дэлхийн улс орнууд импортын барааны улс орны гарал үүсэл (өндөр хөгжилтэй орон, манай улстай Чөлөөт худалдааны хэлэлцээртэй орон, хөгжиж байгаа орон гэх мэт), үйлдвэрлэж байгаа салбар (ХАА, аж үйлдвэр), уг барааны боловсруулалтын түвшин (0-20 хувь), уг барааны найрлагад орсон түүхий эдийн шинж чанар зэрэг олон шалгуур, үзүүлэлтээс (барааг тодорхойлох, кодлох уялдуулах систем) шалтгаалан импортын гаалийн тарифыг ялгавартай тогтоох эрхийг ДХБ-ын гишүүн орнуудад олгодог боловч Монгол Улс энэхүү эрхийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Тухайлбал, нэхмэл, оёмол эдлэл, төмөрлөгийн эдлэл, мод модон эдлэл, өндөр технологийн компьютерийн хэрэгсэл, машин техник, тоног төхөөрөмжийн импортод нэгэн адил 5 хувийн гаалийн татвар ногдуулж байгаа нь маш их боломжийг алдаж байна.

3. ДХБ-д элсэхдээ Монгол Улсын импортын тарифын дээд хэмжээний энгийн дундаж хувь нь нийт барааны хувьд 17,5 хувь байхаар тохирсон боловч одоогийн байдлаар 5,2 хувь байгааг 12,3 хувиар өсгөх, мөн аж үйлдвэрийн бараа 17,3 хувь байхаар тохирсон боловч одоогийн байдлаар 6,5 хувь байгааг 10,8 хувь болгон өсгөх, ХАА-н бараанд 18,8 хувь байхаар тохирсон боловч одоогийн байдлаар 5,0 хувь байгааг 13,8 хувиар тус тус өсгөх боломж байгааг бид ашиглаж чадахгүй байна.

4. Японтой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан боловч Монгол Улсын гаалийн импортын тарифын түвшин хэт бага учир энэхүү чөлөөт худалдааны гэрээнээс манайд үр ашиг гарахгүй байна. Тухайлбал, Монгол Улсын экспортын барааны нэр төрөл цөөн, тоо хэмжээ бага, Японы зүгээс манай экспортын бараанд тавидаг стандартын шаардлага, шалгуур өндөр учир тус зах зээл рүү нэвтэрч чадахгүй харин хариуд нь тус улсын бэлэн бүтээгдэхүүн (машин техник, тээврийн хэрэгсэл) гаалийн татваргүй манай зах зээлд чөлөөтэй орж, гаалийн татварын улсын төсвийн орлогыг бүрдүүлэх үүрэг хангалтгүй биелэгдэж байна.

5. ДХБ-ын зүгээс импортыг хязгаарлах зорилготой тарифын бус хориг саадыг (мал амьтан, ургамлын хорио, цээр, техникийн хязгаарлалт, шаардлага, лиценз, квот, хориг, тоон хязгаарлалт, үнийн хяналт, демпинг, татаас, дэмжлэг, засгийн газрын худалдан авалт, оюуны өмчийн хамгаалалт, гарал үүслийн

дүрэм, барааны техникийн шаардлага, хаяг шошго, сав баглаа боодол, тэдгээрийн химийн найрлага, хүрээлэн буй орчны хамгаалалтын стандарт, шалгуур, орон нутгийн татвар, хураамж, шаардлага, ачилтын өмнөх хяналт шалгалт, тээврийн хэрэгсэлд тавих шаардлага, валютын гүйлгээ, валютын ханш гэх мэт) төдийлөн хянах шалгах боломжгүй учир гишүүн орнууддаа эдгээр арга хэмжээг зохистой хэрэглэж дотоод зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжихэд туслалцаа үзүүлэх эрхийг нээлттэй орхисон байдаг. 2019 оны байдлаар дэлхийн нийт импортын 80 орчим нь тарифын бус зохицуулалтад өртөж, хөгжингүй орнууд илүү түгээмэл ашиглаж байна. Манай хоёр хөрш ОХУ, БНХАУ ч тарифын бус арга хэмжээг маш сайн ашигладаг болох нь бидний судалгаагаар батлагдлаа. Иймд Монгол Улс гадаад худалдааны бодлогод тарифын бус зохицуулалтын арга хэмжээний талаар ямар ч эрх зүйн зохицуулалт байхгүй нь гадаад худалдааны хууль байхгүйтэй холбон үзэж байна.

Монгол Улс өнөөгийн хөгжлийн нөхцөл байдалд тохирсон өөрийн гэсэн гадаад худалдааны хуулийг боловсруулах, мөн түүнийг хэрэгжүүлэх төр, засгийн бүтэц, түүний үйл ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох, зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зайлшгүй шаардлага байна.

Эцэст нь бидний хийсэн энэхүү судалгааны ажил нь нийтдээ 327 хуудас бүхий эцсийн тайлан, 33 хуудас бүхий гадаад худалдааны бодлогын зөвлөмж бичиж төр, засгийн байгууллагуудад хүргүүлсэн гарсанаас гадна судалгааны багийн гишүүдийн уг сэдвээр бичсэн гадаад дотоод эрдэм шинжилгээний хуралд тавьсан 15 илтгэл, хэвлэгдсэн 21 өгүүлэл хэвлэгдсэн байна.

6. УИХ-ын гишүүн Д.Өнөрболороор ахлуулсан “Монгол Улсын гадаад худалдааны хуулийн төсөл” боловсруулах ажлын хэсэгт тус судалгааны ажлын удирдагч А.Даваасүрэн, багийн гишүүд Б.Санжмятав, Н.Отгонсайхан, Д.Цэндсүрэн нар орж ажиллаж манай судалгааны ажлын үр дүн болон үндсэн концепцийн дагуу гадаад худалдааны хуулийн төсөл боловсруулагдаж байна.

10.1. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР БИЙ БОЛСОН БҮТЭЭЛҮҮД:

10.1.1. Хамтын бүтээлүүд:

1. А.Даваасүрэн, Б.Санжмятав, Н.Отгонсайхан, Д.Цэндсүрэн, И.Энхболд, Р.Шарбанди “ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ” Суурь судалгааны хамтын бүтээл, Улаанбаатар, 2022 он, 15.12 х.х.
2. Н.Отгонсайхан, “Демпингийн эсрэг болон нөхөн тэгшитгэх татварын журам”, гэрээт ажил. Захиалагч: Гадаад харилцааны яам. Санхүүжүүлэгч: ЕХ-ны TRAM төсөл, 2021

3. Н.Отгонсайхан, “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх Ерөнхий хэлэлцээрт Монгол Улс нэгдэх боломж”, судалгааны төсөл. Захиалагч: Гадаад харилцааны яам. Санхүүжүүлэгч: НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, 2020-2021
4. Н.Отгонсайхан, “Дэлхийн худалдааны байгууллагын хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам”, гэрээт ажил. Захиалагч: Гадаад харилцааны яам. Санхүүжүүлэгч: ЕХ-ны TRAM төсөл, 2020
5. Н.Отгонсайхан, “ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан үхрийн мах экспортлох бодлогын зөвлөмж”, “ОХУ-ын зах зээлд адууны мах экспортлох бодлогын зөвлөмж” боловсруулах гэрээт ажил. Захиалагч: МҮХАҮТ, Санхүүжүүлэгч: GIZ, 2020.
6. И.Энхболд, “Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны механизмууд ба Монгол Улс”, “Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны механизмууд ба Монгол Улс” 2020 он, Улаанбаатар хот.
7. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын харилцаа 30 жил: Баримт бичгийн эмхэтгэл”, Улаанбаатар хот, 2021 он. 500 хуудас.

10.1.2. Гадаадад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлүүд:

1. А.Даваасурэн, “Нынешнее состояние отношений Монголии и России” научная статья, опубликованная на журнале “Большая ЕвроАзия”, Иркутск, Россия, 2020, 037 п.л.
2. А.Даваасурэн, К вопросу о реальном рывке в социально-экономическом развитии России / Даваасурэн Авирмэд, В. И. Самаруха, А. В. Самаруха //Материалы Международной научно-практической конференции "Развитие малого предпринимательства в Байкальском регионе" (Россия, Иркутск, БГУ. 20 ноября 2019 г.). Изд-во: Global & Regional Research. 2020. Т. 2, № 1 - С. 46-54. Режим доступа. <https://elibrary.ru>. URL: <https://www.elibrary.ru/item.asp?id=42896558> (статья РИНЦ).
3. А.Даваасурэн, Ч.Ариунжаргал, “О проблемах экономического коридора Россия, Монголия и Китай” /научная статья//, Институт экономики и организации промышленного производства СО РАН России, журнал “РЕГИОН” №04, Новосибирск, Россия, 2021, 1,0 п.л.
4. А.Даваасурэн, А.П.Суходолов, Ю.В.Кузьмин, Я.А.Суходолов “Торгово-экономические связи Монголии и России: история и современное состояние, вызовы и перспективы” /научная статья/ подготовлена в рамках проекта Российского фонда фундаментальных исследований 18-514-94002 МОКН_а «Национальные интересы России и Монголии в треугольнике отношений Россия – Монголия – Китай: проблемы, противоречия, сценарии», Российский экономический вестник, 2021, Том 4, №4, с 318-329, 1,1 п.л.

5. А.Даваасурен, А.П.Суходолов, А.В.Колесникова, Я.А.Суходолов “Международно-правовые аспекты российско-монгольского сотрудничества в сфере охраны и использования трансграничных вод бассейна р. Селенги” /научная статья/ юридическая наука, №9, 2021, Москва, с 65-71, 1,3 п.л.
6. Авирмэд Даваасурэн, В.И.Самаруха, “Взаимоотношения России и Монголии: история, настоящее и будущее” /научная статья, опубликованная в сборнике докладов Международной научной конференции, посвящённой 100-летию установления Российско-Монгольских дипломатических отношений (Монголия XX века и российско-монгольские отношения: история и экономика): (Россия, г. Иркутск, 28 мая 2021 г.). – Иркутск : Изд. дом БГУ, 2021. – 258 с. с 20-29, 0,75
7. B.Sanjmayrav, The Coronavirus Pandemic (COVID-19) and its Aftermath in Contemporary World Affairs, /article/ Journal of Academy of Sciences, Mongolia, December 2020.
8. Б.Санжмятав, Евразия и Мир, Россия (Russia), /научная статья/ November 2020, Стр 61-69
9. Munkhnasan G., Otgonsaikhan N., Hong-Jin Kim. Effects of EPA on the Trade Volume between Mongolia and Korea: An empirical analysis using Gravity Model and Revealed Comparative Advantage. // The journal of Mongolian studies (ISSN 1229-7097) vol.65. 2021.05, p.297-320
10. Otgonsaikhan N., Batbold L. Some issues of increasing trade between Mongolia and the Republic of Korea // The Journal of Mongolian Diaspora (JMD), (ISSN: 2765-6519) vol.1 No 1, spring 2021, p.101-126
11. Tumendemberel P., Otgonsaikhan N., Tuya D., Correlations between the attitude towards individual human value and money in the Mongolian culture // Global culture review, (ISSN 2234-6414 print) vol.11.No 2, 2020.09, p.95-117 <https://www.dbpia.co.kr/Journal/articleDetail?nodeId=NODE10478472>
12. Tsendsuren.D, Enkhamgalan. A, Munkhzul.KH, 2020, UNESCAP study paper: ‘Using mirror analysis to support essential data elements for information exchange, in order to mitigate risk of trade mis-invoicing and reduce the illicit financial flows’ 2021;
13. D.Tsendsuren, Kh.Munkhzul, Mr. Enkh-Amgalan Gurjav (2020), “Use of Mirror Analysis For Supporting Essential Data Elements For Exchange Information: In Order To Mitigate Risk Of Trade Mis-Invoicing And To Reduce The Illicit Financial Flows”, UNESCAP, study paper;
14. И.Энхболд, Political cooperation between Mongolia and Korea, 한몽 수교 30주년 기념 국제학술회의 회고화 전망, 2020 한국외대 유라시아 몽골연구센터 국제학술회의 Seoul, Page 17-28.

10.1.3. Дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлүүд:

1. А.Даваасүрэн, “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорыг байгуулах үр ашиг ба бодит хэрэгцээ” 1,1 х.х. /эрдэм шинжилгээний өгүүлэл / Улаанбаатар эрдэм их сургуулийн “Эдийн засаг” сэтгүүл, №4 (066) 2019.
2. А.Даваасүрэн, Ч.Ариунжаргал, “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор төслийн хүрээнд дэхь төмөр замын төслийн санхүүжилт” 0,58 х.х. /эрдэм шинжилгээний өгүүлэл/ Улаанбаатар эрдэм их сургуулийн “Эдийн засаг” сэтгүүл, №2 (068) 2020.
3. А.Даваасүрэн, В.И.Самаруха, С.Нямзагд, “ОХУ, Монгол улсын харилцаа, хамтын ажиллагаа: уламжлал, эдүгээ ба ирээдүй” /эрдэм шинжилгээний өгүүлэл/ 2021 оны 10 сарын 19-ий өдөр ГХЯ дээр зохион байгуулагдсан “Монгол-Оросын харилцаа 100 жилд” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Монгол банкны “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл, № 26 (2021 оны 10 дугаар сар), Улаанбаатар, х 171-183, 1,06 х.х.
4. Н.Отгонсайхан, Д.Цэндсүрэн, Хятад-Монгол-Оросын Эдийн засгийн коридор байгуулах явц дахь гадаад худалдааг хөнгөвчлөх: Практик үнэлгээ, судалгаа (ШУА), Улаанбаатар хот, 2020 он.
5. Д.Цэндсүрэн, Д.Чулуунцэцэг, Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн стандарт”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
6. Д.Цэндсүрэн, Х.Мөнзхул, Дэлхийн гаалийн байгууллагын “Транзит гарын авлага”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
7. Д.Баярсайхан, Д.Цэндсүрэн, Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх зарчим ба суурь стандарт”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
8. Д.Цэндсүрэн, Н.Батнасан. “Гаалийн эрсдэлийн удирдлагын онол, практикийн асуудлууд”. Улаанбаатар хот, 2019 он.
9. Д.Цэндсүрэн, Э.Энхтуул, Дэлхийн гаалийн байгууллагын гарын авлага: ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Нэгдүгээр хэсгийг хэрэгжүүлэх заавар, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
10. Д.Цэндсүрэн, Д.Баярсайхан (2020), Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх зарчим болон практикийн суурь” баримт бичгийг Монгол хэлнээ орчуулсан;
11. Д.Цэндсүрэн, бусад (2019), Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа: Хилийн хяналтад эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх арга зам” эрдэм шинжилгээний өгүүлэл, Монгол Улсын Их Сургууль, SIRPA FORUM 2019;
12. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын хоорондох худалдааг сайжруулах арга замууд”, Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд, өгүүллийн эмхэтгэл, 2019 он, 165-177 дугаар тал.

13. И.Энхболд, “ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцааны зураглал”, Олон улсын харилцаа сэтгүүл, №1, 2019 он, 35-47 дугаар тал.
14. И.Энхболд, “ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцаа”, Монгол Улс, БНСУ-ын харилцаа 30 жил, эмхэтгэл, 2020 он.
15. И.Энхболд, “Академич Ч.Далай ба Зүүн Хойд Ази судлал”, Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Ч.Далай-90, 2020 он, Улаанбаатар, 53-58 тал.
16. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын харилцааны цаашдын хандлага”, Монгол Улс, БНСУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосны 30-н жилийн ойн бэлтгэл, хоёр улсын харилцааны хөгжлийн төлөв, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019.12.13, Бусан хот.

10.1.4. Эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүд:

1. С.Санжмятав, “Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалт” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон ЭШХ дээр илтгэл тавьсан.
2. Н.Отгонсайхан, “ДХБ-ын гишүүн орнуудын гадаад худалдааг зохицуулж байгаа туршлага, онцлог” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон ЭШХ дээр илтгэл тавьсан.
3. И.Энхболд, “ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцаа”, /илтгэл /Бусан хотын олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2019.12.13.
4. Д.Цэндсүрэн, “ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааг хөнгөвчлөх боломж” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон эрдэм шинжилгээний хурал дээр илтгэл тавьсан.
5. Р.Шарбанди, “Гадаад худалдаанд тавигдаж буй тарифын бус хориг, арга хэмжээ” сэдвээр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 2019 оны 12 сарын 17-ий өдөр болсон ЭШХ дээр илтгэл тавьсан.
6. Р.Шарбанди, Б.Даваасүрэн. “Экспортын үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, экспортыг дэмжих бодлого” илтгэл. Экспорт Монгол 2020 бизнес форум. 2020 оны 12 сарын 25-ны өдөр.
7. А.Даваасүрэн, “Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал”, /илтгэл/ ШУА-ийн ОУХХ-ийн лхагва гаригын семинар, 2021 оны 3 сарын 10-ий өдөр, Улаанбаатар,

11. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

11.1. Гүйцэтгэгчдийн ажлын туршлага:

11.1.1. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАГЧ:

Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор **АВИРМЭДИЙН ДАВААСҮРЭН** нь 1983 онд Налайх хотын 10 жилийн 1 дүгээр сургууль, 1987 онд ЗХУ-ын Фрунзе хотын нисэх хүчний дунд сургууль, 1997 онд ОХУ-ын Эрхүү хотын эдийн засгийн академид Олон улсын эдийн засагч мэргэжлээр суралцаж төгссөн.

Тэрээр 2001 онд ОХУ-ын Эрхүү хотын эдийн засгийн академийн аспирантур төгсөж «Монгол-Оросын бүс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал, тэдгээрийн хэтийн төлөв» сэдвээр засгийн ухааны доктор (Ph.D) зэрэг хамгаалсан, 2014 оны 10 дугаар сард ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрх зүйн улсын их «Монгол Улсын эдийн засгийн орон зайн удирдлага, зохион байгуулалт: онол ба практик» сэдвээр эдийн засгийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэргийг хамгаалсан.

А.Даваасүрэн 2008 оноос одоог хүртэл ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, салбарын эрхлэгч зэрэг ажлыг эрхэлж байна.

МУИС-ийн дэргэдэх эдийн засгийн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн,

- ШУА-ийн дэргэдэх эдийн засгийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн

Тэрээр эдийн засгийн хөгжлийн стратеги, төлөвлөлтийн асуудлаар судалгааны ажилд мэргэшсэн, ялангуяа макро эдийн засаг, татвар, төрийн санхүү, гадаад худалдаа, аж үйлдвэр, бүс нутгийн эдийн засгийн удирдлагын асуудлаар томоохон бодлогын судалгаа шинжилгээний ажлыг хийх туршлагатай чадварлаг эрдэмтэн юм.

А.Даваасүрэн нийт 416,3 хэвлэлийн хуудас бүхий 133 бүтээл туурвисанаас: нэг сэдэвт бүтээл ба ном 6, хамтын бүтээл 14, гадаадад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл 69, дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл 42 байна. Үүнээс:

10.1.2. Нэг сэдэв бүтээл ба ном:

1. А.Даваасүрэн Межрегиональное торгово-экономическое сотрудничество между Монголией и Россией: проблемы и перспективы: монография / А. Даваасүрэн; под. ред. д-ра экон. наук, профессора В.И.Самарухи. – Улаанбаатар, 2002.
2. А.Даваасүрэн “Олон улсын валют, санхүү, зээлийн харилцаа” гарын авлага. Редактор МУИС-ын ЭЗС-ын Санхүүгийн тэнхмийн эрхлэгч тэргүүлэх профессор, доктор Д.Дуламсүрэн. 2005 он
3. А.Даваасүрэн “Олон улсын валют, санхүү, зээлийн харилцаа” нэмэлт хийсэн гарын авлага. Редактор МУИС-ын ЭЗС-ын Санхүүгийн тэнхмийн эрхлэгч тэргүүлэх профессор, доктор Д.Дуламсүрэн. 2010 он
4. Даваасүрэн А. Становление предпринимательства в регионах Монголии: монография / А. Даваасүрэн; под. ред. д-ра экон. наук, профессора В.И.Самарухи. – Иркутск :Изд-во БГУЭП, 2013. – 219 с.
5. Развитие региональной экономики Монголии: теория, методология и практика/ А. Даваасүрэн, В. И. Самаруха. – Иркутск : Изд-во БГУЭП, 2014. – 196 с.

6. Даваасурэн А. Пространственная организация региональной экономики Монголии / А. Даваасурэн; Монография под. ред. д-ра экон. наук, профессора В.И.Самарухи. – Улан-Удэ:Изд-во ВСГУТУ, 2015. – 219 с.

11.1.2. Хамтын бүтээл

1. Даваасурэн А. Новые вызовы российско-монгольским торгово-экономическим отношениям /А. Даваасурэн// Современные российско-монгольские отношения: модели и сценарии / под отв. ред. В. А. Родионов. – Улан-Удэ: Изд-во Бурят.гос.ун-та, 2013.- 248с. – Параграф 2.2.2. с.82-102.
2. Даваасурэн А. Российско-Монгольские торгово-экономические отношения в первой четверти XX века, раздел, опубликованный в монографии // Россия и Монголия на начале XX века: дипломатия, экономика, наука. – Кн.3,ч.1:Статьи участников 3-й Международной научно-практической конференции: сб. науч. тр. – Иркутск ; Улан-Батор: Изд-во БГУЭП, 2014. –384., с.98-105.
3. БНХАУ-ЫН ӨМӨЗО-ны Хөгжил, шинэтгэлийн хорооны санхүүжилтээр Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Улаанбаатар Эрдэм их сургуулийн хамтарсан судалгааны багийн “БНХАУ, Монгол Улс, ОХУ-ын эдийн засгийн коридор”-ын хүрээнд тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын судалгаа” GJHZYJXM – 20170501, тайлан. Улаанбаатар хот, 2017 он,
4. “Монгол Улсын эрдэс баялагийн нөөцийн ашиглалт”гарын авлага суурь судалгааны сэдэвт ажлын тайлан, /Төслийн удирдагч А.Даваасурэн/, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, 2018 он, Улаанбаатар хот,
5. “Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ” / Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын судалгааны тайлан-I, /Багийн ахлагч А.Даваасурэн/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, 2018
6. “Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа холбоонд үнэлгээ хийх, бодлогын хүрэх түвшинг тодорхойлох арга зүй” / Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын судалгааны тайлан-II, /Багийн ахлагч А.Даваасурэн/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, 2018
7. “Монгол Улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл” / Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын судалгааны тайлан-III, /Багийн ахлагч А.Даваасурэн/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, 2018
8. “Монгол Улсын дунд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ” / Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын судалгааны тайлан-IV, /Багийн ахлагч А.Даваасурэн/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, 2018

9. “Монгол Улсын хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийг хийх нийтлэг аргачлал” / Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын судалгааны тайлан-V, /Багийн ахлагч А.Даваасүрэн/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, 2018
- 10.Эдийн засгийн хэсгийг бичсэн Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын захиалгаар “АЛСЫН ХАРАА -2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны үзэл баримтлалын судалгааны ажлын эдийн засгийн судалгааны хэсгийн багийн гишүүнээр А.Даваасүрэн ажиллаж, I бүлэг, “Макро түвшний хөгжлийн өнөөгийн байдал”, “Монгол Улсын эдийн засгийн нөөц болон хүчин зүйлийн судалгаа, сорилт”, “Хүн ам зүйн үзүүлэлтүүдийн үнэлгээ”, Байгалийн болон эрдэс баялгийн нөөцийн судалгаа, зам, тээврийн дэд бүтцийн нөөцийн судалгаа, II бүлэг Гадаад орчны шинжилгээ, Дижитал эдийн засаг, холбоо мэдээллийн судалгаа, “хөгжлийн сорилтууд ба эрсдэлүүд”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын хэрэгжилтийн байдалд хийсэн, дүгнэлт судалгаа, III бүлэг, Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжлийн бодлогын логик хүрээ” 6,06 х.х., Улаанбаатар хот, 2020,
- 11.Монгол Улсын Барилга хот байгуулалтын яамын захилгаар Барилгын хөгжлийн төвөөс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын ерөнхий төлөвлөгөө” (ХАНСЕТ) боловсруулах судалгааны ажлын хүрээнд А.Даваасүрэн, “Монгол улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, дүн шинжилгээ”, “Дэлхийн аж ахуйн харилцаан дахь Монгол улс”, “Аймаг нийслэл хот суурин газруудын эдийн засгийн чадавхи (потенциал), Сум суурин газруудын өрсөлдөх чадварын үнэлгээ”, “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшилын ерөнхий төлөвлөгөөний (ХАНСЭТ) хүрээнд хийсэн судалгааны ажлын үр дүнг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа 2050”-д заасан стратегийн зорилтуудтай харьцуулсан судалгаа” 8,75 х.х.,
- 12.Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2,12 х.х. 2020, Улаанбаатар
- 13.“Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд” / Хамтын бүтээл, төслийн удирдагч А.Даваасүрэн, Хөгжлийн бодлогын судалгааны хүрээлэн, “Бэмби сан” хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2020,14,75 х.х.
- 14.А.Даваасүрэн, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2019 оны 02 сарын 25-ний өдрийн А/86 тоот тушаалаар батлагдаж Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр 2019-2021 онд Шинжлэх Ухааны Академийн Олон Улсын Харилцааны Хүрээлэн дээр хэрэгжиж байгаа “Дэлхийн худалдааны байгууллага ба Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал” сэдэвт суурь судалгааны ажлын үр дүнгээр гадаад худалдааны бодлогын зөвлөмж боловсруулсан. Улаанбаатар, 2020, 2,5 х.х.

15. Даваасурэн А., Грайворонский В.В., Дорж Т., Суходолов А.П., Кузьмин Ю.В., Ванина И.Ю., Василенко В.А., Ковальчук Л.Б., Козырская И.Е., Колесникова А.В., Кородюк И.С., Крайнова Л.Н., Манжигеев А.Ф., Рачков М.П., Силантьев А.В., Суходолов Я.А., Третьяков В.В., Цыдэнэ Ш.Ц., Национальные интересы России и Монголии в треугольнике Россия–Монголия–Китай: проблемы, противоречия и сценарии / коллективная монография/ – Иркутск. Изд-во: «Развитие», 2021. – 473 с.

11.2. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН БАГИЙН ГИШҮҮД:

Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) **Б.САНЖМЯТАВ** 1956 онд төрсөн, 1965-1975 онд Завхан аймгийн төвийн 10 жилийн дунд сургууль, 1975-1976 онд Эрхүүгийн Их сургуулийн дэргэдэх орос хэлний бэлтгэл дамжаа, 1976-1981 онд Москвагийн Олон улсын харилцааны сургууль, 1997 онд Лондонгийн Leicester Square School of English, London, 2004 онд Москвагийн Олон улсын харилцааны сургуулийн магистрантур, 2010-2011 онд МУИС-ийн докторантурт суралцаж, Олон улсын эдийн засгийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.

1981-2009 онд Монгол Улсын Дипломат албанд, түүний дотор Монгол Улсаас Алжир, Бельги, Швейцарь, Францад суугаа ЭСЯ-д ажилласан, 2012 оноос МУИС-ийн ОУХНУС-ийн профессор, Тэнхмийн эрхлэгч, МУИС-ийн Эрдмийн Зөвлөл, Хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүн, 2017 оноос УИХ-ын Тамгын газрын зөвлөхөөр ажиллаж байна. Тэрээр нэг сэдэвт бүтээл буюу ном - 3, сурах бичиг - 11, эрдэм шинжилгээний өгүүлэл 39-ийг бичиж, Монгол, Хятад, ОХУ, Япон, БНСУ, Румын зэрэг улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн.

11.2.1. Ном, нэгэн сэдэвт бүтээл:

1. Б.Санжмятав, “Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд” (хамтын бүтээл) Бэмби сан ХХК-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2020,
2. Б.Санжмятав, “Гурван хөршийн дундах Монгол Улс” /нэг сэдэв бүтээл/ МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2019,
3. Б.Санжмятав, “Монгол Улсын гадаад эдийн засгийн хамтын ажиллагаа” /нэг сэдэв бүтээл/ МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2019,
4. Б.Санжмятав, “Монголия меж трех соседей, группа авторов” /нэг сэдэв бүтээл/ Россия, Улан-Уде, 2018
5. Б.Санжмятав, “Дипломат болон бизнесийн олон улсын хэлэлцээ: онол, технологи, хэлэлцээ хийх үндэстний сэтгэлгээний онцлог, ёслол” /нэг сэдэв бүтээл/ МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2018 онд 13.5 хх
6. Б.Санжмятав, “Монгол, Франц хэлний ярианы дэвтэр” Чой. Лувсанжав, Б.Санжмятав, Г.Цэрэндолгор, Ц.Доржсүрэн, Д. Инджудрян /нэг сэдэв

бүтээл/ УБ, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 1983 онд, 2006 онд Адмон ХХК хэвлэлийн үйлдвэр. 2016 онд МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 16 хх

11.2.2. Эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Б.Санжмятав, Монгол Улс АПЕК-т элсэх асуудалд, /Эрдэм шинжилгээний өгүүлэл /Стратегийн судалгаа, Стратеги судлалын хүрээлэн, 2016, 161-177 дугаар тал
2. Б. Санжмятав, Олон улсын харилцааны шинжлэх ухааны онолын сэтгэлгээнд гарч буй шинэ хандлага, /Эрдэм шинжилгээний өгүүлэл/ "Олон улсын харилцааны байдал, төлөв ба Монгол Улс" товхимол, 2016, 132-139 дүгээр тал
3. Б.Санжмятав, Монгол Улсын олон улсын худалдаа /Эрдэм шинжилгээний өгүүлэл/ PAX Mongolica, 1, 2016, Олон улсын харилцааны хүрээлэн, 71-86 дугаар тал
4. Б.Санжмятав, ОХУ, Монгол, Хятадын эдийн засгийн коридорыг байгуулах нь 3 орны эрх ашигт нийцэж байгаа болох нь /Эрдэм шинжилгээний өгүүлэл/ "Орос судлал: тулгамдсан асуудлууд, хэтийн төлөв", МУИС, 2016.11.05
5. Б.Санжмятав, ОХУ, Монгол, Хятадын эдийн засгийн коридор: Монголын хувьд бий болох боломж, эрсдэл /Эрдэм шинжилгээний өгүүлэл / Олон улсын харилцаа, 2018, № 1, МУИС-ийн ОУХНУС,
6. Б.Санжмятав, Монгол, Хятадын харилцааг "хятадын шинэ байдал"-ын нөхцөлд хөгжүүлэх арга зам /Эрдэм шинжилгээний өгүүлэл/ ӨМИС-ийн ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл, 2016, 18-25 дугаар тал
7. B.Sanjmaymav, ASEM and Mongolia /article/ "Beyond the Horizon of Turbulant Asia: Issues and Studies", UB, 2016 (Compilation of selected papers of INHA-NUM conferences)
8. B.Sanjmaymav, Asia Crises Management and Lessons for Mongolia /article/ NUM Contemporary Political society, vol IV, n 1, 2016, p 75-85
9. B.Sanjmaymav, The Formation of Russia-Mongolia-China economic corridor relies on the trade and economic integration between the three countries /article/ China-Mongolia-Russia Think Thank forum 2016, 677-686, Development Research Center of Inner Mongolia Autonomous Region,
10. B.Sanjmaymav, Trends of Regional and Intraregional Economic Integration, /article/ PUBLIC ADMINISTRATION & REGIONAL STUDIES, No.2 (18) – 2016, Galati University Press, ISSN 2065-1759, Rumania, p 80-89
11. B.Sanjmaymav, International trade of Mongolia, /article/ ERINA, Japan, 2018, ERINA Report PLUS, 2018, June, n 142, p 4-9
12. B.Sanjmaymav, The Coronavirus Pandemic (COVID-19) and its Aftermath in Contemporary World Affairs, /article/ Journal of Academy of Sciences, Mongolia, December 2020.

13. Б.Санжмятав, Евроазия и Мир, Россия (Russia), /научная статья/ November 2020, Стр 61-69
14. Б.Санжмятав, Китай обеспечивает субсе доступ к минеральным ресурсам /научная статья/ элекронный научный журнал Регионалистика, №2, 2016
15. Б.Санжмятав, Н.В.Ломакина, Китайской политика обеспеченности минеральными ресурсами: новые задачи и механизмы /научная статья/ Вестник Хабаровскойго Государственного Университета Права и Экономии, Россия, 2017, стр

11.3. Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) **Н.ОТГОНСАЙХАН** нь Н.Отгонсайхан нь Украин улсын Донецк хотын Худалдаа, эдийн засгийн улсын их сургуулийг Бараа судлаач мэргэжлээр, эдийн засгийн ухааны магистрийн зэрэгтэй төгссөн. ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, хуулийн улсын их сургуульд эдийн засгийн ухааны докторын (Ph.D.) зэрэг хамгаалсан.

ХҮИС-ийн профессор Н.Отгонсайхан нь Нэг сэдэвт бүтээл 2, Сурах бичиг, гарын авлага 9, судалгааны өгүүлэл 60 гаруйг хэвлүүлсэн. Тэрээр улсын хэмжээний 30 гаруй томоохон төсөл, судалгааны ажлын хэсгүүдэд үр бүтээлтэй ажиллаж салбартаа хувь нэмрээ оруулсан. Тухайлбал,

- ✓ “Дэлхийн Худалдааны Байгууллагын хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам” боловсруулах
- ✓ “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх Ерөнхий хэлэлцээрт Монгол Улс нэгдэх боломж”-ийн талаар үзэл баримтлал боловсруулах
- ✓ “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020” Нийслэлийн дэд хөтөлбөр боловсруулж батлуулах
- ✓ “Худалдааны үйлчилгээ. Худалдааны газрын ангилал, нэр томъёо” MNS 6506 - 2015, үндэсний стандарт боловсруулж батлуулах
- ✓ “Ази номхон далайн худалдааны хэлэлцээр ба Монгол Улс” судалгааны ажил гүйцэтгэх
- ✓ “Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломж болон эрсдэл” судалгааны ажил гүйцэтгэх
- ✓ Монгол Улсын гадаад худалдааны тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах
- ✓ “Монгол Улсын худалдааны бодлогын үзэл баримтлал” боловсруулах нөхцөл байдлын судалгаа хийх гэх мэт.

Судалгааны ажлын чиглэл: Олон улсын худалдааны бодлого, зохицуулалт: Чөлөөт худалдааны хэлэлцээр, гаалийн тариф гэх мэт.

11.3.1. Ном, нэгэн сэдэвт бүтээл:

1. Н.Отгонсайхан, “Демпингийн эсрэг болон нөхөн тэгшитгэх татварын журам”, гэрээт ажил. Захиалагч: Гадаад харилцааны яам. Санхүүжүүлэгч: ЕХ-ны TRAM төсөл, 2021

2. Н.Отгонсайхан, “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх Ерөнхий хэлэлцээрт Монгол Улс нэгдэх боломж”, судалгааны төсөл. Захиалагч: Гадаад харилцааны яам. Санхүүжүүлэгч: НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, 2020-2021
 3. Н.Отгонсайхан, “Дэлхийн худалдааны байгууллагын хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам”, гэрээт ажил. Захиалагч: Гадаад харилцааны яам. Санхүүжүүлэгч: ЕХ-ны TRAM төсөл, 2020
 4. Н.Отгонсайхан, “ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан үхрийн мах экспортлох бодлогын зөвлөмж”, “ОХУ-ын зах зээлд адууны мах экспортлох бодлогын зөвлөмж” боловсруулах гэрээт ажил. Захиалагч: МҮХАҮТ, Санхүүжүүлэгч: GIZ, 2020
 5. N.Otgonsaikhan, Study on market access requirements and market demand for exporting target products to the European Union Market. төсөлт ажил. Захиалагч: МҮХАҮТ, Санхүүжүүлэгч: ЕХ-ны TRAM төсөл, 2018
 6. Н.Отгонсайхан, “Дотоод худалдааны салбарын нөхцөл байдлын судалгаа”. Гэрээт ажил. Захиалагч ХХААХҮЯ, 2018
 7. Н.Отгонсайхан, “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020” Нийслэлийн дэд хөтөлбөр боловсруулах судалгааны ажил. Захиалагч: НЗАА. 2017-2018
- 11.3.2. Хамтын бүтээл:
1. Н.Отгонсайхан, “Хүнсний ногоо, үр, пестецидийн импортын гаалийн тариф, тарифын бус арга хэрэгслийн зохицуулалтын өнөөгийн байдлын шинжилгээ” судалгааны ажил. Захиалагч, Санхүүжүүлэгч: НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, 2020-2021
 2. Н.Отгонсайхан, “Монгол улсын худалдааны бодлогын үзэл баримтлал” боловсруулах нөхцөл байдлын судалгаа. Захиалагч: ГХЯ, Санхүүжүүлэгч: ЕХ-ны TRAM төсөл, 2020
 3. Н.Отгонсайхан, “Дэлхийн худалдааны байгууллага ба Монгол улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал” судалгааны ажил. Захиалагч: ОУСХ, Санхүүжүүлэгч: ШУТС, 2019-2020
 4. Н.Отгонсайхан, “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор байгуулах явц дах гадаад худалдааг хөнгөвчлөх: практик үнэлгээ, судалгаа”. Захиалагч: ШУА, Санхүүжүүлэгч: ШУТС, 2020
 5. Н.Отгонсайхан, “ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан үхрийн мах экспортлох гарын авлага”, “ОХУ-ын зах зээлд адууны мах экспортлох гарын авлага” боловсруулах гэрээт ажил. Захиалагч: МҮХАҮТ, Санхүүжүүлэгч: GIZ, 2020

6. Н.Отгонсайхан, “МУ-ын бизнесийн орчны судалгаа”. Захиалагч: МҮХАҮТ. 2017 он
7. Н.Отгонсайхан, “Нэг бүс нэг зам санаачлага болон хөгжиж буй далайд гарцгүй орнуудын эдийн засгийн төрөлжилт: Монгол Улсад учирч болох эрсдэл болон боломж” судалгааны ажил. Захиалагч: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв. Санхүүжүүлэгч: GIZ, 2016

11.3.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Munkhnasan G., Otgonsaikhan N., Hong-Jin Kim. Effects of EPA on the Trade Volume between Mongolia and Korea: An empirical analysis using Gravity Model and Revealed Comparative Advantage. // The journal of Mongolian studies (ISSN 1229-7097) vol.65. 2021.05, p.297-320
2. Otgonsaikhan N., Batbold L. Some issues of increasing trade between Mongolia and the Republic of Korea // The Journal of Mongolian Diaspora (JMD), (ISSN: 2765-6519) vol.1 No 1, spring 2021, p.101-126
3. Tumendemberel P., Otgonsaikhan N., Tuya D., Correlations between the attitude towards individual human value and money in the Mongolian culture // Global culture review, (ISSN 2234-6414 print) vol.11.No 2, 2020.09, p.95-117
<https://www.dbpia.co.kr/Journal/articleDetail?nodeId=NODE10478472>
4. Otgonsaikhan N. Common obstacles in conducting foreign trade in Mongolia: Suggestions and solutions // The Northeast Asian Economic Review, (ISSN 2187-5677 (Print), Vol.6 No. 1, July 2018 p.1-14
https://www.erina.or.jp/en/wp-content/uploads/2018/08/naer61-1_tssc.pdf
5. Enkhbayar Sh., Otgonsaikhan N. Impacts of import tariff reforms on Mongolian economy: CGE Analysis with the GTAP 8.1 data base // The Northeast Asian Economic Review, (ISSN 2187-5677 (Print), Vol.5 No. 1, March 2017 p.1-25
<https://www.gtap.agecon.purdue.edu/resources/download/8387.pdf>. Энэ бүтээл
6. Enkhbold V, Otgonsaikhan N, Tegshjargal D. Analyzing the effects of Mongolia’s accession to Asia-Pacific Trade Agreement (APTA) // Academic Journal of Public administration & regional studies, (Print ISSN: 2065-1759, Online-ISSN: 2065-569X) No.1 (17) – 2016
<https://www.ceeol.com/search/article-detail?id=646630>
7. Отгонсайхан Н. Баярхүү Л. Монгол улсад цаасгүй худалдааг хэрэгжүүлэх зарим асуудал. МХНММХ, Хүний нөөцийн удирдлага сэтгүүл, (ISSN 2410-7174), –УБ 2020. – № 02 (53) – Х.69-111
8. Отгонсайхан Н., Энхбаяр Ш. Монгол улсын импортын гаалийн тарифын шинэчлэл. МУ-ын ШУА-ийн олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл, (ISSN 2312-4512 eISSN

- 2663-7871), 2020. – № 02 (111). – X.101-117
<https://doi.org/10.5564/jis.v2i111.1448>
9. Отгонсайхан Н., Нямцэцэг К. Япон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтын зарим асуудал. // МХНММХ, Хүний нөөцийн удирдлага сэтгүүл. Хүний нөөцийн удирдлага сэтгүүл, (ISSN 2410-7174), –УБ 2019. – № 01 – X.101-108
10. Отгонсайхан Н. Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан нөхцөл, боломж. МУ-ын ШУА-ийн олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл, (ISSN 2312-4512 eISSN 2663-7871), –УБ 2018. – № 01(108). – X.52-80.
<https://doi.org/10.5564/jis.v0i1.1122>
<https://www.mongoliajol.info/index.php/JIS/article/view/1122>
11. Отгонсайхан Н. Монгол улсын ОХУ-тай хийж буй худалдааны өнөөгийн байдал // МӨНГӨ, САНХҮҮ, БАЯЛАГ Монгол банкны сэтгүүл (ISSN 2521-1501). –УБ 2018. – № 09 – X.58-70
https://www.mongolbank.mn/documents/MSB_setguul/MB_sanhuu09.pdf
12. Отгонсайхан Н. Хөрш орнуудын дотоод худалдааны төрийн бодлого, зохицуулалтын зарим асуудал // МХНММХ, Хүний нөөцийн удирдлага сэтгүүл, (ISSN 2410-7174). –УБ 2018. – № 4 (049) – X.30-39
13. Отгонсайхан Н., Даваасүрэн Б., Должин М., Энх-Отгон Д. Гадаад худалдаа эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэлийг тодорхойлох судалгаа // МУИС, БС-ийн Бизнес ба инноваци (ISSN 2616-3845). - 2018/04 (12)
14. Б.Даваасүрэн, Д.Энх-Отгон, М.Должин, Н.Отгонсайхан. Монголын бизнесийн орчны өнөөгийн нөхцөл байдал, сайжруулах боломж // МУИС, БС-ийн Бизнес ба инноваци (ISSN 2616-3845). - 2018/03 (11)

11.4. Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) **Д.ЦЭНДСҮРЭН** нь Д.Цэндсүрэн нь эдийн засагч, эрх зүйч мэргэжилтэй, ажил хөдөлмөрийн анхны гараагаа 1995 оноос Сэлэнгэ аймаг дахь гаалийн газраас эхэлсэн. Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хот, Улс хоорондын шуудан илгээмж дэр гаалийн газарт үйл ажиллагааны түвшинд ажилласан бөгөөд 2009 оноос Гаалийн удирдах төв байгууллагад ажиллах болж энэ үеэс гаалийн эрсдэлийн удирдлага, гаалийн үнэлгээ, тариф, татвар, олон улсын худалдаа, сүүлийн жилүүдэд гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр мэргэшин ажиллаж байна. Англи, орос хэлтэй.

Д.Цэндсүрэн нь Профессор Н.Батнасангийн удирдлага дор 2015 онд “Гаалийн хяналтын эрсдэлүүд, тэдгээрийг бууруулах зарим арга зам” сэдвээр бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.

Дэлхийн гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын зөвлөхийн сонгон шалгаруулалтад тэнцэж 2011 онд тэнцэж, 2017 онд Дэлхийн гаалийн байгууллагын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны болон техникийн зөвлөхийн эрхтэй болсон байна.

Дэлхийн Гаалийн Байгууллагын Удирдах Ажилтны Хөтөлбөр 2016/2017-д шалгаруулалтад тэнцэн Хууль сахиулах газарт Татварын хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын чиглэлээр дадлагажин ажилласан.

Түүний албан тушаалын замналд Дэлхийн гаалийн байгууллагын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 2017 онд түүнд Дэлхийн гаалийн байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газраас “Дэлхийн гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр мэдээллийн шинжээчийг хэрхэн төрүүлсэн тухай” богино өгүүлэл бичих санал тавьж “Дэлхийн гаалийн байгууллагын мэдээ сэтгүүл”-ийн 82 дугаарт нийтлэн, тус байгууллагын гишүүн орнуудын гаальчдын мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэхэд түүчээ болжээ.

Д.Цэндсүрэн нь 30 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл болон нийтлэл бичиж гадаад, дотоододын нэр хүндтэй сэтгүүлд хэвлүүлж, гадаад улсад 8 удаа экспертээр ажилласан, олон улсын эрдэм шинжилгээний дотоод, гадаадын хуралд 12 удаа илтгэлээ хэлэлцүүлж, 6 ажлын хэсэг ахлан, 13 ажлын хэсэгт орж ажиллан гадаад худалдааны бодлого, гадаад худалдааг хөнгөвчлөх, гаалийн эрсдэлийн удирдлага, толь статистикийн шинжилгээ болон бусад чиглэлээр өөрийн онол, практикийн мэдлэгээ олон нийтэд хуваалцсан байна.

11.4.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Tsendsuren.D, Enkhamgalan. A, Munkhzul.KH, 2020, UNESCAP study paper: ‘Using mirror analysis to support essential data elements for information exchange, in order to mitigate risk of trade mis-invoicing and reduce the illicit financial flows’ 2021;
2. Н.Отгонсайхан, Д.Цэндсүрэн, Хятад-Монгол-Оросын Эдийн засгийн коридор байгуулах явц дахь гадаад худалдааг хөнгөвчлөх: Практик үнэлгээ, судалгаа (ШУА), Улаанбаатар хлт, 2020 он.
3. Д.Цэндсүрэн, Д.Чулуунцэцэг, Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн стандарт”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
4. Д.Цэндсүрэн, Х.Мөнзхул, Дэлхийн гаалийн байгууллагын “Транзит гарын авлага”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
5. Д.Баярсайхан, Д.Цэндсүрэн, Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх зарчим ба суурь стандарт”, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
6. Д.Цэндсүрэн, Н.Батнасан. “Гаалийн эрсдэлийн удирдлагын онол, практикийн асуудлууд”. Улаанбаатар хот, 2019 он.
7. Д.Цэндсүрэн, Э.Энхтуул, Дэлхийн гаалийн байгууллагын гарын авлага: ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Нэгдүгээр хэсгийг хэрэгжүүлэх заавар, англи хэлнээс хөрвүүлсэн, Улаанбаатар хот, 2020 он.
8. D.Tsendsuren, Kh.Munkhzul, Mr. Enkh-Amgalan Gurjav (2020), “Use of Mirror Analysis For Supporting Essential Data Elements For Exchange

- Information: In Order To Mitigate Risk Of Trade Mis-Invoicing And To Reduce The Illicit Financial Flows”, UNESCAP, study paper;
9. Д.Цэндсүрэн, Д.Баярсайхан (2020), Дэлхийн гаалийн байгууллагын “Гаалийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх зарчим болон практикийн суурь” баримт бичгийг Монгол хэлнээ орчуулсан;
 10. Д.Цэндсүрэн, Э.Энхтуул (2017), Дэлхийн гаалийн байгууллагын “Гааль-Бизнесийн түншлэл” гарын авлагыг Монгол хэлнээ орчуулсан;
 11. Д.Цэндсүрэн, бусад (2019), Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа: Хилийн хяналтад эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх арга зам” эрдэм шинжилгээний өгүүлэл, Монгол Улсын Их Сургууль, SIRPA FORUM 2019;
 12. Д.Цэндсүрэн, Д.Баярсайхан (2017), ДГБ-ын “Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх Багц стандарт”-ыг Монгол хэлнээ орчуулсан;
 13. Tsendsuren.D (2017), “Use of Mirror Statistic Analysis for Customs Risk Management: The Case of Mongolia”, PICARD Conference 2017;
 14. Tsendsuren.D (2017), “Developing data analyst skills: how the WCO contributes to expanding this specialized area of work”, WCO News: N: 82 pp26-27.
http://www.wcoomd.org/~media/wco/public/global/pdf/media/wco-news-magazines/wco_news_82.pdf;
 15. Д.Цэндсүрэн, Н.Батнасан, (2015), “Монгол Улсын гаалийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга зам”, Бизнес & Инноваци сэтгүүл. МУИС. Бизнесийн сургууль, Дугаар 2015/05(02);
 16. Tsendsuren.D., Batnasan.N, 2015, “Ways to modernize customs risk management in Mongolia”. World Customs journal, Volume 9, Number 2, September 2015.
<http://www.worldcustomsjournal.org/index.php?resource=6>;
 17. Tsendsuren.D, 2014, “Improvement of risk management implementation Process of Mongolian Customs”, INCU Global Conference 2014 “Trade facilitation Post-Bali: Putting Policy into Practice” in Baku, Azerbaijan May 2014;
 18. Tsendsuren.D, 2014, “The importance of border security and migration of risk analysing process: Case study of Mongolia”, “Cross-Border Research Conference Border Security: Globalization and Challenges of Migration, Dushanbe, Tajikistan, November 2014;
 19. Д.Цэндсүрэн, (2014), “Гадаад худалдааны бизнесийн орчинг бүрдүүлэхэд гаалийн байгууллагын оролцоо”, Мөнгө Санхүү сэтгүүл, Дугаар 1, Улаанбаатар хот 2014 он;
 20. Д.Цэндсүрэн, (2013), “Монголын гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хөгжлийн өнөөгийн байдал: Японы гаалийн

байгууллагаас суралцах нь”, Удирдахуйн онол, практикийн асуудлууд, Эрдэм шинжилгээний бичиг, Дугаар 13, Улаанбаатар хот 2013 он;

21. Д.Цэндсүрэн, (2012), “Хилийн аюулгүй байдлыг хангахад хилийн хяналтын байгууллага, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа”, “Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа” олон улсын эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар хот, 2012 оны 9 дүгээр сар;

22. Д.Цэндсүрэн, (2012), “Гадаад худалдааны бараа нийлүүлэлтийн сүлжээний аюулгүй байдал ба эрсдэлийн удирдлага”, “Үндэсний Аюулгүй Байдал-Даяаршсан Сүлжээт Гааль” олон улсын эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар хот, 2012 оны 10 дугаар сар.

11.5. Олон улс судлалын ухааны доктор (Ph.D) **И.ЭНХБОЛД** нь 1998-2002 онд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль дээр Солонгос хэл, Маркетинг Менежментийн Бакалаврын зэрэг хамгаалсан, 2002-2004 онд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль дээр Соёл судлалын ухааны магистрын зэрэг хамгаалсан, 2005-2007 онд БНСУ-ын Кён Хи Их Сургууль дээр Эдийн засгийн ухааны магистрын зэргийг “Монгол Улс дахь Солонгосын шууд хөрөнгө оруулалт” сэдвээр хамгаалсан, 2016-2018 онд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Олон улс, орон судлалын докторын зэргийг “Монгол Улс, БНСУ-ын хоорондох худалдааны харилцааг сайжруулах зарим асуудал” сэдвээр хамгаалсан.

Тэрээр 2003 оноос хойш Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнд солонгос судлаач, 2009 – 2010 онд Солонгосын хамтын ажиллагааны агентлагийн санхүүжилттэй “Нийтийн тээврийн ухаалаг систем” төслийн ахлагч, 2010 – 2012 онд “Солонгосын байгалийн нөөцийн хөгжүүлэлт” ХХК-д зөвлөх, 2015 – 2018 онд ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Үйлдвэрчний эвлэлийн дарга, 2018 оноос хойш “Шинэ мянганы хөгжил” ТББ-ын Тэргүүнээр тус тус ажиллаж байна.

11.5.1. Нэгэн сэдэвт бүтээл ба ном:

1. И.Энхболд, “БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн зарим хүчин зүйлс: Соёлын нөлөө”, Магистрын зэрэг горилсон бүтээл, ХУИС, Эдийн засгийн тэнхим, 2004 он, Улаанбаатар хот.
2. И.Энхболд, “한국기업의 몽골직접투자 가능성에 관한 연구”, 경희대학교 대학원 경제학과, 2009년 02월
3. И.Энхболд, Орч: “БНСУ-ын Монгол дахь шууд хөрөнгө оруулалтын боломжийн талаарх судалгаа”, Магистрын зэрэг горилсон бүтээл, Кён Хи Их Сургууль, Эдийн засгийн тэнхим, 2008 он, Сөүл хот, БНСУ.
4. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ хоорондын худалдааны харилцааг сайжруулах зарим асуудал” докторын зэрэг горилох диссертацийн ажил. Улаанбаатар хот, 2018 он.

11.5.2. Хамтын бүтээл:

1. И.Энхболд, “БНСУ-д Шинжлэх ухаан, технологийн парк байгуулсан туршлага”, (Шинжлэх Ухаан, Технологийн Сангийн судалгааны захиалгат ажил), 2013 он.
 2. И.Энхболд, Олон Улсын Харилцааны Хүрээлэн, хагас зууны түүхэн товчоон, 1968-2018 он, ОУХХ-ийн 50 жилийн ойд зориулсан түүхэн бүтээл, Улаанбаатар хот, 2018 он. 5 хэсэг, 320 тал.
 3. И.Энхболд, “Дэлхийн эрдэс баялгийн зах зээлд Монгол улсын оролцоо: Боломж ба сорилт”, судалгааны нэгэн сэдэвт зохиол, Улаанбаатар хот, 2018 он. 5-н бүлэг, 400 тал.
 4. И.Энхболд, “Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны механизмууд ба Монгол Улс”, “Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны механизмууд ба Монгол Улс” 2020 он, Улаанбаатар хот.
 5. И.Энхболд, “Дэлхийн худалдааны байгууллага ба Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал”, Улаанбаатар хот, 2021 он.
 6. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын харилцаа 30 жил: Баримт бичгийн эмхэтгэл”, Улаанбаатар хот, 2021 он. 500 хуудас.
- 11.5.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл:
1. И.Энхболд, “БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлс”, Олон улс судлал сэтгүүл 2003 он, Улаанбаатар хот
 2. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын эдийн засгийн харилцаа”, Олон улс судлал сэтгүүл 2004 он, Улаанбаатар хот
 3. И.Энхболд, “БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн зарим хүчин зүйлс: Соёлын нөлөө”, Магистрын зэрэг горилсон бүтээл, 2004 он, Улаанбаатар хот
 4. И.Энхболд, “БНСУ-ын танилцуулга” товхимол, 2005 он, Улаанбаатар хот
 5. И.Энхболд, “БНАСАУ-ын эрчим хүчний өнөөгийн байдал, хэтийн төлөв” Сэдэвт ажилтай холбогдох өгүүллэг, 2010 он, Улаанбаатар хот
 6. И.Энхболд, “Евразийн санаачилга ба монголын коридор: боломж, сорилт, хэтийн төлөв”, Олон улс сэтгүүл, 2014 он, №3. 87-102 тал.
 7. И.Энхболд, “Монголд өргөнөөр яригдаж буй төслүүдийн тойм”, Монгол Улс ба хөрш орны гадаад бодлого, ОУХХ, Ж.Баясах, эмхэтгэл, 2015 он, Улаанбаатар хот.
 8. И.Энхболд, “Төвийг сахих статусын эдийн засгийн үр дагавар”, Монгол Улсын байнга төвийг сахих статус: сорилт ба боломж” Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2016 он, Улаанбаатар хот. 116-132 тал.
 9. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын эдийн засгийн харилцааны зарим асуудал”, Солонгос Судлал сэтгүүл, 2016.01, 112-120 тал.
 10. И.Энхболд, “USA’s policy and interest toward Korean Peninsula”, British & American Studies 2016/Policy Impacts, Delimmas&Multilateral Relations/, National Conference, 2016 year,
 11. И.Энхболд, “Солонгосын хойг дахь АНУ-ын бодлого, ашиг сонирхол”, Их Британи, Америк судлал 2016, Үндэсний хурал, 2016 он, Улаанбаатар хот.

12. И.Энхболд, “Солонгосын хойг ба Зүүн Хойд Азийн аюулгүй байдал”, Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд, Хууль Сахиулах Их Сургууль, 2016.12.14, Улаанбаатар хот.
13. И.Энхболд, Солонгосын хойг дахь АНУ-ын гадаад бодлого: өнөөгийн байдал, хэтийн төлөв, Рах Mongolica, №1, 2017 он.
14. И.Энхболд, Монгол Улс, БНСУ-ын худалдааны харилцаа, Олон улс судлал сэтгүүл, №1, 2018 он.
15. И.Энхболд, Боломж сорилтын дундах Өмнийн говь, Рах Mongolica, №1, 2018 он.
16. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын хоорондох худалдааг сайжруулах арга замууд”, Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд, өгүүллийн эмхэтгэл, 2019 он, 165-177 дугаар тал.
17. И.Энхболд, “ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцааны зураглал”, Олон улсын харилцаа сэтгүүл, №1, 2019 он, 35-47 дугаар тал.
18. И.Энхболд, “ЗХА дахь Монгол Улс, БНСУ-ын харилцаа”, Монгол Улс, БНСУ-ын харилцаа 30 жил, эмхэтгэл, 2020 он.
19. И.Энхболд, “Академич Ч.Далай ба Зүүн Хойд Ази судлал”, Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Ч.Далай-90, 2020 он, Улаанбаатар, 53-58 тал.
20. И.Энхболд, “유라시아 이니셔티브” 정책 제안 및 연결 통로로서 몽골의 기회, 도전, 향후 전망”, One Northeast Asia Region, One Community, NEAR International Forum 2014, NEAR, 2014년 26-33쪽
21. И.Энхболд, “몽골에서 논의되고 있는 프로젝트에 대한 개요”, Historical Value and the Future of Eastern Mongolia II, International Conference of Eastern Mongolia Project 2015, 동북아역사재단, 2015년 29-35쪽
22. И.Энхболд, “한-몽 관계 정치외교 분야협력 현황과 과제”, 유라시아 시대 한-몽 미래 협력 대화, 한-몽골 국제세미나, 2016년 203-220 쪽
23. И.Энхболд, “Trade relations of Mongolia and Republic of Korea”, 몽골지역연구, 몽골연구소, 2017.01, Соул хот, 2017 он.
24. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын хоорондын худалдааны харилцааг сайжруулах арга замууд”, Өгүүллийн эмхэтгэл, Умардын соёлын хүрээлэн, Данкүкийн Их Сургууль, Сөүл хот, 2018.12.16. 49-65 дугаар тал.
25. И.Энхболд, “Монгол Улс, БНСУ-ын харилцааны цаашдын хандлага”, Монгол Улс, БНСУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосны 30-н жилийн ойн бэлтгэл, хоёр улсын харилцааны хөгжлийн төлөв, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019.12.13, Бүсань хот.
26. И.Энхболд, Political cooperation between Mongolia and Korea, **한-몽 수교 30 주년 기념 국제학술회의 회고회 전망 2020 한국외대 유라시아-몽골연구센터 국제학술회의 Seoul, Page 17-28.**

11.6. Бизнесийн ухааны магистр (МВА) **Р.ШАРБАНДИ** нь 2006-2009 онд МУИС-ын Эдийн засгийн сургуулийн Олон улсын худалдааны тэнхимд магистрын зэрэг хамгаалсан, 1998-2002 онд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургуулийг Олон улсын худалдааны мэргэжлээр Бакалаврыг төгссөн.

Тэрээр 2003 – 2007 онд НХХЯ-ны харьяа Гадаадад ажиллах хүч Зуучлагч товчоо, Сургалтын албаны ажилтан, дарга, 2007 – 2010 онд ХҮДС-д дадлагажигч багш, багш, 2010 – 2014 онд МУИС-ийн Худалдаа Үйлдвэрлэлийн сургуульд багш, 2014 – 2019 онд МУИС-ийн Бизнесийн сургуульд багш, 2019 – 2020 он Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуульд багш, 2020 оноос МУИС-ийн Бизнесийн сургуульд багшаар ажиллаж байна.

11.6.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл ба илтгэл:

1. Р.Шарбанди, Ж.Тунгалаг. “Монгол Улсын импортын тарифын бус зохицуулалтын өнөөгийн байдал, сайжруулах боломж”. Бизнес инноваци сэтгүүл. УБ 2021 (хэвлэлтэд хүлээгдэж байгаа)
2. Р.Шарбанди, Б.Даваасүрэн. “Экспортын үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, экспортыг дэмжих бодлого” илтгэл. Экспорт Монгол 2020 бизнес форум. 2020 оны 12 сарын 25-ны өдөр.
3. Sharbandi R, Tungalag J, Park Eui Burm ‘Transfer pricing regulation in Mongolia’, Asia-Pacific Journal of Business, Vol. 10, p.197-204, Dec 2019
4. Г.Мөнхбаясгалан, Р.Шарбанди, Ж.Тунгалаг, “Глобал жижиглэн худалдааны орчин дахь Монгол Улс”, Бизнес ба инноваци сэтгүүл, 2019/07 (№16) 154-167 хуудас, 2019.
5. Б.Даваасүрэн, Б.Угтахжаргал, Р.Шарбанди, М.Цолмон “Монголын бизнесийн харилцаан дахь ёс зүйн төлөв байдал” илтгэл, Бизнес ба хүний эрхийн зарчмыг нэвтрүүлэхэд эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх нь эрдэм шинжилгээний хурал, ГХЯам, UNDP, WFC, МУИС, 2021 оны 7 сарын 5-6 өдөр
6. Р.Шарбанди ‘Уул уурхайн салбар дахь үнэ шилжүүлэлтийн асуудалд’ үзүүлэн илтгэл. Худалдаа ба Тогтвортой хөгжил ОУЭШХ, зохион байгуулагч ХҮИС, 2020
7. Р.Шарбанди, Н.Батнасан, Н.Отгонсайхан ‘Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөө’. Globalization and Business Development ОУЭШХ, зохион байгуулагч БС-ийн Маркетинг, Худалдааны тэнхим, 2019
8. Р.Шарбанди, Г.Мөнхбаясгалан, Ж.Тунгалаг “Глобал жижиглэн худалдааны хөгжлийн асуудалд”. Globalization and Business Development ОУЭШХ, зохион байгуулагч БС-ийн Маркетинг, Худалдааны тэнхим, 2019

12. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Сэдэвт ажлын багийн гишүүд	Эрдмийн цол, зэрэг	Албан тушаал	Холбоо барих хаяг
---	----------------------------	--------------------	--------------	-------------------

1	А.Даваасүрэн	Доктор (Sc.D), профессор	ШУА-ийн ОУСХ-ийн Бүс нутаг, Олон талт хамтын ажиллагаа судлалын салбарын эрхлэгч, ЭШТА	Утас: 91910523 Email: davaasuren13@yahoo.com
2	Б.Санжмятав	Доктор (Ph.D)	МУИС-ийн ОУХНУС-ийн профессор	Утас: 91918804 Email: b_sanjmyatav@yahoo.fr
3	Н.Отгонсайхан	Доктор (Ph.D)	МУИС-ийн Бизнесийн сургуулийн профессор	Утас: 99237792 Email: otgonsaikhan32@gmail.com
4	Д.Цэндсүрэн	Доктор (Ph.D)	Гаалийн улсын ахлах байцаагч	Утас: 80087722 Email: tsendsuren821@gmail.com
5	И.Энхболд	Доктор (Ph.D)	ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан	Утас: 91031903 Email: enkhboldi@mas.ac.mn
6	Р.Шарбанди	Магистр (MBA)	МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш	Утас: 99032779 Email: re_sharbandi@yahoo.com

13. “Дэлхийн эрдэс баялгийн зах зээлд Монгол Улсын оролцоо: боломж ба сорилт” сэдэвт 18 хэвлэлийн хуудас бүхий хамтын бүтээл, 2022, х-44-288.

УДИРТГАЛ

XXI зуунд олон улсын худалдаа нь Дэлхийн худалдааны байгууллагын (ДХБ) хэмжээнд тогтоосон олон талт гэрээ, хэлэлцээрүүд, олон улсын эрх зүйн зохицуулалт, түүний гишүүн орнуудын хүлээсэн үүрэг, авсан амлалтаас гадна НҮБ болон түүний төрөлжсөн олон улсын байгууллагын хүрээнд дэлхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн орчин, олон улсын тусгай хэм хэмжээгээр зохицуулагдаж байна. ДХБ-ын хүрээнд тогтоосон олон талт эрх зүйн зохицуулалт нь олон улсын худалдааны хэм хэмжээ, зарчмуудыг тогтоож, түүний гишүүн орны төр, засгаас баримтлах гадаад худалдааны бодлогын үндсэн чиглэл, зарчмуудыг тодорхойлдог, заавал хэрэгжүүлэх ёстой олон улсын нийтлэг эрх зүйн орчин юм.

НҮБ-ын хүрээнд батлагдсан томоохон баримт бичиг, гэрээ, конвенциуд нь улс орнуудын хоорондын харилцааны үндсэн суурь зарчмуудыг тогтоож, олон улсын харилцааны дэг жаяг, дүрэм журам зэрэг эрх зүйн актуудыг нэгтгэн жигдрүүлж, адил болгох, олон улсын түвшинд нэгэн ижил эрх зүйн орчныг бий болгодог боловч гишүүн орнуудын хувьд тэдгээрийг заавал биелүүлэх үүрэг хүлээлгэдэггүй болно. Тийм учраас НҮБ-ын гишүүн орнууд олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, хүлээх эрх үүрэгтэй дотоодын хууль тогтоомжуудыг нийцүүлэн батлуулснаар тэдгээрийг хэрэгжүүлэх боломж бүрддэг байна.

Тэгвэл олон улсын тусгай эрх зүй нь олон улсын худалдаа, хамтын ажиллагаанд хувийн компани, гадаадын субъект оролцсон техникийн асуудлуудыг зохицуулах, маргааныг шийдвэрлэх зэрэгт чиглэгдсэн байдгаараа онцлогтой юм.

Монгол Улс 1990-ээд оноос эхлэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихэд шаардлагатай бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн нь манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд шинэ хуудас нээсэн билээ. Энэ үеэс гадаад худалдаан дахь төрийн монополийг эрхийг халж, гадаад худалдааг чөлөөлснөөр, түүнд оролцогч хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, төр засаг болон түнш гадаад улс орнууд болон экспорт, импортын газар зүйн болон барааны бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан.

Өнөөдөр Монгол Улсын эдийн засагт гадаад худалдааны оруулж буй хувь нэмэр маш өндөр ч гэсэн тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжил нь гадаад худалдаанаас хэт их хамааралтай болж байна. Тухайлбал, 2020 онд Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 12,7 тэрбум долларт хүрч (үүнээс экспорт 7,5 тэрбум доллар, импорт 5,2 тэрбум доллар) 1990 оныхоос 1,5

тэрбум доллар (үүнээс 660 сая доллар, импорт 924 сая доллар) 8 дахин өссөн байна. 2020 онд манай улсын гадаад худалдааны эргэлтэд ОХУ 11,3 хувь, БНХАУ 50 хувийг тус тус эзлэж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн шилжилтийг эхлүүлсэн цагаасаа хойш гадаад худалдаанд хэт либерал чөлөөт бодлого баримталсаны үр дүнд экспортод түүхий эд, импортод бэлэн бүтээгдэхүүн зонхилсон шинж чанартай болж, дотоодын зах зээлээс үндэсний үйлдвэрлэгчид шахагдан гарч, гадаад худалдаа нь цөөн тооны уул уурхайн түүхий эдээс хэт хамааралтай болсон байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5-д “гадаад худалдаа, интеграцийн оновчтой бодлогыг эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нэг чухал арга хэрэгсэл” гэж томъёолж, 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна” гэсэн зорилтыг тавьсан ч гэсэн 2020 онд Монгол Улсын экспортод БНХАУ 72,5 хувь, ОХУ 0,8 хувь, импортод БНХАУ 35,7 хувь, 26,4 хувийг тус тус эзэлж байгаа нь гадаад худалдааны эмзэг байдлыг нэмэгдүүлж, хөрш хоёр улсаас хэт хараат байх нөхцөлийг бүрдүүлж байна.

2010 онд Монгол Улсын экспортын барааны бүтцэд эрдэс бүтээгдэхүүн 81,0 хувийг эзэлж байсан бол 2020 онд 88,0 хувь болсон байна. 2020 оны байдлаар эрдэс бүтээгдэхүүний экспортод нүүрс нийт экспортын 40,3 хувь, зэсийн баяжмал 23,6 хувь байгаа ба эдгээр нь үндсэндээ зөвхөн нэг оронд экспортлогдож байгаа нь эдийн засгийн хэт хамаарлыг бий болгож, экспортын хувьд Монгол Улс хоёр хөршөөс 73,3 хувийн хамааралтай байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.3-д “нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална. Түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, монополь, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж заасан нь хэрэгжихгүй байна. Тухайлбал, импорын хувьд Монгол Улс хоёр хөршөөс 62,1 хувийн хамааралтай байна. ОХУ-аас түлш, шатахуун, тослох материал, цахилгаан эрчим хүч, БНХАУ-аас, ачааны тэрэг, техник хэрэгсэл, барилгын материал, хоол хүнс, хувцас зэрэг олон нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийг голлон импортолдог. Монгол Улс нь машин, цахилгаан бараа, тээврийн хэрэгсэл, түлш шатахуун, тослох материал зэргийг 100 хувь, барилгын материалын дийлэнх хэсгийг, хүнсний бүтээгдэхүүний 70 хувийг импортоор авч байгаа нь эдийн засгийг эмзэг болгож, гадаад зах зээлээс хараат байдлыг нэмэгдүүлж байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд төр, засгаас үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, нэмүү өртөг өндөртэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулах үйлдвэрлэлийг урамшуулах зорилгоор импортын гаалийн тарифын хувь

хэмжээг ДХБ-ын өмнө үүрэг хүлээж тохирсон хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг импортын хэт их өсөлт болон шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах, гаалийн тарифыг барааны боловсруулалтын түвшин болон эдийн засгийн салбараас хамааруулан ялгавартай тогтоох бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж эхэлсэн ч гэсэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх бодлого, зохицуулалт тодорхойгүй байсаар байна. Иймээс манай улсын сүүлийн үед авч хэрэгжүүлж буй зарим бодлого шийдвэрийг ДХБ-ын Барааны хорооны хуралдааны үеэр ОХУ “Монгол Улсыг ДХБ-ын хэлэлцээрийн заалт болон авсан үүрэг амлалтаа зөрчсөн” гэсэн гомдолыг гаргаж тавьсан нь ДХБ-ын маргаан хянан шийдвэрлэх байгууллагад татагдах нөхцөл байдал үүсч байв.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтыг ялгавартай зохицуулж өгсөн байдаг ба дотоод зах зээл, ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтаар хамгаалахыг зөвшөөрсөн байдаг. Тухайлбал, БНСУ -ын мөрдөж буй гаалийн тарифын дээд түвшин 887 хувь, Япон улсын хувьд 723 хувь байна.

Түүнчлэн Өмнөд Азийн орнуудын ХАА-н барааны гаалийн тарифын түвшин хамгийн өндөр буюу 10 хувь ба түүнээс дээш, эцсийн бэлэн бүтээгдэхүүний тариф 15 хувиас дээш байна. Ялангуяа үндсэн метал, уул уурхайн болон металын баяжмал, газрын тос, байгалийн хий, нүүрс, нефтийн бүтээгдэхүүнээс бусад салбарын бараа, бүтээгдэхүүнүүд нь боловсруулалтын түвшингээс хамаарсан гаалийн тарифтай байгаа ба тухайн улс орнууд ДХБ-д элсэж үүрэг амлалт авахдаа ч барааны боловсруулалтын түвшинг харгалзан үзэж байжээ.

Эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын ялгавартай бодлого зохицуулалтыг ихэнх улс орнууд хэрэгжүүлж байна. Тухайлбал, ХАА-н салбарын бараа бүтээгдэхүүний гаалийн тариф аж үйлдвэрийн болон байгалийн баялгийнхаас илүү өндөр байна. Боловсруулах салбараас хүнсний бүтээгдэхүүн, амьтны гаралтай бүтээгдэхүүн тариф маш өндөр байхад аж үйлдвэрийн салбараас нэхмэл сүлжмэл, хувцасны тариф нилээд өндөр байгаа нь манай орны хувьд анхаарах асуудлын нэг болж байна. Тухайлбал, БНХАУ хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн дээр мөрдөж буй дундаж нэн тааламжтай тариф 11-29 хувь, хамгийн өндөр тариф 20-65 хувь байна. Гэтэл ОХУ-ын гаалийн тарифын зөрүү их буюу мөрдөж буй тариф нь 0-26 хувь, хамгийн өндөр тариф 0-303 хувь, Монгол улсын мөрдөж буй тариф 5-14,8 хувь, хамгийн өндөр тариф 5-40 хувь байгаа нь харьцангуй бага тариф ногдуулж байна гэж үзэхээр байна.

Бидний хийсэн судалгааны үр дүнгээр Монгол Улс импортын тарифын дундаж хэмжээ 17,5 хувь, түүний дотор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд 18,5 хувь, хөдөө аж ахуйн бүх бүтээгдэхүүнд 17,3 хувь байхаар тохиролцож

ДХБ-ын өмнө авсан үүрэг, амлалт нь харьцангуй бага хувь хэмжээ гэж үзэхээр байгаа ба одоо мөрдөж байгаа импортын 5 хувийн тариф нь үндэсний үйлдвэрийг гадаадын хямд, чанар муутай бүтээгдэхүүнээс хамгаалж чадахгүйгээр барахгүй, түүнийг сүйрүүлэх нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Ялангуяа Засгийн газраас 1997-1999 онд импортын тарифыг “0” болгосон нь үндэсний үйлдвэрүүдэд маш том цохилт болж, манай улс зах зээлийн харилцааны шилжилтийн эхний цөөхөн жилүүдэд өмнөх тогтолцооны үед байгуулсан үндэсний боловсруулах үйлдвэрүүд үндсэндээ устаж үгүй болж, одоо хүртэл сэргэж чадахгүй байна.

Иймд энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс өнөөг хүртэл импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтад шинэчлэл хийхдээ барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбар, дэлхийн улс орнуудын барааны гарал үүслээс шалтгаалан импортын гаалийн тарифыг ялгавартай тогтоосон дотоодын зах зээлийг хамгаалах, экспортыг дэмжсэн бодлого зохицуулалтыг хийх шаардлага гарч байна гэсэн дүгнэлтийг хийхэд хүрлээ.

Эдийн засгийн хөгжлийн хувьд Монгол Улс хөрш орнуудтай харьцуулахад буурай хөгжилтэй боловч хөрш орнуудын, түүний дотор Монгол Улсын гадаад худалдаанд БНХАУ-ын гүйцэтгэх үүрэг үлэмж их билээ. Иймд зөвхөн нэмүү өртөг шингэсэн экспортын худалдааг хөгжүүлэхийн зэрэгцээ, худалдааны урсгалыг илүү түргэтгэх зорилгоор худалдааг хөнгөвчлөх, гаалийн горимыг хөнгөвчлөн дэлхийн үнийн сүлжээ (global value chain)-д оролцох, тээврийн салбарыг хөгжүүлэх боломжтой юм.

Дэлхийн ихэнхи улс орнуудын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын үндсэн арга хэрэгсэл бол тарифын бус зохицуулалтыг хэлбэр төрлөөс нь хамааруулан ашиглаж ирсэн. Жишээлбэл, квот, лиценз, татаас, хориг арга хэмжээ, эрүүл ахуйн хорио цээрийн шаардлага, техникийн зохицуулалт, төр, засгийн газрын худалдан авалт, дотоод зах зээлээ хамгаалах арга хэмжээ, шударга бус өрсөлдөөний эсрэг зохицуулалт зэрэг олон арга хэрэгсэлүүдийг нэрлэж болно.

Тарифын бус арга хэмжээ нь Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжлийг хангах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлээс хэт хараат байдлыг багасгах, хүн, амьтан, ургамлын эрүүл ахуйн аюулгүй байдлын баталгааг хангах, импортын бүтээгдэхүүнд тавих стандарт, шаардлага, шалгуурыг өндөрсгөх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно гэж үзэж байна.

Гадаад худалдааны бодлого, зохицуулалтад тарифын бус арга хэмжээг ашиглаж буй олон улсын туршлага, практикийг судалж, түүнд үндэслэн Монгол Улсын тарифын бус зохицуулалтыг боловсронгуй болгох, тарифын бус зохицуулалтаар импортыг хязгаарлах боломжийн талаар бид судлаж үзлээ. Ингэхдээ тарифын бус арга хэмжээний онцлог, хэлбэр, нэр төрөл, олон улсын байгууллагуудаас гаргасан ангилал, дэлхийн улс орнуудад тарифын бус

зохицуулалтыг ашиглаж буй статистик, тоо баримт, хамгийн түгээмэл ашиглагдаж буй тарифын бус арга хэмжээ, тарифын бус зохицуулалтад хамгийн их өртөж буй барааны нэр төрлийн талаар судаллаа. Мөн манай улсын худалдааны гол түнш орнууд болох БНХАУ, ОХУ-ын хэрэгжүүлж буй тарифын бус зохицуулалтын зарим онцлогийн талаар авч үзлээ.

Тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх 3 тулгуур нөхцөлийг тодорхойлж, тэрхүү нөхцөл байдал манай улсад бүрдсэн эсэхэд дүгнэлт хийж, цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохих талаар санал, зөвлөмж боловсрууллаа.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 14.2 заалтын дагуу БНСУ-ыг гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тусгайлан баримталж буй билээ. Тус улстай 1990 онд дипломат харилцаа тогтоосноос хойших 30 жилийн хугацаанд худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээний хувьд эхний тавд багтах гол түнш орон болж хөгжжээ. Энэ утгаараа манай улсын хамгийн ойр дотны хөрш яах аргагүй мөн.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ.....	52
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	54
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	56

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ, ЖУРМЫН ХҮРЭЭНД МОНГОЛ УЛСЫН АВСАН АМЛАЛТ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.1. Дэлхийн худалдааны байгууллагын худалдааны олон талт тогтолцоо ба Монгол Улсын гадаад худалдааны бодлого зохицуулалт.....	58
1.2. НҮБ болон бусад байгууллагын хүрээнд тогтоосон олон улсын худалдааны эрх зүйн орчин.....	64
1.3. Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчин.....	67
1.3.1. Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжилтийн байдал.....	69
1.4. ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийн хүрээнд гишүүн орнуудад олгож буй боломжууд.....	72
1.5. ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд тарифын бус зохицуулалтын байдал.....	77

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙ ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Дотоодын зах зээлийг импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт..	85
2.2. Барааны гарал үүслийн орноос хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт.....	95
2.3. Дэлхийн худалдааны байгууллага ба гаалийн тариф.....	98
2.4. Чөлөөт худалдааны хэлэлцээр ба гаалийн тариф.....	101
2.5. Барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт.....	105
2.6. Эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт.....	110

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ИМПОРТЫН БАРААНД ҮЗҮҮЛЭХ ТАРИФЫН БУС ХОРИГ СААДУУД

3.1. Тарифын бус зохицуулалтын онцлог, өнөөгийн нөхцөл байдал, олон улсын туршлага.....	120
3.1.1. Тарифын бус зохицуулалт, түүний хамрах хүрээ, ангилал.....	121

3.1.2. Дэлхий дахинд тарифын бус зохицуулалтыг ашиглаж буй байдал...	124
3.1.3. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлж буй зарим орны туршлага	130
3.1.4. Тарифын бус зохицуулалтын онцлог, ашиглалтад нөлөөлөх хүчин зүйл, олон улсын байгууллагуудын баримталж буй зарчим.....	135
3.2. Импортыг тарифын бус арга хэмжээгээр зохицуулах нь.....	139
3.2.1.Тарифын бус зохицуулалтын талаар баримтлах бодлого, зохицуулалт.....	143
3.2.2. Чанарын дэд бүтэц.....	154
3.2.3. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоо.....	156

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

4.1. Европын холбооноос үзүүлж байгаа GSP+ системийн онцлог.....	165
4.2. Монгол Улс Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системд хамрагдсан байдал, ирээдүйн боломж.....	169

ТАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС, БНХАУ, ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

5.1. Монгол Улсын гадаад худалдааны бодлогыг хөрш орнуудтай харьцуулсан байдал.....	180
5.1.1. Монгол Улсын гадаад худалдааны бодлогын өнөөгийн байдал.....	180
5.1.2. Гадаад худалдаатай холбоотой үйл ажиллагааны гүйцэтгэл.....	188
5.2. ОХУ-ын гадаад худалдааны бодлого, хоёр улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа.....	193
5.3. БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, хоёр улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа.....	198
5.3.1. Монгол Улс, БНХАУ-ын гадаад худалдаа, хамтын ажиллагаа.....	202
5.4. Гурван улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдааны бодлого, чиглэлийг уялдуулах боломж.....	205

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

6.1. Бүгд Найрамдах Солонгос улсын гадаад худалдааны үндсэн хүчин зүйлс.....	218
6.2. БНСУ-ын гадаад худалдааны бодлого.....	226
6.3. БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээр хийх болсон шалтгаан.....	229
6.4. БНСУ-ын гадаад худалдааны төлөв.....	232
6.5. БНСУ-ын худалдааны зохицуулалт.....	239
6.6. БНСУ-ын худалдааг дэмжих бодлого.....	244
6.7. БНСУ-ын худалдаа дахь техникийн зарим саад тотгор.....	251

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО**

Монгол Улсад гадаад худалдааны тухай хуулийг батлаж хэрэгжүүлэхийн ач холбогдол.....	255
НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	260
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	261
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ.....	264
ХАВСРАЛТ.....	268

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ:

НҮБ – Нэгдсэн Үндэсний Байгууллага
ДХБ – Дэлхийн худалдааны байгууллага
ДГБ – Дэлхийн гаалийн байгууллага
ЕХ – Европын Холбоо
ЕАЭЗХ – Евразийн эдийн засгийн холбоо
ДБ – Дэлхийн Банк
АХБ – Азийн хөгжлийн банк
АНДЭЗНК – Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс
ДООБ – Дэлхийн оюуны өмчийн байгууллага
ДЭМБ – Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ОУХБ – Олон улсын хөдөлмөрийн байгууллага
НҮБ-ын ХХБХ – Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа хөгжлийн бага хурал
ТХЕХ – Тариф, Худалдааны Ерөнхий хэлэлцээр (ГАТТ)
ХХААБ – НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ДҮС – Дэлхийн үнийн сүлжээ
ЮНЕСКО – НҮБ-ын Соёл, шинжлэх ухаан, боловсролын байгууллага
ЭЗХАХБ – Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
АСЕАН – Зүүн өмнөд азийн орнуудын холбоо
АНУ – Америкийн Нэгдсэн Улс
ОХУ – Оросын холбооны улс
ЗХУ – Зөвлөлт Холбоот Улс
БНСУ – Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ – Бүгд найрамдах Хятад Ард улс
АНЭУ – Арабын Нэгдсэн Эмират улс
УИХ – Улсын Их Хурал
ГХЯ – Гадаад Хэргийн яам
ЗТХЯ – Зам тээврийн хөгжлийн яам
ШУА – Шинжлэх ухааны академи
ҮАБЗ – Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл
ХХААХҮЯ – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ГЕГ – Гаалийн Ерөнхий Газар
МХЕГ – Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭЕГ – Мал эмнэлгийн ерөнхий газар
ОУХТ – Олон Улсын худалдааны төв
СХЗГ – Стандартчилал хэмжил зүйн газар
МҮХАҮТ – Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
БТКУС – Барааг тодорхойлох, кодлох уялдуулах систем
ЭЗТХ – Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр
НБДНГ – Нарийн бичгийн дарга нарын газар
ЗХА – Зүүн Хойд Ази

ОУБ –Олон улсын байгууллага
ТБАХ –Тарифын бус арга хэмжээ
ХАБҮЛЛ –Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ХТСТ –Худалдаан дахь техникийн саад тотгор (ТВТ)
ШӨХТГ–Шударга Өрсөлдөөн Хэрэглэгчийн Төлөө Газар
ДНБ – Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЧХХ – Чөлөөт Худалдааны хэлэлцээр
ГШХО – Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ХАА – Хөдөө аж ахуй
ЖДҮ–Жижиг дунд үйлдвэр

Amber box – Хайрцагны бодлого
Blue box –Хөх хайрцагны бодлого
Green box –Ногоон хайрцагны бодлого
Development box–Хөгжлийн хайрцагны бодлого
“G20-ын бүлэг– Дэлхийн бодлогыг тодорхойлогч томоохон 20 орны бүлэг
On-line үйлчилгээ – цахим үйлчилгээ
UNICITRAL (United Nations Commission On International Trade Law) – НҮБ-ын олон улсын худалдааны эрх зүйн комисс
ТВТ – (Technical barriers to trade) Худалдаа дахь техникийн саад
SPS – (Sanitary phytosanitary) Эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ
INCOTERMS (International Chamber of Commerce) –Олон улсын худалдааны танхимаас боловсруулсан арилжааны гэрээний нөхцөл
GATS (The General Agreement on Trade in Services) – Үйлчилгээн дэх худалдааны ерөнхий хэлэлцээр
ICAO (International Civil Aviation Organization) –Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага
KIEP (Korea Institute for International Economic Policy) – БНСУ-ын олон улсын эдийн засгийн судалгааны хүрээлэн
KORES (Korea Resources Corporation) -Солонгосын эрдэс баялгийн корпорац
КОТРА (Korean Trade and Investment Agency) –Солонгосын худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ:

- Хүснэгт 1. ДХБ-ын НБДНГ-аас гаргасан Монголын Худалдааны илтгэлд дурдсан анхаарах зарим заалтууд
- Хүснэгт 2. 2020 оны байдлаар Монгол Улсад мөрдөж буй онцгой татварын байдал
- Хүснэгт 3. 2018 оны Монгол Улсын импортын дундаж тарифын хэмжээ
- Хүснэгт 4. 2018 оны Монгол Улсын үүрэг, амлалтын тарифын хуваарилалт, бүтээгдэхүүнээр, хувиар
- Хүснэгт 5. Монгол Улсын авсан орны үүрэг, амлалтыг зарим орныхтой харьцуулсан байдал
- Хүснэгт 6. Стратегийн хүнсний бүтээгдэхүүн
- Хүснэгт 7. Зарим улс орны гаалийн тарифын жагсаалтын бүтэц зохион байгуулалт
- Хүснэгт 8. 2018 оны байдлаар зарим улс орнуудын нэн тааламжтай тарифын харьцуулалт
- Хүснэгт 9. Япон улсын бусад улстай байгуулсан ЭЗТХ-ийн хүрээнд гаалийн тарифыг чөлөөлсөн байдал, хувиар
- Хүснэгт 10. Гаалийн тарифын талаар оруулах санал
- Хүснэгт 11. ЧХХ-ийн хүрээнд гаалийн тарифын жагсаалт гаргах хүснэгтийн загвар
- Хүснэгт 12. Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээрт гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх талаар тусгасан байдал
- Хүснэгт 13. ДХБ-тай тохирсон болон мөрдөж буй какао болон кофений тарифын дундаж хувь
- Хүснэгт 14. Монгол улс болон хөрш орнуудын мөрдөж буй гаалийн тарифын дундаж, хамгийн өндөр тариф
- Хүснэгт 15. Тарифын бус арга хэмжээний ангилал
- Хүснэгт 16. Монгол Улсад ашиглах боломжтой тарифын бус зохицуулалтын ангилал
- Хүснэгт 17. Зарим салбарт мөрдөгдөж буй стандартын тоо
- Хүснэгт 18. Монгол Улсын Европын Холбоотой хийсэн гадаад худалдааны өсөлт, бууралт (2006-2020 он)
- Хүснэгт 19. 2005-2020 оны Монгол Улсын гадаад худалдааны гүйцэтгэл (тэрбум ам.долл.)
- Хүснэгт 20. Монгол Улсаас экспортолсон 2020 оны уул уурхайн бүтээгдэхүүний харьцуулалт (2020 оныг 2019 онтой харьцуулсан байдал)
- Хүснэгт 21. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны статистик, түнш орон, барааны тоогоор (2016-2020 он, тэрбум ам. доллар)
- Хүснэгт 22. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээлэл (2019/2020)

Хүснэгт 23. Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт 2020, гурван улсын харьцуулалт

Хүснэгт 24. Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ-ын эзлэх хувь, (2005-2020 он)

Хүснэгт 25. Монгол Улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх хувь (2005-2019 он)

Хүснэгт 26. ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс, ОХУ, БНХАУ нэгдэн орсон байдал

Хүснэгт 27. 2020 оны байдлаар БНХАУ, ОХУ, Монгол Улсын импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээ

Хүснэгт 28. Монгол Улсын зарим албан татварын хувь хэмжээг хөрш орнуудтай харьцуулсан харьцуулалт, хувиар

Хүснэгт 30. БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээр хийсэн улсууд

Хүснэгт 31. БНСУ-ын импортлохыг хориглосон бүтээгдэхүүнүүд

ЗУРГИЙН ЖАГСААЛТ:

Зураг 1. Олон улсын худалдааны зардлын бүтэц

Зураг 2. 2018 оны барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын түвшин, бус нутгаар, хувиар,

Зураг 3. 2018 оны салбаруудын барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын түвшин

Зураг 4. 2018 оны улс орнуудын экспортод өндөр технологийн бараа эзэлж буй байдал

Зураг 5. Дэлхийн улс орнуудын олон талт (нэн тааламжтай) болон хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн тарифын либералчлал, (салбараар)

Зураг 6. Гаалийн тарифын жигнэсэн дундаж түвшин, салбараар, хувиар

Зураг 7. 2018 оны байдлаар өндөр тарифтай салбарууд

Зураг 8. 2018 оны байдлаар өндөр тариф, салбараар, бүсээр

Зураг 9. Дэлхийн худалдаанд ногдуулж энгийн тарифын дундаж хэмжээ, хувиар

Зураг 10. Дэлхийн худалдааг тарифын бус арга хэмжээгээр зохицуулж буй байдал

Зураг 11. Барааны импортыг тарифын бус арга хэмжээгээр зохицуулж байгаа барааны нэр төрлөөр

Зураг 13. Шинээр хэрэгжүүлэхээр санаачилсан SPS, TBT арга хэмжээ

Зураг 14. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх зураглал

Зураг 15. Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн ерөнхий системийн бүтэц

Зураг 16. Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий системийн гол шаардлага

Зураг 17. Монгол Улсын Европын Холбооны гишүүн орнуудтай хийсэн гадаад худалдаа, сая, ам доллар

Зураг 18. Европын Холбооны Бүртгэгдсэн экспортлогчийн системд хяналт тавих Монгол Улсын эрх бүхий байгууллагын гүйцэтгэх үүрэг

Зураг 19. Бүртгэгдсэн Экспортлогчийн системийн хяналтын үе шат

Зураг 20. Монгол Улсын экспорт, улс орноор, (сая ам доллар)

Зураг 21. 2019-2020 оны Монгол Улсын экспортын барааны бүтцийн харьцуулалт (хувиар)

Зураг 22. 2019-2020 оны Монгол Улсын импортын барааны бүтэц, хувиар

Зураг 23. Дэлхийн банкны "Бизнес эрхэлхүй" дүгнэлт, Монгол, Орос, Хятадын хил дамнасан худалдаа хийх үзүүлэлт"

Зураг 24. 1921-2015 онд Монгол Улс, ОХУ-ын засгийн газар хооронд байгуулсан баримт бичгийн тоо

Зураг 25. БНХАУ-ын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдааны бодлогын систем

Зураг 26. БНХАУ-ын худалдааны хориглолт, хязгаарлалт

Зураг 27. 1955-2015 онд Монгол Улс, Хятадын засгийн газар хооронд байгуулсан баримт бичгийн тоо

Зураг 28. Гадаад худалдааны бодлогод нөлөөлөх хүчин зүйл

- Зураг 29. БНСУ-ын гадаад худалдааны эргэлт, (тэрбум ам доллар)
Зураг 30. 2019 оны БНСУ-ын импорт, (мянган ам доллар)
Зураг 31. 2019 оны БНСУ-ын импорт (мянган ам доллар)
Зураг 32. 2019 оны БНСУ-ын экспорт, (мянган ам доллар)
Зураг 33. 2019 оны БНСУ-ын экспорт, (мянган ам доллар)
Зураг 34. 2019 оны БНСУ-ын үйлчилгээний импорт, (мянган ам доллар)
Зураг 35. 2019 оны БНСУ-ын үйлчилгээний экспорт, үйлчилгээний төрлөөр,
(мянган ам доллар)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ, ЖУРМЫН ХҮРЭЭНД МОНГОЛ УЛСЫН АВСАН АМЛАЛТ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.1. Дэлхийн худалдааны байгууллагын худалдааны олон талт тогтолцоо ба Монгол Улсын гадаад худалдааны бодлого зохицуулалт

Хураангуй: Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ хүлээсэн орны үүрэг, амлалт, хэрэгжилтийн байдал, худалдааны олон талт тогтолцооны хүрээнд гишүүн орнуудад олгодог боломж, давуу талуудыг ашиглах асуудлыг хөндөж байна.

Монгол Улс худалдааны олон талт тогтолцоог бүрдүүлж хянадаг ДХБ-д 1997 онд элссэн боловч өнөөдрийг хүртэл олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй, эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлж дуусаагүй байгаа төдийгүй Худалдааны олон талт тогтолцоогоор гишүүн орнуудад олгодог боломж, давуу талуудыг ашиглаж чадаагүй байна. Тийм ч учраас ДХБ-д 2021 оны 3 дугаар сард Монгол Улсын худалдааны илтгэлийг авч хэлэлцэхэд, гишүүн орнуудын зүгээс Засгийн газарт хандан хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, зарим тодорхой асуудлыг, тухайлбал үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих асуудлыг хариуцах төрийн бүтцийг бий болгох, Худалдааны олон талт тогтолцооны хүрээнд гишүүн улсад олгодог боломж, давуу талуудыг ашиглах талаар бичлээ.

Түлхүүр үгс: Худалдааны олон талт тогтолцоо, хэлэлцээрүүд, ДХБ, Засгийн газрын хүлээсэн орны үүрэг, амлалт, гишүүн улсуудад олгодог боломж, давуу талуудыг ашиглах гэх мэт.

ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хүрээнд олон талт худалдааны эрх зүйн орчныг гишүүн орнуудын сайд нарын бага хурлаас баталсан худалдааны олон талт тохиролцооны хэлбэрээр тогтоодог. ДХБ-ыг байгуулах тухай 1994 оны Марракешийн хэлэлцээрийн 2.1-д “ДХБ нь гишүүн орнуудын хооронд худалдаа хийх нэгдсэн тогтолцоог бий болгоно”, 2.2-т гишүүн орнууд олон талт худалдааны хэлэлцээрүүдийг заавал дагаж мөрдөнө”, 8.1-д “ДХБ үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай эрх мэдлийг гишүүн орон бүр түүнд олгоно”, 9.1-д “ДХБ шийдвэрийг гишүүн орнуудын хамтын тохиролцоогоор гаргана” гэж заасан нь ДХБ-ын гишүүн орнуудын худалдааны эрх зүйн нийтлэг орчинг бүрдүүлдэг. Олон талт худалдааны Уругвайн хэлэлцээрийн дүнд нийт 58 олон талт хэлэлцээр байгуулагдсан. Дохагийн үе шатны хэлэлцээрийн явцад худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, зарим бүтээгдэхүүний худалдааны асуудлаар зарим тохиролцоонд хүрсэн байна.

ДХБ-ын Маргаан шийдвэрлэх байгууллага нь гишүүн орнуудын зүгээс үүргээ заавал биелүүлэх баталгаа болдог. Өөрөөр хэлбэл ДХБ-ын Маргаан шийдвэрлэх байгууллага нь олон талт худалдааны хэлэлцээрүүд, гишүүн

орнуудын үүрэг, амлалтын хэрэгжилтийн явцад үүссэн аливаа маргааныг авч хэлэлцэн шийдвэр гаргах ба шаардлагатай тохиолдолд хүчлэн хэрэгжүүлэх эрхтэй байдгаараа онцлогтой.

ДХБ-ын Худалдааны бодлогыг хянах механизм нь гишүүн орнуудын зүгээс олон талт зохицуулалтын эрх зүйг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж, зөвлөлгөө өгөх бололцоог олгодог. Уг механизм нь олон улсын худалдаанд нөлөө бүхий томоохон орнуудын худалдааны бодлогын илтгэлийг 2 жил тутамд, тэдгээрийн дараа жагсах 17 орны худалдааны илтгэлийг 4 жил тутамд, хөгжиж буй орнуудын худалдааны илтгэлийг 6 жил тутамд хуваарийн дагуу авч хэлэлцэн зөвлөлгөө өгдөг болно. Мөн гишүүн орнууд худалдааны бодлогодоо гарч буй өөрчлөлтийн тухай мэдээллийг тухай бүр бусад гишүүн орнуудад хүргэх арга хэмжээг авахаас гадна худалдааны бодлогын тулгамдаж буй асуудлуудыг цаг тухайд нь авч хэлэлцэн шийдвэрлэж байдаг.

ДХБ-ын хүрээнд явагддаг байнгын олон талт худалдааны хэлэлцээр нь худалдааг либералчлах, түүний нөхцлийг сайжруулах, цаг үеийн шаардлагад нийцээгүй хэлэлцээр, тодорхой үүргийн талаар тухай бүр авч хэлэлцэн шийдвэр гаргах боломжийг олгодог ихээхэн уян хатан механизм болно.

ДХБ нь ГАТТ буюу Тариф, Худалдааны Ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-ын хүрээнд Урагвайн үе шатны олон талт хэлэлцээрийн үр дүнд 1994 онд Марракешт байгуулагдсан олон талт худалдааны эрх зүйн нэгдсэн тогтолцоо болно. ДХБ 164 гишүүнтэй, Нарийн бичгийн дарга нарын газар нь Женевт байрладаг.

ДХБ-ын олон талт худалдааны зохицуулалт нь гишүүн орнуудын худалдааны бодлогын ил тод бөгөөд тогтвортой, урьдчилан харах боломжийг бүрдүүлж, тарифыг аль болохоор бууруулах, худалдааг чөлөөтэй болгосноос урган гарах давуу талуудыг нийтээр ашиглахаас гадна гишүүн орнууд үндэсний эрх ашгаа тэгш эрхтэйгээр хамгаалах бололцоог давхар олгодгоороо давуу талтай.

ДХБ-ын гишүүн орнуудын хоорондын олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь 4 үндсэн зарчимд тулгуурлана¹:

1. *Үндэстний нэн тааламжтай байх зарчим* гэж аливаа нэг гишүүн орноос нөгөө нэг гишүүнд олгосон хөнгөлөлт, давуу талыг бусад гишүүн нь аяндаа эдлэх бололцоог олгохыг хэлнэ.

2. *Худалдаанд ялгаварлан гадуурхахгүй байх зарчим* нь тухайн орны дотоодод үйлчлэх бөгөөд хамтын ажиллагаанд оролцогч орон, компани, барааг өөр хооронд нь гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахыг хориглодог.

Худалдаанд ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь хэсэг бүлэг орны хооронд, эсвэл бүс нутагт байгуулсан гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсийн дотоод зохицуулалтад хамаарахгүй.

¹ Б.Санжмятав, Олон улсын худалдаа, нэг сэдэвт бүтээл, Улаанбаатар, 2015,

3. *Хөгжиж байгаа орнуудад тусгайлан, ялгавартай хандах зарчим* нь ДХБ-ын зүгээс хөгжиж буй орны хөгжлийн шаардлагыг харгалзан үзэж, тэдэнд дэлхийн худалдаа, эдийн засгийн интеграцчилалд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс харилцан адил байхыг шаардахгүй байх нөхцлийг бүрдүүлсэн. Гишүүн орнууд дээрх зарчмыг хэрэгжүүлэн хөгжиж буй орнуудад зориулсан “Худалдааны хөнгөлөлтийн систем”, нэн буурай хөгжилтэй орнуудад хөнгөлөлт үзүүлж байсныг хэвээр хадгалах бололцоог олгоод зогсохгүй, хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад техникийн хамтын ажиллагааны туслалцааг түлхүү авах эрхийг баталгаажуулсан.

4. *Худалдааны бодлогын ил тод байдлыг хангаж, урьдчилан харах бололцоотой байх зарчим* нь бизнесийн эрх зүйн орчин тогтвортой бөгөөд бодлогын өөрчлөлтийг урьдчилан харах боломжтой байх нөхцлийг бүрдүүлсэн. Гишүүн орноос авсан үүргийн тарифын хэмжээ нь тогтвортой, үндэсний хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, худалдааны практикийг ил тод байлгаж, холбогдох мэдээллийг олон нийт, бизнесийн хүрээнийхэнд болон ДХБ-д өгч байх замаар ил тод, нээлттэй байлгах аргаар зохицуулжээ.

ДХБ-ын гишүүн орнууд олон талын хүрээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн худалдааны бодлогыг олон талт худалдааны эрх зүйн орчинд тодорхойлж, түүнийгээ худалдааны бодлогын арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг болно.

Гишүүн орнуудын худалдааны бодлого.

Үндэсний Засгийн газраас боловсруулан хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа нь худалдаанд эерэгээр, эсвэл сөрөг байдлаар нөлөөлөх боломжтой. Олон улсын практикт засгийн газраас явуулах худалдааны бодлогыг

1. Худалданы либераль (чөлөөт) бодлого
2. Худалдааны протекционист (хамгаалах) бодлого гэж хувааж үздэг.

Худалдааны либераль бодлого гэдэг нь төрөөс олон улсын худалдаанд аливаа зохицуулалтыг багасаж чөлөөт худалдааг дэмжих, гаалийн саад тотгорыг арилгах бодлогыг хэлнэ. Энэ утгаар худалдааны либераль бодлогыг хэрэгжүүлэхэд харьцангуй зардал багатай, хэрэглэгчдэд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ харьцангуй хямд үнээр хүрэх, тэргүүний техник, технологийг нэвтрүүлэхэд хялбар байхаас гадна хүнд суртал, хээл хахуулийн бололцоо бага байдаг байна. Харин худалдааны протекционист бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн зохицуулалт их байна. Худалдааны протекционист бодлогыг хэрэгжүүлэхэд үндэсний үйлдвэрлэл, дотоодын зах зээл харьцангуйгаар хамгаалагдах, экспорт, импортын татвараас засгийн газрын орлого нэмэгдэж, ажил эрхлэлт буурахгүй буюу өсөх хандлагатай байдаг. Улс орнууд үндэсний язгуур эрх ашиг, өөрийн онцлог, эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцсэн бодлогыг сонгож хэрэгжүүлдэг.

Худалдааны протекционист бодлогыг өндөр хөгжсөн орнуудад илүүтэй, харин худалдааны либераль бодлогыг эдийн засаг нь гадаад худалдаанаас илүү хамааралтай, ихэвчлэн хөгжиж буй орнууд өргөн хэрэглэж байна. ДХБ-ын хүрээнд гишүүн орнууд татвараас бусад аргаар худалдааг саармагжуулах, саад тотгор учруулах арга хэмжээг хэрэглэхийг зарчмын хувьд хориглосон байдаг. Гэвч одоогийн байдлаар улс орнуудаас протекционист бодлогыг хэрэгжүүлэхдээ импорт, экспортын татвар, тооны хязгаарлалт, лиценз, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ, татаас, саармагжуулах, хамгаалах арга хэмжээг тодорхой түвшинд хэрэглэж байна. Худалдааны бодлогыг боловсруулахад эдийн засгийн үр ашгийн асуудлаас гадна улс төр, интеграцчиллын бодлого, байгаль орчны гэх мэт асуудлууд бас нөлөөтэй байдаг.

Засгийн газраас худалдааны бодлогоо хэрэгжүүлэхдээ а)тариф, б)тарифын бус арга хэмжээ, в)техникийн саад тотгорыг ашиглаж байна²:

Тариф:

➤ Гаалийн тариф буюу экспорт, импортын тариф³

Тарифын бус арга хэмжээ:

- Татаас
- Импорт, экспортын лиценз
- Импорт, экспортын тооны хязгаарлалт⁴,
- Сайн дурын хязгаарлалт⁵
- Бүтээгдэхүүний өртөгт эзлэх дотоодын хүчин зүйлийн хэмжээ, дотоодын худалдан авалтын зохицуулалт⁶
- Мөнгө солилт, санхүүгийн шаардлага⁷
- Демпингийн эсрэг татвар
- Хамгаалалтын арга хэмжээний татвар⁸
- Саармагжуулах арга хэмжээий татвар
- Хил дээр авах урьдчилсан татвар⁹

²Б.Санжмятав, Олон улсын худалдаа, нэг сэдэвт бүтээл, Улаанбаатар, 2020.

³ДХБ-ын хүрээнд гишүүн орнуудын импортын хувьд тарифын хэмжээг тогтоож, зохицуулж байдаг боловч экспортын хувьд үндсэндээ зохицуулалт хэрэглэдэггүй онцлогтой.

⁴Тоо ширхэгээр буюу үнийн дүнгээр, хугацааны тодорхой хэмжээгээр хязгаарлаж болно.

⁵Томоохон орнуудын зүгээс ихэнх тохиолдолд хөгжиж буй орнуудтай тохиролцсон хязгаарлалтын арга хэмжээ. Энэ арга хэмжээний хязгаарлалтыг экспортлогч орон өөрөө тогтоож, хэрэгжилтэд өөрөө хяналт тавьдаг.

⁶Ихэнх тохиолдолд ГШХО-тай компанийн бүтээгдэхүүний өртөгт дотоодын хүчин зүйлүүдийн доод хэмжээг тогтоосон хувь хэмжээ буюу худалдан авалтад дотоодын бүтээгдэхүүний доод хэмжээг тогтоосон шаардлага

⁷Засгийн газрын зүгээс зөвхөн үндэсний валютаар гүйлгээ хийх, хөрөнгийг төвлөрүүлэх зэрэг салбарт тавьдаг шаардлагууд

⁸Гадаадын орны засгийн газрын дэмжлэгтэй бүтээгдэхүүн импортлогч орны зах зээлд хохирол учруулахаар бол тухайн орон хамгаалалтын арга хэмжээ авч, хамгаалалтын татварыг тогтоодог

⁹Тухайн орны хуулиар тогтоосон бол хил дээр импортын барааны НӨАТ-ыг авч болно.

- Эрүүл ахуй, эрүүл мэндийн арга хэмжээний шаардлага
- Импортын бараанд борлуулалтын дээд ба доод үнийг зааж өгөх
- Худалдааны хөнгөлөлт гэх мэт.

Техникийн саад тогтоор:

- Техникийн болон стандартын шаардлага тавих
- ГШХО-тай компанид үндэсний норм, стандартыг хэрэглэхийг шаардах
- Өрсөлдөөнийг хязгаарласан дотоодын эрх зүйн орчныг мөрдүүлэх
- Оюуны өмчийг хамгаалах нийтлэг бус шаардлагыг тавих
- Шилжин суурьших, визийн хатуу журам мөрдүүлэх
- Засгийн газрын худалдан авалтад гадаадын компанийг ялгаварлан гадуурхах
- Улсын худалдаанд онцгой эрх олгох, монопол эрхтэй байх
- Гаалийн үнэлгээ, барааг гаалиас авахад хатуу журам тогтоох гэх мэт.

Мөн түүнчлэн далайд гарцгүй байх, авто, төмөр замын хүчин чадал муу, хилийн боомтуудын тоо цөөн, валютын ханш, эрх зүйн орчин тогтворгүй байх нь худалдаанд саад болдог.

ДХБ-аас гишүүн орнуудын Засгийн газрын зүгээс гадаад худалдааг зохицуулахад тарифын бус аргыг аль болохоор хэрэглэхгүй байх, тарифын бус арга хэрэгслийг тарифт шилжүүлэх бодлого баримтлахыг 1994 оны Марракешийн хэлэлцээрт зааж өгсөн болно.

ДХБ нь байнгын ажиллагаатай олон талт хэлэлцээрийн механизм болох бөгөөд олон талт худалдааны тогтолцоог байнга боловсронгуй болгож, тарифыг бууруулах, үйл ажиллагааныхаа хүрээг тэлж, амьдралаас хоцорсон зохицуулалтуудыг шинэчлэж байх үүрэгтэй. Энэ талаар ДХБ-ыг байгуулсан тухай олон талт Марракешийн хэлэлцээрт түүний үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хэлэлцээрийн III зүйлийн 1-д, ДХБ нь Урагвайн үе шатны хэлэлцээрийн дүнд тохиролцсон эрх зүйн тохиролцоонуудыг хэрэгжүүлэх, зохион байгуулах ажлыг хариуцах,
- Хэлэлцээрийн III зүйлийн 2-т ДХБ нь өөрийн эрх мэдлийн чиглэлээр буюу худалдааг либералчлах асуудлаар олон талт хэлэлцээрийг үргэлжлүүлэн явуулах гишүүн орнуудын хэлэлцээр байх,
- Хэлэлцээрийн III зүйлийн 3-т ДХБ нь гишүүн орнуудын хооронд худалдааны асуудлаар гарсан аливаа маргааныг шийдвэрлэх,
- Хэлэлцээрийн III зүйлийн 4-т ДХБ нь гишүүн орнуудын худалдааны бодлогыг байнга хянан хэлэлцэж байх механизм байх гэх мэт.

Ийнхүү ДХБ нь олон талт хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, явцын байдалд хяналт тавих, гишүүн орнуудын хооронд байнгын хэлэлцээр явуулах хүрээ байхаас гадна гишүүн орнуудад зориулан нэлээд тооны сургалт зохион байгуулан, тодорхой асуудлаар судалгаа хийж, үнэлэлт

дүгнэлтээ гарган гишүүн орнуудад танилцуулах, бодлогын асуудлаар бусад ОУБ-тай хамтран ажиллах, байр сууриа зохицуулах үйл ажиллагааг явуулдаг болно.

ДХБ-ын хүрээнд явагдах олон талт худалдааны хэлэлцээр

ДХБ-ын хэлэлцээрийн III зүйлийн 2-т, бараа, үйлчилгээний худалдааг цаашид либералчлах, одоогийн мөрдөгдөж байгаа хэлэлцээрүүдийг сайжруулан өөрчлөх, шинэ салбарт тохиролцоонуудыг бий болгох зорилгоор байнгын олон талт хэлэлцээрийг гишүүн орнуудын хооронд явуулахыг заасан байна.

Олон талт зарим хэлэлцээрт, юуны өмнө ДХБ-ын хүрээнд шинээр орж ирсэн бөгөөд олон талт тохиролцоо нь асуудлыг шийдвэрлэх эхний шатандаа байгаа салбарт, тухайлбал Оюуны өмчийн холбогдолтой худалдааны хэлэлцээрийн XIX зүйлийн 1-д, ХАА-н хэлэлцээрийн 20 дугаар зүйлд тэдгээрийг бүхлээр нь буюу хэсэгчлэн авч үзэж хүрээг нь өргөжүүлэн боловсронгуй болгох, эсвэл амьдралаас дэвшигдэн гарч ирсэн асуудлуудын зохицуулалтыг үйлчилж байгаа хэлэлцээрүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлэлцээрийг явуулах талаар тусгасан байна. Ийм хэлэлцээрийн нөхцөл байдлыг дагаж байнга өөрчлөгдөж байх ёстой тул тодорхой хугацааны дараа тэдгээрийг бүхлээр нь буюу хэсэгчлэн эргэн хянаж үзэх, өөрчлөлт оруулах ёстой байдаг. Энэ чиглэлээр тодорхой хугацаанд гишүүн орнуудын хооронд хийгдэж байгаа хэлэлцэлийг “Хэлэлцээрийг хянан үзэх хэлэлцээр” гэж нэрлэдэг байна.

Хоёр жил тутам болдог ДХБ-ын гишүүн орнуудын Сайд нарын бага хурлаас ДХБ-ын хүрээнд явагдаж байгаа шинэ үе шатны олон талт хэлэлцээрт зарим асуудлыг нэмж оруулах, шинэ тохиролцоог байгуулах шийдвэрийг гаргадаг. Тухайлбал Сайд нарын бага хурлаас “Худалдаа ба Хүрээлэн буй орчны асуудал”, “Худалдаа ба Хөрөнгө оруулалт”, “Худалдаа ба Өрсөлдөөн”, “Солилцоог хөнгөвчлөх”, “Улсын худалдан авалтын ил тод байдал”, “Электрон худалдаа” зэрэг асуудлыг ДХБ-ын хүрээнд худалдааны олон талт болон Дохагийн хэлэлцээрээр шийдвэрлэжээ.

Худалдааны олон талт Дохагийн хэлэлцээр

Гишүүн орнууд ДХБ бэхжихийн хирээр олон улсын худалдааны тогтолцоо, түүний эрх зүйн нэгдсэн орчны хамрах хүрээг тэлэх, түүнийг илүү боловсронгуй бөгөөд өнөөгийн шаардлагад нийцсэн болгохын тулд 2001 онд худалдааны олон талт Доха үе шатны хэлэлцээрийг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. ДХБ-ын гишүүн орнуудын Худалдааны сайд нарын 2001 оны 11 дүгээр сарын 14-нд тусгай Тунхаглал гаргаж, Худалдааны олон талт Доха үе шатны хэлэлцээрийг эхлүүлсэн. Сайд нарын баталсан 52 зүйлт Тунхаглал¹⁰ нь Дохагийн үе шатны хэлэлцээрийг явуулах удирдамж болно.

¹⁰WT/MIN(01)DEC/1, www.wto.org

Дохагийн үе шатны хэлэлцээр нь өмнө байгуулсан худалдааны олон талт хэлэлцээрүүдийн хүрээг тэлэх, сайжруулахаас гадна худалдааны олон талт тогтолцоонд зарим салбарыг шинээр оруулж, эрх зүйн орчныг тогтоох зорилготой.

Дохагийн үе шатны хэлэлцээрийн өөр нэг онцлог бол хөгжиж буй орнуудыг олон улсын худалдааны тогтолцоонд илүү идэвхтэй татан оролцуулж хамруулах, тэдний эрх ашгийг илүү хамгаалах, олон улсын худалдааны тогтолцооны үр өгөөжөөс илүү хүртэх тэдэнд бололцоог олгоход зорьж байгаад оршино. Тийм ч учраас худалдааны олон талт шинэ хэлэлцээрийн хөтөлбөрийг “Дохагийн хөгжлийн хөтөлбөр” гэж нэрлэсэн.

Шийдвэр гаргах дэг жаяг

ДХБ нь ТХЕХ (ГАТТ) 1974-ийн хэлэлцээрийн IX зүйлд зааснаар аливаа шийдвэрийг консенсусаар буюу хамтын тохиролцооны зарчмаар шийддэг ба уг шийдвэрийг гишүүн орнууд заавал хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэдэг байна.

ДХБ-ын хүрээнд хөгжиж буй орнуудад үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт

Хөгжиж буй орнууд нь ДХБ-д ялгавартай бөгөөд тусгайлан хандах зарчмын үндсэн дээр зарим хөнгөлөлт эдэлнэ:

- Хөгжиж буй орнуудын экспортыг дэмжих зорилготой тарифын хөнгөлөлт эдлэх;
- Хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй орнууд нь ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдийг, тухайлбал ХАА-н хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ зарим хөнгөлөлт эдлэх;
- Хөгжиж буй орнууд нь ДХБ-ын хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, техникийн нөхцөл бүрдүүлэх зэрэгт ДХБ, бусад гишүүн орнуудын зүгээс техникийн хамтын ажиллагааны туслалцааг түлхүү авах – зэрэг болно.

1.2. НҮБ болон бусад байгууллагын хүрээнд тогтоосон олон улсын худалдааны эрх зүйн орчин

НҮБ-ын хүрээнд боловсрогдсон олон баримт бичиг, конвенциуд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг нэгтгэн ижилтгэж, гишүүн орнуудын хоорондын харилцааны, түүний дотор олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг тогтоож, нэгдсэн эрх зүйн орчныг бий болгож байдаг.

НҮБ-ын дүрмийн 2 дугаар зүйлд зааснаар, дэлхийн улс орнууд нь газар нутаг, хүн ам, эдийн засгийн хэмжээнээс үл хамааран тэгш эрхтэй, хүн төрөлхтөний хувь заяаг шийдвэрлэхэд адил тэнцүү оролцоотой байх зарчмаар хангагдсан байдаг. НҮБ-аас боловсруулсан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн 1 дүгээр зүйлд зааснаар, ард түмэн өөрийн орны улс төрийн дэглэмийг сонгож, өөрийн гэсэн бодлогыг дотооддоо болон олон улсын хэмжээнд биеэ даан явуулах, байгалийн болон бусад баялгаа өөрсдөө мэдэж зарцуулах эрхийг

баталгаажуулсан бол НҮБ-аас боловсруулсан конвенцид далай, тэнгис сансар огторгуйг хүн төрлөхтний нийтийн өмч болгон зарлаж, тэдгээрийг хамтран ашиглах, далайд чөлөөтэй гарах эрхийг тунхаглажээ. Олон улсын гэрээ, конвенци нь улс орнуудын дотоодын хууль эрх зүйн актуудаас давуу эрхтэй байх нь чухал ач холбогдолтой гэж үздэг.

НҮБ-аас, мөн олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны эрх зүйн орчныг ижилтгэсэн орчныг бүрдүүлэхэд анхаарч, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулах НҮБ-ын олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNICTRAL)-ыг 1966 онд байгуулжээ¹¹. ЮНСИТРАЛ-аас Барааг худалдах, худалдан авах тухай 1980 оны Венийн конвенци, Ачааг усан замаар тээвэрлэх тухай 1978 оны конвенци, Хамбургийн журам, Барааг худалдан авах, худалдаанаас үүсэх маргааны хөөн хэлэлцэх хугацааны тухай 1974 оны Нью Йоркийн зэрэг конвенциудыг боловсруулан батлуулсан байна.

Бараа, үйлчилгээний худалдааны гэрээ хэлцлийн эрх зүйн ерөнхий нөхцөл нь бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенци болдог. Худалдан авах, худалдах олон улсын гэрээний тухай конвенцид дуудлагын худалдаа, үнэт цаас, агаарын болон далайн хөлгийн худалдаа, эрчим хүчний салбарын худалдааны асуудлууд хамрагдаагүй. Мөн түүнчлэн конвенцид тодорхой ажлыг гүйцэтгэж байгаа буюу үйлчилгээ үзүүлж байгаа компанид нийлүүлэх бараа, үйлчилгээний худалдаа хамрагдахгүй.

Конвенци нь олон улсын худалдааны гэрээ, хэлцлийг зохицуулах ижилтгэсэн заалтуудаас бүрдсэн боловч оролцогч талуудад байгуулах гэрээ хэлэлцлийн заалтыг хэлцлийн онцлогт тааруулан өөрсдөө томъёолох өргөн бололцоог олгож, гэрээ хэлцэлд тодорхойлоогүй үлдээсэн зүйлүүдийг конвенцийн зарчим, үзэл санааны дагуу зохицуулахыг зөвшөөрч байдгаараа онцгой уян хатан байдаг. Энэхүү конвенцийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох үүднээс 1985 оны 10 дугаар сард олон улсын тусгай эрхийн Гаагийн бага хурлаар нэмэлт шинэ конвенцийг баталжээ. Энэхүү конвенциор нэг янзаар бүрэн зохицуулагдаагүй асуудалд хэрэглэх эрхийн хэм хэмжээг тодорхойлох, ижилсгэсэн маргааны журмыг боловсруулах, улмаар түүнийг барааг худалдах, худалдан авах олон улсын гэрээний Венийн конвенцийн нэмэлт болгохыг зорьжээ. Уг конвенцид нэгдсэн орнууд конвенцийн заалтыг хэрэглэх үүрэгтэй болсон.

Гаагийн шинэ конвенцид хэлцлээр зохицуулагдаагүй асуудлыг шийдвэрлэхэд аль орны хуулийг баримтлах чиглэлд зарим тодотгол хийсэн нь ач холбогдолтой болсон байна. Тухайлбал, хэрэв талууд эдлэх эрхээ сонгоогүй бөгөөд гэрээ байгуулах үед худалдагч өөрийн худалдааны газартай бол худалдах-худалдан авах уг гэрээг тухайн улсын хуулиар зохицуулна гэж конвенцийн ерөнхий журамд тогтоосон. Худалдан авагчийн оронд талуудын

¹¹Уг тогтоолд “задача комиссии состоит в том, чтобы содействовать прогрессивному согласованию и унификации правил международной торговли” гэж заасан. 1966.12.17-ны ЕА-н тогтоол

оролцоотой хэлэлцээр явагдаж гэрээ байгуулсан, худалдагч нь худалдан авагчийн оронд зориулж бараа нийлүүлэх, худалдан авагчаас худалдааны тендер зарласан үед гэрээ байгуулсан тохиолдолд худалдан авагчийн орны хуулийг хэрэглэхээр заасан байдаг. Энэ мэтчилэн Гаагийн конвенцийн эрх зүйн зохицуулалтыг урьд өмнө нь шийдлээ олоогүй байсан дараах тохиолдолд хэрэглэхийг зөвлөжээ. Үүнд:

- Аль орны хуулийг хэрэглэх;
- Талуудын эрх ба үүргийг хэрэгжүүлж эхлэх;
- Худалдан авагч барааны ашиг, орлого олох эрхийг тодорхойлох;
- Худалдан авагч бараатай холбогдсон эрсдэл хүлээх үеийг тодорхойлох;
- Өмчлөх эрхийг хадгалах эрх зүйг тодорхойлох;
- Гэрээний үүргийг биелүүлээгүйгээс гарах уршиг;
- Төлбөр барагдуулах арга;
- Гэрээний хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох гэх мэт.

ЮНЕСКО, ICAO¹², ДОӨБ, ДЭМБ, ОУХБ, ХХААБ зэрэг байгууллагын хүрээнд олон ижилтгэсэн хэлэлцээрүүд боловсрогдож, батлагдсан.

Сүүлийн үед дэлхийн бодлогод нөлөө бүхий бүлэглэлийн зүгээс ч олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах болов. Тухайлбал, “G20-ын бүлэг”-ээс Гадаадын хөрөнгө оруулалтын асуудлаар бодлогын зөвлөмж (G20 Guiding Principles for Global Investment Policymaking)-ийг 2017 онд онд боловсруулан баталж гаргасан байна¹³.

Улс орнууд хоёр талын харилцааны хэм хэмжээг тогтоох үүднээс өөр хоорондоо худалдаа, хөрөнгө оруулалт, давхар татвар, эрхийн туслалцааны зэрэг салбарт олон улсын гэрээ хэлэлцээр байгуулан ажилладаг нь олон улсын худалдааны эрх зүйн нэг үндсэн эх сурвалж болдог.

Олон улсын тусгай эрх зүйн хэмжээ

Олон улсын тусгай эрх зүй нь улс хоорондын харилцааг бус, харин бизнесийн тусгай харилцааг буюу өмчийн, хэлцлийн, маргааны зэрэг харилцааг зохицуулдаг тул түүнийг зөрчилдөөний эрх зүй ч гэж нэрлэх нь бий. Олон улсын тусгай эрх зүйн субъект нь төр засаг, хуулийн этгээд, хувь хүн байна.

КОВИД-19 өмнө дэлхийн даяаршиж худалдаа, эдийн засгийн ажиллагаа, хөрөнгө оруулалт ихээхэн нэмэгдэж, аялал жуулчлал хөгжиж, тэдгээрийн харилцан хамаарал нэмэгдэж, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн өсөж байсан бол түүний дараа эдгээр юмс үздэгдэл эсрэгээр эргэж байгаа нөхцөлд олон улсын худалдааг зохицуулах эрх зүйн ач холбогдол өсөхөөр байна. Ингэснээр улс орнуудын гадаад худалдааны эрх зүйн орчныг ойртуулах, ижилсгэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймд юуны өмнө нийтээр

¹²Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага

¹³ WIR 2017, UNCTAD, www.unctad.org

хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ, зан заншилд тулгуурлан ижилтгэсэн эрх зүйн орчныг бий болгох шаардлага гарч байна.

Түүхэн талаас нь авч үзвэл Олон улсын тусгай эрх зүйн Гаагийн бага хурал нь олон улсын худалдааны зан заншил, эрх зүйн нийтлэг зүйлүүд дээр үндэслэн ижилтгэсэн конвенцийн төслүүд боловсруулан батлуулж байжээ. Тухайлбал уг бага хурал Иргэний хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тухай конвенцийг 1954 онд, Гадаадад иргэний болон худалдааны маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдсон материалыг гардуулах тухай конвенцийг 1965 онд, Гадаадаас иргэний болон худалдааны маргаантай холбоотой нотлох баримт авах тухай конвенцийг 1970 онд, Гадаадын албан ёсны баримт бичгийг дахин баталгаажуулахыг шаардахыг зогсоох тухай конвенцийг 1961 онд тус тус батлуулсан нь одоо ч ач холбогдолтой хэвээр байж, мөрдөгдөж байна.

Түүнчлэн 1926 онд үндэслэгдсэн UNIDROIT буюу Унидруа нь олон улсын ачаа болон зорчигч тээвэрлэлт, олон улсын худалдааны гэрээ зэрэг материаллаг асуудлаар нэгдсэн 70 гаруй гэрээний төсөл боловсруулсан буюу батлуулсан. Тэдгээрээс Олон улсын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай 1956 оны Женевийн конвенци, Олон улсын барааны худалдаа-худалдан авахад төлөөлөгчийн эрх, үүргийн талаарх 1983 оны конвенци, Олон улсын санхүүгийн лизингийн тухай Оттавагийн 1988 оны конвенци, Олон улсын худалдааны гэрээний зарчмуудын тухай 1994 оны конвенци, 2004 оны Олон улсын иргэний процессын үндсэн зарчмууд, 2001 оны Хөдлөх хөрөнгийн олон улсын баталгааны тухай конвенци зэргийг дурдаж болох юм.

Олон улсын худалдааны танхимаас 1936 онд эмхэтгэн гаргасан “Олон улсын арилжааны гэрээний нөхцөл” ИНКОТЕРМС одоог хүртэл мөрдөгдөж ирсэн ба ИНКОТЕРМС-2020 ашиглагдаж байна.

1.3. Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчин

Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчин нь 1. ДХБ-ын хүрээнд боловсруулан баталсан Худалдааны олон талт хэлэлцээрүүд, Сайд нарын бага хурлын шийдвэрүүд; 2. Монгол Улсаас бусад орнуудтай байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээр, нэгдэж орсон худалдааны олон талт хэлэлцээрүүд; 3. Монгол Улсын хууль, тогтоомжуудаас бүрдэнэ.

1. Монгол Улс ДХБ-д 1997 онд гишүүнээр хөгжиж буй орны статустай элссэн. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг 2016 оны 11 дүгээр сард соёрхон баталсан, Агаарын хөлгийн худалдааны тухай хэлэлцээрт 2019 онд нэгдсэн.

Монгол Улс нь ДХБ-ын гишүүн болохынхоо хувьд ДХБ-ыг байгуулсан Марракешийн хэлэлцээрийн 2.2-т “Гишүүн орнууд Олон талт худалдааны хэлэлцээрүүдийг заавал дагаж мөрдөнө” гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 2 дугаар

бүлгийн 2-т “дотоодын эрх зүйн баримт бичгийн тодорхой заалт нь олон улсын гэрээний заалттай зөрчилдвөл тэр заалт хүчингүй болно” гэж заасныг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Ийнхүү Монгол Улсын олон улсын худалдааны эрх зүйн орчин нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоос гадна ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүд, Сайд нарын бага хурлаас баталсан олон талт тохиролцоонуудаас бүрдэж байна. ДХБ-ын эрх зүйн орчин Монгол Улсын дотоодод ч үндэсний хууль, тогтоомжийн нэгэн адил үйлчлэх ёстой.

2.Монгол Улс хоёр талын үндсэн дээр байгуулсан ЧХХ, ЭЗТХ болон нэгдэж орсон худалдааны олон талт хэлэлцээрүүдийг УИХ-аар баталсан бол тэдгээрийг дагаж мөрдөх үүрэгтэй. Түүнчлэн Японтой Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2016 оны 6 дугаар сарын 7-нд байгуулж, хоёр орны худалдаанд тусгай дэглэмийг мөрдүүлсэн.

Энэхүү Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс 97 бүлгийн 5700 орчим төрлийн бараа, Япон улс 97 бүлгийн 9300 орчим төрлийн барааны импортын гаалийн тарифын заримыг чөлөөлж, нөгөө хэсгийг нь үе шаттайгаар бууруулахаар болсон билээ. Хэлэлцээрийг хэрэгжүүлэхээр Япон, Монгол хоорондын хамтарсан комисс байгуулж, энэ хүрээнд 13 дэд хороог байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар 1999 онд Вьетнамтай, 2001 онд Кубатай, 2004 онд АНУ-тай Худалдааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын харилцааны тухай, 2013 онд Худалдаа, хөрөнгө оруулалтын салбар дахь ил тод байдлын асуудлаар байгуулсан хэлэлцээр (2017 онд хүчин төгөлдөр болсон) тус тус байгуулсан.

Монгол Улс Австрали, Канад, Евразийн эдийн засгийн холбоо, ЕХ, Япон, Шинэ Зеланд, Норвеги, Турк, АНУ-ын Худалдааны хөнгөлөлтийн тогтолцоонд хамрагдаж, экспортын бүтээгдэхүүний хувьд тарифын хөнгөлөлт эдлэх эрхтэй болсон.

Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, 366 нэр төрлийн барааг багтаасан үндэсний хөнгөлөлтийн жагсаалтаар хэлэлцээрийн оролцогч талуудтай цуврал хэлэлцээр хийж, улмаар нэгдэн орох нөхцлийг 2018 оны 9 дүгээр сард хангасан. Улсын Их хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай” хуулийн төслийг соёрхон баталснаар АНДХХ-ийн 7 дахь гишүүн улс болсон бөгөөд хэлэлцээрийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.

Хэлэлцээрийн хүрээнд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс 366 бүлэг (НК)-ийн бүтээгдэхүүний хувьд, оролцогч бусад орнууд Монголын хувьд татвараа 10000 бараа бүтээгдэхүүний хувьд ойролцоогоор 30 хувиар хорогдуулахаар тохиролцсон.

Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан ажлын хэсгийг

байгуулах саналыг Монголын тал 2016 оноос тавьж ирсэн. Үүний үр дүнд 2020 оны 9 дүгээр сард Евразийн эдийн засгийн комисс Монгол Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгаа хийх саналыг дэмжсэн шийдвэр гаргасан. Түүнээс хойш хамтарсан судалгааны багийн уулзалтыг хоёр удаа зохион байгуулаад байна.

3. Монгол Улс олон улсын худалдааны салбарт ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдээс гадна НҮБ, Дэлхийн гаалийн байгууллага зэрэг ОУБ-ын хүрээнд боловсрогдон батлагдсан олон талт 50 гаруй гэрээ, конвенцид, түүний дотор барааг худалдах, худалдан авах олон улсын гэрээний Венийн конвенци, түүний нэмэлт, Арбитрын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх тухай Нью Йоркийн конвенцид нэгдэн орсон байна (Хавсралт 1-ээс харна уу).

1.3.1. Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжилтийн байдал

Монгол Улс 1997 онд ДХБ-д хөгжиж буй орны статустайгаар элссэн. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээгээр, ДХБ-д хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж ирсэн байна. Тухайлбал, худалдааны эрх зүйн орчныг бий болгох, хариуцах төрийн бүтцийг бий болгох, худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүдийг бизнесийн орчинд сурталчлах, таниулах, хэрэгжүүлэх, мөн худалдааны олон талт тогтолцооны хүрээнд олгодог давуу талууд, боломжийг ашиглах талаар хангалтгүй ажиллаж ирсэн нь илэрхий байна. Энд юуны өмнө УИХ-аас “Монгол Улс ДХБ-д гишүүнээр элсэж байгаатай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 тоот тогтоолоор Засгийн газарт 5 төрлийн үүрэг авсан боловч ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийг орчуулан хэвлэх, яамдын холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулахаас бусад ажил нь үндсэндээ хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Монгол Улсын хууль тогтоомжийг ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрүүдэд нийцүүлэн 1996 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэх,
- ДХБ-ын Олон талт худалдааны хэлэлцээрүүдийг хариуцан хэрэгжүүлэх, тэдгээрт заасан мэдээ, мэдээллийг тогтмол гаргаж байх,
- ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ГХЯ-ны орон тоо, зохион байгуулалтад холбогдох өөрчлөлт оруулах.

Дээрх тогтоолд заасан ёсоор ГХЯ-ны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулан олон улсын худалдааны асуудлыг эрхлэх хангалттай тооны орон тоог бий болгож, бэхжүүлж чадаагүй учраас Монгол Улсын хууль, тогтоомжийг ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдэд нийцүүлэн өөрчлөх, худалдааны мэдээллийн нэг цонхны үйлчилгээг бий болгох, худалдааны олон талт хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, эл тогтолцооны давуу талуудыг ашиглах асуудал хариуцах эзэнгүй үлджээ. Тийм ч учраас ДХБ-д Монголын худалдааны

илтгэлийг 2014, 2021 онд авч хэлэлцэхэд НБДНГ-аас гаргасан илтгэл¹⁴-д тодорхой дурдсан байна. ДХБ-ын НБДНГ-аас гаргасан Монголын Худалдааны илтгэлд дурдсан анхаарах зарим заалтуудыг хүснэгт 1-ээс харна уу.

Хүснэгт 1. ДХБ-ын НБДНГ-аас гаргасан Монголын Худалдааны илтгэлд дурдсан анхаарах зарим заалтууд

2014 оны илтгэлд дурдсан нь	2021 оны илтгэлд дурдсан нь
2.16-д Монгол ямар нэгэн гишүүнтэй худалдааны маргаан үүсгээгүй.	5 ба 2.27-д Монгол Улс ямар нэгэн гишүүнтэй худалдааны маргаан үүсгээгүй.
3.31-д Монгол Улсад демпингийн эсрэг арга хэмжээг хариуцсан байгууллага төрийн албаны бүтцэд нь байхгүй , демпингийн эсрэг арга хэмжээ авч байгаагүй.	14.Монгол Улс демпингийн эсрэг арга хэмжээ, нөхөн тэгшитгэх арга хэмжээ, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай хууль, тогтоомжгүй. Mongolia does not have any legislation concerning anti-dumping, countervailing or safeguard measures.
3.32-д Монгол Улс нөхөн төлбөрийн арга хэмжээ авч байгаагүй.	3.56. Монгол Улс демпингийн эсрэг арга хэмжээ, нөхөн тэгшитгэх арга хэмжээ, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх асуудлыг хариуцан ажиллах бүтцээ байгуулж амжаагүй. Mongolia does not have any legislation on anti-dumping, countervailing or safeguard measures nor has it established any authority to initiate or conduct investigations related to these measures. Thus, it has not imposed any anti-dumping, countervailing, or safeguard measures at this time.
3.33-д Монголын хуулинд хамгаалалтын арга хэмжээ авч болох талаар ямар нэгэн заалт байхгүй, тийм төрлийн арга хэмжээг 2005 оноос хойш авч байгаагүй	

Монгол Улсын зүгээс ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрийн дагуу ДХБ-ын НБДНГ-д гарган өгч байх ёстой мэдээллүүд ч тогтмол биш, бизнесийн хүрээнд олон талт худалдааны эрх зүйн талаар мэдээлэлгүй шахам байна.

Монгол Улс 1997 онд ДХБ-д элсээд хүлээсэн үүргийнхээ дагуу худалдааны олон талт хэлэлцээрүүдийг орчуулан бизнесийн орчинд түгээх, худалдааны мэдээллийн нэг цонхны үйлчилгээг нээх ёстой байсан. Засгийн газраас олон талт хэлэлцээрүүдийг төслийн хүрээнд орчуулан 2000 онд товхимол болгон хэвлэж, төрийн байгууллагуудын холбогдох хүмүүст тараасан,

¹⁴TPRB, TPR of Mongolia, Secretariat Report, September 2014, www.wto.org

хожим нь 2007 онд “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарын VII, VIII боть болгон хэвлэж, www.legalinfo вэб хуудсанд байршуулжээ. Гэвч Монгол Улс ДХБ-д элсэхэд Засгийн газраас хүлээсэн орны амлалт, үүргийг нарийвчлан заасан хамгийн чухал баримт бичиг болох “ДХБ-ын Монголыг тус байгууллагад гишүүнээр элсүүлэх Ажлын хэсгийн илтгэл”¹⁵-ийг өнөөдөр хүртэл албан ёсоор хэвлээгүй байна.

Монгол Улсын Хууль, тогтоомжийн тухай хуулинд зааснаар эрх зүйн баримт бичгүүд нь “Төрийн мэдээлэл” сэтгүүлд албан ёсоор хэвлэгдсний дараагаас дотоодод хэрэгжих эрх зүйн орчин бүрэлдэх ёстой. Ингэж үзвэл, ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүд нь дөнгөж 2007 оноос Монголд хэрэгжих нөхцөл бүрдсэн бол, ДХБ-ын Ажлын хэсгийн илтгэл дотоодод хүчин төгөлдөр болж чадаагүй байна.

Монгол Улсад ДХБ-ын “худалдааны олон талт хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллах зарим бүтэц монголын төрд байхгүй” байгаа нь худалдааны нэгдсэн бодлогогүй, салбар хоорондын ажлын уялдаагүй, олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх Үндсэн хуулийн заалт хэрэгжихгүй явж ирэх нөхцлийг бүрдүүлсэн байна. Мөн дээрх шалтгаанаар Монгол Улс нь худалдааны олон талт тогтолцооны хүрээнд үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, шинээр үүсч бий болсон үйлдвэрлэлийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлаа сайжруулах, төлбөрийн тэнцлийн алдагдлын үед тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх эрх зүйн бололцоог ч ашиглаж чадаагүй болно.

Монгол Улсын Засгийн газраас ДХБ-ын үйл ажиллагаанд оролцох, тэнд өөрийн эрх ашгийг хамгаалах ажил эхнээсээ хангалтгүй явж ирсэн болно. Эл байдал нь Монгол Улс худалдааны асуудлыг хариуцсан төрийн нэгдсэн бүтэцгүй, нэгдсэн удирдлагагүй явж ирсний үр дүн гэж үзэх үндэстэй. Тухайлбал, Монгол Улсаас ДХБ-д яаран элсэх болсон нэг үндэслэл гэвэл, ДХБ-д шийдвэрийг нийтийн тохиролцоогоор гаргадаг тул ОХУ, БНХАУ-аас түрүүлж ДХБ-д элсээд тэдгээрийг тус байгууллагад элсэхэд нь “ихээхэн буулт хийлгэх” явдал байсан болно. Гэвч Монголын төр, засгийн бодлого тогтворгүй байж, худалдааны асуудлыг хариуцсан яамыг татан буулгаж, асуудлыг өөр өөр яамдад хавсарга болгон хариуцуулснаас Монгол Улс нь БНХАУ, ОХУ-ыг ДХБ-д элсэхэд олигтой хэлэлцээр явуулж чадаагүй. ДХБ-ын эрх зүйн орчны хүрээнд импортын болон экспортын тарифыг тогтоох, үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрийг дэмжих боломжийг гишүүн орнуудад олгодог боловч бид ашиглаж чадахгүй байна.

Монгол Улс тарифыг эдийн засгийн зохистой бүтэц, үндэсний үйлдвэрлэлийн болон импортын барааны зохистой харьцааг бий болгох, мөн экспортын тарифыг түүхий эдийн дотоодод боловсруулалтыг гүнзгийрүүлэх,

¹⁵ Ажлын хэсгийн илтгэл нь батлагдмагц ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж, заавал биелүүлэх үүрэг хүлээлгэдэг. Б.Санжмятав.

нэмэгдэл өртөг шингээх хэрэгсэл болгон ашиглаж чадахгүй байгаа. Тарифын бус арга хэрэгслийг ч үр ашигтай ашигладаггүй.

1.4. ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийн хүрээнд гишүүн орнуудад олгож буй боломжууд

ДХБ-ын хүрээнд бий болгосон олон талт худалдааны эрх зүйн орчин нь нэг талаас гишүүн орнуудад хатуу үүрэг хүлээлгэх боловч үндэсний хэмжээнд зах зээлээ хамгаалах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, хөгжиж буй орнуудад нэн тулгамдсан эдийн засгийн аюулгүй байдал, юуны өмнө хүнсний аюулгүй байдлыг хангах, төлбөрийн тэнцлийн хэт алдагдлыг бууруулах зэрэг салбарт ашиглах томоохон боломжийг бий болгосон байдаг. Эдгээр бололцоог ашиглах нь тухайн гишүүн орон, төрийн бүтцийн мэдлэг, дипломат ажиллагаа, авхаалж самбаанаас нэлээнд хэмжээгээр шалтгаалдаг.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас дээрх бололцоог тун бага ашиглаж, олон тохиолдолд үндэсний эдийн засаг, үйлдвэрийн салбарт хохиролтой бодлого баримталж ирсэн. Энэ байдлыг зарим жишээн дээр авч үзвэл:

Тарифын зохицуулалтын байдал

Монгол Улс 1997 онд ДХБ-д элсэхийн тулд 46 оронтой 260 гаруй бүтээгдэхүүний импортын тарифын асуудлаар хоёр талт хэлэлцээрийг явуулсан ба эцсийн байдлаар импортын тарифыг дунджаар 17,5 хувь, түүний дотор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд 18,5 хувь, хөдөө аж ахуйн бус бүтээгдэхүүнд 17,3 хувь байхаар тохиролцож үүрэг, амлалт авсан нь харьцангуй бага хувь хэмжээ болсон юм.

Монгол Улс нийтийн жишгээр зарим бүтээгдэхүүнд онцгой татварыг ногдуулах талаар тохиролцож чадсан байдаг. Тухайлбал, цэвэршүүлсэн спиртэд 85 хувийн, согтууруулах ундаанд 80 хувийн, дарсанд 30 хувийн, тамхинд 100 хүртэлх хувийн, бензинд тн тутамд нь 15300 төгрөгийн, дизелийн түлшинд тн тутамд нь 17180 төгрөгийн тарифыг ногдуулахаар болжээ¹⁶. 2020 оны Монгол Улсад мөрдүүлж буй онцгой татварын хэмжээг хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 2. 2020 оны байдлаар Монгол Улсад мөрдөж буй онцгой татварын байдал¹⁷

Онцгой татвартай бүтээгдэхүүн	Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнд ногдуулах татвар	Импортын бүтээгдэхүүнд ногдуулах татвар
Хэрэглээний спирт: -Үйлдвэрлэгчдэд	1740 төг/литр	1740 төг/литр

¹⁶Монгол Улс ДХБ-д нэгдэн орох асуудлаарх Ажлын хэсгийн илтгэл, www.wto.org WT|ACC|MNG|9, 1996.06.27(96-2472)

¹⁷ TRPR by WTO Secretariat, Mongolia, 2021, p

-Ариутгалын бодис үйлдвэрлэгчдэд	1450 төг/литр	1450 төг/литр
Архи, согтууруулах ундаа: -25 градусаас дээш хатуулагтай -25-40 градустай -40 ба түүнээс дээш	3480 төг/литр 6960 төг/литр 17400 төг/литр	3480 төг/литр 6960 төг/литр 17400 төг/литр
Бүх төрлийн коньяк, виськи, ром, жин: -25 градус хүртэл -25-40 градус -40 ба түүнээс дээш	8700 төг/литр 17400 төг/литр 20880 төг/литр	8700 төг/литр 17400 төг/литр 20880 төг/литр
Дарс: -35 градус хүртэл -35 ба түүнээс дээш	870 төг/литр 7830 төг/литр	870 төг/литр 7830 төг/литр
Шар айраг	3500 төг/литр	3500 төг/литр
Янжуур ба бусад тамхи	4180 төг/ 100 ширхэг	4180 төг/100 ширхэг
Гаансны тамхи	3130 төг/литр	3130 төг/литр
Түлш, шатахуун: бензин -90 хүртэлх октантай -90-ээс дээш	0-15950 төг/тонн 0-17400 төг/тонн	0-215 000 төг/тонн 0-223 000 төг/тонн 0-750 000 төг/тонн 0-217 000 төг/тонн 0-229 000 төг/тонн 0-750 000 төг/тонн
Дизелийн түлш:	0-21750 төг/тонн	0-221 000 төг/тонн 0-226 000 төг/тонн 0-850 000 төг/тонн
Суудлын авто машин: -моторын багтаамж 1500-аас бага см3 0-3 жил 4-6 7-9 10-	-	750 000/375 000 1 600 000/800 000 3 350 000/1 675 000 10 000 000/5 000 000 төг
-Моторын багтаамж 1501-2500 см3 0-3 жил 3-6 7-9 10-	-	2 300 000/1 150 000 3 200 000/1 600 000 5 000 000/2 500 000 11 700 000/5 850 000
-Моторын багтаамж 2501-3500 см3 0-3 3-6		3 050 000/1 525 000 4 000 000/2 000 000

7-9		6 700 000/3 350 000
10-		13 350 000/6 675 000

Монгол Улсын Засгийн газар нь хэрэглэж буй тарифын хэмжээг худалдааны бодлогынхоо хүрээнд дундаж тарифын дээд хэмжээнд хүргэн нэмэгдүүлэх буюу бууруулах эрхтэй. Засгийн газраас ийм шийдвэр гаргавал тухай бүр ДХБ-ын НБДНГ-т мэдэгдэж, үндэслэлээ тайлбарлаж байх боломжтой. Монгол Улсын үүрэг, амлалтын тарифын түвшинг хүснэгт 3;4-өөс харна уу.

Хүснэгт 3. 2018 оны Монгол Улсын импортын дундаж тарифын хэмжээ¹⁸

Үзүүлэлт	Он	Бүгд	ХАА-н бүтээгдэхүүн	ХАА-н бус бүтээгдэхүүн
Тарифын үүрэг амлалтын дээд хэмжээний дундаж	1997	17,5	18,9	17,3
Хэрэглэж байгаа ҮНТТ-ын дундаж	2018	5,2	6,5	5,0
Хэрэглэж байгаа ҮНТТ-ын дундаж	2017	5,0	6,2	4,9
Хэрэглэж байгаа ҮНТТ-ын дундаж	2009	5,0	5,1	5,0
Худалдааны жигнэсэн дундаж	2007	5,1	6,4	4,9
Импорт тэрбум US\$	2007	2,1	0,3	1,9

Хүснэгт 4. 2018 оны Монгол Улсын үүрэг, амлалтын тарифын хуваарилалт, бүтээгдэхүүнээр, хувиар,¹⁹

Бүлэг бүтээгдэхүүн	Үүрэг амлалт авсан тарифын хэмжээ %				Хэрэглэж буй ҮНТТ %			Импорт	
	Дундаж Тариф	Тэг Тариф	Тарифын дээд хэмжээ	Үүрэг амлалтын Хамрах хүрээ	Дундаж тариф	Тэг Тариф	Тарифын дээд хэмжээ	Хамрах Хувь	Тэг тарифын Хамрах Хүрээ
Амьтны гаралтай бүтээгдэхүүн	15,2	5,9	20	100	7,1	5,4	20,0	0,7	4,1
Сүү, сүүн бүтээгдэхүүн	16,3	0	20	100	12,4	0	20,0	0,5	0
Жимс, ногоо	18,7	0	20	100	5,6	0	20	1,4	0
Кофе, цай	19,7	0	20	100	5,0	0	5	1,4	0
Үр тариа, бэлдэц	19,1	0	20	100	6,0	0	15	3,8	0

¹⁸Tariffs, WTO, 2019 www.wto.org

¹⁹Мөн адил

Тос, өөх	19,5	0	20	100	5,0	0	5	0,7	0
Саахар	19,7	0	20	100	5,0	0	5	1,3	0
Ундаа, архи, тамхи	23,8	0	75	100	14,8	0	40,0	2,5	0
Хөвөн	19,0	0	20	100	5,0	0	5	0,0	0
ХАА-н бусад бүтээгдэхүүн	19,6	0	20	100	5,0	0	5	0,3	0
Загас, загасан бүтээгдэхүүн	20,0	0	20	100	5,0	0	5	0,1	0
Эрдэс түүхий эд, метал	19,6	0	20	100	5,1	0	20,0	11,5	0
Нефть	20,0	0	20	100	3,9	21,8	5	18,2	2,1
Химийн бүтээгдэхүүн	5,8	5,4	20	100	5,0	0	7	8,5	0
Мод, цаас	19,4	0	30	100	5,4	0	20	3,2	0
Сүлжмэл	19,7	0	30	100	5,4	0	5	2,0	0
Хувцас	26,0	0	30	100	5,1	0	20,0	0,7	0
Арьсан зүйлс, гутал	19,5	2,5	20	100	4,9	1,7	5	12,9	5,2
Цахилгаан бус машин механизм	19,5	2,5	20	100	4,9	1,7	5	12,9	5,2
Цахилгаан машин	18,8	5,7	20	100	4,7	5,2	5	8,2	4,5
Тээврийн хэрэгсэл	20,0	0	20	100	5,0	0	5	14,3	0
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	20,2	0	30	100	4,7	5,3	5	6,1	6,1

Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ авсан үүрэг, амлалтыг зарим орныхтой харьцуулсан байдлын хүснэгт 5-аас харна уу.

Хүснэгт 5. Монгол Улсын авсан орны үүрэг, амлалтыг зарим орныхтой харьцуулсан байдал

Улс	Тарифын үүрэг, амлалтын хэмжээ			Хэрэглэж буй тариф		
	Дундаж тариф	ХАА-н бүтээгдэхүүн	ХАА-н бус бүтээгдэхүүн	Дундаж тариф	ХАА-н бүтээгдэхүүн	ХАА-н бус бүтээгдэхүүн
Монгол	17,5	18,8	17,3	5,2	6,5	5,0
ОХУ	7,6	11,2	7,1	6,8	11,2	6,1
БНХАУ	10,0	15,7	9,1	9,8	15,6	8,8
Япон	4,7	19,3	2,5	4,4	15,7	2,5
БНСУ	16,5	58,0	9,8	13,7	57,0	6,7
Энэтхэг	50,8	113,1	36,0	17,1	38,8	13,6
ЕХ	5,1	12,8	3,9	5,2	12,0	4,2
Казахстан	6,5	10,0	6,0	6,4	9,6	5,8
Марокко	41,3	54,4	39,3	11,4	27,6	8,8
Вьетнам	11,7	18,8	10,5	9,5	16,5	8,4
Лаос	19,0	19,6	18,9	8,5	11,2	8,1

Кыргыз	7,5	12,8	6,7	6,5	9,1	6,1
--------	-----	------	-----	-----	-----	-----

Эх сурвалж: Дэлхийн Худалдааны байгууллага, www.wto.org

Хүснэгт 5-аас харахад эдийн засаг нь хүнс, хөдөө аж ахуйн салбараас хамааралтай орнууд энэхүү салбараа сайн хамгаалж чадсан байх бөгөөд хэрэглэж байгаа тариф нь үүрэг, амлалтын дээд хэмжээтэй ойролцоо байна. Гэтэл Монгол Улс нь уг хэлэлцээрээр ХАА салбараа сайн хамгаалж чадаагүйгээр барахгүй, одоо хэрэглэж буй тариф нь харьцангуй бага байгаагаас болж хүнсний аюулгүй байдал эрсдэлд ороод байна.

Монгол Улс ХХААБ-ын хүнсний дутагдалд орсон орны жагсаалтад, ДХБ-ын хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортоор авч байгаа орны жагсаалтад тус тус ороод олон жил болж байгаа боловч ХАА-н бүтээгдэхүүний импортод маш бага тариф ногдуулж байгаа нь үндэсний эрх ашигт нийцэхгүй байна.

Гэтэл ДХБ-ын гишүүн орнуудын зүгээс хүнсний асуудалд онцгойлон анхаарч өндөр тариф тогтоож байна. Тухайлбал, **Япон** ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын хүрээнд ХАА-н импортын бүтээгдэхүүнд 19,3 хувийн тарифыг хадгалж үлдсэн бөгөөд 2018 оны байдлаар дунджаар 15,7 хувь, түүний дотор сүү, сүүн бүтээгдэхүүнд 95,1-633 хувь, амьтны гаралтай бүтээгдэхүүнд 13,2-564 хувь, жимс, хүнсний ногоонд 10,5-356 хувь, кофе, цайнд 14,7-149 хувь, үр тариа, түүгээр хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүнд 37,5-723 хувийн тарифыг тус тус ногдуулж байна. Мөн Азийн орон болох **БНСУ** нь ХАА-н бүтээгдэхүүнд дунджаар 58 хувийн татварыг ногдуулах бололцоог хадгалж үлдсэн бөгөөд одоо малын гаралтай бүтээгдэхүүнд 21,5-89 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүнд 66-176 хувь, жимс, хүнсний ногоонд 59,5-887 хувь, кофе, цайнд 514 хувь, үр тариа, түүгээр хийсэн бэлдцүүдэд 187,1-800 хувь, өөх тосонд 40,7-630 хувь, элсэн сахарт 21,5-243 хувь, ундаа, тамхинд 31,4-270 хувийн тарифыг, **Энэтхэгт** ХАА-н бүтээгдэхүүнд дунджаар 38,8 хувийн, түүний дотор малын гаралтай, сүү, сүүн бүтээгдэхүүнд 34,8-60 хувь, жимс, хүнсний ногоонд 32,4-105 хувь, кофе, цайнд 56,5-100 хувь, үр тариа, түүний бэлдцэд 37,1-150 хувь, өөх тосонд 54,1-100 хувийн тарифыг тус тус ногдуулж байгаа болно²⁰.

Эндээс харахад ДХБ-д Монгол Улсыг элсэх хэлэлцээрт оролцсон монголын төлөөлөгчид маш муу ажилласанаас гадна одоогийн засгийн газар ХАА, хүнсний бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, зах зээлээ хамгаалах талаар хангалтгүй ажиллаж байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Монгол Улс хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортоор авч байгаа боловч Монгол Улстай харьцуулсан орнуудын дотроос ХАА, хүнсний бүтээгдэхүүнд бага тарифтай байгаа нь дээрх дүгнэлтийг нотолж байна.

Монгол Улсын хэмжээнд мөрдөж буй импортын 5 хувийн тариф нь үндэсний үйлдвэрийг гадаадын хямд, чанар муутай бүтээгдэхүүнээс хамгаалж

²⁰Tariff, WTO, www.wto.org

чадахгүйгээр барахгүй, түүнийг сүйрүүлэх сөрөг нөлөөтэй байна. Эл шалтгааны улмаас зах зээлийн харилцаанд шилжсэн эхний жилүүдэд үндэсний үйлдвэрлэл үндсэндээ устан үгүй болж, шинээр үйлдвэрүүд баригдаагүй юм. Ялангуяа засгийн газраас 1997-1999 онд тарифыг тэглэсэн шийдвэр нь үндэсний үйлдвэрт ихээхэн хохирол учруулсан.

Экспортын тарифын асуудлаар худалдааны олон талт эрх зүйн зохицуулалт дэлхийн хэмжээнд одоогоор байхгүй боловч улс орнууд экспортын тарифыг дотоодын бараа, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх хөшүүрэг болгон ашигладаг. Гэтэл монголын экспортын бүтээгдэхүүний 90 гаруй хувь нь байгалийн түүхий эд байхад Засгийн газраас экспортын тарифыг шинэчлэн нэмэгдүүлж тогтоох талаар санаачилга гаргахгүй байна.

1.5. ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд тарифын бус зохицуулалтын байдал

Тарифын бус арга хэмжээ нь олон улсын худалдаанд тарифаас илүү нөлөөлөх чадвартай, нуугдмал шинж чанартай байдаг онцлогтой. Энэ утгаар ДХБ-аас тарифын бус арга хэмжээг аль болохоор бууруулах, тарифт шилжүүлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг баримталдаг болно.

Тарифын бус арга хэмжээнд

- тооны хязгаарлалт, хориг;
- экспорт, импортын татаас, дэмжлэг;
- демпингийн эсрэг арга хэмжээ;
- хамгаалалтын арга хэмжээ;
- саармагжуулах арга хэмжээ авах.

техник, стандартын саад учруулах зэрэг арга хэмжээ орох бөгөөд худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүдэд авах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцлийг зааж өгсөн байдаг. Гэвч Засгийн газраас дээрх асуудлыг хариуцах бүтэц, эрх зүйн орчныг бүрэлдүүлж өгөөгүй тул Монголд хэрэгжээгүй болно.

Худалдааны олон талт хэлэлцээрүүдийн хүрээнд зөвшөөрөгдсөн дараах арга хэмжээ авах бололцоо байна. Үүнд:

- ХАА-н тухай хэлэлцээр;
- Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр;
- Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр;
- Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр;
- Төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалтыг харилцан ойлголцлын баримт бичиг гэх мэт.

ХАА-н олон талт хэлэлцээрийн хүрээнд Засгийн газраас дараах зөвшөөрөгдсөн арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- Зах зээлд нэвтрэх;
- Дотоодын дэмжлэг;

- Тариф;
- Экспортын татаас;
- Экспортын хязгаарлалт;
- Олон улсын хүнсний тусламж;
- Green box;
- Blue box;
- Amber box;
- Development box;
- Тарифын хязгаарлалт;
- Тусгай хамгаалах арга хэмжээ;
- 6.2-т заасан Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлэх бололцоотой.

Олон улсын худалдаанд зардлын 10 орчим хувь нь тариф, үлдсэн 90 хувь нь тарифын бус арга хэмжээний зардал байдаг. Эдгээр зардлын задаргааг зураг 1-ээс харна уу.

Зураг 1. Олон улсын худалдааны зардлын бүтэц



Эх сурвалж: UN ESCAP

Зураг 1-ээс харахад олон улсын худалдаанд тарифаас тарифын бус хүчин зүйлүүд нь илүү чухал үүрэгтэй болохыг бэлхнээ харуулж байна. Тийм ч учраас улс орнууд тарифын бус хүчин зүйлүүдийн нөлөөг арилгах зорилгоор бүс нутгийн интеграцийн бүсүүдийг байгуулж, тэдгээр нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн таатай нөхцөл болж байдаг учиртай.

Монгол Улсын хувьд тарифын бус хүчин зүйлийг ашиглан олон улсын худалдаандаа зарим арга хэмжээг авч байдаг болно. Эдгээрийн зарим жишээг дурдахад:

Импортлох буюу экспортлохыг хориглосон. Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 24-ний 86 дугаар тогтоолын дагуу дараах барааг Монгол Улсад импортлох эсвэл Монгол Улсаас экспортлохыг хориглосныг бусад гишүүн орнуудаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Үүнд:

- Наркотикууд болон тэдгээрийг үйлдвэрлэх, хэрэглэх зориулалттай тоноглол (импорт болон экспортыг хориглосон),
- Садар самуун болон хүчирхийллийг сурталчилсан ном, кино, дүрс бичлэг, фото зураг, негатив (импорт, экспортыг хориглосон),
- Олон улсын болон Монголын Улаан номд орсон болон Монголын хуулийн дагуу агнахыг хориглосон амьтад, тэдгээрийн олзвор болон бүтээгдэхүүн (экспортлохыг хориглосон),
- Олон улсын байгууллагууд болон донор орноос зээл, тусламжийн шугамаар хүлээн авсан бараа (экспортыг хориглосон),
- Мал эмнэлгийн гэрчилгээ эсвэл холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй мал, амьтан, шувуу болон тэдгээрийн гаралтай түүхий эд, үр хөврөл, эмброн болон микро организмууд (импорт болон экспортыг хориглосон),
- Түүхий ноолуур (экспортыг хориглосон).

Монгол Улсад импортлох, экспортлохыг хориглосон зүйлээс засгийн газар ДХБ-д элсэхдээ хүлээсэн үүргийн дагуу түүхий ноолуур экспортлохыг хориглосон шийдвэрээ хүчингүй болгосон.

Зөвшөөрөлтэйгээр экспортлох, импортлох бараа, бүтээгдэхүүн. засгийн газрын шийдвэрийн дагуу лицензээр дараах барааг экспортлох буюу импортлоно²¹. Үүнд:

- Түүхийн болон соёлын эд зүйлс, палеонтолог, археологийн олдворууд, хөрсний дээж, ургамал болон амьтад (экспорт болон импорт),
- Үнэт метал, үнэт болон хагас үнэт чулуу (экспорт),
- Зэвсэг, сум, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг
- Тэсрэх бодис (экспорт болон импорт),
- Цусан эвэр, Олон улсын болон Монголын Улаан номонд орсон ургамал (экспорт),
- Радио идэвхит элементүүд, ховор элементүүд, химийн элементүүд (импорт болон импорт),
- Үржлийн мал, ховор амьтад, судалгаа шинжилгээний мал, амьтад, тэдгээрийн гаралтай түүхий эд, эрхтэн,
- Цэвэршүүлсэн спирт болон согтууруулах ундаа (импорт)
- Тамхи
- Түлш шатахуун,

²¹ TRPR by WTO Secretariat, Mongolia, 2021, p-58

- Эмнэлгийн тоног төхөөрөмж, хангамжийн материал
- Ургамал хамгааллын бүтээгдэхүүн,
- Биологийн иэдвхит бүтээгдэхүүн,
- Модны үр,
- Пиротехникийн бүтээгдэхүүн,
- Сэтгэцэд нөлөөлөх эм, бүтээгдэхүүн,
- Стратегийн хүнсний зүйлс,
- Цахилгаан
- Эмнэлгийн зориулалттай хүний эд эс, эрхтэн,
- Түүхийн болон соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах зориулалттай бүтээгдэхүүн,
- Аюултай ургамал, амьтны төрөл, зүйл,
- Аюултай, хортой химийн бодис
- Озоны давхаргад хор, хөнөөл бүхий бүтээгдэхүүн гэх мэт.

Монгол Улсын стратегийн хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг хүснэгт 6-аас харна уу.

Хүснэгт 6. Стратегийн хүнсний бүтээгдэхүүн²²

№	БТКУС-ийн код	Хүнсний нэр төрөл
I. ҮХРИЙН МАХ		
1	0201.10.00	Үхрийн гулууз махан өрөөл, шинэ эсвэл хөргөсөн мах
2	0201.20.10	Үхрийн ястай нь хэсэглэсэн, шинэ эсвэл хөргөсөн мах
3	0201.30.10	Үхрийн ясгүй, шинэ эсвэл хөргөсөн мах
4	0202.10.00	Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах
5	0202.20.10	Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах
6	0201.30.10	Үхрийн ясгүй, хөлдүү мах
II. ХОНИНЫ МАХ		
7	0204.21.00	Хонины гулууз болон өрөөл, шинэ эсвэл хөргөсөн мах
8	0204.22.00	Хонины ястай нь хэсэглэсэн, шинэ эсвэл хөргөсөн мах
9	0204.23.00	Хонины ясгүй, шинэ эсвэл хөргөсөн мах
10	0204.41.00	Хонины гулууз болон өрөөл, хөлдүү мах
11	0204.42.00	Хонины ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах
12	0204.43.00	Хонины ясгүй, хөлдүү мах
III. ЯМААНЫ МАХ		
13	0204.50.00	Ямааны шинэ, хөргөсөн, хөлдүү мах
IV. АДУУНЫ МАХ		
14	0205.00.11	Адууны ястай шинэ, хөргөсөн, хөлдүү мах
15	0205.00.12	Адууны ясгүй (шулсан) шинэ, хөргөсөн, хөлдүү мах
V. САРЛАГИЙН МАХ		
16	0201.20.20	Сарлагийн ястай нь хэсэглэсэн, шинэ эсвэл хөргөсөн мах

²² <http://www.customs.gov.mn/btkus/pdf/strategyfood.pdf>.

17	0201.30.20	Сарлагийн ясгүй, шинэ эсвэл хөргөсөн мах
18	0202.20.20	Сарлагийн ястай хөлдүү мах
19	0202.30.20	Сарлагийн ясгүй хөлдүү мах
VI. ШИНГЭН СҮҮ		
20	0401.10.00	Жингийн 1 %-иас ихгүй хэсэгт тослог агуулсан шингэн сүү
21	0401.20.00	Жингийн 1 %-иас их боловч 6%-иас ихгүй хэсэгт тослог агуулсан шингэн сүү
22	0401.40.00	Жингийн 6 %-иас их боловч 10%-иас ихгүй хэсэгт тослог агуулсан шингэн сүү
23	0401.50.00	Жингийн 10 %-иас их хэсэгт тослог агуулсан шингэн сүү
VII. ХУУРАЙ СҮҮ		
24	0402.21.10	Хуурай сүү
VIII. ХҮНСНИЙ УЛААН БУУДАЙ		
25	1001.19.00	Хүнсний хатуу улаан буудай
26	1001.99.10	Хүнсний зөөлөн улаан буудай
IX. ҮРИЙН УЛААН БУУДАЙ		
27	1001.11.00	Үрийн хатуу улаан буудай
28	1001.91.10	Үрийн зөөлөн улаан буудай
X. УЛААН БУУДАЙН ГУРИЛ		
29	1101.00.11	Дээд
30	1101.00.12	I зэргийн
31	1101.00.13	II зэргийн
32	1101.00.20	Улаан буудай –хөх тарианы гурил
XI. УНДНЫ УС		
33	2201.90.10	Ундны савласан цэвэр ус

Худалдааны бодлогын ил тод байдал

Монгол Улсад худалдаанд хамаарах бүх хууль, зохицуулалт, тогтоолыг шинж чанараас нь үл хамааруулан хэрэгжүүлж эхлэхээс нь өмнө олон нийтэд танилцуулах, танилцах бололцоогоор хангахын тулд хэвлэн нийтлэх ёстой, тийнхүү хэвлэгдэхээс нь өмнө хүчинтэй болох ёсгүй. Энэ утгаар хил, гаалийн бүх дүрэм, журам нийтэд ил тод байх ёстой.

Олон улсын практикт Гаалийн байгууллага нь дотоодын зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлогыг зангидаж, тариф, бусад хамгаалалт, зохицуулалтын асуудлыг санаачлах гол байгууллага байдаг бол Монгол Улсад гаалийн байгууллагыг татвар хураах тогтолцооны хэсэг болгон Сангийн яаманд харьяалуулсан нь сонгодог тогтолцоог буруу ажиллуулах нөхцлийг бүрдүүлсэн.

Монголын гаалийн байгууллага Азийн бусад орон, юуны өмнө хөрш ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагуудтай үйл ажиллагааны нэг стандартад шилжих, гурван орны худалдааг дэмжих талаар гаалийн байгууллагуудын хооронд 2015 онд байгуулсан санамж бичиг, хилийн боомтын салбарт хамтран

ажиллах тухай гурван талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

Монгол Улсад бараа, бүтээгдэхүүний гарал, үүслийн гэрчилгээг МХАҮТ олгож байгааг өөрчилж, төрийн байгууллагаас олгодог болгох ДХБ-аас өгч байгааг зөвлөлгөөг бид биелүүлэхгүй байна.

ДХБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн дагуу хил, гаалийн ажиллагааг нэг цэгийн ба онлайн үйлчилгээний хэлбэрт бүрэн шилжүүлэх шаардлагатай байна.

Хилийн худалдааны чөлөөт бүс

ДХБ-д нэгдэн орсны дараагаар Монгол Улс нь чөлөөт бүсэд хамаарах бүхий л үүргийг ханган биелүүлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улсад Замын Үүд, Алтанбүлаг, Цагаан нуур зэрэг томоохон боомтод худалдааны чөлөөт бүс байгуулах зорилгоор тухайн бүсэд зориулсан тусгай хууль батлаж байсан бол, 2015 онд Чөлөөт бүсийн тухай нэгдсэн нэг хуулийг боловсруулан батлуулсан. Мөн Замын Үүд, Эрээний хил дамнасан чөлөөт худалдааны бүсийг байгуулах талаар тохиролцож, хэлэлцээрт 2019 онд гарын үсэг зурсан.

Алтанбүлаг, Цагаан нуурын худалдааны чөлөөт бүсийн хувьд Монгол Улс чөлөөт худалдааны бүс байгуулах хашаа, зарим байгууламжийг барьсан боловч нөгөө түнш орнуудтайгаа тохиролцсон зүйл байхгүй, удааширсан хэвээр байна.

Монгол Улсад худалдааны чөлөөт бүс байгуулах асуудлыг ард олонд танилцуулж, зөв ойлголт өгөөгүйгээс буруугаар мушгин тайлбарлах нь ч байна. Иймд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар урьдчилан олон нийтэд мэдээлж, ойлгуулж байх шаардлагатай байна. Энэ байдал Орос, Монгол, Хятадын эдийн засгийн коридорын асуудалд ч адилхан хамаатай.

Чөлөөт худалдааны хэлэлцээр

Олон улсын худалдаанд ЧХХ байгуулах нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн таатай нөхцөл болдог. Монгол Улсын Засгийн газар 2016 онд Японтой Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан боловч тэр нь Монголын хувьд үр дүнгүй болсон. Энэ нь олон улсын худалдааны онолоор өндөр хөгжсөн ба ядуу орнууд ЧХХ байгуулбал хөгжиж буй оронд ашиггүй байдаг гэсэн үзэл баримтлалтай, мөн монголын тал хэлэлцээрийг муу явуулсантай холбоотой болно.

Засгийн газар 2020 онд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэж орсон, уг хэлэлцээр Монгол Улсын хувьд 2021 оноос хүчинтэй болно.

Дээрх утгаар одоо Засгийн газраас судлаж буй БНСУ-тай байгуулах ЭЗТХ, БНХАУ-тай байгуулах ЧХХ-ээс Монголын тал томоохон ашиг хүлээхэд бэрхшээлтэй байх юм. Харин Засгийн газраас Евразийн эдийн засгийн холбоотой ЧХХ байгуулбал ашигтай байх боломжтой болохыг доктор

Б.Санжмятав нарын ГХЯ-ны захиалгаар хийсэн судалгаа нотлон харуулсан байдаг.

Дүгнэлт, зөвлөмж

Монгол Улс өнөөгийн нөхцөл байдалд тохирсон өөрийн гэсэн худалдааны бодлогыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх бүтцийг байгуулж, түүний үйл ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох, зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зайлшгүй шаардлага гарч байна. Үүний тулд дараах чиглэлээр ДХБ-тай хамтран ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Монгол Улс ДХБ-д хүлээсэн үүрэг, Олон улсын гэрээний дагуу Худалдааны олон талт хэлэлцээрүүд, авсан үүрэг, амлалтыг орчуулан дотооддоо хэвлэх, мөрдүүлэх үүргийг хүлээсэн. Гэтэл Засгийн газраас дээрх эрх зүйн баримт бичгүүдийг 2000 онд орчуулан товхимол болгон хэвлэж, хязгаарлагдмал хүрээнд тараасан. 2007 онд зөвхөн олон талт хэлэлцээрүүдийн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлж, харин үүрэг, амлалт буюу Ажлын хэсгийн илтгэлийг орхигдуулжээ.

Эндээс Монгол Улс ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүдийг 2007 оноос хэсэгчлэн хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан боловч дотооддоо өнөөг хүртэл эрх зүйн орчныг бүрдүүлж чадаагүй, хариуцсан төрийн бүтэц ч байхгүй байгааг өөрчлөх шаардлагатай болжээ.

2. УИХ-аас “Монгол Улсыг ДХБ-д элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 1996 оны 71 тоот тогтоолын 1-д заасан Монгол Улсын хууль тогтоомжийг ДХБ-ын Олон талт худалдааны хэлэлцээрүүдэд нийцүүлэх, тогтоолын 5-д заасан энэ ажлыг хариуцан ажиллах орон тоог ГХЯ-ны бүтцэд бий болгох үүрэг хэрэгжээгүй үлдснийг залруулах хэрэгтэй байна.
3. Эрх зүйн хувьд заавал биелүүлэх үүрэг хүлээсэн ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүд, Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ хүлээсэн үүрэг, амлалтыг хэрэгжүүлэх асуудлыг Худалдааны хуулиар зохицуулж, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг бий болгох,
4. Худалдааны асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь дараах үндсэн асуудлуудыг хариуцан ажиллах үүрэгтэй байж болох юм. Үүнд:
 1. Тарифын зохицуулалт;
 2. Үндэсний зах зээлээ хамгаалах;
 3. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;
 4. ДХБ-ын худалдааны олон талт зохицуулалтын хүрээнд гишүүдэд олгосон эрх зүйн таатай орчныг ашиглах, тухайлбал

демпингийн эсрэг арга хэмжээ, хамгаалах, саармагжуулах, татаасын арга хэмжээг хэрэглэх;

5. Худалдааны бодлогын ил тод байдлыг бэхжүүлж, гишүүн орнуудаас олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийн асуудлаар гаргах тайланг илүү хариуцлагатай болгох гэх мэт.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙ ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Дотоодын зах зээлийг импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт

Хураангуй: Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж 70 орчим оронтой худалдаа хийж байсны 14 улстай нь худалдааны хэлэлцээртэй буюу нэн тааламжтай нөхцөлийг олгож байсан бол 1997 онд ДХБ-ын гишүүн болсноор уг байгууллагын 160 гаруй гишүүн оронтой энэ нөхцөлөөр худалдаа хийх боломж бүрдсэн билээ. Гэтэл өнөөдөр импортын урсгал эрс нэмэгдэж, түүхий эдийн экспорт хөгжсөнөөр дотоодын үйлдвэрлэл уналтад орсон, уул уурхайн бүтээгдэхүүнээс хэт хамааралтай улс болжээ. Иймд гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг эргэн харах, тэдгээрийг хэрхэн оновчтой хэрэглэх, шинэчлэх зэрэг асуудлыг судлах зайлшгүй шаардлага бий болоод байна. Энэхүү ажлын хүрээнд Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс өнөөг хүртэл импортын гаалийн тарифын шинэчлэлийн бодлогыг хэрхэн явуулсан, дэлхийн улс орнууд барааны гарал үүслийн орон, барааны боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтыг хэрхэн хийж байгаа талаар судалж, дотоодын зах зээлийг импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтаар хэрхэн хамгаалж болох талаар судалсан болно.

Түлхүүр үг: Гаалийн тарифын зохицуулалт, Чөлөөт худалдааны хэлэлцээр, барааны боловсруулалтын түвшингөөс хамаарсан гаалийн тариф, Гаалийн тарифын жигнэсэн дундаж түвшин, Оргил тариф, Мөрдөж буй гаалийн тариф, ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн гаалийн тариф гэх мэт.

Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн шилжилтийг эхлүүлсэн 1990 оноос хойшхи импортын гаалийн тарифын зохицуулалтыг дараах үе шатуудад²³ хувааж болох юм. Үүнд:

1. Шилжилтийн үе (1991 -1996 он)
2. Олон талт зохицуулалтын үе (1997 -2007 он)
3. Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлсэн үе (2008-2014 он)

²³ Н.Отгонсайхан. Пополнение бюджета Монголии на основе тарифного регулирования внешней торговли // диссертация. –с.83

4. Үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжсэн үе (2015 оноос хойш)

Шилжилтийн үе (1991 -1996 он)

ЗХУ болон Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ) задарснаар Монгол Улсын хувьд дэлхийн эдийн засагт эзлэх байр сууриа үндсээр нь өөрчлөх зайлшгүй шаардлага бий болсон. Үүний нэг гол өөрчлөлт нь гааль, тарифын бодлогыг шинээр тодорхойлох шаардлага байсан юм.

Монгол Улсын Засгийн газрын 1990 оны 10 дугаар сарын 19-ний 101 дүгээр тогтоолоор төрөөс гаалийн талаар явуулах бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага болох Гаалийн ерөнхий газрыг Засгийн газрын дэргэд байгуулсан.

Улсын бага хурал 1991 оны 1 дүгээр сарын 28-нд "Гаалийн тухай" Монгол Улсын хуулийг баталж, тус оны 3 сарын 1-ээс мөрдөж эхэлсэн. Улмаар 1991 оны 6 дугаар сарын 21-ний "Гаалийн татварын тухай" Монгол Улсын бага хурлын 45 дугаар тогтоолоор импортын барааны гаалийн тарифыг 15 хувиар тогтоож, шаардлагатай тохиолдолд импортын зарим нэрийн барааг гаалийн татвараас чөлөөлөх эрхийг Засгийн газарт олгосон. Энэхүү тогтоолыг шилжилтийн эхэн үеийн гаалийн тарифын бодлогыг тодорхойлох үндсэн баримт гэж судлаачид үзэж байгаа бөгөөд өнөөгийн Монгол Улсын гаалийн тарифын үндэсний зохицуулалт бий болох үндэс суурь тавигдсан.

Монгол Улс барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн тухай Олон улсын конвенцид 1991 оны 9 дүгээр сарын 17-нд нэгдэн орж, 1993 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь гадаад худалдаанд идэвхитэй оролцох, үндэсний гаалийн тарифын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээр хийх, зарим нэр төрлийн барааг гаалийн татвараас чөлөөлөх анхны алхам болсон.

Ийнхүү 1993 оноос БТКУС-ийн дагуу үндэсний гаалийн тарифын жагсаалтыг боловсруулсан нь тарифыг ялгавартай тогтоох, зарим барааны гаалийн тарифыг бууруулах боломжтой болсон. Тухайлбал, цахилгаан эрчим хүч, эмийн бүтээгдэхүүн - 0 хувь; сургуулийн хүүхдийн дэвтэр, брезент, цагаан даавуу -5 хувь; гутал, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон арьс боловсруулах тоног төхөөрөмж, автобус, троллейбус – 7,5 хувь; цагаан будаа, элсэн чихэр – 10 хувь гэх зэргээр тогтоож үндэсний гаалийн тарифын бодлогыг хэрэгжүүлж байв.

Түүнчлэн Монгол Улс 1991 онд Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-г нэгдэн орох хүсэлт гаргасан нь гаалийн тарифын үндэсний зохицуулалтыг олон улсын дүрэмд нийцүүлэн боловсруулах шаардлага гарсан. Энэ хугацаанд тус хэлэлцээрийн гишүүн 9 оронтой (АНУ, ЕХ, Канад, Япон, Австрали, Швейцар, Мексик) тарифын хэлэлцээр хийж импортын гаалийн тарифын дээд хязгаар 20 хувь, дотоодод үйлдвэрлэх боломжтой мод, модон бүтээгдэхүүн, хивс, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн, савхи, савхин бүтээгдэхүүн зэрэг БТКУС-ийн 23 кодын барааны хувьд 30 хувь, цагаан архи, ликёр, ром, жин

зэрэг согтууруулах ундаанд 35-50 хувь, хувилаагүй этилийн спирт 75 хувь, боловсруулаагүй болон дүнсэн тамхинд 40 хувь, янжуур 30 хувь байхаар тохиролцсон.

Монгол Улсын үндэсний гаалийн тарифын бодлогыг олон улсын жишигт хүргэх зорилгоор “Гаалийн тарифын тухай” хуулийг 1996 оны 5 дугаар сарын 20-нд УИХ-аас баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ээс мөрдсөн. Уг хуулиар гаалийн тарифыг тогтоох, түүнийг хэрэглэх аргыг тодорхой болгож үндэсний гаалийн тарифын тогтолцоог бүрдүүлж өгснөөрөө чухал ач холбогдолтой болсон. *Гаалийн тарифыг Монгол Улсын Их Хурал батлах ба шаардлагатай бол Засгийн газарт эрх олгох замаар гаалийн тарифын хувь, хэмжээг өөрчилж болохоор тусгасан.* Гаалийн тарифын хувь, хэмжээг тогтоох, бууруулах, нэмэгдүүлэх, гаалийн татвараас чөлөөлөхдөө тухайн барааны код, нэр төрлийг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн дагуу заана гэж хуульчилсан.

Энэхүү хууль нь Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед гадаад худалдаанд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх боломж олгосон. Өөрөөр хэлбэл, гаалийн үнийг тогтоох, барааны ангилал, гарал үүслийг тодорхойлоход олон талт зохицуулалтыг нэвтрүүлэх шинэ нөхцлийг бүрдүүлсэн гэж хэлж болно.

Олон талт зохицуулалтын үе (1997 -2007 он)

Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-нд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын 130 дахь (анхдагч) гишүүн болсон нь гаалийн тарифын бодлогыг ДХБ-ын олон талт зохицуулалтын хүрээнд өөрчлөн шинэчлэх үүрэг хүлээсэн. Монгол улс ДХБ-д элссэнээр бусад гишүүн орнуудаас гарал үүсэлтэй бараанд нэн тааламжтай гаалийн тарифын хувь хэмжээ мөрдөх шаардлагатай болсон.

1996 оны “Гаалийн тарифын тухай” хуулийн 4.3-т “Гаалийн тариф нь ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй хувь, хэмжээнээс бүрдэнэ” гээд 4.4-т “Монгол Улсад үндэсний нэн тааламжтай нөхцөл олгодог улсын гарал үүсэлтэй бараанд гаалийн тарифын нэн тааламжтай хувь, хэмжээ хэрэглэж болно” гэж заасан нь энэ шаардлагыг хангаж байсан гэж хэлж болно. Уг хуулийг худалдааны олон талт зохицуулалтын хэм хэмжээнд нийцүүлэх зорилгоор 1998, 1999, 2000, 2001, 2004, 2005 онуудад 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн Монгол улс ДХБ-д элсэхдээ импортын гаалийн тарифын дээд хувь хэмжээг тохиролцож, ДХБ-ын холбогдох хэлэлцээрээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд тарифыг уг хэмжээнээс өсгөхгүй байх үүрэг амлалт авсан. ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээний энгийн дундаж хувь нь нийт барааны хувьд 17,5 хувь байгаа бөгөөд БТКУС-ийн 6 орны түвшинд ангилагдсан нийт барааны 77,7 хувьд нь 15 болон түүнээс дээш хувийн гаалийн тариф ногдуулах үүрэг амлалт авчээ²⁴.

²⁴ https://www.wto.org/english/res_e/booksp_e/tariff_profiles19_e.pdf

Монгол Улсыг ДХБ-д элсэх үед импортын гаалийн тариф 15 хувь байсан ба хүлээсэн үүрэг амлалтын дагуу зарим барааны гаалийн тарифыг үе шатаар бууруулах төдийгүй зарим барааны гаалийн тарифыг өсгөх ч боломж байлаа. Гэтэл ДХБ-ын гишүүн болсноос хойш хэдхэн сарын дараа импортын бүх төрлийн барааны гаалийн тарифын хувь хэмжээг Засгийн газрын шийдвэрээр “тэг” болгосон²⁵. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчдэд хүнд цохилт болж ихэнх үйлдвэрүүд хаалгаа барихад хүргэсэн ба Монгол улс хагас үйлдвэржсэн орноос хэрэглэгч, түүхий эдийн бааз улс болоход түлхэц болсон аж. Ганцхан жишээ хэлэхэд, 1980-аад онд жилд гурван сая хос гутал үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахаас гадна илүүг нь экспортолж байсан бол импортын барааны гаалийн тарифыг тэглэснээр өмнөд хөршийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадамжгүй болж, дотоодын үйлдвэрүүд устжээ. Энэ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, 1996 оны “Гаалийн тарифын тухай” хуулиар гаалийн тарифыг Монгол Улсын Их Хурал батлахаар заасны дагуу 1999 оны 6 дугаар сарын 3-нд “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолын хавсралтаар гаалийн тарифын хувь, хэмжээг УИХ баталсан. Уг тогтоолоор ихэнх барааны импортын гаалийн тарифыг 5 хувь болгосон. БТКУС-ийн 8 орны түвшинд ангилагдсан нийт 5639 барааны зөвхөн 1,3 хувь нь ялгаатай тарифтай (19 бараа 15 хувь, 8 бараа 3 хувь, 48 бараа 0 хувь) байжээ. Энэ нь ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын тарифын дээд хязгаараас 4 дахин доогуур байсан. Уг тогтоолд 2007 оныг хүртэл дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- ✓ 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор импортын гаалийн тарифыг 7 хувь болгож мөрдсөн.
- ✓ 2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор импортын гаалийн тарифын 7 хувийг 5 хувь болгож, 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн.
- ✓ 2002 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор Импортын гурилын (БТКУС-ийн 11.01, 11.02) улирлын ялгавартай тариф мөрдөх хугацаа болох “8 дугаар сарын 1” гэснийг “7 дугаар сарын 1” гэж өөрчлөн 2002 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс дагаж мөрдсөн.

“Гаалийн тарифын тухай” хуулийн 4.2-т “Монгол Улсын хилээр нэвтрүүлэх барааны гаалийн тарифыг Улсын Их Хурал батална” гэж заасан нь мөн хуулийн 4.3-т заасны дагуу “...ердийн, нэн тааламжтай” 2 төрлийн тарифын хувь, хэмжээг аль алиныг нь батлахаар ойлгогдож байна.

Гэсэн хэдий ч “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолоор баталсан тарифын хувь, хэмжээ нь ердийн эсвэл нэн тааламжтай тарифын аль нь болох талаар тодорхой заагаагүй нь энэ хуулийн гол дутагдал болж байсан.

²⁵ “Импортын барааны гаалийн албан татварын тухай” Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол

ДХБ-ын гишүүн орнууд худалдааны бодлогоо тодорхой хугацаанд тогтмол хянуулах үүрэг хүлээдэг бөгөөд Монгол улс энэ үүргийнхээ дагуу 2005 оны 3 сард анх удаа бодлогоо хянуулсан. Монгол Улсын худалдааны нээлттэй бодлого явуулснаар гарсан өөрчлөлтийн үр дүнг сайшаан, өөрчлөлт шинэчлэлтийг цаашид улам эрчимжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогын ил тод байдлыг хангах, зарим бараанд олгож буй экспортын татварыг арилгах, импортын болон дотоодын үйлдвэрийн зарим бараанд ногдуулж буй ялгавартай онцгой албан татварыг тэгшитгэх гэх мэт олон асуудлыг тодотгон зөвлөмж өгсөн.

Монгол Улс ДХБ-д элсэн орсноос хойш 10 жилийн дотор худалдаа дөрөв дахин буюу 919,8 сая ам.доллараас 2007 он гэхэд 4119,3 сая ам.доллар болж өссөн. Худалдааны бүтэц болон чиглэлүүдэд огцом өөрчлөлт гарсан хэдий ч Монгол улс ДХБ-ын гишүүн болсны ялангуяа импортын гаалийн тарифын бодлогын үр нөлөөг хэмжсэн дорвитой судалгаа алга байгаа юм.

Шилжилтийн болон олон талт зохицуулалтын үед гаалийн тарифын улсын төсвийн орлого бүрдүүлэх үүрэг өндөр байсан бол 2008 оноос гаалийн тарифыг дотоодын импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулахад чиглэгдэж эхэлсэн гэж үзэж байна.

Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлсэн үе шат (2008-2014 он)

Энэ үе шатанд хоёр гол онцлог байсан. Үүнд:

- 1. Төрийн бодлогын баримт бичигт гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх замаар үндэсний эдийн засгийг хөгжүүлэх асуудлууд тусгалаа олсон.*

Монгол Улс 2008 онд Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг боловсруулсан. Уг цогц бодлогод “Экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гаалийн тарифын бодлогоор дэмжих”; “Импорт орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжих”; “Өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник, тоног төхөөрөмжийн импортыг гаалийн тарифын бодлогоор дэмжих” гэх зэргээр тусгасан нь гаалийн тарифын зохицуулах үүргийг хангахад чухал баримт бичиг болсон.

Энэхүү цогц бодлогыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2009 онд “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр: 2009-2016”-ийг хавсралтаар баталсан. Хөтөлбөрт үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа тоног төхөөрөмж болон Монгол улсад орлуулах боломжгүй түүхий эд, тухайн түүхий эдээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний гаалийн татварыг тодорхой хугацааны дараа буюу уг тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрсэн үед авах боломж; цөм технологийн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, татварыг дараа тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

2010 оны 7 дугаар сард Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг Улсын Их Хурлаар шинээр баталсан. Уг үзэл баримтлалд “...Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ...” гэж заасан.

2. Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх зорилгоор хууль эрхзүйн актуудад өөрчлөлт оруулсан байдал

Дээрх бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 онд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг шинэчлэн баталсан ба 2012-2014 онд 8 удаа²⁶ нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжихэд гаалийн тарифын зохицуулах үүргийг хэрэгжүүлэхэд чиглэж байсан. Тухайлбал, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт орж, дараах бараа гаалийн татвараас чөлөөлөгдөхөөр болсон. Үүнд:

- ✓ 2012 оны 5 дугаар сарын 22-ны өөрчлөлтөөр инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис.
- ✓ 2014 оны 07 дугаар сарын 01-ны өөрчлөлт:
 - гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилийн хугацаанд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;
 - газрын тос болон уламжлалт бус газрын тостой холбогдсон тайлан материал, дээж болон газрын тос;
 - нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж.

Түүнчлэн УИХ-ын 1999 оны “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолын хавсралтад энэ хугацаанд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 45 дугаар тогтоолоор газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн тариф 0-5 хувь; эрдэс түлш, битумын эрдэс, эрдэс лав, цахилгаан эрчим хүчний гаалийн тариф 5 хувь байхаар өөрчлөлт оруулж мөрдсөн.

²⁶ 2012 онд 4 удаа, 2013 онд 1 удаа, 2014 онд 3 удаа өөрчлөлт оруулсан.

- 2009 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шувууны өндөг 15 хувь; цагаан идээ, зөгийн бал ба бусад газар заагдаагүй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн 5 хувь; төмс 15 хувь байхаар гаалийн тарифын хувь, хэмжээнд өөрчлөлт оруулж мөрдсөн.
- 2011 оны 05 дугаар сарын 16-ны 19 дүгээр тогтоолоор Сонгино, байцаа, шар лууван, шар манжинд 15 хувь, БТКУС-ийн ангилалын 11.01, 11.02 дахь зүйлийн гурилыг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортолсон бол 07 сарын 01-ээс 04 сарын 01 хүртэл 15 хувь, 04 сарын 01-ээс 07 сарын 01 хүртэл 5 хувь, харин бусад боомтоор импортолсон бол 15 хувь байхаар гаалийн тарифын хувь, хэмжээнд өөрчлөлт оруулж мөрдсөн.
- 2012 оны 9 дүгээр сарын 11-ний 27 дугаар тогтоолд заасан хязгаарт багтаан газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг салбарын онцлогийг харгалзан тогтоох эрхийг Засгийн газарт олгосон.
- 2013 оны 05 дугаар сарын 24-ний 40 дүгээр тогтоолоор Бухын үр (HS 0511.10.00), Үржлийн мал, амьтны үр (бухын үр орохгүй), ийлдэс (HS 0511.99.10), Малын хөврөл үр (HS 0511.99.50) гаалийн тарифыг “тэг” болгосон.
- 2013 оны 06 дугаар сарын 07-ий өдрийн 44 дүгээр тогтоолоор 1 жилийн насжилттай нийтийн тээврийн автобус (HS 8702.10.21 & 8702.90.31), троллейбус (HS 8702.90.13)-ны гаалийн тарифыг “тэг” болгосон.

Хэдийгээр энэ үе шатанд гаалийн тарифын зохицуулалтын үүргийг нэмэгдүүлэх зорилготой томоохон бодлогын бичиг баримтууд гарч, гаалийн тарифын тухай хуулийг шинэчлэн найруулсан ч хэрэгжилт төдийлөн сайн байж чадаагүй юм.

2011 онд 17,5 хувиар өсч байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурдац тогтмол саарч²⁷ 2016 оны эхний 3 сарын байдлаар 3,1 хувь болсон. Энэхүү бууралтад экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ унасан, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурсан зэрэг гадаад хүчин зүйлс ихээхэн нөлөөлсөн.

ДНБ-д боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэмүү өртгийн эзлэх хувийн жин 5-6 хувь²⁸ байгаа нь дэлхийн дундаж болон бага орлоготой орнуудын дунджаас даруй 3-4 дахин доогуур байна.

Монгол Улс эдийн засгийн олон тулгуурт, бие даасан, тогтвортой хөгжилд шилжихийн тулд экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, нэмүү өртөг

²⁷ 2012 онд 12,5 хувь, 2013 онд 11,7 хувь.

²⁸ Монгол Улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед үйлдвэрлэл хөгжин боловсруулалтын нэмүү өртөг ДНБ-ий 1/3-г эзэлж байсан.

шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийг төрөөс онцгойлон анхаарч нэгдсэн бодлого зохицуулалт, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага байсан. Энэ хүрээнд тухайн үеийн Аж үйлдвэрийн яамнаас “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийн төслийг боловсруулан 2014 онд УИХ-д оруулж, хэд хэдэн удаа нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үеэс үндэсний үйлдвэрийг төрийн бодлогоор дэмжих үйл явц хүчтэй өрнөж эхэлсэн гэж хэлж болно.

Үйлдвэржилтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, боловсруулах үйлдвэрийн чадавхийг дээшлүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн дотоодын зах зээлийн хэрэгцээг хангах, улмаар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин ажлын байр бий болгох зорилгоор ХАА, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай ажлуудыг төлөвлөсөн.

ДХБ нь гаалийн тарифыг худалдаанд хамгийн бага хохирол учруулах ил тод механизм гэж үзэхийн зэрэгцээ дотоодын үйлдвэрлэлийг гаалийн тарифаар хамгаалах явдлыг гол зорилгоо болгодог. Монгол улс импортын барааны гаалийн тарифын ижилтгэсэн хувь, хэмжээг тогтвортой байдлаар мөрдөж ирсэн бөгөөд гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх зорилгоор ялгавартай тарифыг хэрэглэх саналыг холбогдох яам, агентлагуудаас оруулж эхэлсэн.

Монгол Улс ДХБ-ын Худалдааны бодлогыг хянан хэлэлцэх зөвлөл (ХБХХЗ)-ийн 2014 оны 9 дүгээр сарын 24-26-ий өдрүүдийн хуралдаанаар Монгол Улсын худалдааны бодлогын тухай илтгэлийг 2 дахь удаагаа хэлэлцүүлж, 2005-2014 онд Монгол Улсын гадаад худалдааны бодлогод гарсан өөрчлөлтүүдийг ДХБ-ын гишүүн орнуудын анхааралд сонордуулахын зэрэгцээ худалдаа, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, зорилтыг танилцуулсан билээ.

Үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжсэн үе буюу 2015 оноос хойш үе шат

УИХ-ын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн чуулганаар “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийг баталсан нь үндэсний үйлдвэрлэлийг тарифын бодлогоор дэмжих үйл явц шинэ шатанд гарах боломжийг бүрдүүлсэн. Хуулийн зорилт нь өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн²⁹. Энэ хуультай холбогдон дагалдах бусад хуулиудад чухал өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2015 оны 12 сард өөрчлөлт орж, сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийг гаалийн татвараас чөлөөлөхөөр болсон.

²⁹ Монгол Улсын Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, 2015

Монгол Улс Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) байгуулснаар тус улсаас гарал үүсэлтэй бараанд бусад ийм хэлэлцээргүй орноос давуу нөхцөл олгож “хөнгөлөлттэй тариф”-ыг хэрэглэх ёстой. Иймд “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулж³⁰ энэ асуудлыг шийдвэрлэсэн.

Түүнчлэн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд оруулсан өөрчлөлт нь үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжих, хамгаалах нэг гол зохицуулалт болжээ. Уг өөрчлөлтийн³¹ хүрээнд зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосон нь үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан тарифын бодлогоор дэмжихэд томоохон түлхэц болсон гэж үзэж болох юм.

Дэлхийн улс орнууд өөрийн орны импортын тарифын бодлогыг тодорхойлохдоо үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын хүнсний хэрэгцээг хангах, стратегийн барааны гадаад худалдааны эргэлтэд хяналт тавих үйл ажиллагаатай уялдуулдаг билээ.

Монгол Улс ч энэ чиглэлд ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд Засгийн газар хүнсний зарим бүтээгдэхүүн, ноос, ноолууран болон оёмол бүтээгдэхүүн зэрэг БТКУС-ийн 30 гаруй бүлгийн³² барааны одоо мөрдөж байгаа импортын гаалийн тарифын 5 хувийн түвшинг ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын тарифын дээд хязгаарт хүргэх эрхтэй болсон.

Монгол Улсын Засгийн газар энэ эрхийнхээ дагуу “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулж ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын тарифын дээд хязгаарт хүргээд байна. Үүнд:

- 2015 оны 8 дугаар сард БТКУС-ийн 02, 04, 16, 25, 87 дугаар бүлгийн мах, дайвар мах, зөгийн бал, нөөшилсөн бүтээгдэхүүн, цемент, троллейбусны гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн³³. Тарифын энэхүү бодлого нь эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Тухайлбал, цементийн импорт 46 хувь буюу 82 тэрбум төгрөгөөр буурч, экспорт 1,2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, үхрийн махны импорт 40 хүртэл хувь буюу 84 сая төгрөгөөр буурч, экспорт 65 хувь буюу 2 тэрбум төгрөгөөр

³⁰ “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль”-ийн 4.2.Импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф гэж ангилах бөгөөд ердийн тариф нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. Хөнгөлөлттэй тарифыг олон улсын гэрээгээр тогтооно” гэж /Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

³¹ УИХ-ын 74 дүгээр тогтоолыг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар баталсан.

³² БТКУС 02, 04, 07, 08, 16, 19-21, 22 (22.01, 22.02, 22.09), 25, 26, 35, 39, 40- 44, 48, 49, 51, 56, 57, 61-64, 68-70, 87, 94

³³ 2015.08. 17-ний өдрийн 332 дугаар тогтоол

нэмэгдсэн, зөгийн балны импорт 16 хувь буюу 460 сая төгрөгөөр буурч, экспорт 10 дахин буюу 41 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Зөвхөн цемент, үхрийн мах, зөгийн балд дүн шинжилгээ хийхэд 82,5 тэрбум төгрөгийн гадагшлах урсгалыг зогсоож, 3,2 тэрбум төгрөгийг эдийн засагт оруулсан гэсэн тооцоо байна.

- 2016 оны 3 дугаар сард БТКУС -ийн 14 бүлгийн (04, 07, 21, 39, 44, 49, 51, 56, 61, 63, 64, 68, 69, 94) дотоодод үйлдвэрлэх боломжтой сүү, сүүн бүтээгдэхүүн; хүнсний ногоо; хуванцар болон модон хаалга, цонх; барилгын зарим материал; модон тадилга зэрэг 100 гаруй барааны гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн ба 5 дугаар сарын 1-ээс дагаж мөрдсөн³⁴. Тухайлбал, 39 дүгээр бүлгийн барилгын зориулалттай хаалга, цонхны гаалийн тариф 6,5 хувь бусад бүлгийн барааны хувьд 10-20 хувь болж өссөн. Эдгээр барааны тухайн үед мөрдөж байсан тариф нь ихэнхдээ 5 хувь байсан бол зөвхөн 07 бүлгийн төмс, байцаа, лууван, манжингийн хувьд 15 хувь байжээ.

Түүнчлэн УИХ-ын тогтоолоор “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулж ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын тарифын дээд хязгаарт хүргээд байна. Үүнд:

- 2016 оны 2 дугаар сард импортын архи, дарсны гаалийн тарифыг нэмэгдүүлсэн. Тухайлбал, мөн оны 3 дугаар сарын 1-ээс цагаан архинд 40 хувь, дарсанд 20 хувийн гаалийн татвар ногдуулж эхэлсэн³⁵. Үүний зэрэгцээ Монгол Улс ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улс хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд 2016 оны 2 сард нэмэлт, өөрчлөлт оруулж импортын болон дотоодын үйлдвэрийн архи, дарсанд ногдуулж байсан ялгавартай татварыг ижилтгэсэн³⁶.
- 2017 оны 4 дүгээр сард импортын тамхины гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлэхээр болсон ба 5 дугаар сарын 1-ээс дагаж мөрдсөн³⁷. Тухайлбал, янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхинаас бусад төрлийн тамхины гаалийн тариф 20-30 хувь болсон.
- 2020 оны 5 дугаар сард³⁸ БТКУС-ийн 7 дугаар бүлгийн зарим хүнсний ногооны гаалийн тарифын хувь, хэмжээг 30 хүртэл нэмэгдүүлэхээр болсон ч ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын тарифын дээд хязгаараас давж байгаа тул үндэслэлийг нь нотолж мэдэгдэл хүргүүлээгүй тохиолдолд улаан буудай, шингэн сүү дээр тоо

³⁴ 2016.03. 28-ны өдрийн 185 дугаар тогтоол

³⁵ 2016.02. 04-ний өдрийн 17 дугаар тогтоол

³⁶ Монгол Улсын Онцгой албан татварын тухай хууль, 2006

³⁷ 2017.04.14-ний өдрийн 27 дугаар тогтоол

³⁸ 2020.05.01-ний өдрийн 35 дугаар тогтоол

хэмжээний хязгаарлалт тогтоосноос үүссэнтэй ижил нөхцөл бий болохыг үгүйсгэхгүй юм.

Цаашид гаалийн тарифын бодлогыг хэрэгжүүлэхэд бусад улс орнуудын гаалийн тарифын бодлого зохицуулалтын туршлага чухал бөгөөд дараагийн дэд хэсэгт барааны гарал үүслийн орон, боловсруулалтын түвшин, эдийн засгийн салбараас шалтгаалан гаалийн тарифын бодлогыг хэрхэн хэрэгжүүлж болох талаар авч үзсэн болно.

2.2.Барааны гарал үүслийн орноос хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт

Улс орнууд импортын гаалийн тарифын бодлого боловсруулж, зохицуулалт хийхдээ гаалийн тарифын жагсаалтыг барааны гарал үүслээс хамааруулан олон шатлалтай боловсруулдаг. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, гол төлөв ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тарифын үндсэн шатлалтай байдаг. Монгол улс энэ жишгийн дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4.2-т Импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тарифын шатлалтай бөгөөд дараах тохиолдолд хэрэглэхээр заажээ. Тухайлбал:

Монгол Улсын хуулийн дагуу дор дурдсан гадаад улсаас гарал үүсэлтэй бараанд нэн тааламжтай тариф хэрэглэнэ. Үүнд:

1. Монгол Улсын нэгдэн орсон тариф, худалдааны талаархи олон талт гэрээний гишүүн улс;
2. 1-д зааснаас бусад олон улсын гэрээний дагуу тохиролцсон улс;
3. нэн тааламжтай тариф хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн бусад улс.

Монгол Улсын хуулийн дагуу ердийн тариф нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байх ба гол төлөв дээр заасан нэн тааламжтай тариф хэрэглэх орнуудаас бараа импортолж байгаа ч барааны гарал үүслийг нотолж чадахгүй тохиолдолд ердийн тариф хэрэглэх тохиолдлууд байна. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар Барааны гарал үүслийг нотлох баримт бичиг нь дараахь хэлбэртэй байхаар заасан. Үүнд:

- Барааны гарал үүслийн мэдүүлэг буюу үйлдвэрлэгч, худалдагч, экспортлогчоос барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичиг;
- Барааны гарал үүслийг баталгаажуулсан мэдүүлэг буюу тухайн улсын эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлэг;
- Барааны гарал үүслийн гэрчилгээ буюу барааны гарал үүслийг гэрчилж, тухайн улсын эрх бүхий байгууллагаас тусгай маягтаар баталгаажуулан олгосон гэрчилгээ.

Дээрх баримт бичгээс үзэхэд, худалдаа эрхлэгчид гарал үүслийг нотлох боломж өндөр байгаа ч холбогдох баримт бичгийг бүрдүүлж чадаагүйн улмаас ердийн буюу өндөр татвар төлдөг. Хэрэв барааг гаалийн нутаг дэвсгэрт

оруулахыг гаалийн байгууллага зөвшөөрсөн өдрөөс хойш уг барааны гарал үүслийг нотлох баримт бичгийг 45 хоногийн дотор нөхөн гаргаж өгсөн бол илүү төлсөн татварыг гаалийн байгууллага холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буцаан олгохоор хуульд заасан.

- Хөнгөлөлттэй тарифыг зөвхөн Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Япон улсын гарал үүсэлтэй бараанд хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс буюу 2016 оны 6 дугаар сарын 7-оос хэрэглэж байгаа билээ.

Барааны гарал үүслийн орноос хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтын талаар ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, ЕХ зэрэг орны туршлагыг судалж үзэхэд, гол төлөв ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тарифын шатлал хэрэглэж байгаа бөгөөд хөнгөлөлттэй тарифын шатлалыг гарал үүслийн орноос шалтгаалан ялгаатай тогтоож байгааг хүснэгт 7-оос харна уу.

Хүснэгт 7. Зарим улс орны гаалийн тарифын жагсаалтын бүтэц зохион байгуулалт

Улс	Ердийн	Нэн тааламжтай	Хөнгөлөлттэй	Тайлбар
Монгол	Нэн тааламжтай тарифыг 2 дахин өсгөх	ДХБ-ын гишүүн болон бусад хэлэлцээр	<ul style="list-style-type: none"> ✓ Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ)-ийн хүрээнд ✓ Ази номхон далайн худалдааны хэлэлцээрийн гишүүн орнуудын Монгол Улсын хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бараанд заасан хувиар 	Тарифын жагсаалтыг 1) нэн тааламжтай 2) хөнгөлөлттэй гэж тусад нь гаргасан.
Япон	Бараа бүрээр ялгаатай.	ДХБ-ын гишүүн	<ul style="list-style-type: none"> ✓ Хөнгөлөлтийн ерөнхий систем ХЕС (Generalized system of preferences-GSP) ✓ Нэн буурай орон (LDC) ✓ Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр ЭЗТХ: 18 улс, бүс нутагтай уг хэлэлцээрийг байгуулсан ба хөнгөлөлтийг хэлэлцээрээр ялгаатай тогтоосон. 	Тарифын хувь, хэмжээг харуулсан нэг жагсаалтыг гарал үүслийн орноор нь гаргаж харуулсан. Тарифын хөнгөлөлтийг шууд харьцуулан харах

				боломжтой.
ОХУ	Нэн тааламжтай тарифыг 2 дахин өсгөх	ДХБ-ын гишүүн болон бусад хэлэлцээр	<ul style="list-style-type: none"> ✓ Хөнгөлөлтийн ерөнхий систем ХЕС (Generalized system of preferences-GSP) ✓ Нэн буурай орон (LDC) ✓ Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ-FTA): 3 улстай уг хэлэлцээрийг байгуулсан ба хөнгөлөлтийг хэлэлцээрээр ялгаатай тогтоосон. ✓ Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр БНХАУ-тай байгуулсан ч тарифыг бууруулах асуудлыг авч үзээгүй. ✓ Иран улстай тодорхой нэр төрлийн барааны хувьд тарифын хөнгөлөлт байхаар 3 жилийн хугацаатай хэлэлцээр байгуулсан. 	Нэн тааламжтай тарифын жагсаалтыг гаргаж, ХЕС-ийн дагуу хөнгөлөлт үзүүлэх орны бараанд нэн тааламжтай тарифаас 25 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр заасан. Харин худалдааны хэлэлцээрийн дагуу үзүүлэх тарифын хөнгөлөлтийг хэлэлцээр тус бүрээс харж болно.
БНХАУ	Бараа бүрээр ялгаатай.	ДХБ-ын гишүүн бусад хэлэлцээртэй орон болон хятадын гарал үүсэлтэй бараа	<ul style="list-style-type: none"> ✓ ЧХХ (FTA): 14 улс, бүс нутагтай уг хэлэлцээрийг Макао болон Хонгконгтой тусгай маягаар байгуулсан ба хөнгөлөлтийг хэлэлцээрээр ялгаатай тогтоосон. ✓ Ази номхон далайн худалдааны хэлэлцээр – АНДХХ (Asia Pacific trade agreement-APTA): энэ хэлэлцээрийн гишүүн орнуудад тарифын хөнгөлөлтийг үнлэсний болон тусгай жагсаалтын дагуу эдлүүлж байна. Монгол улс энэ хэлэлцээрийн гишүүн. 	Сүүлийн үед ЧХХ байгуулах тал дээр нилээд идэвхитэй байгаа. Одоогоор 13 улс, бүс нутагтай хэлэлцээр байгуулах яриа хэлцэл хийгдэж, 8 улстай (Монгол улс орж байгаа) хэлэлцээр байгуулах эсэх талаар хамтарсан судалгаа хийгдэж байна.

БНСУ	Бараа бүрээр ялгаатай.	ДХБ-ын гишүүн	✓ ЧХХ (FTA): 15 улс, бүс нутагтай уг хэлэлцээрийг байгуулсан ба хөнгөлөлтийг хэлэлцээрээр ялгаатай тогтоосон.	
ЕХ	Бараа бүрээр ялгаатай.	ДХБ-ын гишүүн	✓ Хөнгөлөлтийн ерөнхий систем ХЕС (Generalized system of preferences-GSP): Ерөнхий; тусгай-GSP+; зэвсгээс бусад (EBA-everything but arms) ✓ ЧХХ-ийн хүрээнд олгох тарифын хөнгөлөлт	ЕХ-ны “GSP+”-ийн дагуу олгох хөнгөлөлтийг эдлэх орны жагсаалтад Монгол улс багтаж байна.

Эх сурвалж: Улс орнуудын гаалийн тарифын жагсаалт

Хүснэгт 7-оос харахад Монгол Улс болон ОХУ ердийн тарифыг тогтоохдоо нэн тааламжтай тарифыг 2 дахин өсгөхөөр заасан бол бусад орнууд гаалийн тарифыг бараа бүрээр ялгаатай тогтоожээ. Нэн тааламжтай тарифыг ДХБ-ын гишүүн орнуудаас гадна ДХБ-ын гишүүн бус хэдий ч нэн тааламжтай тариф хэрэглэхээр хэлэлцээр байгуулсан орнуудаас гарал үүсэлтэй бараанд (улс орнуудын нэн тааламжтай тарифын талаар дэлгэрүүлж хүснэгт 8-аас харна уу), хөнгөлөлттэй тарифыг (дэлгэрүүлж хүснэгт 8-аас харна уу) олон улсын гэрээний дагуу байгуулсан гэрээ хэлэлцээрийн хүрээнд хэрэглэж байна.

2.3. Дэлхийн худалдааны байгууллага ба гаалийн тариф

Дэлхийн улс орнуудын нэн тааламжтай тарифын дундаж хэмжээ ДХБ-ын гишүүн орнуудад буурсаар ирсэн. Тухайлбал, Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн эхний үе шатанд буюу 1947 онд гишүүн орнуудын тариф дундажаар 19 хувь, 1973-1979 онд 34 хувь, 1986-1994 онд 40 хувиар буурсан ба дараах хүснэгтэд 2018 оны байдлаар зарим улс орнуудын нэн тааламжтай тарифыг Монгол Улсын зохицуулалтай харьцуулсан байдлыг хүснэгт 8-аас харна уу.

Хүснэгт 8. 2018 оны байдлаар зарим улс орнуудын нэн тааламжтай тарифын харьцуулалт

№	Улс	Энгийн дундаж тариф*		Татваргүй бараа*, %		15-аас дээш тариф*, %		Ad valorem бус татвар		Хамгийн өндөр тариф*		Number of MFN applied tariff
		Bound	MFN	Bound	MFN	Bound	MFN	Bound	MFN	Bound	MFN	

		Applied	applied	applied	applied	applied	applied	applied	applied	applied	lines	
БҮХ БАРААНЫ ХУВЬД												
1	АНУ	3.4	3.4	46.5	46.3	2.8	2.7	8.2	8.4	350	350	11635
2	Канад	6.5	4.0	40.3	77.4	6.9	6.5	2.9	1.5	555	549	7303
3	ЕХ	5.1	5.2	29.2	28.0	4.3	4.5	4.7	5.0	556	235	9532
4	Япон	4.7	4.4	53	53.0	3.7	3.6	3.5	3.5	723	723	9611
5	БНСУ	16.5	13.7	16.2	15.1	20.2	10.7	0.7	0.5	887	887	12488
6	ОХУ	7.6	6.8	3.4	16.0	1.8	1.9	9.1	9.3	303	303	12049
7	БНХАУ	10.0	9.6	6.4	7.4	16.3	15.1	0	0.3	65	65	11791
8	Энэтхэг	50.8	17.1	2.2	2.0	71.5	33.2	5.0	4.8	300	150	11776
9	Вьетнам	11.7	9.5	13.9	35.4	27.9	24.4	0	0	200	135	10925
10	Монгол	17.5	5.2	1.5	0.9	77.7	0.9	0	0	75	40	5944
ХАА-Н БАРААНЫ ХУВЬД												
1	АНУ	4.9	5.3	30.2	30.6	5.6	5.8	41.3	41.7	350	350	1704
2	Канад	15.0	15.9	48.1	68.5	8.4	9.0	18.6	11.1	555	549	1276
3	ЕХ	12.8	12.0	31.4	31.0	25.5	23.2	31.7	32.9	556	235	2099
4	Япон	19.3	15.7	34.1	35.7	23.0	21.6	15.1	13.2	723	723	1887
5	БНСУ	58.0	57.0	2.2	5.5	75.5	53.1	5.2	3.2	887	887	1741
6	ОХУ	11.2	11.2	3.0	9.8	8.0	8.0	22.9	24.1	303	303	2551
7	БНХАУ	15.7	15.6	5.9	7.2	35.5	35.0	0	0.3	65	65	1486
8	Энэтхэг	113.1	38.8	0	3.1	98.5	94.2	0.3	0.3	300	150	1504
9	Вьетнам	18.8	16.5	8.8	15.0	45.9	41.9	0	0	135	135	1391
10	Монгол	18.8	6.5	0.9	0.8	73.5	4.2	0	0	75	40	899
АЖ ҮЙЛДВЭРИЙН БАРААНЫ ХУВЬД												
1	АНУ	3.2	3.1	49.0	48.8	2.4	2.2	3.2	3.1	56	56	9931
2	Канад	5.1	2.1	39.0	78.8	6.7	6.1	0.3	0	20	25	6027
3	ЕХ	3.9	4.2	28.9	27.5	1.0	1.5	0.6	0.5	26	26	
4	Япон	2.5	2.5	55.9	55.8	0.7	0.7	1.7	1.9	481	357	7724
5	БНСУ	9.8	6.7	18.3	16.6	11.9	3.9	0.1	0	385	504	10747
6	ОХУ	7.1	6.1	3.4	17.0	0.8	0.9	7.0	7.0	138	73	9498
7	БНХАУ	9.1	8.8	6.6	7.2	13.3	11.9	0	0.3	50	50	10305
8	Энэтхэг	36.0	13.6	2.6	1.8	67.0	23.4	5.7	5.5	150	125	10272
9	Вьетнам	10.5	8.4	14.7	38.6	24.8	21.5	0	0	200	100	9534
10	Монгол	17.5	5.0	1.7	0.9	78.4	0.4	0	0	30	20	5045

Эх сурвалж: World Tariff Profiles 2019

Тайлбар:

Bound tariff– ДХБ-тай тохирсон нэн тааламжтай тарифын дээд хэмжээ

MFN applied tariff – Улс орнуудын мөрдөж буй тариф

Ad valorem бус татвар – Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоох татвар

* Ad valorem татвар – Гаалийн үнээс хувиар тогтоох татвар

Улс орнууд ДХБ-д элсэхдээ импортын нэн тааламжтай гаалийн тарифын дээд хувь хэмжээг хэлэлцэгч улс орнуудтай тохиролцож, ДХБ-ын холбогдох хэлэлцээрээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд тарифыг уг тохирсон хэмжээнээс өсгөхгүй байх үүрэг амлалт авдаг. Түүнчлэн хүснэгт 8-аас харахад, улс орнууд нэн тааламжтай тарифыг ДХБ-ын гишүүн орнуудаас гадна ДХБ-ын гишүүн бус хэдий ч нэн тааламжтай тариф хэрэглэхээр хэлэлцээр байгуулсан орнуудаас гарал үүсэлтэй бараанд хэрэглэж байна.

Зарим улс орнуудын нэн тааламжтай тарифын харьцуулалт нь дэлхийн улс орнууд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг маш өндөр тарифаар хамгаалж байгаа бөгөөд дээр сонгогдсон орнуудаас БНСУ-ын хамгийн өндөр буюу 887 хувь, Япон улс 723 хувийн тарифтай байна. Түүнчлэн ихэнх хөгжингүй улс орнуудын одоо мөрдөж буй тарифын түвшин ДХБ-тай тохирсон нэн

тааламжтай тарифын дээд хэмжээтэй бараг ижил байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд энэ 2 тарифын түвшингийн зөрүү нилээд өндөр байна. Тухайлбал, Энэтхэгийн ДХБ-тай тохирсон нэн тааламжтай тарифын дээд хэмжээ нийт барааны хувьд 50,8 хувь, ХАА-н бараанд 113,1 хувь, аж үйлдвэрийн бараанд 36 хувь байгаа бол одоо мөрдөж буй тариф тус тус 17,1 хувь, 38,8 хувь, 13,6 хувь байна.

Харин Монгол Улсын хувьд ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээний энгийн дундаж хувь нь нийт барааны хувьд 17,5 хувь, аж үйлдвэрийн бараа 17,3 хувь, ХАА-н бараанд 18,8 хувь байгаа бол одоо мөрдөж буй тариф тус тус 5,2 хувь, 6,5 хувь, 5,0 хувь байгаа нь бидэнд тарифыг ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээнд хүргэх боломж байгаа гэдгийг харуулж байгаа юм. Түүнчлэн ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд гаалийн тарифыг өсгөх боломжийг хайх хэрэгтэй бөгөөд энэ тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх эрхзүйн актыг боловсруулж батлуулах шаардлагатай юм. Тухайлбал, Хамгаалалтын арга хэмжээний журам, демпингийн эсрэг болон татаасын эсрэг нөхөн тэгшитгэх арга хэмжээ хэрэгжүүлэх, түүнчлэн төлбөрийн балансын алдагдлыг бууруулахтай холбоотой эрхзүйн акт гэх мэт.

Монгол Улс үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжсэн үе буюу 2015 оноос хойш 300 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүний гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон нэн тааламжтай тарифын дээд хэмжээнд хүргэж өсгөх асуудал ихээхэн яригдаж 2018 оныг хүртэл хэрэгжилт сайн байсан. Гэсэн хэдий ч тарифыг ийнхүү нэмэгдүүлснээр дотоодын үйлдвэрлэл болоод эдийн засаг, хэрэглээнд ямар өөрчлөлт гарах талаар судалгаа хийж байж өөрчлөлт хийх нь чухал.

Судлаач Ш.Энхбаяр, Н.Отгонсайхан нарын “Монгол Улсын импортын гаалийн тарифын шинэчлэлийн эдийн засагт үзүүлэх нөлөө: GТAP 8.1 мэдээллийн санд тулгуурласан шинжилгээ”³⁹ бүтээлд “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан суурь тарифын хувь, хэмжээг өөрчлөхөд эдийн засагт үзүүлэх нөлөөллийг GТAP мэдээллийн сангийн 8.1 хувилбар болон GТAP загвар ашиглан дараах 2 хувилбараар тооцоолсон. Үүнд:

А хувилбар: 2015-2016 онуудад зарим барааны импортын гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээнд хүргэж шинэчилснээр гарсан нөлөөлөл;

Б хувилбар: Нийт барааны импортын гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээнд хүргэсэн тохиолдолд гарах нөлөөлөл.

³⁹ <https://www.gtarp.agecon.purdue.edu/resources/download/8387.pdf>

Симуляцын зарим үр дүнгээс⁴⁰ харахад гаалийн тарифын шинэчлэлийн бодлого нь Монгол Улсын ДНБ-ний хэмжээнд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Салбарын шинжилгээнээс харахад хэдийгээр дотоодын зах зээлээс түүхий эдээ бүрэн хангах боломж сайтай сүү, сүүн бүтээгдэхүүний хувьд дотоодын хэрэгцээгээ хангах хувь бага хэмжээгээр буюу 2 хувилбар дээр 1,4 хувь, 3,4 хувь тус тус нэмэгдэхээр байгаа нь хангалтгүй үзүүлэлт. Энэ нь Монгол Улсын аж үйлдвэрлэлийн бүтэц, салбар хоорондын уялдаа холбоо өнөөгийн байдлаар дотоодын түүхий эдээ бүрэн ашиглан сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр өөрийн хэрэгцээгээ бүрэн хангах төвшинд хүртэл хөгжиж чадаагүй байгааг харуулж буй нэг хүчин зүйл юм. Бусад хүнсний бүтээгдэхүүн, хүнсний ногоо, улаан буудай, үр тариа гэх зэрэг салбаруудын хувьд ч мөн ижил дүр төрх ажиглагдаж байна. Тэгэхээр дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүхий эдийн татан авалтын болон нийлүүлэлтийн гинжин хэлхээг бүхэлд нь сайжруулахад юуны түрүүн анхаарч ажиллах шаардлага тулгарч байна.

Хэдийгээр гаалийн тарифын шинэчлэлийн нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх тооцоо гарч байгаа боловч тарифын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх бүртээ салбарын нарийн шинжилгээ хийхгүй бол дотоодын үйлдвэрлэлийн сул хөгжлөөс үүдэн тарифыг өсгөснөөр дотоодод үнийн хөөрөгдөл үүсэх нөхцөл гарахыг үгүйсгэхгүй юм.

2.4. Чөлөөт худалдааны хэлэлцээр ба гаалийн тариф

Аливаа улс орнууд ЧХХ байгуулахдаа ДХБ-ын хэлэлцээрт заасан тодорхой шаардлагыг хангах ёстой. ЧХХ гэдэг нь улс орнууд өөр хоорондоо ДХБ-ын хүрээнд олгодог нэн тааламжтай нөхцөлөөс илүү тааламжтай нөхцөлийн дор худалдаа хийхээр харилцан тохиролцдог хэлэлцээр. Өөрөөр хэлбэл, нэн тааламжтай тарифыг бууруулах, тэглэх асуудал яригдаж байна.

Гаалийн тарифыг чөлөөлөх асуудлыг ТХЕХ-ийн 24 дүгээр зүйлд “Хэлэлцээрт оролцогч талууд хоорондын худалдааны дийлэнх хэсгийн импортын гаалийн тарифыг тодорхой хугацаанд чөлөөлөх, гуравдагч оронтой хийх худалдаанд нэмэлт саад хориг бий болгохгүй байх” гэж заасан.

ЧХХ байгуулж буй орнуудын туршлагаас харахад, хэлэлцээрт оролцогч талууд хоорондын худалдааны 90 орчим хувийг 10 жилийн хугацаанд гаалийн тарифаас чөлөөлөхөөр тохиролцдог. Монгол улс зөвхөн Япон улстай энэ төрлийн хэлэлцээрийг хийсэн ба Япон улсын бусад улстай байгуулсан хэлэлцээрийн хүрээнд гаалийн тарифыг хэрхэн чөлөөлсөн байдлыг хүснэгт 9-өөс харна уу.

Хүснэгт 9. Япон улсын бусад улстай байгуулсан ЭЗТХ-ийн хүрээнд гаалийн тарифыг чөлөөлсөн байдал, хувиар

⁴⁰ Шинжилгээний дэлгэрэнгүйг үндсэн судалгаанаас буюу дээрх холбоосоор үзнэ үү

ЭЗТХ байгуулсан орон	Японы импорт	Түнш орны импорт	Монгол улс, Япон улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр
	10 жилийн хугацаанд, %		
Сингапур	94,7	100	✓ Монгол улс 5722, Япон улс 9096 нэр төрлийн барааны хувьд тарифын хэлцэл хийсэн. Үүнээс Монгол Улсын барааны 59,8 хувь, Японы барааны 79 хувийнх нь гаалийн тариф хэлэлцээр байгуулсан өдрөөс (2016.06.07) “0” болсон бол 2036 онд Монгол Улс - 82,6 хувь, Япон -87,7 хувь нь “0” болно. ✓ Хоёр орны хоорондын худалдааны 2013-2015 оны үнийн дүнгээр тооцсон хувиар авч үзвэл 2016 онд Монгол Улс-59,3 хувь, Япон-99,3 хувь нь “0” болсон.
Мексик	86,8	98,4	
Малайз	94,1	99,3	
Филиппин	92,0	96,6	
Чили	90,5	99,8	
Тайланд	91,6	97,4	
Швейцарь	99,3	99,7	
Бруней	99,99	99,9	
Индонез	93,2	89,7	
Вьетнам	94,9	87,7	

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсны үр дүнд гол төлөв аж үйлдвэрийн барааны гаалийн тарифын хэмжээ маш сайн буурсан боловч хөдөө аж ахуйн зарим салбарт өндөр хэвээрээ байсаар байна. Энэ нь нэг талаас улс орнууд ХАА-н салбарыг импортоос ихээхэн хамгаалдаг учраас гаалийн тариф өндөр байгаа, нөгөө талаас үнийн мэдрэмж өндөр эмзэг бүтээгдэхүүн гэж үздэг учраас тарифыг чөлөөлөхгүй үлдээх талууд байдаг. Өөрөөр хэлбэл, талууд нэн тааламжтай гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх талаар хэлцэл хийхдээ зарим эмзэг бараа бүтээгдэхүүний тарифыг хэвээр үлдээх, бага хэмжээгээр, удаан хугацаанд чөлөөлөх эрхтэй байдаг үүнийг хүснэгт 10-аас харна уу.

Хүснэгт 10. Гаалийн тарифын талаар оруулах санал

№	Тариф буулгах хэлбэр	Тайлбар
1.	“ A ” - шууд “0”	Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс гаалийн тарифыг тэглэх
2.	“ Bn ” – үе шаттай бууруулах	Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс тодорхой үе шатаар гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх
.	“ TRQ ” – тарифын квот	Тодорхой тооны бараанд тарифын хөнгөлөлт олгоод түүнээс илүү гарсанд нь ердийн эсвэл нэн тааламжтай тарифийг ноогдуулах
4.	“ R ” – цаашид хэлэлцэх	Тарифыг бууруулах, чөлөөлөх асуудлыг тодорхой хугацаагаар хойшлуулах
5.	“ X ” – хэлэлцэхгүй	Тухайн хэлэлцээрээс гадуур үлдээх буюу гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх асуудлыг хэлэлцэхгүй
6.	“ SS ” – одоогийн тарифын түвшинг өсгөхгүй	Нэрлэсэн тарифаас өсгөхгүй байх

Тайлбар:

“A” - shall be duty free on the date of entry into force of this Agreement (энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр татвараас чөлөөлөгдөнө).

“B3”- shall be eliminated, from the Base Rate to free, in four equal annual instalments beginning on the date of entry into force of this Agreement (Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үндсэн хувиас үнэ төлбөргүй болгож, жил тутамд төлөх ёстой төлбөрийг 4 тэнцүү хувааж хасна).

“B7”- shall be eliminated, from the Base Rate to free, in eight equal annual instalments beginning on the date of entry into force of this Agreement (Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үндсэн хувиас үнэ төлбөргүй болгож, жил тутамд төлөх ёстой төлбөрийг 8 тэнцүү хувааж хасна);

“R”- shall be excluded from any tariff commitment referred to in subparagraphs (дэд зүйлд заасан ямар нэгэн тарифын үүрэг хариуцлагаас хасагдана)

“X”-excluded from any tariff commitment (ямар нэгэн тарифын үүрэг, хариуцлагаас хасагдана)6

“TRQ” - tariff quota (тарифын квот)

Хүснэгт 10-аас харахад, хэлэлцээрт оролцогч талууд ямар бараан дээр тарифын саналаа хэрхэн өгөх вэ? гэдэг асуудал чухал бөгөөд хэлэлцээрийн үе шатанд Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн дагуу барааны код бүрээр хэлэлцэж тохирох гаалийн тарифын жагсаалтыг гаргах загварыг хүснэгт 11-ээс харна уу.

Хүснэгт 11. ЧХХ-ийн хүрээнд гаалийн тарифын жагсаалт гаргах хүснэгтийн загвар

HS код	Барааны тодорхойлолт	Суурь тариф	Тариф буулгах хэлбэр	Тайлбар
01xxxx	xxxxxxxxxxxxxxxx			
01xxxx	xxxxxxxxxxxxxxxx			

ЧХХ байгуулж буй улс орнуудын туршлагаас харахад, хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс (“A”) нийт худалдааны 50,0-70,0 хувийн гаалийн тарифыг шууд тэглэх, хэрэв дотоодын үйлдвэрлэлийг тодорхой хугацаанд хамгаалах шаардлагатай гэж үзвэл энэ чиглэлийн бараа бүтээгдэхүүний гаалийн тарифыг тодорхой үе шатаар (“Bn”) бууруулж, чөлөөлөх байдлаар хэлцэл хийж, харин үнийн мэдрэмж өндөр эмзэг бүтээгдэхүүний гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх асуудлыг тухайн хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэхгүй (“X”) үлдээдэг байна.

Монгол Улс өөрийн эмзэг, хамгаалах шаардлагатай салбар, түүнчлэн бараа бүтээгдэхүүнийг тодорхойлж, ямар ч улс оронтой ЧХХ хийсэн баримтлах стратегитэй байх хэрэгтэй юм. Судлаачдын судалгаанаас харахад, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, улаан буудай, гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, согтууруулах болон согтууруулах бус ундаа,

савхин болон нэхий хувцас, хивс, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүн зэрэг нь Монгол Улсын хувьд үнийн мэдрэмжтэй, эмзэг бараанд тооцжээ.

Япон улсын бусад орнуудтай хийсэн ЧХХ-ээс харахад, эмзэг бараа бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн бараанаас сүү, сүүн бүтээгдэхүүн, будаа, будаагаар хийсэн бүтээгдэхүүн, улаан буудай, гурил, гурилан бүтээгдэхүүн, элсэн чихэр, чихрийн төрлийн бүтээгдэхүүн, шоколад, жимсний чанамал, вино, гахайн мах, үхрийн мах, ургамлын тос, аж үйлдвэрийн бараанаас арьс, шир болон арьс, ширэн бүтээгдэхүүн, боловсруулсан хоолны давс зэргийг оруулжээ.

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улс хоорондын хэлэлцээрээр тохиролцсон гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх хэлбэр болон эдгээр хэлбэрийн дагуу Монгол улсаас Японы зах зээлд экспортлох бараа бүтээгдэхүүний товч хураангуйг хүснэгт 12-оос харна уу.

Хүснэгт 12. Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээрт гаалийн тарифыг бууруулах, чөлөөлөх талаар тусгасан байдал

№	Тариф бууруулах, чөлөөлөх хэлбэр (Япон улс)	Монгол Улсын экспортын бараа
1	“А” – Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн бараанд ногдуулж байгаа гаалийн татварыг тэглэнэ.	<ul style="list-style-type: none"> • Хонь, ямаа, адууны мах, өндөг, цэвэр ус, пиво, чацарганаар хийсэн бүтээгдэхүүн, төмс болон бүх төрлийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ; • Өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэр, газрын тос, нүүрс-химийн үйлдвэрийн үндсэн болон дайвар бүтээгдэхүүн; • Бүх төрлийн ган, төмөр, түүгээр хийсэн бүтээгдэхүүн, тунгаагаагүй зэс, катодын зэс; • Хонины ноос, мал, амьтны нарийн эсвэл бүдүүн үс,ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл болон нэхмэл даавуу болон Хивс болон бусад нэхмэл дэвсгэр, Оёмол, сүлжмэл, ноос, ноолууран бүтээгдэхүүн оруулаад БТКУС-ийн Нэхмэл, сүлжмэлийн 13 бүлгийн 1200 орчим төрлийн бүтээгдэхүүн; • Зарим модон эдлэл гэх мэт
2	“Вп” – Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс тухайн бараанд ногдуулж байгаа гаалийн суурь	<ul style="list-style-type: none"> • Зарим төрлийн боловсруулсан арьс ширэн болон үслэг эдлэл, түүгээр хийсэн гутал, эд анги, цүнх, түрийвч, бээлий гэх мэт • Архи, дарс, зарим төрлийн жимсний ундаа,

	татварыг n+1 жил дараалан жил бүр ижил хэмжээгээр бууруулж, улмаар тэглэнэ.	<p>чанамал бүтээгдэхүүн</p> <ul style="list-style-type: none"> Зарим цайр болон түүгээр хийсэн зүйлс, төмөр, төмөрлөг зүйлс, зэс бүтээгдэхүүн зэрэг
3	“Q”- Тодорхой тоон хязгаарлалтын хүрээнд гаалийн татварыг тэглэх, түүнээс илүү гарсанд нь нэн тааламжтай тариф хэрэглэх	<ul style="list-style-type: none"> Хагас боловсруулсан үхрийн махан бүтээгдэхүүн, Сүү болон аарцан бүтээгдэхүүн, зөгийн бал, Гоймон болон зарим гурилан бүтээгдэхүүн.
4	“R” – тарифын аливаа үүрэг амлалтад хамрагдахгүй бөгөөд эдгээр бараанд ногдуулж байгаа гаалийн татварыг Талуудын тодорхойлсон нөхцлийн дагуу дахин хэлэлцэнэ.	<p>Тухайлбал, Үхрийн ястай (HS 0202.20), ясгүй мах (HS 0202.30).</p> <p>Талууд 2.4 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт заасны дагуу зах зээлд нэвтрэх нөхцлийг сайжруулах зэрэг асуудлаар 5 дахь жилд, эсвэл Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас Монгол Улс, эсвэл түүний хэсгийг малын шүлхий өвчнөөс ангижирсан улс, эсвэл бүс нутаг хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрөн, түүнчлэн Япон Улсын ЗГ-аас эрсдлийн үнэлгээ хийж, монголын салаа туурайтай малын мах, махан бүтээгдэхүүний импорт нь аливаа өвчний эрсдэлгүйг тогтоосон бөгөөд эдгээр нөхцлийн аль түрүүлж бүрдсэн тохиолдолд Талууд хэлэлцэнэ.</p>
5	“X” – тарифын аливаа үүрэг амлалтад хамаарахгүй	<p>Үхрийн шинэ эсвэл хөргөсөн мах (HS 02.01), үхрийн хөлдүү гүлүүз болон өрөөл мах (HS 020101), дайвар бүтээгдэхүүн (HS 020610, 0206.21, 0206.22, 0206.29) гэх мэт.</p>
6	“P”- Талуудын тодорхойлсон нөхцлийн (хугацаа, хувь) дагуу гаалийн татварыг бууруулна.	<p>Өрмөнцөрийн (хүүхдийн печень) 18 хувийн гаалийн татварыг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн 6 жил дараалан жил бүр ижил хэмжээгээр бууруулан 10 хувь болгож бууруулна гэх мэт.</p>

Эх сурвалж: Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээрт үндэслэн боловсруулав.


2.5. Барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт

Барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан импортын гаалийн тариф нь дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих зорилготой байдаг. Улс орнуудын гаалийн тариф тогтоож буй туршлагаас (Зураг-2) харахад, тухайн бараа бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн ямар нэг боловсруулалт хийгдсэн эсэхээс нь хамааруулан тарифыг ялгаатай байдлаар тогтоосон нь нилээд байна. Өөрөөр хэлбэл, эцсийн болон завсрын бүтээгдэхүүний гаалийн тариф нь түүхий эдийнхээс өндөр байдаг. Тухайлбал,

- Боловсруулаагүй буюу анхан шатны түүхий эдэд (арьс) ногдуулж буй гаалийн тариф - 0 хувь;
- Хагас боловсруулсан завсрын бараа бүтээгдэхүүний (савхи) гаалийн тариф - 10 хувь;
- Эцсийн бэлэн бүтээгдэхүүний (савхин цүнх) гаалийн тариф 20 хувь гэх мэт.

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын зохицуулалт чухал байсаар байгаа бөгөөд гол төлөв аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн, ялангуяа хувцас дээр хэрэглэж байна. 2018 оны барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын түвшинг зураг 2-оос харна уу.

Зураг 2. 2018 оны барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын түвшин, бүс нутгаар, хувиар,



Эх сурвалж: UNCTAD: Key statistics and trends in trade policy 2019.

Зураг 2-оос харахад, бүс нутгуудын гаалийн тарифын түвшин барааны боловсруулалтын түвшингээр ялгаатай байна. Өмнөд Азийн орнуудын ХАА-н барааны гаалийн тарифын түвшин хамгийн өндөр буюу 10 ба түүнээс дээш хувьтай, эцсийн бэлэн бүтээгдэхүүний тариф 15-аас дээш хувьтай байна.

Хөгжингүй орнууд, Латин Америкийн орнууд, Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гаалийн тарифын дундаж түвшин 5 хувиас доогуур байгаа ч боловсруулалтын түвшингээр ялгаатай тогтоожээ.


Харин аж үйлдвэрийн барааны хувьд гаалийн тарифын түвшин ХАА-н бараатай харьцуулахад доогуур байгаа ч бүх бүс нутгийн орнууд барааны боловсруулалтын түвшингээр нилээд ялгаатай тогтоожээ. Тухайлбал,

шилжилтийн эдийн засагтай орнуудын эцсийн бүтээгдэхүүнд ногдуулж буй гаалийн тариф анхдагч түүхий эдийнхээс 3 дахин, хагас боловсруулсан завсрын бүтээгдэхүүнийхээс 2 дахин өндөр байна.

Гэтэл Монгол Улсын хувьд дотоодын үйлдвэрээ дэмжих нэрээр лаа үйлдвэрлэхэд шаардлагатай анхдагч түүхий эд болон завсрын бүтээгдэхүүн, бэлэн лааны тарифыг бүгдийг тэглэж байсан түүхтэй. Энэ үед лааны үйлдвэр бус, импортын лааны үнэ буурч үйлдвэр нь дампуурахад хүрч байсныг бид мэдэх билээ.

Цаашид бараа бүтээгдэхүүний гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээнд хүргэхдээ эдийн засаг, нийгэм, хэрэглээний нөлөөллийг тооцохоос гадна барааны боловсруулалтын түвшинг харах хэрэгтэй юм. Сүүлийн жилүүдэд энэ талаар үүнийг нилээд ярьж байгаа бөгөөд 2020 оны 5 дугаар сарын УИХ-ын 35 дугаар тогтоолоор үр тариа, тосны ургамал, тэжээлийн таримал, төмс, хүнсний ногооны үрийн гаалийн албан татварын хувь, хэмжээг “0” болгоод байна. Салбарууд болон барааны боловсруулалтын түвшингээр гаалийн тарифыг ялгаатай тогтоож буй улс орнуудын туршлагыг зураг 3-аас харна уу.

Зураг 3. 2018 оны салбаруудын барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын түвшин



Эх сурвалж: UNCTAD: Key statistics and trends in trade policy 2019.

Зураг 3-аас харахад, үндсэн метал; уул уурхайн болон металын баяжмал; газрын тос, байгалийн хий, нүүрс; газрын тосны бүтээгдэхүүнээс бусад салбарын ихэнх нь боловсруулалтын түвшингээс хамаарсан гаалийн тарифтай байгаа юм. Гэхдээ зарим эцсийн бүтээгдэхүүний (тухайлбал химийн, өөх тос, автомашин гэх мэт) тариф хагас боловсруулсан завсрын бүтээгдэхүүнээс бага байна. Харин хөгжиж буй орны хувьд чухал салбар болох хувцас хунар, метал бус эрдэс баялаг (цемент, элс, хайрга, шохойн чулуу, шавар, гантиг гэх мэт), мал амьтны гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын зохицуулалтыг сайн хийжээ.

Түүнчлэн улс орнууд ДХБ-д элсэхдээ барааны боловсруулалтын түвшингээс шалтгаалан тарифын дээд түвшинг тохиролцож үүрэг амлалт авдаг ба хөгжингүй болон хөгжиж буй орнууд түүхий эд болох какао, боловсруулалт хийсэн кофе дээр тарифын дээд түвшинг (bound tariffs) хэрхэн тохирсон болон мөрдөж буй тарифыг (applied tariff) харьцуулан хүснэгт 13-аас харна уу.

Хүснэгт 13. ДХБ-тай тохирсон болон мөрдөж буй какао болон кофений тарифын дундаж хувь

БТКУС код	БҮТЭЭГДЭХҮҮН	ДХБ-ын үүрэг хүлээсэн дундаж тариф, % (2012-13)		Мөрдөж буй дундаж тариф, % (2012-13)	
		Хөгжиж буй орон	Хөгжингүй орон	Хөгжиж буй орон	Хөгжингүй орон
КАКАО БОЛОН ЭНЭ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН					
1801	Какаоны түүхий эсвэл хуурсан, бүтэн буюу буталсан шош	41,88	0,11	6,88	0,00
1802	Какаоны хальс, яс болон какаоны бусад хаягдал	40,79	0,13	7,76	0,00
1803	Тосыг нь ялгасан эсвэл ялгаагүй, зуурмаг какао	43,07	3,7	7,95	2,14
1804	Какаоны хайлмал, өтгөн болон шингэн тос	42,03	0,96	7,92	0,96
1805	Сахарын эсвэл бусад амтлагчийн хольцгүй нунтаг какао	41,37	8,13	9,78	3,84
1806	Шоколад болон какао агуулсан хүнсний бусад бэлдмэл	44,94	15,21	15,7	8,17
КОФЕ БОЛОН ЭНЭ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН					
090111	Хуураагүй кофе: кофеинтой	49,47	0,13	13,62	0,00
090112	Хуураагүй кофе: кофеингүй	49,49	1,16	13,87	0,92
090121	Хуураагүй кофе: кофеинтой	51,79	5,67	20,94	3,06
090122	Хуурсанкофе: кофеингүй	51,68	5,92	20,64	3,25
090109	Кофе агуулсан кофе орлуулагч	50,67	2,22	20,12	1,58
210111	Кофений ханд, охь, концентраци	47,14	13,92	17,41	6,24
210112	Ханд, охь, өтгөн ханданд эсвэл кофенд суурилсан бэлдмэл	46,89	16,93	18,34	8,36

Эх сурвалж: WTO tariff data. Developing countries also include LDCs.

Хүснэгт 13-аас харахад, мөрдөж буй тариф нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд нилээд ялгаатай байна. Хөгжингүй орнууд дээрх 2 барааны боловсруулалтын түвшингээс хамаарч хоёр төрлийн тарифын хувь хэмжээг тогтоосон. Тухайлбал, эдгээр орны мөрдөж буй тарифын түвшинг харахад какао болон кофений үрний хувьд “0” байгаа бол харин эдгээрийг агуулсан хүнсний бүтээгдэхүүний дундаж мөрдөж буй тариф 8 хувиас дээш, ДХБ-тай тохирсон нь 15-17 хувь байна. Өөрөөр хэлбэл, боловсруулалтын түвшин нэмэгдэж, нэмүү өртөг шингэх тусам гаалийн тарифын хувийг өсгөжээ.

Хэдийгээр импортлогч орнууд барааны боловсруулалтын түвшингээс хамаарсан тарифын зохицуулалтыг хийсээр байгаа ч экспортлогч орнууд экспортын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд технологи шингээх замаар нэмүү өртөг бий болгож экспортын орлогоо нэмэгдүүлэх, гадаад худалдааны нөхцөл сайжруулахад ихээхэн анхаарч байна.


Улс орнууд барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС буюу HS)-ийн ангиллаар гаалийн тарифын жагсаалтыг гаргасан байдаг нь барааны технологийн түвшинээр тарифыг харахад төвөгтэй. Pavit (1984), OECD (1994), Sanjaya Lall (2000)⁴¹ нар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанд тулгуурлан НҮБ-аас боловсруулсан Олон Улсын Худалдааны Стандарт (SITC) ангиллыг ашиглан технологийн 5 түвшинд илүү нарийвчлан ангилжээ. Үүнд:

- Үндсэн суурь бүтээгдэхүүн: шинэхэн жимс, мах, будаа, какао, цай, кофе, нүүрс, түүний нефт, байгалийн хий зэрэг хүн төрөлхтний үндсэн суурь хэрэгцээ болсон бүтээгдэхүүнүүд
- Байгалийн баялагт тулгуурласан бүтээгдэхүүн: боловсруулсан мах, жимс, хүнсний ногоо, ус ундаа зэрэг энгийн хөдөлмөрийн багтаамж ихтэй хүнсний бүтээгдэхүүнүүд болон мод модон эдлэл, боловсруулсан арьс шир, барилгын материал зэрэг капитал, ур чадвар шаардсан зарим бүтээгдэхүүнүүд
- Нам технологитой бүтээгдэхүүн: нэхмэл сүлжмэл, гар урлал, тавилга эд хогшил, тоглоом, хуванцар эдлэл зэрэг үйлдвэрлэлийн процесст нь өргөн тархсан технологи бүхий капитал тоног төхөөрөмж ашигладаг, энгийн урчадвар шаардсан бүтээгдэхүүнүүд
- Дунд технологитой бүтээгдэхүүн: нилээд ур чадвар шаардсан, технологийн цар хүрээ өргөнтэй, хөрөнгө оруулалт шаардсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг багтаасан. Тухайлбал автомашин, аж үйлдвэрийн болон инженерийн тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүнүүд

⁴¹ Sanjaya Lall, *The Technological Structure and Performance of Developing Country Manufactured Exports, 1985-1998*, QEHWPS44, University of Oxford, June 2000

- Өндөр технологийн бүтээгдэхүүн: Энэ төрлийн бүтээгдэхүүнд судалгаа хөгжлийн хөрөнгө оруулалт, дэвшилтэт ухаалаг технологи, өндөр ур чадвар ихээр шаарддаг ба 9 үндсэн группт хуваагддаг. Агаарын болон сансрын хөлөг; компьютер болон оффисын тоног төхөөрөмж; цахилгаан-харилцаа холбоо; эрдэм шинжилгээний тоног төхөөрөмж; цахилгаан машин тоног төхөөрөмж; химийн бүтээгдэхүүн; цахилгаан бус машин тоног төхөөрөмж; эм эмийн бүтээгдэхүүн; зэвсэг.

Зураг 4. 2018 оны улс орнуудын экспортод өндөр технологийн бараа эзэлж буй байдал




Улс орнуудын туршлагаас харахад, өндөр технологи шингэсэн бүтээгдэхүүний гаалийн тарифын түвшин нилээд доогуур, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд өндөр байгаа нь энэ салбарт хөгжингүй орнуудтай өрсөлдөж чадахгүй, нөгөө талаас эдгээр бүтээгдэхүүн нь тухайн улсын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдагт оршино. Харин эм болон зэвсгийн бүтээгдэхүүний хувьд өөр бодлого баримталж байна. Манай улсын хувьд технологийн түвшингээс нь хамааруулж гаалийн тарифыг оновчтой тогтоож өндөр технологийн барааны импортын тарифыг “0” болгох бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.6. Эдийн засгийн салбараас хамаарсан импортын гаалийн тарифын бодлого зохицуулалт

Дэлхийн улс орнуудын гаалийн тариф эдийн засгийн салбараас хамааран ялгаатай байгаа бөгөөд ХАА, аж үйлдвэрийн болон байгалийн баялгийн бүтээгдэхүүний 2008 болон 2018 оны нэн тааламжтай (олон талт худалдаа) болон хөнгөлөлттэй (хөнгөлөлттэй худалдаа) энгийн болон жигнэсэн дундаж тарифыг зураг 5–аас харна уу.

Зураг 5. Дэлхийн улс орнуудын олон талт (нэн тааламжтай) болон хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн тарифын либералчлал, (салбараар), 2008/2018




Эх сурвалж: UNCTAD: Key statistics and trends in trade policy 2019.

Зураг 5-аас харахад, ХАА-н гаралтай бараа бүтээгдэхүүнд ногдуулж буй нэн тааламжтай тариф хамгийн өндөр буюу 15-аас дээш хувьтай, аж үйлдвэрийн салбарын бараа бүтээгдэхүүний гаалийн тариф ХАА-н бараа бүтээгдэхүүнээс 2 дахин доогуур, байгалийн баялагт ногдуулж байгаа гаалийн тариф нь аж үйл үйлдвэрийн бүтээгдэхүүнээс 2 дахин доогуур байна. Тухайлбал, ХАА-н барааны энгийн дундаж тариф 2008 онд 9,5 орчим, 2018 онд 7,5 орчим хувь байсан нь нэн тааламжтай тарифаас 8 орчим хувиар буурсан байна.

Түүнчлэн энэ 10 жилийн хугацаанд ХАА-н барааны нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф буурсан. Тухайлбал, нэн тааламжтай тариф энгийн дундажаар 2 хувь, жигнэсэн дундажаар 3 хувь, хөнгөлөлттэй тариф энгийн дундажаар 2 хувь, жигнэсэн дундажаар 1,5 хувь байна. Дэлхийн улс орнуудын гаалийн тарифын түвшинг зураг 6-аас харна уу.

Зураг 6. Гаалийн тарифын жигнэсэн дундаж түвшин, салбараар, хувиар




Эх сурвалж: UNCTAD: Key statistics and trends in trade policy 2019.

Зураг 6-аас харахад, ХАА-н салбарын бараа бүтээгдэхүүний гаалийн тариф аж үйлдвэр болон байгалийн баялгийнхаас илүү өндөр байна. Аж үйлдвэрийн салбараас нэхмэл сүлжмэл, хувцасны тариф нилээд өндөр байгаа нь хөгжиж буй улс орнуудын хувьд анхаарах асуудлын нэг юм.

2018 оныг 2008 онтой харьцуулахад дийлэнх салбарын бараа бүтээгдэхүүний жигнэсэн дундаж тариф буурсан бол уул уурхай болон металын баяжмал, тамхи болон ундаа, арьс, ширэн бүтээгдэхүүн, амьтны гаралтай бараа бүтээгдэхүүний хувьд өссөн.

Тарифын жигнэсэн дундаж түвшинг ерөнхийлөн харахад доогуур мэт харагдаж байгаа боловч өндөр буюу 15-аас дээш хувийн гаалийн тарифтай салбарыг нарийвчлан харвал, хүнсний бүтээгдэхүүн, хувцас, амьтны гаралтай бүтээгдэхүүн дээр тариф маш өндөр байгаа юм. Тухайлбал, хүнсний бүтээгдэхүүний олон улсын худалдааны 8 орчим хувь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 25-аас илүү хувь, хувцасны хувьд олон улсын худалдааны 10 орчим хувь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 20 гаруй хувь, амьтны гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааны 13 орчим хувь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 20 гаруй хувь нь 15-аас дээш тарифтай байгааг зураг 7-оос харна уу.

Зураг 7. 2018 оны байдлаар өндөр тарифтай салбарууд




Эх сурвалж: UNCTAD: Key statistics and trends in trade policy 2019.

Зураг 7-оос харахад өндөр буюу 15-аас дээш хувийн гаалийн тарифыг мэдрэмж өндөртэй эмзэг бүтээгдэхүүн дээр олгодог ба гол төлөв ХАА-н бүтээгдэхүүн хамрагддаг.

Хөгжиж буй орнуудын хувьд өндөр тарифаар зах зээлээ хамгаалахад илүү анхаарч байгаа бөгөөд Өмнөд Ази, Сахарын Африкийн орнуудыг дурдаж болно. Тухайлбал, Өмнөд Азийн орнуудын олон улсын худалдааны 20 орчим хувь нь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 70 гаруй хувь, Сахарын Африкийн олон улсын худалдааны 30 орчим хувь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 50 орчим хувь нь 15-аас дээш тарифтай байгааг зураг 8-аас харна уу.

Зураг 8. 2018 оны байдлаар өндөр тариф, салбараар, бүсээр,



Эх сурвалж: UNCTAD: Key statistics and trends in trade policy 2019.

Зураг 8–аас харахад аж үйлдвэрийн барааны хувьд мөн Өмнөд ази болон Сахарын африк өндөр тарифыг хамгийн их хэрэглэж байна. Тухайлбал, Өмнөд азийн орнууд олон улсын худалдааны 7 орчим хувь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 30 орчим хувь, Сахарын африкийн орнууд олон улсын худалдааны 15 орчим хувь буюу БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 30 гаруй хувь нь 15-аас дээш тарифтай байна.

Харин байгалийн баялгийн хувьд мөн энэ 2 бүсийн орнууд БТКУС-ын 6 орны түвшинд ангилсан нийт барааны 10 орчим хувьд нь 15-аас дээш гаалийн тариф тогтоожээ. ДХБ-аас гаргасан барааны бүлгээр Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын гаалийн тарифыг хүснэгт 14–өөс харна уу.

Хүснэгт 14. Монгол Улс болон хөрш орнуудын мөрдөж буй гаалийн тарифын хамгийн өндөр дундаж тариф

Барааны бүлэг	Дундаж тариф (MFN)			Хамгийн өндөр тариф		
	Монгол	БНХАУ	ОХУ	Монгол	БНХАУ	ОХУ
Амьтны гаралтай бүтээгдэхүүн	7,1	14,2	25,8	20	25	80
Сүү, сүүн бүтээгдэхүүн	12,4	12,3	15,2	20	20	47
Жимс, ногоо	5,6	14,8	8,0	20	30	18
Кофе, цай	5,0	14,9	5,4	5	32	13
Үр тариа	6,0	23,0	9,5	15	65	78
Тосны үр, өөх тос	5,0	10,9	6,5	5	30	15
Сахар, чихрийн бүтээгдэхүүн	5,0	28,7	11,5	5	50	53
Архи, тамхи	14,8	23,7	22,4	40	65	303

Даавуу	5,0	18,0	0,0	5	40	0
ХАА-н бусад бүтээгдэхүүн	5,0	11,8	4,7	5	38	10
Загас, загасан бүтээгдэхүүн	5,0	10,9	6,9	5	23	73
Эрдэс, метал	5,1	7,8	7,2	20	50	20
Нефт	3,9	5,3	4,4	5	9	5
Химийн бүтээгдэхүүн	5,0	6,7	4,6	7	47	10
Мод, цаас, цаасан бүтээгдэхүүн	5,4	4,1	8,0	20	20	18
Нэхмэл сүлжмэл	5,1	9,6	7,5	20	38	18
Хувцас	5,1	16,0	7,8	20	25	23
Савхи, гутал бусад	5,1	13,2	5,7	20	25	15
Цахилгаан бус тоног төхөөрөмж	4,9	8,1	2,6	5	35	15
Цахилгаан тоног төхөөрөмж	4,7	8,4	4,4	5	35	15
Тээврийн хэрэгсэл	5,0	12,3	8,2	5	45	25
АҮ-ийн бусад бүтээгдэхүүн	4,7	11,6	7,2	5	35	20

Эх сурвалж: World tariff profiles 2019

Хүснэгт 14-өөс харахад, 3 улс архи тамхинд хамгийн өндөр тариф тогтоожээ. ОХУ-д даавууны (БТКУС-ийн 5201-5203 зүйлийн бараа) импортын гаалийн тариф “0” байхад БНХАУ-д 40 хувьтай байна.

БНХАУ хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн дээр мөрдөж буй дундаж нэн тааламжтай тариф 11-29 хувь, хамгийн өндөр тариф 20-65 хувь байна. Гэтэл ОХУ-ын гаалийн тарифын зөрүү их буюу мөрдөж буй тариф нь 0-26 хувь, хамгийн өндөр тариф 0-303 хувь, Монгол Улсын мөрдөж буй тариф 5-14,8 хувь, хамгийн өндөр тариф 5-40 хувь байна.

Дүгнэлт, санал зөвлөмж

Монгол Улс ДХБ-д элсээд 25 орчим жил өнгөрч байгаа хэдий ч уг байгууллагын хүрээнд дотоодын үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх бодлого, зохицуулалт тодорхойгүй байна. Манай Улсын авч хэрэгжүүлж буй зарим бодлого шийдвэрийг ДХБ-ын хэлэлцээрийн заалтыг зөрчсөн хэмээн үзэж экспортлогч орны аж ахуй эрхлэгчид гомдол гаргасан, улмаар ДХБ-ын барааны хорооны хуралдааны үеэр уг асуудлыг ОХУ хөндсөн нь ДХБ-ын маргаан хянан шийдвэрлэх байгууллагад манай улс татагдах нөхцөл үүсч байв. Иймээс худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгохдоо ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг зөрчихгүй байх, хэлэлцээрийн хүрээнд хөгжиж буй орнуудад олгодог болон бусад нөхцөлийг ашиглах шаардлагатай байгаа бөгөөд гаалийн тарифтай холбоотой дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улс ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаарын энгийн дундаж хувь нь нийт барааны хувьд 17,5 хувь, аж үйлдвэрийн бараа 17,3 хувь, ХАА-н бараанд 18,8 хувь байгаа бол одоо мөрдөж буй тариф тус тус 5,2 хувь, 6,5 хувь, 5,0 хувь байгаа тул тарифыг өсгөх боломж байгааг анхаарах хэрэгтэй юм. Үүнд:

- Үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжсэн үе буюу 2015 оноос хойш 300 гаруй нэр төрлийн барааны гаалийн тарифыг ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаарт хүргэсэн. Ингэснээр дотоодын үйлдвэрлэл болоод эдийн засаг, хэрэглээнд ямар өөрчлөлт гарсан, түүнчлэн бусад барааны тарифыг ийм замаар нэмэгдүүлснээр ирээдүйд ямар өөрчлөлт бий болох талаар салбар бүр дээр нөлөөллийн судалгааг зайлшгүй хийх хэрэгтэй. Бидний хийсэн судалгаагаар хэрэв Монгол Улс бүх барааны импортын гаалийн тарифын хувь, хэмжээг ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаарт хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд боловсруулах аж үйлдвэрлэлийн голлох салбарууд болох арьс шир, мах, сүү, ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын хэмжээ аль аль нь нэмэгдэх үр дүн гарсан. Гэсэн хэдий ч тооцоололд ороогүй гэнэтийн нөлөөлөх хүчин зүйлс (Жишээ нь Ковид 19) байнга гардаг гэдгийг бодох шаардлагатай.
- Сүүлийн жилүүдэд худалдааны гол түнш орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад ихээхэн анхаарч байгаа боловч манай гаалийн тарифын түвшин доогуур тул тарифын хэлцэл дээр үр ашиг гарахгүй байх магадлал их. Иймд гаалийн тарифыг ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаарт хүргэх, түүнчлэн худалдааны бодлогын бусад арга хэрэгслээр хамгаалах салбарын жагсаалтыг гаргах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг ямарч оронтой байгуулсан энэ салбарын импортын барааны гаалийн тарифыг чөлөөлөх асуудал яригдахгүй болно.
- Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх буюу барааны боловсруулалтын түвшин, технологийн насжилт болон түвшин, дотооддоо үйлдвэрлэх боломжтой эсэх, үйлдвэрлэлийн орц, гарц, кластер, дагалдах салбар зэргийг харгалзан үзэж байж тарифын хувь, хэмжээг ялгаатай тогтоох шаардлагатай. Одоогийн байдлаар манай гаалийн тарифын хувь, хэмжээ дийлэнх бараан дээр 5 хувь байгаа нь гаалийн тариф зохицуулалтын гол үүргээ биелүүлэх бус төсөв бүрдүүлэх төдий л байдалтай байгаа юм.
- Гаалийн тарифын хувь, хэмжээг тогтоохдоо тухайн барааны хувьд тарифын оновтой түвшин буюу үндэсний эдийн засгийн сайн сайхан байдлыг хамгийн өндөр байлгаж чадах нөхцөлийг хангах тарифын түвшин тогтоох нь чухал. Түүнчлэн тарифын хамгаалалтын бодит түвшинг тооцдог байх. Жишээ нь бидний өмнө хийсэн судалгаагаар улаан буудайн гурилын гаалийн тариф 21 хувь (тооцоо хийх үед 5 хувь байв) байж дотоодын үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ потенциал хэмжээнд нь хүртэл

үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх замаар дотоодын хэрэгцээг 100 хувиар хангах тооцоо гарсан. Гэтэл гурилны хувьд ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаар 15 хувь учраас энэхүү 21 хувийг шууд хэрэгжүүлэх боломжгүй. Иймд гурилын импортын тарифыг улирал, боомт харгалзахгүйгээр 15 хувь болгож, хүлээсэн үүрэг амлалтын хүрээнд дотоодын үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх замаар дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих нь чухал гэдэг зөвлөмжийг өгч байсан⁴².

- Монгол Улс “Гаалийн тариф, татварын тухай хууль”-д гаалийн тарифыг УИХ баталж, түүнд өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг гаалийн тарифын орон тооны бус зөвлөл боловсруулснаар Засгийн газраас УИХ-д өргөн барьж, өөрчлөлт шинэчлэлийг хийхээр тусгасан. Энэ нь нилээд хугацаа, шат дамжлага шаардсан ажил байсан тул 2015 онд УИХ-ын 74 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосон нь үндэсний үйлдвэрийн хөгжлийг тарифын бодлогоор дэмжихэд томоохон түлхэц болсон гэж үзэж болох юм. Гэсэн хэдий ч импортын тарифыг тогтоох нэгдсэн аргачлал одоог хүртэл байхгүй, энэ талын судалгаа, шинжилгээний ажил ч ховор байгаа юм. Иймд институцийн болоод хүний нөөцийн чадавхийг сайжруулахад ихээхэн анхаарах шаардлагатай байна.
 - “Гаалийн тариф, татварын тухай хууль”-ийн 6.1-д Гаалийн татвар, тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг бүхий *гаалийн тарифын орон тооны бус зөвлөл* ажиллахаар заасан ба зөвлөлийн дүрмийг нь Засгийн газар 2009 онд баталсан ч энэ зөвлөл үүрэгт ажлаа хийхгүй байна.
2. ДХБ-д элсэхдээ авсан үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаараас өндөр тарифаар дотоодын үйлдвэрийг дэмжих боломж, нөхцөлийг судлан хэрэгжүүлэх. Үүнд:
- ДХБ-ын хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээрийн хүрээнд импортын хэт их нийлүүлэлтээс үүдэн дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учирсан, эсвэл учрах бодит эрсдэл бий болсон үед тариф (ДХБ-д элсэхдээ авсан үүрэг) болон тарифын бус арга хэрэгслээр хамгаалах боломж байдаг ч Монгол Улсад түүнийг авч хэрэгжүүлэх механизм тодорхойгүй учраас өдийг хүртэл бодитой алхам хийгээгүй ба улаан буудайн гурил, шингэн сүү дээр тоо

⁴² Н.Отгонсайхан. Импортын тарифын оновчтой хувь, хэмжээг тогтоох асуудалд. Үндэсний аюулгүй байдал – даяаршсан сүлжээт гааль сэдэвт ОУЭШ хурлын эмхтгэл (2012.10.19). –УБ 2012. – Х.78-80

хэмжээний хязгаарлалт тогтоосон нь ДХБ-ын маргаан шийдвэрлэх байгууллагад татагдаж болзошгүй нөхцөл үүсгэв. Энэхүү нөхцөл байдалд дүгнэлт хийж ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газраас санаачлан гадаад, дотоодын судлаачид, холбогдох яам, агентлагийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг “ДХБ-ын Хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам”-ыг боловсруулан 2021 оны 1 дүгээр сарын 27-нд батлуулаад байна. Гэсэн хэдий ч уг журмыг боловсруулах, хэлэлцүүлэх, санал авах явцад төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд, олон нийт энэ талын нэгдсэн ойлголт байхгүй, асуудлын мөн чанарыг ойлгохгүй байх, олон улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэх журмыг бусад журамтай адилтган үзэх зэрэг ихээхэн хүндрэл гарч байсан. Энэ журам батлагдсанаар хамгаалалтын арга хэмжээ хэрэглэхэд дотоодын үйлдвэрлэгчид хэнд хандаж хүсэлт гаргах, хянан магадлах ажиллагааг ямар хугацаанд, ямар нотлох баримтад үндэслэн хэн хийх, хамгаалалтын арга хэмжээг ямар хэлбэрээр, хэдий хугацаанд хэрхэн хийх механизм тодорхой болсон ч журмыг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавх сул байсаар байна. Дэлхийн улс орнуудад энэхүү бодлого, зохицуулалт аль хэдийн тодорхой болсон ба дараагийн үе шатанд хянан магадлах үйл ажиллагааг илүү хурдан, ил тод болгох талруу боловсронгуй болгож байгаа туршлагаас суралцах нь чухал юм.

- ДХБ-ын демпингийн эсрэг арга хэмжээний хэлэлцээрийн (1994 оны тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр) хүрээнд импортын шударга бус өрсөлдөөнөөс (демпингийн үнэ) дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилгоор ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаараас давсан гаалийн нэмэлт татварыг демпингийн зөрүүгээр авах боломжтой ч үүнийг хэрэгжүүлэх механизм алга байна. Бусад орнуудад бие даасан хууль, журмаар демпингийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх механизмыг бий болгосон байдаг. Монгол Улсад демпингийн эсрэг хуулийн төсөл боловсруулж хэлэлцүүлсэн ч уг хууль нь энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх гол механизм бус хэлэлцээрийн орчуулга төдийхнөөр хязгаарлагдсан байсан учраас батлагдаагүй өдий хүрсэн байна. Иймд демпингийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгосон зохицуулалт төдийгүй дэлхийн болон экспортлогч орны зах зээл үнийн мэдээллийн санг үүсгэх асуудал чухлаар тавигдаж байна.
- ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн хүрээнд импортын шударга бус өрсөлдөөнөөс (татаастай үнэ) дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилгоор

ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаараас давсан гаалийн нэмэлт татварыг өгсөн татаасын хэмжээнээс хэтрэхгүй байдлаар авах боломжтой ч үүнийг хэрэгжүүлэх механизм мөн алга байгаа юм. Бизнес эрхлэгчид БНХАУ-ын зарим бүтээгдэхүүн татаас авсан учраас дэндүү хямд манай зах зээлд орж ирж байна гэж үздэг ч үүнийг хянан магадлах тогтолцоо, механизм байхгүй учраас бид ярихаас өөр юу ч хийж чадахгүй байна. Иймд энэ асуудлыг тодорхой болгож зохицуулах шаардлага зүй ёсоор гарч байна.

3. Монгол-Японы хооронд байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд бий болсон тарифын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс бизнес эрхлэгчид, ялангуяа экспортлогчид ямар үр ашиг хүртэж байгаа талаар нарийвчилсан судалгаа хийж дараагийн түнш орнуудтай хэлэлцээр байгуулахдаа анхаарах хэрэгтэй байна.
4. Монгол Улс Ази Номхон Далайн худалдааны хэлэлцээрт нэгдэж 2021 онын 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж БНХАУ, БНСУ, Энэтхэг, Шри-Ланк, Бангладеш, Лаосаас гарал үүсэлтэй бараа манай зах зээлд тарифын хөнгөлөлттэй нэвтрэх, Монгол Улсын гарал үүсэлтэй бараа эдгээр орны зах зээлд тарифын хөнгөлөлттэй нэвтрэх боллоо. Иймд дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, тарифын бус хориг саадыг нь даван туулах арга замыг эрэлхийлэх нь зүйтэй. Түүнчлэн уг хэлэлцээрийн 5 дугаар шатны хэлэлцээрт өөрийн байр суурийг тодорхойлж, идэвхи санаачлагатай оролцох хэрэгтэй байна.
5. Монгол Улсад бие даасан гадаад худалдааны бодлого, зохицуулалт байхгүй ч урт хугацааны хөгжлийн хөтөлбөр 2050-ын зорилт 4.2-т Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгохоор тусгасан ба энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг тодорхойлсон. Эхний үе шат буюу 2020-2030 онд түүхий эд экспортлогчоос боловсруулсан бүтээгдэхүүний экспортлогч орон болохоор төлөвлөсөн бөгөөд энэ хүрээнд *худалдааны зохицуулалтын хуулийг батлах, импортын тарифын зохицуулалтаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийг дэмжихээр тусгасан байна.* Худалдааны тухай хуулийн төслийг 1996 оноос хойш хэд хэдэн удаа боловсруулж 2015 онд УИХ-д өргөн барьсан боловч хуулийн хэрэгцээ шаардлагыг нарийн тодорхойлж чадаагүй, бүтэц, агуулгын хувьд нэгдсэн ойлголтод хүрээгүй зэрэг олон шалтгаанаар уг хууль батлагдаагүй байдаг. Түүнчлэн хуулийн төслийг боловсруулах явцад үзэл баримтлал, бүтэц агуулга байнга өөрчлөгдөж ирсэн нь түүний хэрэгцээ, бүтэц, агуулгыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай гэдгийг харуулж байна. Улс орнуудын туршлагаас харахад, худалдааны хууль нь нэг талаас худалдаанд оролцогч субъект хоорондын харилцааг зохицуулах процессийн хууль байгаа бол нөгөө талдаа төрөөс худалдааг дэмжин

хөгжүүлэхэд ямар үүрэг оролцоотой байх, түүнчлэн ДХБ-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн зохицуулалтын шинжтэй байгаа юм. Монгол улсад худалдаанд оролцогч субъект хоорондын харилцааг Иргэний хуулиар зохицуулж байгаа бөгөөд энд зохицуулалт байхгүй хэсгийг Арилжааны хуулиар зохицуулахаар хуулийн төсөл боловсруулаад байна. Иймээс Монгол Улсын Худалдааны зохицуулалтын хууль нь ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай гэж үзэж байна. Бусад асуудал 60 орчим хэсэгчилсэн хуулиар зохицуулагдаж байгаа ч хэрэгжилт маш сул байгаа гэж хэлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ИМПОРТЫН БАРААНД ҮЗҮҮЛЭХ ТАРИФЫН БУС ХОРИГ СААДУУД

3.1. Тарифын бус зохицуулалтын онцлог, өнөөгийн нөхцөл байдал, олон улсын туршлага

Хураангуй: Тарифын бус зохицуулалт нь гадаад худалдааг зохицуулах бодлогын чухал арга хэрэгсэл юм. ДХБ-ын бодлого, үйл ажиллагаа, хоёр талт болон олон талт худалдааны хэлэлцээрийн үр дүнд импортын бараанд ногдуулах тарифын хувь хэмжээ буурсан нь тарифын бус арга хэмжээг гадаад худалдааны зохицуулалтын гол арга хэрэгсэл болгон ашиглахад түлхэц үзүүлж байна. Түүнчлэн, тарифын бус зохицуулалтын олон улсын худалдаанд үзүүлж буй нөлөө, сөрөг үр дагаврыг тоон утгаар хэмжиж, үнэлэхэд бэрхшээлтэй, олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулахад төвөгтэй, улс орон бүр харилцан адилгүй зорилго, үндэслэл, шалтгаанаар тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой, түүний гадаад худалдаа эрхлэгчдэд учруулах хүндрэл, саад тотгор нь өндөр тул улс орнууд гадаад худалдааг зохицуулахад, ялангуяа импортыг хязгаарлахад тарифын бус арга хэмжээг өргөнөөр ашиглаж байна.

Дэлхийн улс орнуудад тарифын бус зохицуулалтыг ашиглаж буй байдал, түүнийг илэрхийлэх тоон үзүүлэлтээс⁴³ дүгнэхэд тарифын бус арга хэмжээг гадаад худалдааны зохицуулалтад ашиглах байдал улам бүр нэмэгдсээр байгаа бөгөөд ялангуяа эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага болон худалдаан дахь техникийн зохицуулалтыг түлхүү ашиглаж байна.

Монгол Улс стратегийн хүнс болон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн хүрээнд зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний экспорт, импортод хориг, хязгаарлалт тогтоодгийг эс тооцвол гадаад худалдааг тарифаар голчлон зохицуулж байна. Монгол Улсын хэрэгжүүлж буй тарифын бус зохицуулалтын тоо, хамрах хүрээг дэлхийн бусад улс орны статистиктай харьцуулахад эрс бага буюу хангалтгүй түвшинд байна.

⁴³ Судалгааны ажлын 4.1-ээс үзнэ үү.

Тарифын бус зохицуулалтын олон улсын туршлагаас дүгнэхэд тарифын бус арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах 3 нөхцөл, механизмыг бүрдүүлсэн байх шаардлагатай нь харагдаж байна. Үүнд: (1) холбогдох эрх зүйн зохицуулалт, стандарт, дүрэм журмыг баталж, мөрдүүлэх; (2) тухайн зохицуулалтад тусгагдсан шаардлага, шалгуур хангагдсан эсэхийг баталгаажуулах, хянах чанарын дэд бүтцийг бий болгох, (3) тарифын бус арга хэмжээний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдааг хангах. Судалгааны ажлын хүрээнд энэхүү 3 механизмын өнөөгийн байдлыг үнэлж, хэрхэн сайжруулах талаар санал, зөвлөмж дэвшүүлээ.

Түлхүүр үг: Дэлхийн Худалдааны Байгууллага, гадаад худалдаа, импорт, үндэсний эрх ашиг, гадаад худалдааны зохицуулалт, тарифын бус арга хэмжээ, тарифын бус хориг саад, эрүүл ахуй хорио цээрийн шаардлага, техникийн зохицуулалт, стандарт, лаборатори, барааны чанар гэх мэт.

3.1.1. Тарифын бус зохицуулалт, түүний хамрах хүрээ, ангилал

Тарифын бус зохицуулалт нь гадаад худалдааны барааны нэр төрөл, чанар, тоо хэмжээ, үнэ, урсгал чиглэлд нөлөөлөх, зохицуулах, хязгаарлах зорилгоор төр, засгаас авч хэрэгжүүлж буй өргөн хүрээтэй арга хэмжээг ойлгодог. Дэлхийн улс орнууд үндэсний аюулгүй байдал, хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, хүрээлэн буй орчныг хамгаалах, эдийн засгаа эрчимжүүлэх, үндэсний үйлдвэрээ дэмжих зэрэг олон зорилго, шалтгаанаар тарифын бус зохицуулалтыг ашиглаж байна.

Тарифын бус зохицуулалт нь гадаад худалдааны бодлого, зохицуулалтын чухал хэрэгсэл болсон хэдий ч дэлхийн улс орнуудын хэрэгжүүлж буй тарифын бус зохицуулалтын талаар нэгдсэн тоо баримт, мэдээллийн сангүй, тарифын бус арга хэмжээний хэлбэр төрлүүдийн талаар нэгдмэл ойлголт, ангилалгүй байсан тул НҮБ-ын ХХБХ⁴⁴ үүнд анхаарлаа хандуулж, 1990-д оноос хойш тарифын бус арга хэмжээний талаар судалгаа хийж, статистик гаргаж байна. Тус байгууллагаас тарифын бус арга хэмжээг дараах байдлаар тодорхойлжээ.

“Тарифын бус арга хэмжээнд бүтээгдэхүүний (goods) олон улсын худалдаанд эдийн засгийн нөлөө үзүүлэх, худалдаалж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ, эсвэл үнэ болон тоо хэмжээнд нөлөө үзүүлж буй гаалийн тарифаас бусад бодлогын арга хэмжээг хамруулан ойлгоно⁴⁵.”

НҮБ-ын ХХБХ нь ДХБ, ДБ, ОУХТ, ЭЗХАХБ, НҮБ-ын ХХАБ зэрэг 10 орчим олон улсын байгууллагатай хамтран *тарифын бус арга хэмжээний глобал*

⁴⁴ НҮБ-ийн Худалдаа хөгжлийн бара хурал – United Nations Conference on Trade and Development UNCTAD

⁴⁵ Guideline for the collection of data on official non-tariff measures, UNCTAD 2021 version

мэдээллийн сан TRAINS (<https://trains.unctad.org/>) –г хөгжүүлж, 2020 оны 12 сарын байдлаар энэхүү санд дэлхийн 100 гаруй улсын⁴⁶ хэрэгжүүлж буй 70 мянга гаруй тарифын бус зохицуулалт, арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэсэн байна.

Түүнчлэн тарифын бус арга хэмжээний зорилго, үр нөлөө, онцлогийг харгалзан 16 бүлэгт ангилсан ба үүнд импортыг зохицуулахад чиглэсэн 150, экспортод чиглэсэн 30 арга хэмжээний ангилалыг хүснэгт 15–аас харна уу.

Хүснэгт 15. Тарифын бус арга хэмжээний ангилал

Бүлэг А	Техникийн арга хэмжээ	Эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ /SPS - Sanitary and Phytosanitary measures/ Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор бодисын агууламжийг хязгаарлах, эрүүл ахуйн шаардлага тавих, өвчин тархахаас сэргийлэх арга хэмжээг хамаарна. Мөн сертификатжуулалт, дээжид сорил хийх, хяналт шалгалт, хорио цээр, тохирлын үнэлгээний арга хэмжээ багтана.
Бүлэг В		Худалдаан дахь техникийн саад тотгор /TBT - Technical barriers to trade/ Барааны чанар, техникийн шаардлага, хаяг шошго, хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбоотой стандарт, шалгуур, тэдгээртэй холбоотой сорил, хяналт шалгалт, баталгаажуулалт үүнд хамаарна.
Бүлэг С		Ачилтын өмнөх хяналт шалгалт /Pre-shipment inspection and other formalities/ Ачилтын өмнөх хяналт шалгалт, ачаа барааг тээвэрлэлтэд шилжүүлэхээс өмнө экспортлогч оронд хийж гүйцэтгэх бусад үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмууд үүнд хамаарна.
Бүлэг D	Техникийн бус арга хэмжээ	Худалдааны хамгаалалтын арга хэмжээ /Contingent trade-protective measures/ Импортын бүтээгдэхүүн импортлогч улсын зах зээлд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдол болон гадаад худалдааны шударга бус практикийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ үүнд багтана. Тухайлбал демпингийн эсрэг арга хэмжээ, нөхөн төлөөсийн арга хэмжээ, хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, дүрэм журмыг хамаарна.
Бүлэг E		Автомат бус лиценз, квот, хориг, тоон хязгаарлалтын арга хэмжээ /Non-automatic licensing, quotas, prohibitions and quantity-control measures other than for SPS or TBT reasons/ Бүтээгдэхүүний тоо хэмжээг хязгаарлах зорилго бүхий лиценз, квот, тоо хэмжээний хязгаарлалтын бусад арга хэмжээг хамруулна.
Бүлэг F		Үнийн хяналтын арга хэмжээ /Price-control measure, including additional taxes and charges/ Импортын бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх, үнэд хяналт тавих арга хэмжээг багтаана. Мөн импортын зардлыг тарифтай адил нөлөөллөөр өсгөдөг тарифаас бусад арга хэмжээ багтана.
Бүлэг G		Санхүүгийн арга хэмжээ /Finance measures/ Импортын төлбөр төлөхийг хязгаарлах, валютын ханш, солилцоог зохицуулах, төлбөр тооцооны нөхцөлд хязгаарлалт тогтоох арга хэмжээг

⁴⁶ Европын Холбооны улсуудыг нэг улсад тооцсон.

		хамруулна.
Бүлэг Н		Өрсөлдөөнд нөлөөлөх арга хэмжээ /Measures affecting competition/ Эдийн засгийн оролцогчдод онцгой эрх, давуу тал олгохтой холбоотой арга хэмжээг хамруулна.
Бүлэг I		Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээ /Trade-related investment measures/ Хөрөнгө оруулагчдыг дотоодын орц, материал ашиглах, импортыг орлох, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг шаардах зэрэг арга хэмжээг багтаана.
Бүлэг J		Хуваарилалтын сувгийн хязгаарлалт /Distribution restrictions/ Импортын бүтээгдэхүүний дотоодын хуваарилалт, дистрибьюторын үйл ажиллагаатай холбоотой хязгаарлалтын арга хэмжээг хамаарна.
Бүлэг K		Борлуулалтын дараах үйлчилгээнд тогтоох хязгаарлалт /Restrictions on post-sales services/ Борлуулалтын дараах үйлчилгээнд хязгаарлалт тогтоох арга хэмжээг хамрана.
Бүлэг L		Татаас /Subsidies/ Худалдаанд нөлөөлж буй татаастай холбоотой арга хэмжээг хамарна.
Бүлэг M		Засгийн газрын худалдан авалтад тогтоох хязгаарлалт /Government procurement restrictions/ Засгийн газрын худалдан авалттай холбоотой хязгаарлалтууд багтана.
Бүлэг N		Оюуны өмчийн зохицуулалт /Intellectual property/ Оюуны өмчийн эрх болон оюуны өмчтэй холбоотой хязгаарлалтын арга хэмжээг хамаарна.
Бүлэг O		Гарал үүслийн дүрэм /Rules of Origin/ Бүтээгдэхүүний гарал үүсэлтэй холбоотой гарал үүслийн дүрмийн бүлэг зохицуулалт
Бүлэг P	Экспортын зохицуулалт	Экспорттой холбоотой арга хэмжээ /Export-related measures/ Экспортод нөлөөлөх зорилготой бүлэг арга хэмжээ. Үүнд экспортын татвар, экспортын квот, экспортын хориг зэргийг хамруулна.

Эх үүсвэр: UNCTAD, *International Classification of Non-Tariff measures, 2021 version*

Тарифын бус арга хэмжээнд хамаарах, гадаад худалдааны зохицуулалтын нэг чухал чиглэл нь *тарифын бус хориг саад (non-tariff barriers)* юм. Үүнд “Дотоодын үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд гадаадын өрсөлдөгчтэй харилцуулахад илүү таатай нөхцөл олгох зорилгоор, ялгаварласан байдлаар хэрэгжүүлж буй тарифаас бусад арга хэмжээ”-г хамааруулдаг. Тарифын бус хориг саадыг дотоодын болон гадаадын бүтээгдэхүүн, үйлчилгээнд ялгавартай хандаж, гадаадын бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдааг хязгаарлах зорилгоор хэрэгжүүлдэг тул олон улсын байгууллагууд гадаад худалдаан дахь тарифын бус хориг саадын ашиглалтыг дэмждэггүй.

Түүнчлэн тарифын бус арга хэмжээг үндсэн зорилгоос нь хамааруулан дараах хоёр бүлэгт ангилах боломжтой. Үүнд:


1. Гадаад худалдааг зохицуулах зорилготой арга хэмжээ – Квот, лиценз, татаас, хамгаалалтын арга хэмжээ, экспортын хязгаарлалт зэрэг гадаад худалдааны урсгал, хөдөлгөөнд шууд нөлөөлөх зохицуулалтууд;
2. Гадаад худалдааг зохицуулах зорилгогүй арга хэмжээ – Хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, аюулгүй байдал, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилготой зохицуулалтууд;

ДХБ-ын хэлэлцээрийн дагуу **гадаад худалдааг зохицуулах зорилгогүй** арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй тохиолдолд улс орнууд бие даан хэрэгжүүлэх эрхтэй⁴⁷ байхаар зохицуулсан бол **гадаад худалдааг зохицуулах зорилго** бүхий арга хэмжээг зөвхөн ДХБ-ын хэлэлцээрт заасан нөхцөл, шаардлагын хүрээнд ашиглахыг зөвшөөрдөг⁴⁸.

3.1.2. Дэлхий дахинд тарифын бус зохицуулалтыг ашиглаж буй байдал

ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хэрэгжилт, худалдааг хөнгөвчлөх, чөлөөлөхөд чиглэсэн бүс нутгийн болон хоёр талт хэлэлцээрүүдийн нөлөөгөөр гадаад худалдааг тарифаар зохицуулах боломж хумигдаж, эсрэгээр тарифын бус зохицуулалтын ашиглалт нэмэгдсэн ерөнхий төлөв ажиглагдаж байна.

1994 онд дэлхийн улс орнуудын энгийн дундаж тарифын хувь (simple mean applied tariff) 10,76 хувь байсан бол 2017 онд 5,17 хувь болж 2 дахин буурсаныг зураг 9–өөс харна уу.



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/TM.TAX.MRCH.SM.AR.ZS>

Зураг 9–өөс харахад 2018 оны байдлаар хөгжингүй орнууд импортын бараанд дунджаар 1,5 хувийн тариф ногдуулж байгаа бол Өмнөд Ази,

⁴⁷ ДХБ-ын Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн хэлэлцээр ба бусад хэлэлцээрийн шаардлага.

⁴⁸ ДХБ-ын Татаас болон Саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр ба бусад хэлэлцээрийн шаардлага.

Африкийн (sub-Saharan Africa) орнуудын импортын тариф хамгийн өндөр буюу дунджаар 8,0 орчим хувь байна⁴⁹.


Ийнхүү гадаад худалдааг тарифаар зохицуулах боломж хумигдаж, тарифын хувь хэмжээ буурахын хэрээр тэрхүү орон зайг тарифын бус зохицуулалт эзэлж, зохицуулалтын арга хэлбэр өргөжиж, ашиглалт нэмэгдэж байна.

Тарифын бус зохицуулалтын глобал өгөгдлийн сан TRAINS-д дэлхийн 100 улс орны тарифын бус зохицуулалтын мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд тэрхүү 100 улсын хооронд хийгдэж буй худалдаа дэлхийн нийт худалдааны 90 хувийг бүрдүүлж байгаа юм. Иймд энэхүү өгөгдлийн сангийн мэдээлэлд үндэслэн тарифын бус зохицуулалтын ашиглалтын өнөөгийн байдлыг дүгнэлээ.

2019 оны байдлаар дэлхийн нийт импортын 80 орчим хувь, нийт экспортын 40 гаруй хувь нь тарифын бус зохицуулалтад өртөж байна.

Мөн тарифын бус арга хэмжээний (ТБАХ) зохицуулалтын хүрээнд импортын барааны нэр төрөл тутамд дунджаар 3, экспортын бараанд дунджаар 1,3 тарифын бус арга хэмжээнд хамрагдаж байгааг зураг 10-аас харна уу.

Зураг 10. Дэлхийн худалдааг ТБАХ-ээр зохицуулж буй байдал



сурвалж: WTO, ITC, UNCTAD, World Tariff Profiles 2021. Special topic: Non-Tariff measures.


Тарифын бус зохицуулалтыг хөгжингүй орнууд илүү түлхүү ашиглаж байна. Тэд нэг нэр төрлийн бараанд дунджаар 4 ТБАХ, харин хөгжиж буй болон хөгжил буурай орнууд тус бүр 2-3 арга хэмжээ ногдуулж байна.

Зураг 10-аас харахад барааны нэр төрлөөр авч үзвэл, хүнсний бүх төрлийн барааны импорт тарифын бус зохицуулалтад хамгийн их өртөж, дунджаар 12 ТБАХ-ээр зохицуулагдаж байгаа бол химийн бүтээгдэхүүн, нэхмэл

⁴⁹ Key Statistics and Trends in Trade Policy 2019, UNCTAD

сүлжмэл, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, арьс ширэн бүтээгдэхүүн зохицуулалт ихтэй салбарт тооцогдож байна.


Зураг 11. Барааны импортыг ТБАХ-ээр зохицуулж буй байдал, барааны нэр төрлөөр



Эх сурвалж: WTO, ITC, UNCTAD, World Tariff Profiles 2021. Special topic: Non-Tariff measures.


Дэлхийн улс орнууд худалдаан дахь техникийн хориг саадыг импортын бараанд хамгийн түгээмэл ашигладаг бөгөөд энэ төрлийн зохицуулалт нь дэлхийн нийт импортын 70 гаруй хувийг хамарч, нэг нэр төрлийн бараанд дунджаар 3 оногдож байна. Харин эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг нэг төрлийн бараанд хамгийн олон тоогоор буюу дунджаар 6 арга хэмжээгээр зохицуулж байна. Түүнчлэн дэлхийн импортын дөрөвний нэг нь лиценз, квот, бусад хэлбэрийн тоо хэмжээний хязгаарлалтад өртдөг ба энэ нь нийт импортын үнийн дүнгийн тал хувьд хамаарч байна.

Зураг 12. Барааны импортыг ТБАХ-ээр зохицуулж буй байдал, ТБАХ-ний ангиллаар



Эх сурвалж: WTO, ITC, UNCTAD, World Tariff Profiles 2021. Special topic: Non-Tariff measures.

ТБАХ-ний хамгийн түгээмэл ашиглагддаг хэлбэр болох эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн шаардлага (цаашид SPS гэх) болон худалдаан дахь техникийн саад тотгор (цаашид TBT гэх)-ын ашиглалт сүүлийн жилүүдэд хэрхэн өсөн нэмэгдэж буйг зураг 13-аас харна уу.



Эх сурвалж: <http://i-tip.wto.org/goods/Forms/GraphView.aspx?period=y&scale=lg>

2008 онд дэлхийн улс орнууд 587 SPS, 1235 TBT арга хэмжээг шинээр хэрэгжүүлж эхлэхээр ДХБ мэдүүлж⁵⁰ байсан бол 2019 онд энэ тоо харгалзан 1224 ба 1986 болж, 50-60 хувиар өсжээ. 2020 оны 7 сар хүртэлх хугацаанд дэлхийн хэмжээнд нийт 16489 SPS арга хэмжээг хэрэгжүүлэхээр санаачилж,

⁵⁰ ДХБ-ын гишүүн орнууд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тарифын бус арга хэмжээг ДХБ-д мэдүүлэх үүрэгтэй байдаг.

тэдгээрээс 3494 арга хэмжээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бол 25776 ТВТ арга хэмжээг хэрэгжүүлэхээр санаачилж, 3045 арга хэмжээ хүчин төгөлдөр үйлчилж байна⁵¹.

Дээрх тоо баримтууд болон ТБАХ-ний талаар хийгдсэн бусад судалгааны тайланд⁵² үндэслэн ТБАХ-ний ашиглалтыг доорх байдлаар дүгнэх боломжтой байна. Үүнд:

- Дэлхийн улс орнууд ТВТ арга хэмжээг хамгийн өргөн ашиглаж байна. Дэлхийн нийт импортын 70 гаруй хувь, худалдаалагдаж буй барааны нэр төрлийн 40 орчим хувь нь энэ төрлийн зохицуулалтад өртдөг. Хоёрдугаарт SPS арга хэмжээ эрэмбэлэгдэж, дэлхийн нийт худалдааны 15 орчим хувьд энэ төрлийн шаардлага тавигдаж байна.
- Хөгжингүй орнууд эдийн засгийн чадамж, амьжиргааны түвшин, техник, технологийн хүчин чадалдаа тулгуурлан SPS, ТВТ-ын өндөр шалгуур тогтоож байгаа нь техник технологи, мэдлэг, ур чадварын түвшингээр хоцрогдмол хөгжиж буй орнуудын худалдаанд саад тотгор учруулж байна.
- Улс орнууд SPS, ТВТ арга хэмжээг хэрэгжүүлэхдээ олон талт хүрээнд хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнээс илүү хатуу шаардлага тавих практик түгээмэл байна. Түүнчлэн тухайн улсын хэрэгжүүлж буй ТБАХ нь протекционист зорилго агуулаагүй ч тэрхүү өндөр шалгуурыг нь хангаж чадахгүйгээс хөгжиж буй болон буурай орны импортын бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрч чадахгүйд хүрч байна. Ялангуяа үйлдвэржилтийн түвшин доогуур, бүтээгдэхүүний чанар, стандарт, баталгаажуулалтын тогтолцоо сайн хөгжөөгүй улс орнуудын экспортод сөрөг нөлөө үзүүлж байна.
- SPS, ТВТ арга хэмжээг үндэслэл, тооцоогүйгээр хэрэгжүүлэх нь импортод төдийгүй үндэсний үйлдвэрлэл, цаашилбал тухайн улсын өрсөлдөх чадварт сөрөг нөлөө учруулах магадлалтай юм. Учир нь олон төрлийн SPS, ТВТ зохицуулалтын улмаас гадаад худалдааны эргэлт саарч, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал татрах, улмаар харьцангуй давуу талыг сулруулах эрсдэл үүсдэг байна.
- ТБАХ-ний нэг хэлбэр болох ачилтын өмнөх хяналт шалгалт нь тээвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарыг баталгаажуулах замаар олон улсын худалдааг хөнгөвчлөх давуу талтай ч энэ процесс нь худалдааны зардлыг өсгөдөг тул тарифын бус арга хэмжээнд тооцдог. Ачилтын өмнөх хяналт шалгалтад дэлхийн нийт худалдааны болон худалдаалж буй барааны нэр төрлийн 20 орчим хувь өртөж байна.
- Дэлхийн нийт худалдааны 23 хувь, бүтээгдэхүүний нэр төрлийн 18 хувьд хамаарах тоо хэмжээний хязгаарлалтыг квот, экспортын сайн дурын

⁵¹ <http://i-tip.wto.org/goods/Forms/GraphView.aspx?period=y&scale=lg>

⁵² Non-Tariff Measures to Trade: Economic and Policy Issues for Developing Countries, UNCTAD, 2013

хязгаарлалт, автомат бус лицензийн хэлбэрээр түлхүү хэрэгжүүлж байна.

- Нийт худалдааны 20 гаруй хувь, бүтээгдэхүүний нэр төрлийн 16 хувийг *үнийн хяналтаар* зохицуулж байгаа бөгөөд үнийн хяналтыг ихэвчлэн демпингийн эсрэг болон нөхөн төлөөсийн татвар хэлбэрээр, мөн хүнсний бүтээгдэхүүн (стратегийн хүнс), эрчим хүч, улс төр, эдийн засгийн мэдрэмтгий бүтээгдэхүүнд ноогдуулж байна.
- Тарифын бус арга хэмжээний ашиглалтаар хөгжингүй орнууд тэргүүлж байна. Ази, Латин Америкийн орнуудад тоо хэмжээний хязгаарлалт, лицензийг, Африкийн орнуудад импортын төрөл бүрийн зохицуулалтыг түлхүү ашиглаж байна.
- Тарифын бус арга хэмжээний ашиглалт эдийн засгийн салбаруудад харилцан адилгүй байна. Хамгийн их *зохицуулалттай салбар* нь ХАА, хөнгөн үйлдвэр, тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл бол байгаль орчинд хор хөнөөл ихтэй эрдэс бүтээгдэхүүний салбар тарифын бус зохицуулалтад *хамгийн бага* өртөж байна.
- ХАА салбар, ялангуяа амьтны гаралтай бүтээгдэхүүний худалдаанд SPS зохицуулалт хамгийн түгээмэл ашиглагддаг. Хэрэглэгчийн эрх ашиг, эрүүл ахуй, хүрээлэн буй орчныг хамгаалах шалтгааны улмаас хүнсний бүтээгдэхүүний 60 гаруй хувь нь хамгийн багадаа нэг SPS арга хэмжээгээр зохицуулж байна.
- ТВТ зохицуулалтыг маш олон нэр төрлийн бүтээгдэхүүнд, ялангуяа нэхмэл сүлжмэл, гутал, боловсруулсан хүнс, химийн бүтээгдэхүүнд түлхүү ашиглаж, нэг нэр төрлийн бүтээгдэхүүнд хэд хэдэн ТВТ шалгуур тавигдаж байна.
- Хамгаалалтын арга хэмжээний онцлогоос хамааран тухайн төрлийн зохицуулалтыг ашиглах тохиолдол харьцангуй цөөн бөгөөд бүтээгдэхүүний нэр төрөл ч явцуу байна
- Тоо хэмжээний зохицуулалтыг амьтны гаралтай бүтээгдэхүүн, моторт тээврийн хэрэгсэл, химийн бүтээгдэхүүнд илүү их ашиглаж байна.
- Тарифын бус арга хэмжээг, ялангуяа SPS, ТВТ арга хэмжээг *эдийн засгийн бус зорилгоор*, бүтээгдэхүүнд тавих техникийн шаардлага талаас нь түлхүү ашиглаж байна.
- Хоёр өөр улс нэгэн адил тарифын бус арга хэмжээг, нэг адил бүтээгдэхүүнд ноогдуулахад гарах үр дагавар нь ялгаатай байна. Үүнд тэдгээр улс орны эдийн засгийн хүчин чадал, үйлдвэрлэлийн төрөлжилт, өрсөлдөөний нөхцөл байдал зэрэг эдийн засгийн хүчин зүйлсээс гадна тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, ур чадвар, хүчин чармайлт нөлөөлж байна.

3.1.3. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлж буй зарим орны туршлага

Тарифын бус арга хэмжээг ашиглан импортыг зохицуулж, хязгаарлаж буй туршлагыг БНХАУ болон ОХУ-ын жишээгээр авч үзлээ⁵³. Мөн КОВИД19 цар тахлын үеийн тарифын бус арга хэмжээний ашиглалтын талаар судалж үзлээ⁵⁴.

БНХАУ-ын хэрэгжүүлж буй зарим ТБАХ: БНХАУ нь дэлхийн эдийн засаг, худалдаанд голлох байр суурьтай, томоохон үйлдвэрлэгч улс тул ТБАХ-ний олон хэлбэр, төрлийг ашиглан импортыг зохицуулж, хязгаарлаж байна. Үүнд:

- *Үйлдвэрлэлийг дэмжих бодлого*: 2015-2025 онд үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 жилийн төлөвлөгөө баталж, стратегийн 10 салбарыг тодорхойлсон. Хөтөлбөрийн зорилго нь эдгээр салбар дахь гадаадын бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологиор солих, улмаар тэдгээр салбарын олон улсын зах зээлд тэргүүлэгч болоход чиглэсэн. Үүний тулд татаас олгох, төрийн худалдан авалтаар дэмжих, зах зээлийн эрэлтээс давсан илүүдэл үйлдвэрлэл явуулах боломж олгох, гадаадын технологийг дотоодын компанид шилжүүлэх шахалт үзүүлэх, тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах, лиценз авахыг шаардах зэрэг олон арга замаар гадаадын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хязгаарлах, ялгавартай хандах, тэдний давуу талыг саармагжуулах бодлогыг хэрэгжүүлж байна.
- *Стандарт*: Хятад улс стандартын шинэчлэл, стандартын бодлогодоо ихээхэн анхаарч байна. Шинэчлэн баталсан Стандартын тухай хууль 2018 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус хуульд орсон өөрчлөлтийн дагуу олон улсын стандартыг нутагшуулах бодлого баримтлахын зэрэгцээ Хятад улсын үндэсний стандарт боловсруулахад гадаадын компаниуд оролцох боломжийг олгосон. Гэвч олон улсын хэмжээнд мөрдөж хэвшсэн олон улсын стандартыг бус дотоодын стандартаа баримтлах, стандарт боловсруулах, батлах үйл явцад гадаадын компаниуд оролцох нөхцөлийг бүрдүүлэхгүй байх зэргээр хэрэгжилтийн явцад хүндрэл үүсгэж байна. 2019 оны “Хятадын стандартчиллын тайлан”-д⁵⁵ дурдсанаар тус улс 2019 онд 2021 үндэсний стандарт, 4880 үйлдвэрлэлийн стандарт, 7238 орон нутгийн стандарт, 6227 нийгмийн холбоодын стандартыг шинээр баталж, 55962 аж ахуйн нэгж 370000 гаруй стандартаа бүртгүүлсэн байна⁵⁶. Ингэснээр нийт үндэсний стандартын тоо 38347 болсон ба үүний 2131 нь

⁵³ Ашигласан эх сурвалж: US Trade Representative, 2021 National Trade Estimate Report on Foreign Trade Barriers

⁵⁴ Ашигласан эх сурвалж: UNCTAD, COVID-19 Non-Tariff Measures: The Good and the Bad, through a Sustainable Development Lens, 2021/3

⁵⁵ Annual Report on China's Standardization Development, 2019

⁵⁶ <https://www.qualityandcertification.com/2020/the-full-text-of-china-standardization-development-annual-report-2019-is-here/>

заавал мөрдөх стандарт байв. Мөн нийт үйлдвэрийн стандартын тоо 65,998, орон нутгийн стандартын тоо 42881-д хүрчээ. 2019 онд үндэсний хэмжээний 41 стандартын техникийн хороо шинээр байгуулагдаж, улсын хэмжээнд 1324 мэргэшсэн стандартын техникийн хороо ажиллаж байна.

- *Дахин үйлдвэрлэсэн (remanufactured product) барааны импортын хориг.* БНХАУ дахин үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглээнд болон үйлдвэрлэлийн орц, эд анги болгон ашиглах зорилгоор импортлохыг хориглосон. Энэхүү зохицуулалтын улмаас уул уурхай, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, тээвэр, харилцаа холбооны салбарт ашиглагддаг байсан хямд өртөгтэй боловч боломжийн чанартай барааны импорт хумигджээ.
- Дахин боловсруулсан хог хаягдлын импортын хориг. Тус улс 2017 оноос цаас, хуванцар, металлын хаягдал болон тэдгээрийг дахин боловсруулсан материалыг олон улсын стандартын шаардлага хангахгүй гэсэн үндэслэлээр импортлохыг хязгаарлаж, импортын лиценз, хяналт шалгалттай болгосон боловч дотооддоо худалдаалагдаж буй энэ төрлийн хог, хаягдалд хяналт, зохицуулалт хийдэггүй.

2020 онд БНХАУ-ын Экологи, Хүрээлэн буй орчны яамнаас дахин боловсруулсан хог, хаягдлын худалдааны талаар баримтлах дүрэм журмаа улам чангатгахаа зарласан. Тухайлбал 2021 оноос стандартын шаардлага хангах хэмжээнд дахин боловсруулсан зэс, хөнгөн цагаан, гуулийн хаягдал, мөн хаягдал хуванцрын бөмбөлөг, хаягдал цаасны шахмалаас бусад бүх төрлийн боловсруулаагүй хаягдал, материалын импортыг зогсоохоо мэдэгдсэн.

2020 оны 9 сард Хатуу хог хаягдлын хуулийг⁵⁷ шинээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хуульд хатуу хог хаягдлын импортыг тэглэх заалт оруулсан. Гэвч хатуу хог хаягдлын талаарх тодорхойлолт, хамрах хүрээ, заалтыг хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхой заагаагүй байна.

- *Зах зээлээ хамгаалах арга хэмжээ.* Хятад улс 2021 оны 3 сарын байдлаар 16 улсын бүтээгдэхүүнд 111 демпингийн эсрэг арга хэмжээ, 4 улсын импортод 6 нөхөн төлөөсийн арга хэмжээг хэрэгжүүлж, демпингийн эсрэг 7, нөхөн төлөөсийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр мөрдөн шалгалтын үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн тус улс демпингийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ДХБ-ын хэлэлцээрийн ил тод, шударга байх суурь зарчмыг биелүүлдэггүй гэсэн шүүмжлэлд өртдөг.

БНХАУ дээрх зохицуулалтуудаас гадна импортыг хориглох, хязгаарлахад чиглэсэн олон төрлийн арга хэмжээ хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр зохицуулалтын шаардлага нь шинжлэх ухааны үндэслэл муутай, хэт хатуу чанга, хэрэгжилтийн байдал нь ойлгомжгүй, тодорхой бус, хүнд сурталтай байдаг нь импортод хүндрэл учруулж, саад тотгор болдог.

⁵⁷ Solid Waste Law

ОХУ-ын хэрэгжүүлж буй зарим ТБАХ: ОХУ нь тарифын бус зохицуулалтыг өргөн хүрээтэй ашигладаг бөгөөд ЕАЭЗХ-ны гишүүн орон юм.

- *Импортын хориг.* ОХУ нь 2014 онд Австрали, Канад, ЕХ-ны орнууд, Норвеги, АНУ-аас гаралтай хүнс, хөдөө аж ахуйн тодорхой нэр төрлийн бараанд (*үхэр, гахай, шувууны мах, загас ба далайн бүтээгдэхүүн, жимс, самар, ногоо, зарим төрлийн хиам, ихэнх боловсруулсан хүнс*) нэг жилийн хугацаатай импортын хориг тавьсан юм. Улмаар энэхүү хоригт хамаарах улс орны жагсаалтад Албани, Исланд, Лихтенштэйн, Монтинегро, Украин, Их Британи улсыг нэмж, хоригт хамаарах барааны жагсаалтыг шинэчилсний зэрэгцээ үйлчлэх хугацааг 2021 оны 12 сарын 31 хүртэл сунгажээ.

Мөн 2018 оны 12 сараас Украин улстай хийх экспорт, импортын бараанд өргөн хүрээтэй хориг тавьсан. Энэхүү хоригт зөвхөн Украин улсаас гаралтай төдийгүй тус улсаар дамжин тээвэрлэгдсэн барааг хамруулсан. 2018 оны 12 сараас хойш хоригт хамаарах барааны жагсаалтад 8 удаа нэмэлт оруулж, 2021 оны 3 сарын байдлаар импортын хоригт БТКУС-ын 92 кодын бараа, экспортын хоригт 14 кодын барааг хамруулсан байна.

- *Импортын лиценз.* Олон нэр төрлийн бараанд (*эм, эмийн бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, нойрсуулах бодис, цөмийн бодис, аюултай хог хаягдал, зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүн гэхмэт*) импортын лиценз шаардахын зэрэгцээ импортын бүтээгдэхүүнийг бөөнөөр худалдаалах, үйлдвэрлэлд ашиглах, хадгалах, түгээхэд үйл ажиллагааны лиценз авсан байхыг шаарддаг нь давхар хүндрэл учруулдаг. Тухайлбал, архи согтууруулах ундаа импортлогч импортын лицензийн зэрэгцээ хадгалах ба түгээх үйл ажиллагаа эрхлэх лиценз авах шаардлагатай болдог.

Тус улс ДХБ-д элссэнээс хойш лицензийн дүрэм, журмаа хялбарчилсан боловч лиценз олгох үйл явц нь ойлгомжгүй, хүнд сурталтай, хүндрэл бэрхшээлтэйд тооцогддог. Импортын лицензийг зохицуулах дүрэм журам нь ЕАЭЗХ-ны орнуудад нэгэн адил боловч гишүүн улс тус бүрт ялгаатай байдлаар хэрэгжүүлдэг.

- *Импортыг орлуулах бодлого:* Хөдөө аж ахуй, тээврийн хэрэгсэл, теле харилцаа холбоо, хэрэглээний бүтээгдэхүүн, нэхмэл сүлжмэл, шилэн кабел, батлан хамгаалах, газрын тос, байгалийн хий, нар, салхины эрчим хүч, программ хангамж, эмнэлгийн төхөөрөмж зэрэг хэд хэдэн салбарт үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих бодлого баримталж, тэрхүү дэмжлэгээ голчлон төрийн худалдан авалтаар дамжуулан хэрэгжүүлж байна. Өмнө нь зөвхөн төрийн байгууллагууд дотоодын бараа, үйлчилгээг худалдан авах бодлого баримталдаг байсан бол 2015 оноос төрийн өмчийн компаниудыг ийм бодлого баримтлахыг шаардах болжээ.
- *SPS арга хэмжээ.* Төрөл бүрийн махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, мал, амьтны тэжээл зэрэг хүнс, ургамлын гаралтай олон

нэр төрлийн бүтээгдэхүүнд эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага тавьдаг. Ингэхдээ хүнсний бүтээгдэхүүн, тэжээлд агуулагдах зарим бодисын агууламжийг “0” түвшинд байлгахыг шаарддаг нь бодисын үлдэгдлийн дээд хязгаарыг тогтоосон олон улсын стандартаас (Codex) илүү чанга, хатуу шаардлага болж, импортыг хязгаарлах нөлөө үзүүлдэг. Ийнхүү олон улсын стандартаас давсан хатуу шаардлага тавихын зэрэгцээ экспортлогч улсад амьтны гаралтай халдварт өвчин гараагүйг батлах гэрчилгээтэй байх, боловсруулалт хийж эрсдэл үүсгэх магадлал нь багассан ургамлын гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлэг, хорио цээрийн сертификат шаардах, зөвхөн ЕАЭЗХ-ны бүх гишүүн орнууд зөвшөөрч баталсан жагсаалтад орсон лабораторийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, эсвэл заавал дотоодын лаборатори, хяналт шалгалтын байгууллагын дүгнэлттэй байхыг шаардах зэргээр эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх шатанд олон хүнд суртал үүсгэдэг. Мөн аливаа зохицуулалт нь урьдчилан харах боломжгүй, ил тод бус байдаг.

- *ТВТ арга хэмжээ:* Харилцаа холбооны тоног төхөөрөмж, газрын тос, байгалийн хийн тоног төхөөрөмж, барилгын материал болон барилгын тоног төхөөрөмж, мал эмнэлэг, биологийн бэлдмэл, төрөл бүрийн вакцин зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүнд тусгай зөвшөөрөл, лабораторийн дүгнэлт, сертификат шаарддаг. Түүнчлэн зөвшөөрөл олгоход шаардагдах зарим баримт бичгийг зөвхөн ОХУ-ын аж ахуйн нэгж, байнгын оршин суугчид олгодог, тухайн чиглэлээр мэргэшсэн гадаадын байгууллагын дүгнэлт, сертификатыг хүлээн зөвшөөрдөггүй зэргээр экспортлогчдод зардал, чирэгдэл учруулдаг нь худалдааны зардлыг нэмэгдүүлдэг. Мөн техникийн зохицуулалтын талаарх мэдээлэл нь нээлттэй, ил тод байдаггүй.
- *Хаяг шошго, ул мөр мөшгөх зохицуулалт.* 2019 оноос барааны хаяглалтад дотроо мэдээлэл агуулсан шошго, код (barcode, QR code гэхмэт) ашиглах шаардлага тавьж эхэлсэн ба цаашид импортын болон дотоодын үйлдвэрлэлийн бүх бараанд энэ зохицуулалтыг мөрдөхөөр зорьж байна. Тухайн код нь үйлдвэрээс, эсвэл импортолсон үеэс эцсийн борлуулалтын цэг хүртэл ямар шат дамжлага дамжсан тухай мэдээллийг агуулж, ул мөр мөшгөх нөхцлийг бүрдүүлэх юм. Эхний ээлжинд эм эмийн бүтээгдэхүүн, гутал хувцас, үнэртэн гоо сайхан зэрэг хэд хэдэн салбарт мөрдөх ба 2024 оноос бүх төрлийн бараанд ийм шаардлага тавих юм. Ингэснээр хуурамч бүтээгдэхүүнтэй тэмцэх, татвараас зайлсхийх нөхцлийг хаана гэж тооцжээ. Тухайн кодыг ОХУ-ын аж ахуйн нэгжүүдэд олгох тул гадаадын үйлдвэрлэгч, импортлогчид дотоодын аж ахуйн нэгжтэй түншлэх шаардлагатайн зэрэгцээ код авахын тулд барааны талаарх бүхий л нарийвчилсан мэдээллийг оператор компанид шилжүүлэх шаардлага


тавигдана. Энэ зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацаа давчуу, үйл ажиллагааны нарийвчилсан удирдамжгүй, бүтээгдэхүүний талаарх нууц мэдээлэл алдагдах эрсдэлтэй, гадаадын аж ахуйн нэгжүүд код авахад хүндрэлтэй, ул мөр мөшгөх хуучин зохицуулалттай давхардсан зэрэг нь импортыг хязгаарлах нөлөө үзүүлж байгааг импортлогчид онцолжээ.

Ковидын нөхцөл байдал ба ТБАХ

Дэлхий дахинд дэгдсэн КОВИД19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг, гадаад худалдааны урсгал саатаж, нөхцөл байдалтай уялдуулан улс орнууд гадаад худалдааны бодлого, зохицуулалтаа өөрчилсөн байна.

2020 оны 8 дугаар сарын байдлаар дэлхийн 140 гаруй улс цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд зориулж 384 худалдааны бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсний 101 нь тарифын, 283 нь тарифын бус арга хэмжээ байв.

Тарифын арга хэмжээний дийлэнх нь тарифын бууруулах, цуцлах зэргээр тодорхой нэрийн барааны импортыг дэмжихэд чиглэсэн бол тарифын бус арга хэмжээг экспортын урсгалыг сааруулах, тодорхой нэрийн барааны импортыг хязгаарлах зорилгоор түлхүү ашиглажээ.



Эх сурвалж: UNCTAD, COVID-19 Non-Tariff Measures, 2021

Ковид 19-ын нөхцөл байдалтай уялдуулан эм, эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортын зохицуулалтыг хялбарчлах, тухайлбал тухайн төрлийн бараанд хамаарах SPS, TBT арга хэмжээ, импортын квот, лицензийг түр цуцлах, хил гаалийн хяналт, шалгалт, горимыг хөнгөвчлөх, нөгөө талаар өвчин, халдвар хил дамнан орж ирэхээс сэргийлж, амьтан, ургамлын гаралтай хүнсний

бүтээгдэхүүнд тавих SPS, TBT зохицуулалтыг чангатгах, хориглох, ачилтын өмнөх хяналт шалгалтад хамрагдсан байхыг шаардах, мөн хүнс, өргөн хэрэглээ, үндэсний аюулгүй байдалд нөлөөтэй бүтээгдэхүүний дотоодын нөөц, хангамжийг тасалдуулахгүй байх, эдийн засгийн өсөлт, эрчимжилтийг хангах зорилгоор экспорт, импортын хориг тогтоох, төрөл бүрийн төлбөр, хураамжаас түр чөлөөлөх зэргээр тарифын бус арга хэмжээг өргөн хүрээтэй хэрэгжүүлсэн байна. Эндээс дүгнэхэд ТБАХ нь гадаад худалдааны бодлогод төдийгүй гэнэтийн, онцгой нөхцөл байдлын үеийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх гол хэрэгсэл болдог нь харагдаж байна.

3.1.4. Тарифын бус зохицуулалтын онцлог, ашиглалтад нөлөөлөх хүчин зүйл, олон улсын байгууллагуудын баримталж буй зарчим

Дэлхийн улс орнууд тарифын бус зохицуулалтыг өргөн хүрээтэй ашиглах болсон нь дараах хүчин зүйлсээс шалтгаалж байна. Үүнд:

1. ТБАХ нь харилцан адилгүй олон хэлбэр, арга замтай бөгөөд тэдгээрийг олон улсын гэрээ, хэлэлцээрээр нэгбүрчлэн зохицуулах боломжгүй. Энэ нь улс орнууд өөр өөрсдийн ашиг сонирхлоор ТБАХ-г хэрэгжүүлэх боломжийг олгож байна.
2. Гаалийн тарифын гадаад худалдаа, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг статистик, тоо баримтад үндэслэн бодитоор тооцож, улмаар тарифыг тодорхой үе шаттайгаар бууруулахыг шаардах зэргээр зохицуулалт хийж болдог бол тарифын бус арга хэмжээний ашиглалтыг ийм байдлаар зохицуулах боломж бага юм.
3. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилго, шалтгаан, зохицуулалтын шаардлага, шалгуур нь улс орон бүрийн нөхцөл байдлаас хамаарч ялгаатай байхын зэрэгцээ хэрэгжилтийн үр нөлөө ч харилцан адилгүй байх тул улс орнуудын хэрэгжүүлж буй ТБАХ-г харьцуулан дүгнэх, нэгдсэн байдлаар зохицуулах, ашиглалтыг нь хязгаарлах боломжгүй.
4. Тарифын бус зохицуулалтыг зөвхөн гаалийн хил дээр бус үнэ цэнийн гинжин хэлхээний бүхий л үе шатанд хэрэгжүүлэх боломжтой тул олон улсын түвшинд зохицуулах боломж хомс юм.

Түүнчлэн тарифын бус зохицуулалт нь тухайн улс орны дотоодод мөрдөгдөх аль нэг эрх зүйн зохицуулалт, хууль, дүрэм, журам, стандарт, техникийн зохицуулалтын зүйл, заалтад тусгагдаж, “нуугдмал” байдлаар хэрэгжих боломжтой нь ТБАХ-ний ашиглалтыг нэмэгдүүлэх өөр нэг шалтгаан болдог.

Тарифын бус зохицуулалтад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

1. *Эдийн засгийн чадавх, хүн амын худалдан авах чадвар* - Эдийн засгийн чадавх, хүн амын худалдан авах чадвар сайжрахын хэрээр хэрэглэгчдийн зүгээс бүтээгдэхүүний сонголт, түүнд тавих шалгуураа

өндөрсгөдөг бол нийлүүлэлт талаас худалдан авах чадвар өндөртэй зах зээлд нэвтрэх сонирхол, өрсөлдөөн үүсч, тэр хэрээр бүтээгдэхүүнийхээ чанарт анхаардаг. Үүний улмаас хөгжингүй орнууд SPS, TBT зохицуулалтаа чангатгах, илүү хатуу шаардлага тавих нөхцөл бүрддэг.

2. *Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх бүтэц, удирдлага менежментийн тогтолцоо* - Тарифын бус зохицуулалт нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх олон байгууллагын оролцоотой хэрэгждэг тул тэдгээрийг нэгтгэн удирдах, үйл ажиллагааг уялдуулах бүтэц, институци шаардлагатай. Тэрхүү бүтэц нь зохицуулалт шаардлагатай буюу эрсдэлтэй бүтээгдэхүүнийг хянан анхааруулах систем бий болгох, түүнд үндэслэн зохицуулах барааны нэр төрлийг тодорхойлох, ТБАХ-ний нөлөөллийн үнэлгээ хийх, хэрэгжүүлэх арга хэмжээг сонгох, хүрэх үр дүнг тодорхойлох, холбогдох дүрэм, журмыг боловсруулах зэрэг олон талын үүрэг гүйцэтгэдэг.

3. *Шинжлэх ухаан, техник, технологийн хүчин чадал* – Хөгжингүй орнууд шинжлэх ухааны ололт амжилтын үр дүнд бүтээгдэхүүний физик, химийн шинж чанар, агуулагдах бодис, найрлагыг маш өндөр түвшинд тодорхойлох арга технологийг нээн эзэмшиж байна. Үүний үр дүнд хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага, бүтээгдэхүүнд тавих техникийн нөхцөлийг улам нарийвчлан тодорхойлж, барааны сорил, шинжилгээг өндөр хүчин чадалтай лаборатори, тоног төхөөрөмжөөр хийж байгаа нь тарифын бус зохицуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэх боломж, давуу нөхцөлийг олгож байна.

Харин хөгжиж буй болон хөгжил буурай орнууд хүний нөөц, техник, технологийн хүчин чадал хязгаарлагдмал, тарифын бус зохицуулалтын бодлого, шийдвэр нь тодорхойгүй бус, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаагүй, хоорондоо өрсөлдөөнтэй, зөрчилтэй байдаг нь тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Улс орнууд тарифын бус арга хэмжээг олон хэлбэр төрлөөр, харилцан адилгүй зорилго, шалтгаанаар, өргөн цар хүрээг хамруулан ашиглаж байгааг шууд зохицуулсан олон улсын механизм хараахан бий болоогүй ч ДХБ, НҮБ-ын ХХБХ зэрэг олон улсын байгууллагууд ТБАХ-г хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлахыг зөвлөсөн байна.

ДХБ-аас тарифын бус зохицуулалтын талаар баримталж буй зарчим

Өнөөгийн глобал худалдааны тоглоомын дүрмийг тодорхойлогч ДХБ нь чөлөөт худалдааны зарчмыг эрхэмлэж, олон улсын худалдаанд саад тотгор учруулах, гажуудуулах аливаа нөлөөллийг арилгах, хамгийн бага түвшинд хүргэхийг зорьдог. Тийм ч учраас тарифын бус зохицуулалтын зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг хүлээн зөвшөөрөх боловч түүнийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлахыг шаарддаг. Үүнд:

1. Аливаа зохицуулалт, зохицуулалтын шаардлага нь шинжлэх ухааны үндэстэй байх;
2. Тарифын бус зохицуулалт нь худалдааг гажуудуулах, худалдааны зардлыг өсгөх зорилгогүй байх;
3. Тарифын бус зохицуулалтын талаарх мэдээллийг ДХБ болон худалдааны түнш орнуудад нээлттэй хүргэх, тэрхүү мэдээллийг олж авах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байх буюу мэдээллийн ил тод байдлыг хангах;
4. Тарифын бус зохицуулалтыг ялгаварлан гадуурхсан байдлаар хэрэгжүүлэхгүй байх. Өөрөөр хэлбэл аль нэг улс орон, үйлдвэрлэгч, эсвэл бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр ялгавартай хандаж болохгүй;
5. Тарифын бус зохицуулалт зохих үр дүнд хүрч, зорилгоо биелүүлсэн бол зохицуулалтын шаардлагыг суллах, үйлчлэлийг цуцлах ёстой.

Дээрх зарчмын зэрэгцээ зарим тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэхдээ олон талт хэлэлцээрийн хүрээнд хүлээн зөвшөөрч, тохиролцсон хэм хэмжээ, нөхцөл шаардлагыг баримтлахыг шаарддаг.

ДХБ-ын гишүүн орнууд аливаа тарифын бус зохицуулалтыг шинээр нэвтрүүлэхийн тулд зохих үндэслэл, зайлшгүй хэрэгцээг тодорхойлсон нотолгоо, бичиг баримтыг ДХБ-д хүргүүлж, хянуулдаг. ДХБ-ын холбогдох алба, нэгж хүсэлтийг хянан үзэж, ДХБ-ын зарчимд харшлаагүй тохиолдолд ашиглахыг зөвшөөрөх механизм үйлчилж байна. Хэдийгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтын хувь хэмжээ нь хэрэгжүүлэхээр санаачилсан арга хэмжээний тоотой харьцуулахад харьцангуй бага байгаа ч хэрэгжүүлэхээр төлөвлөж, санаачилсан арга хэмжээний тоо тогтмол өссөөр байгаа нь анхаарал татаж байна.

ДХБ-ын гишүүн улс орнууд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТБАХ-ний талаар ийнхүү ДХБ-д мэдэгдэж, хянуулах үүрэгтэй ч онцгой тохиолдолд шууд хэрэгжүүлэх уян хатан боломжийг олгодог. ДХБ-ын зарим хэлэлцээрийн дагуу хойшлуулшгүй нөхцөл үүссэн тохиолдолд ТБАХ-г ДХБ-аар хянуулж, зөвшөөрөл авахгүйгээр шууд хэрэгжүүлэх боломжтой юм.

Эдгээр нөхцөл байдлаас дүгнэвэл ДХБ нь тарифын бус арга хэмжээг гадаад худалдаанд аль болох саад тотгор учруулахгүй, худалдааг гажуудуулахгүй байх нөхцөлөөр ашиглахыг шаардаж байна.

НҮБ-ын ХХБХ-ын зөвлөмж, сайн туршлага

Глобал худалдаа, бизнесийн орчин, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр идэвхтэй ажилладаг өөр нэг байгууллага бол НҮБ-ын ХХБХ юм. Тус байгууллага ДХБ-ын баримталж буй бодлого, зарчмыг дэмжихийн зэрэгцээ тарифын бус зохицуулалтыг зохих ёсоор, үр дүнтэй хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагыг судалж, дараах сайн туршлагыг нэвтрүүлэхийг зөвлөжээ. Үүнд:

1. *Эрх зүйн орчинг бүрдүүлэх* - Тарифын бус зохицуулалтын эрх зүйн хэм хэмжээ нь тухайн улсын дотоод нөхцөл байдал, онцлогт нийцсэн, *хэрэгжүүлж болохуйц*, түүнчлэн *ДХБ-ын зарчимд* харшлахгүй байх шаардлагатай. Хэт ерөнхий тодорхойлсон, эсвэл тухайн зохицуулалт, заалтыг хэрэгжүүлэх боломж, хүчин чадал бүрдээгүй бол зохицуулалт үр дүнд хүрэхгүй юм.
2. *Стандарт, тохирлын үнэлгээний тогтолцоо бий болгох* – Тарифын бус зохицуулалтын аливаа шаардлага, шалгуурын тоон үзүүлэлт *олон улсын хэм хэмжээнээс* хэтэрсэн, хэт хатуу чанга байх ёсгүй. Түүнчлэн шаардлага, шалгуур хангагдсан эсэхийг үнэлэх, баталгаажуулах, нотлох хүчин чадал бүхий, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, итгэмжлэгдсэн лаборатори, *чанарын дэд бүтэцтэй* байх шаардлагатай.
3. *Мэдээллийн сан бүрдүүлэх* – Мөрдөж буй тарифын бус зохицуулалтын талаарх мэдээлэл нь сонирхогч талуудад нээлттэй байх шаардлагатай. Мэдээллийн нээлттэй байдал нь худалдааг хөнгөвчлөх боломж олгохын зэрэгцээ тухайн мэдээлэлд үндэслэн нөлөөллийн болон эрсдэлийн үнэлгээ хийх боломж олгодог. Түүнчлэн тухайн мэдээлэл олон улсын байгууллагууд, худалдааны түнш орнуудад нээлттэй байх шаардлагатай.
4. *Эрсдэлд суурилсан системтэй байх* – Тарифын бус зохицуулалтын хяналт, шалгалтыг эрсдэлд суурилсан системээр хийдэг байх нь оновчтой юм.
5. *Гэнэтийн нөхцөлд бэлэн байх* – Онцгой нөхцөл байдлын улмаас БТАХ-г хэрэгжүүлэгч байгууллагад хэт их ачаалал үүсэх, гэнэтийн эрсдэл тулгарах, аюултай, хурдацтай тахал, өвчин тархсан тохиолдолд түүнийг илрүүлж, таслан зогсоох, хяналт шалгалт хийж чадах тоног төхөөрөмж, технологийн хүчин чадалтай байх шаардлагатай.
6. *Хэлэлцээр хийх хүчин чадалтай байх* - Худалдааны түнш орнуудтай харилцан ашигтай тохиролцоонд хүрч, гэрээ хэлэлцээр байгуулахын тулд худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрөгдөхүйц туршилт, онош зүйн хүчин чадалтай байх шаардлагатай.
7. *Олон улсын чанарын баталгаажуулалт, эрсдэлийн менежментийн системийг ашиглах* – Дор дурдсан олон улсын байгууллагуудын стандарт, чанарын баталгаажуулалт, эрсдэлийн менежментийг өөрийн улсад нэвтрүүлсэн байх нь давуу талтай юм. Үүнд:
 1. Хөдөө аж ахуйн салбарын зохистой дадал (GAP: Good Agricultural Practices)
 2. Эрүүл ахуйн зохистой дадал (GHP: Good Hygiene Practices)
 3. Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP: Good Manufacturing Practices)
 4. Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянах тогтолцоо (HACCP: Hazard Analysis and Critical Control Points)

Дүгнэлт

Дэлхийн улс орнууд гадаад худалдааны бодлого, зохицуулалтад ТБАХ-г ашиглаж буй зорилго, шинж чанараас харахад гадаад худалдааг тарифаар зохицуулах боломж, нөхцөл хумигдаж, эсрэгээр тарифын бус зохицуулалтын хэлбэр нэр төрөл, хамрах хүрээ өргөжиж байна. ТБАХ нь олон хэлбэр, төрөлтэйгээс гадна түүнийг ашиглах үндэслэл, зорилго, гарах үр дүн харилцан адилгүй, түүнийг зохицуулах олон талт зохицуулалт одоохондоо бий болоогүй зэрэг нь ТБАХ-г өргөн хүрээтэй ашиглах боломжийг улс орнуудад олгож байна.

ТБАХ-г ашиглаж буй улс орнуудын туршлага, олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, чиглэлээс дүгнэхэд тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн байхыг шаардаж байна. Үүнд:

- ТБАХ-г хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох;
- Батлан гаргасан аливаа зохицуулалтын хэрэгжилтийг хангах хүний нөөц, лаборатори, тоног төхөөрөмжийн хүчин чадалтай байх;
- Тэрхүү үүргийг гүйцэтгэж буй төрийн байгууллагууд хоорондын ажил, үүргийг уялдуулах, нэгдмэл бодлого, үйл ажиллагаатай байх шаардлагатай ажээ.

3.2. Импортыг тарифын бус арга хэмжээгээр зохицуулах нь

Дэлхийн улс орнуудын гадаад худалдааны бодлогод тарифын бус зохицуулалтын эзлэх орон зай улам бүр өргөжин тэлж байна. Монгол Улсын хувьд ч нийгэм, эдийн засгийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэхийн тулд тарифын бус зохицуулалтыг ашиглах бодит хэрэгцээ, шаардлага байна.

Тарифын бус зохицуулалтыг ашиглан импортыг хянах, зохицуулахын тулд юуны өмнө тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх үндэслэлийг зөв гаргах, тарифын бус арга хэмжээний олон хэлбэр, төрлөөс нэн тэргүүнд анхаарч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг сонгох, улмаар тэрхүү арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төвлөрч ажиллах нь зохистой юм. Энэ хэсэгт тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх үндэслэл, тарифын бус арга хэмжээг хэрэгцээ, ач холбогдлоор нь ангилах хувилбарын талаар авч үзэв.

Тарифын бус зохицуулалт хийх үндэслэлийг зөв тодорхойлох

Тарифын бус зохицуулалтыг шинээр санаачлан хэрэгжүүлэхийн тулд үндэслэл бүхий хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байх шаардлагатай. Тухайлбал ДХБ-ын хэд хэдэн хэлэлцээрээр тарифын бус арга хэмжээний ашиглалтыг хязгаарлаж, зохицуулдаг ч дараах үндэслэлийг эш болгон гадаад худалдаанд тарифын бус зохицуулалт хийх боломжтой юм. Үүнд:

- ДХБ-аас тарифын бус зохицуулалтыг олон улсын худалдаанд сөрөг нөлөөтэй гэж үздэг ч *“гишүүн орны засгийн газруудад эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор дотооддоо бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх орон зайг үлдээсэн”* байдаг. Энэ нь гадаад

худалдааны бодлогод тарифын бус арга хэмжээг ашиглах томоохон боломж юм.

- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхийн тулд, тухайлбал хүн амыг ядууралд өртөхөөс сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг урамшуулах зорилгоор тарифын бус зохицуулалтыг ашиглаж, гадаад худалдааг, тэр тусмаа импортын урсгалыг хязгаарлах нь зөвшөөрөгддөг.
- Тарифын бус зохицуулалт нь гадаад худалдаанд зөвхөн сөрөг нөлөө үзүүлдэг гэж үзэж болохгүй юм. Тарифын бус зохицуулалтаар дамжуулан чанарын баталгаажуулалт, хөдөлмөрийн нөхцөл стандарт, хүрээлэн буй орчны зохицуулалт, шударга худалдааны тогтолцоог бүрдүүлэх боломжтой тул эдгээр үндэслэлээр тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой.

Эдгээр үндэслэл нь тарифын бус зохицуулалтыг ашиглах боломжийг нээж байна. Хамгийн чухал нь тухайн зохицуулалтыг ямар цар хүрээг хамруулан, ямар удирдлага, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх, зорьсон үр дүндээ хүрч чадахуйц нөхцөл, боломжийг бүрдүүлэхийн тулд юунд анхаарах ёстойг оновчтой тодорхойлсон байх шаардлагатай.

Тарифын бус арга хэмжээг ач холбогдлоор эрэмбэлэх

Тарифын бус арга хэмжээ нь олон хэлбэр, төрөлтэй тул тарифын бус зохицуулалтыг оновчтой хэрэгжүүлэхийн тулд өөрийн орны боломж, онцлог, нөхцөл байдалд тохирсон арга хэлбэрийг сонгон тодорхойлж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төвлөрч ажиллах шаардлагатай юм.

Дэлхийн улс орнуудын тарифын бус арга хэмжээний ашиглалтын судалгаа, туршлагаас харахад дараах зохицуулалтын хэлбэрүүдийг түлхүү ашиглаж байна. Үүнд:

- Хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага
- Импортын бүтээгдэхүүний орц, найрлага, агуулгад тавих шаардлага
- Хаяг, шошго, сав баглаа боодолд тавих шаардлага
- Тээвэрлэлтэд тавих шаардлага
- Хүрээлэн буй орчны шаардлага
- Гадаад валютын хориг, хязгаар
- Татаасын эсрэг арга хэмжээ
- Демпингийн эсрэг арга хэмжээ
- Лиценз, тусгай зөвшөөрөл
- Квот – тоо хэмжээний хязгаарлалт
- Үнийн зохицуулалт
- Эмбарго
- Сайн дурын экспортын хязгаарлалт
- Ашгаа гадагш шилжүүлэхэд тавих шаардлага гэх мэт.

Эдгээр зохицуулалтын арга хэрэгслийг бүгдийг нь ашиглах шаардлагагүйн зэрэгцээ нөөц бололцоо дутах тул тухайн зохицуулалтыг ашиглах зайлшгүй хэрэгцээ, хэрэгжүүлэх боломж, хүрэх үр дүн, ашиглах зориулалт зэрэг хэд хэдэн шалгуураар дараах 3 бүлэгт ангилах боломжтой гэж үзлээ. Үүнд:

1. *Импортын бүтээгдэхүүний зохицуулалт* – Эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага, бүтээгдэхүүний орц, найрлага, агуулгад тавих шаардлага, хаяг, шошго, сав баглаа боодлын шаардлага, хүрээлэн буй орчны шаардлага, лиценз, тусгай зөвшөөрөл, стандарт;
2. *Дотоод зах зээлээ хамгаалах арга хэмжээ* – Квот, лиценз, хамгаалалтын арга хэмжээ, демпинг, татаасын эсрэг арга хэмжээ;
3. *Бусад зохицуулалт* - Тээвэрлэлтийн шаардлага, гадаад валютын зохицуулалт, үнийн зохицуулалт, эмбарго, сайн дурын экспортын шаардлага, ашиг шилжүүлэх зохицуулалт.

Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой тарифын бус арга хэмжээг ойролцоо шинж чанараар нь дээрх 3 бүлэгт ангилсны зэрэгцээ аль ангиллын зохицуулалтыг нэн тэргүүнд хэрэгжүүлж, анхаарч ажиллах шаардлагатайг тодорхойлох зорилгоор дараах хүснэгт 16-д харуулсан шалгуураар үнэлж үзлээ.

Хүснэгт 16. Монгол Улсад ашиглах боломжтой тарифын бус зохицуулалтын ангилал

	Импортын бүтээгдэхүүнд тавих шаардлага	Дотоод зах зээлээ хамгаалах арга хэмжээ	Бусад зохицуулалт
Хамрах хүрээ	Өргөн	Явцуу	Маш явцуу
Зохицуулах шаардлага, ач холбогдол	Маш өндөр	Өндөр	Дунд
Зохицуулах боломж	Дунд	Бага	Бага
Хэрэгжүүлэх арга зам	Ойролцоо	Ойролцоо	Ялгаатай

Эх сурвалж: Судлаачийн ангилал

Зохицуулалтын хамрах хүрээ – Дээрх гурван бүлэг арга хэмжээг хэр өргөн цар хүрээг хамруулан хэрэгжүүлэх боломжтойг авч үзвэл:

- Импортын бүтээгдэхүүнд тавих шаардлагын тухайд импортоор оруулж буй маш олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамруулан хэрэгжүүлэх боломжтой тул зохицуулалтын хамрах хүрээ *маш өргөн* юм.
- Дотоод зах зээлээ хамгаалах арга хэмжээг зөвхөн импортын бүтээгдэхүүн дотоод зах зээлд нэвтэрч, дотоодын үйлдвэрлэл, үндэсний үйлдвэрлэгчдэд ноцтой хохирол учирсан, эсвэл хохирол учруулах магадлалтай нөхцөлд л хэрэгжүүлэх боломжтой. Иймд энэхүү зохицуулалтыг ашиглах боломж харьцангуй явцуу хүрээнд тодорхойлогдоно.

- Бусад зохицуулалтын тухайд зөвхөн тухайн зорилтот хүрээнд буюу гадаадын шууд хөрөнгө оруулагч ашгаа гадагш шилжүүлэх, экспортыг сайн дураар хязгаарлах, онцгой нөхцөл байдлын эсрэг хориг арга хэмжээ (эмбарго) авах зэрэгт ашиглах тул хамрах хүрээ *маш явцуу* юм.

Зохицуулах шаардлага, ач холбогдол – Монгол Улсын гадаад худалдааны урсгал, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл дээрх 3 бүлэг арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага, тэрхүү арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бий болох ач холбогдол дараах байдлаар тодорхойлогдож байна.

- Импортлож буй бүтээгдэхүүнд тавих хяналт, шалгуурыг чангатгах, зарим төрлийн бүтээгдэхүүний импортын урсгалыг хязгаарлах бодит хэрэгцээ бий болсон байна. Иймд импортын бүтээгдэхүүнд тавих зохицуулалтын хэрэгцээ шаардлага, гарах ач холбогдол *маш өндөр* юм.
- Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын өнөөг хүртэлх нөхцөл байдлаас дүгнэхэд дотоодын зах зээл, үндэсний үйлдвэрлэгчдийг бодитоор дэмжиж, хамгаалсан арга хэмжээ маш цөөн байв. Үр дүнд нь үндэсний үйлдвэрлэл уналтад орж, өрсөлдөх чадвар суларчээ. Иймд дотоод зах зээлээ хамгаалсан бодлогыг тодорхой үндэслэлтэйгээр, олон улсын хэлэлцээр, зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлага, зохицуулалт хийснээр гарч ирэх ач холбогдол *өндөр* юм.
- Монгол Улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдлаас дүгнэвэл бусад ангилалд багтаж буй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага, ач холбогдол харьцангуй *бага* байна.


Зохицуулах боломж – Тарифын бус зохицуулалтын үр нөлөөг тодорхойлох нэг чухал үзүүлэлт бол тухайн төрлийн зохицуулалтын бодитоор хэрэгжих боломж (эрх зүйн зохицуулалт, дүрэм журам, тоног төхөөрөмж, лаборатори, боловсон хүчин, олон улсын гэрээ хэлэлцээр гэхмэт) юм. Энэ шалгуураар авч үзвэл эхний бүлэгт багтсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж *дундаж* түвшинд бүрдсэн бол үлдэх хоёр ангиллын зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, чадамж хараахан *бүрдээгүй* байна.

Хэрэгжүүлэх арга зам – Сонгосон 3 бүлэг үзүүлэлтийн эхний 2 бүлэгт багтах зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломж нь харьцангуй ойролцоо байв.

Монгол Улсад ашиглах боломжтой тарифын бус зохицуулалтын хэлбэрүүдийг дээрх байдлаар ангилж, бүлэглэж үзэхэд эхний хоёр ангилал буюу (а) импортын бүтээгдэхүүнд тавих шаардлага, (б) дотоод зах зээлээ хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээ, ач холбогдол, хэрэгжих боломж харьцангуй өндөр байна.

Импортын бүтээгдэхүүнд тавих шаардлага болон *дотоод зах зээлээ хамгаалах* арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд 4.1-р бүлэгт авч үзсэн дараах 3 тулгуур нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

Зураг 14. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх зураглал



Эх үүсвэр: Судлаачийн томъёолол

Зураг 14–өөс харахад нөхцөл байдал ямар түвшинд байгаа талаар дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, бодлого чиглэлийг тодорхойллоо.

3.2.1. Тарифын бус зохицуулалтын талаар баримтлах бодлого, зохицуулалт

Тарифын бус зохицуулалттай холбоотой бодлого, зохицуулалтыг дараах 3 хүрээнд тодорхойлов. Үүнд:

- Тарифын бус зохицуулалтын талаар төрөөс баримтлах бодлого;
- Тарифын бус зохицуулалттай холбоотой хууль, дүрэм журам;
- Стандарт, техникийн зохицуулалт.

Тарифын бус зохицуулалтын талаар төрөөс баримтлах бодлого

Төрөөс тухайн асуудлаар баримталж буй бодлого, зорилтыг төрийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого⁵⁸, төлөвлөлтийн баримт бичигт хэрхэн туссанаас дүгнэх боломжтой юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлсон “Алсын хараа 2050” хөтөлбөр, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тарифын бус зохицуулалтыг гадаад худалдааны бодлогын зорилгоор ашиглах талаар ямар нэгэн зорилт, заалт шууд байдлаар тусгагдаагүй байна. Харин гадаад худалдаа, эдийн засгийн гадаад бодлоготой холбоотой дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

“Алсын хараа 2050” хөтөлбөрт⁵⁹:

⁵⁸ “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” Монгол Улсын хуульд зааснаар “Хөгжлийн бодлого гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг хэлнэ”.

⁵⁹ <https://www.legalinfo.mn/annex/details/11057?lawid=15406>

- Зорилт 4.2: “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, *экспортын баримжаатай* эдийн засгийг бий болгоно”,
- Зорилт 4.4: “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, *худалдааг хөнгөвчилнө*”.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд⁶⁰:

- Зорилт 19: “Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг *нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө*. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ”
- Зорилт 21.6: “Гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны *тааламжтай нөхцөлүүдийг* олгох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг төлөх нөхцөл бүрдүүлэх”

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт⁶¹

- 3.1.10: “Гадаад худалдааг дэмжсэн *гаалийн үйлчилгээг хялбаршуулж*, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ”,
- 3.1.20: “Бүтээгдэхүүнээ *экспортод гаргасан* аж ахуйн нэгжийг *тусгайлан дэмжих* Экспортын баталгааны сан байгуулж ажиллуулна”,
- 4.5.2: “Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан *экспортыг нэмэгдүүлэх*, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа *хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх* бодлогыг үргэлжлүүлнэ” гэж заажээ.

Гадаад худалдааны талаар баримтлах бодлогыг тодорхойлсон дээрх заалтуудаас дүгнэхэд Монгол Улс олон талт хэлэлцээрийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг баримталж, гадаад худалдааг **хөнгөвчлөх** бодлого баримталж байна.

Харин 2018 онд батлагдсан “Монгол экспорт” хөтөлбөрт⁶²:

- 4.1.1: Үйлдвэрлэл, гадаад худалдаа, экспортын асуудлыг хариуцсан байгууллага, салбаруудын үйл ажиллагааг **уялдуулах**, үйлдвэрлэл – худалдаа – хөрөнгө оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн “Төрөөс гадаад худалдааны талаар **баримтлах бодлого**”-ыг боловсруулж, батлуулах;
- 4.2.4: Ноос, ноолуур, арьс шир, чацаргана, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүний стандартыг европын болон **олон улсын стандартад** нийцүүлэх;

⁶⁰ <https://www.legalinfo.mn/annex/details/3362?lawid=6340>

⁶¹ <https://www.legalinfo.mn/annex/details/11219?lawid=15586>

⁶² <https://www.legalinfo.mn/annex/details/8719?lawid=13692>

- 4.2.5: Ноос, ноолуур, арьс шир, мах болон сүүн бүтээгдэхүүн зэрэг экспортын баримжаатай бүтээгдэхүүний шинжилгээ, сорилтын **лабораторийн чадавхыг олон улсын жишигт хүргэх**, энэ чиглэлийн лаборатори байгуулах, тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг бүх түвшинд дэмжих;
- 4.3.9: Экспортын бүтээгдэхүүнд хийсэн **тохирлын үнэлгээний үр дүнг** худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрт тусгуулах чиглэлээр хамтран ажиллах зэрэг заалтуудыг тусгажээ.

Эдгээр зорилтыг экспортыг дэмжих хүрээнд дэвшүүлсэн боловч тарифын бус зохицуулалтыг гадаад худалдааны бодлогод ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой заалтууд болжээ.

Цаашид тарифын бус арга хэмжээгээр гадаад худалдааг зохицуулахын тулд *хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тарифын бус зохицуулалтын талаар тодорхой зорилт, заалтыг тусгах* шаардлагатай байна. Ингэснээр тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, төрийн байгууллагуудын зүгээс тухайн асуудалд анхаарлаа хандуулах нөхцөл бүрдэх юм.

Импортын бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангахад тарифын бус зохицуулалт чухал үүрэгтэй билээ. 2016 онд баталсан “Үндэсний чанарын хөтөлбөр”-д:

- Чанарын дэд бүтцийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Чанарын дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;
- Экспортын чиг баримжаатай, *импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин үндэсний үйлдвэрлэлийн* бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчны болон хүнсний аюулгүй байдлыг хамгаалан иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэн байна.

Үндэсний чанарын хөтөлбөрийн эдгээр зорилтыг хэрэгжүүлэх, ялангуяа иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтыг биелүүлэх нэг арга зам нь импортын бүтээгдэхүүнд тавих шалгуурыг өндөрсгөж, хяналт шалгалтыг чангатгах явдал юм. Үүний тулд нэг талаас уг хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэгч СХЗГ, нөгөө талаас гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэгч институцийн уялдаа, хамтын ажиллагаа шаардлагатай. Мөн манай улс гадаад худалдааны бодлого хариуцсан тусгайлан бүтэцгүй тул импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг гадаад худалдааны бодлогын түвшинд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Иймд гадаад худалдааны бодлогын асуудал хариуцсан бүтцийг бий болгох шаардлагатай байна.

Тарифын бус зохицуулалттай холбоотой хууль, дүрэм журам

Монгол Улс гадаад худалдаа, гадаад эдийн засгийн харилцааг тусгайлан зохицуулсан хуульгүй юм. Гадаад худалдааны зохицуулалтын нэг чиглэл болох гаалийн татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг “Гаалийн тариф, гаалийн татварын тухай”⁶³ хуулиар зохицуулдаг. Тус хуульд Монгол Улс экспортын болон импортын бараанд гаалийн тарифыг хэрэглэх боломжтойг хуульчилж, гаалийн тарифын тогтолцоо, гаалийн татвар тогтоох хэлбэр, гаалийн тарифын зөвлөл, гаалийн үнийн талаар тодорхойлж, гаалийн болон бусад татвар ногдуулах харилцааг зохицуулсан.

Тарифын бус арга хэмжээний тухайд мөн л тусгайлан зохицуулалтгүй. Харин 2017 онд баталсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулиар стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Энэ хуульд стандарт, техникийн зохицуулалтыг хэрхэн баталж, мөрдүүлэх талаар тусгасан тул тарифын бус зохицуулалтыг ашиглах хүрээг тодорхойлсон хууль гэж үзэх боломжтой юм.

2002 онд батлагдсан “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” хуулиар тус хуулийн 4.1-р зүйлд заасан мал, амьтан, ургамлын гаралтай түүхий, эдийн бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Тарифын бус зохицуулалтын нэг хэлбэр нь валютын гүйлгээ, валютын ханшийг зохицуулах арга хэмжээ юм. Монгол Улс 1993 онд “Валютын зохицуулалтын тухай хууль”⁶⁴-ийг баталж, валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Тус хуульд 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд дахин эрс өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Дотоодын болон импортын бүтээгдэхүүнд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын шалгуур, хэм хэмжээг тодорхойлсон дараах хуулиуд үйлчилж байна. Үүнд:

- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль;
- Нялх балчир насны хүүхдийн хоол хүнсний тухай хууль;
- Баяжуулсан хүнсний тухай хууль;

⁶³ <https://www.legalinfo.mn/law/details/208>

⁶⁴ <https://www.legalinfo.mn/law/details/127>

- Органик хүнсний тухай хууль;
- Ургамал хамгааллын тухай хууль.

Эдгээр хуулиар хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг тодорхойлсон боловч хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, хуулийг биелүүлэх байдал хангалтгүй байна.

Хүнсний бус бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах “Хүнсний бус бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” хууль төслийн шатандаа явж байна. Тус хуулиар хүнсний бус бараа, бүтээгдэхүүнээс үүдэлтэй хүний ам нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийн эсрэг зохицуулалтыг хийх юм. Энэ хууль батлагдсанаар хүнсний бус бүтээгдэхүүнд тавих шаардлага, шалгуурыг тодорхой болгож, хяналт, шалгалтыг өндөрсгөх, тарифын бус зохицуулалтын эрх зүйн илүү тодорхой болох хүлээлттэй байна.

Хуулиас гадна тарифын бус зохицуулалтын хэм хэмжээтэй холбоотой хэд хэдэн тогтоол, дүрэм журам мөрдөгдөж, зарим нь төслийн шатанд боловсруулагдаж байна. Үүнд:

1. Монгол Улсын засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 1-р хавсралтаар “Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт”, 2-р хавсралтаар “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам”, 3-р хавсралтаар “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ыг баталж, тэдгээр бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох, холбогдох мэргэжлийн хяналтын байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.
2. Монгол Улсын засгийн газрын 2003 оны 219 дугаар тогтоолоор “Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам”-ыг батласан.
3. Монгол Улсын засгийн газрын 2014 оны 233 дугаар тогтоолоор “Импортын барааны эрсдэлийг тодорхойлох шалгуур, үзүүлэлт”-ийг баталж, энэхүү батлагдсан шалгуур үзүүлэлтийг үндэслэн импортын барааг эрсдэлээр ангилан хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах импортын барааны жагсаалтыг баталж мөрдүүлж байхыг даалгасан.
4. Монгол Улсын засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”, “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-ыг тус тус шинэчлэн баталсан. Баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнд (а) амьд мал, амьтад, мал амьтны гаралтай - 7 нэр төрөл (БКТУС-ын 4 оронтой кодын түвшинд), (б) ургамлын гаралтай – 16 нэр төрөл, (в) хүнсний бэлэн бүтээгдэхүүн, согтууруулах болон согтууруулах

бус ундаа, тамхи болон тамхи орлуулагч – 27 нэр төрөл, (г) эрдэс бүтээгдэхүүний – 14 нэр төрөл, (д) химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн – 19 нэр төрөл зэрэг нийт 200 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамруулсан байна.

5. Монгол Улсын засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэн батласан. Тус журмаар стратегийн хүнсний дотоодын хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарал, үнийн хэлбэлзлээс сэргийлэх, гадаад худалдааны түнш орны зорилтот зах зээлд стратегийн хүнсийг экспортлохыг дэмжих, стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох үйл явцыг шуурхай болгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн.
6. ГХЯ-аас “Хамгаалалтын арга хэмжээний тухай журам”-ын төслийг боловсруулж байна. Энэхүү журмаар дотоод зах зээлээ хамгаалахад чиглэсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх харилцааг зохицуулах тул тарифын бус зохицуулалтад чухал ач холбогдолтой байх болно.

Тарифын бус зохицуулалттай холбоотой хууль, дүрэм журмууд дээрх байдалтай байгаад бөгөөд эдийн засгийн салбар бүрт хамаарах нилээдгүй олон зохицуулалтын шаардлага үйлчилж, түүний хэрэгжилтийг төрийн хяналт шалгалт, хил, гаалийн байгууллагууд хэрэгжүүлж байна.

Гэхдээ тус тусын чиг үүрэгтэй төрийн байгууллагууд нэгдсэн бодлого, төлөвлөгөөгүйгээр, тодорхой нөхцөл байдал, тохиолдлыг шийдэх байдлаар, тус бүрд нь тогтоол журам баталж, зохицуулж байгаа нь зорьсон үр дүнд хүрч, зохицуулалт хийхэд сөргөөр нөлөөлж байна. Энд мөн л гадаад худалдааны бодлогыг нэгтгэн зангидах, хүрсэн үр дүнг үнэлэх, дараагийн шатны зорилго, зорилтыг тодорхойлж ажиллах үүрэг бүхий бие даасан бүтцийн орон зай үгүйлэгдэж байгааг илэрхийлж байна.

Тарифын бус зохицуулалтад хамаарах стандарт, техникийн зохицуулалт

Тарифын бус зохицуулалтын ерөнхий хүрээ, хэрэгжилт, дэс дарааллыг хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулж байгаа бол тодорхой бүтээгдэхүүнд хамаарах шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтоодог. Стандарт⁶⁵ нь тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, *сонгон хэрэглэх* баримт бичиг юм.

Монгол Улсын стандартын мэдээллийн сан <https://estandard.gov.mn/>-д манай улсад мөрдөгдөж буй нийт 6548 стандартыг байршуулсан байна. Үүний

⁶⁵ Хүн, амьтан, ургамлын эрүүл ахуйн шаардлагыг хангах, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны бүхий үе шатуудад тавигдах шаардлагыг тодорхойлсон бичиг баримтыг стандарт гэнэ.

4200 гаруй нь үндэсний, 2200 гаруй нь үндэсний болгосон олон улсын стандарт юм. Стандартыг олон улсын ангиллын дагуу 50 салбарт ангилдаг бөгөөд импортын худалдаанд илүү хамаарах 18 салбарын стандартын тоог хүснэгт 17 –оос харна уу.

Хүснэгт 17. Зарим салбарт мөрдөгдөж буй стандартын тоо

№	Стандартын ангилал	Тоо	№	Стандартын ангилал	Тоо
1	Хүрээлэн буй орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдал	320	10	Хүнсний технологи	380
2	Нийтлэг хэрэглээний механик	57	11	Уул уурхай, ашигт малтмал	237
3	Үйлдвэрлэлийн техник	25	12	Газрын тос, хүүний технологи	76
4	Эрчим хүч, дулааны техник	46	13	Модны технологи	97
5	Цахилгаан техник	16	14	Шил, керамикийн үйлдвэр	15
6	Сав баглаа боодол	22	15	Каучук ба хуванцарын үйлдвэр	2
7	Нэхмэл арьс, шир	235	16	Цаасны технологи	10
8	Хувцасны үйлдвэр	45	17	Будаг, будгийн үйлдвэр	14
9	Хөдөө аж ахуй	372	18	Барилга, барилгын материал	267

Эх сурвалж: <https://estandard.gov.mn/> вэбсайтаас түүвэрлэв.

Хүснэгт 17-оос харахад хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой 320 стандарт, хөдөө аж ахуйн чиглэлээр 372, хүнсний технологийн 380, уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр 237, барилга, барилгын материалын салбарт 267 стандарт мөрдөгдөж байна.

Хүний эрүүл мэнд, амьдралын чанарт чухал нөлөөтэй **хүнсний технологийн** чиглэлийн 380 стандартыг бүтээгдэхүүний нэр төрлөөр задалж харуулбал:

- Хүнсний бүтээгдэхүүний нийтлэг асуудлыг хамарсан стандарт – 18;
- Тариа буудай, буурцаг, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүнд хамаарах стандарт – 64;
- Жимс, ногоонд хамаарах стандарт – 46;
- Сүү, сүүн бүтээгдэхүүний стандарт – 50;
- Мах, махан бүтээгдэхүүний стандарт – 51;
- Цай, кофе, какаотой холбоотой стандарт – 6;
- Ундааны стандарт – 43;
- Элсэн чихэр, цардуулын стандарт – 20;

- Шоколадны стандарт – 0;
- Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний стандарт – 16;
- Жижиглэн савласан бэлэн хүнсний стандарт – 5;
- Зохицуулах үйлчилгээтэй хүнсний стандарт - 14 байна.

Эдгээр тоон үзүүлэлтээс харахад хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тус бүр тодорхой тооны стандарт мөрдөж байгаа ч Монгол Улс дотооддоо үйлдвэрлэхийн зэрэгцээ их хэмжээгээр импортолдог шоколад стандартгүй байна.

Иймд импортын хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр тэдгээрт тавигдах стандарт, техникийн зохицуулалтын жагсаалтыг гаргах, ямар нэгэн стандарт, зохицуулалтгүй бүтээгдэхүүнийг тодорхойлох, түүнд эрсдэлийн үнэлгээ хийх, улмаар стандарт, шалгуурыг тодорхойлох шаардлагатай байна.

Хэдийгээр тухайн салбар, тодорхой нэрийн бүтээгдэхүүнд хамаарах олон тооны стандарт байгаа ч импортын бүтээгдэхүүнд ямар стандарт мөрдөж буйг тодорхойлох зорилгоор цай, кофе, какао төрлийн бүтээгдэхүүний 6 стандартыг⁶⁶ авч үзэхэд тэдгээрийн 5 нь (монгол цай, баялаг цай, шахмал ногоон цай, кофе, сүүтэй кофе) дотооддоо үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний стандарт байв. Зөвхөн какао, какао бүтээгдэхүүний стандарт импортын бүтээгдэхүүнд хамаарч байгаа бол их хэмжээгээр импортлогддог кофены үр, төрөл бүрийн цайнд хамаарах стандартгүй байна.

Иймд импортын бүтээгдэхүүний чанар, стандартыг тогтоосон зохицуулалтыг бий болгох, мөрдүүлэх шаардлагатай байна. Үүний нотолгоог МХЕГ-ын “Хүнсний бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагын стандартуудыг шинэчлэх, стандарт, техникийн ерөнхий шаардлага байхгүй хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлагыг боловсруулж гаргах нь зүйтэй байна. 1970, 1980-д оны бүтээгдэхүүний стандарт, техникийн ерөнхий шаардлага нь одоогийн бүтээгдэхүүнд тохирдоггүйн зэрэгцээ тахианы махан хиам, зайдас, элэгний нухаш, цагаан будааны боов, бэйкэри зэргийг ямар ч стандартгүй үйлдвэрлэсээр байна. Мөн иоджуулсан давснаас бусад баяжуулсан бэлэн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх батлагдсан шинжилгээний арга, аргачлал байхгүй. Иймд батлагдсан арга, аргачлалтай болох шаардлагатай” гэсэн дүгнэлтээс харж болно⁶⁷.

Тарифын бус арга хэмжээний нэг хэлбэр болох сав баглаа боодлын зохицуулалт, түүнд тавигдах шаардлагатай холбоотой дараах стандартыг мөрдөж байна. Үүнд:

1. Хүнсний шингэн савлах шилэн сав MNS-3157;
2. Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS-5684:2006;

⁶⁶ <https://estandard.gov.mn/>

⁶⁷ Нийслэлийн МХГ-ийн 2020 оны эхний хагас жилийн ажлын тайлан

3. Сав баглаа боодлын зориулалттай үелээт цаасан картон. Техникийн шаардлага MNS-6382:2013;
4. Нийлэг хальсан уут. Техникийн шаардлага MNS-5296:2003;
5. Консервын төрөл бүрийн лааз MNS-1568:1981;
6. Хүнсний бүтээгдэхүүнд зориулсан хуванцар сав. Ерөнхий техникийн нөхцөл MNS-1010:1986.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуванцар савны стандартыг шинэчлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Учир нь иргэдийн мэдлэг, мэдээлэл дутуугаас зориулалтын бус хуванцар савыг ундны ус зөөвөрлөх, халааж хэрэглэж болохгүй хүнсний саванд хоол хүнс халаах зэргээр эрсдэл үүсгэж байгааг дурджээ.

Түүнчлэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдаалж буй аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний шошгод заах тэжээллэг чанар, илчлэг, уураг, нүүрс ус, тослогийн хэмжээг зөрүүтэй, бодитой бус, ижил бүтээгдэхүүнүүдийг нэг нэгнээсээ хуулбарлаж, тэмдэглэдэг зөрчил их гарч байна.

Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын тоон үзүүлэлтээс дүгнэхэд *хангалттай тооны* стандарт мөрдөгдөж байгаа ч тэдгээр стандартыг олон улсын түвшинд хүргэх, олон нийтэд таниулан сурталчлах, практикт ашиглах байдал дутагдаж байна.

Монгол Улс стандартыг мөрдөх хэм хэмжээг *сонгон хэрэглэх* тогтолцоонд шилжүүлэх зорилт дэвшүүлж, 2018 оны 7 сарын 1-ээс стандартыг *сонгон хэрэглэх* (заавал мөрдөх бус, зөвлөмжийн шинжтэй) болсон. Тиймд стандартаас илүүтэйгээр техникийн зохицуулалтаар импортыг зохицуулах шаардлагатай байна.

Техникийн зохицуулалт⁶⁸

Техникийн зохицуулалтыг хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор, гадаад худалдааны зохицуулалтад хамгийн түгээмэл ашигладаг.

Техникийн зохицуулалтыг нийтээр *заавал дагаж мөрдөх* ёстой. Техникийн зохицуулалтыг тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналаар Засгийн газарт баталж, хэрэгжилтийг улсын хэмжээнд Засгийн газар, хэрэгжилтийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын хуульд заасан байгууллага тус тус хариуцдаг.

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-д зааснаар:

- Монгол Улсаас *гадаад худалдаанд* хэрэглэх техникийн зохицуулалтын төслийг батлагдахаас гурваас доошгүй сарын өмнө стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны

⁶⁸ Бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсвэл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг техникийн зохицуулалт гэнэ.

байгууллага Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад мэдээлэх үүрэгтэй.

- Мөн Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож байгаа гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ гэжээ.

Техникийн зохицуулалт боловсруулах үйл явцыг СХЗГ-ын 2018 оны А/31 Зшийдвэрээр баталсан “Техникийн зохицуулалт боловсруулах заавар”- аар зохицуулсан байна. Монгол Улсад дараах 5 техникийн зохицуулалтыг мөрдөж байна. Үүнд:

1. Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт (2013);
2. Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт (2012);
3. Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт (2016);
4. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт (2012);
5. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт (2008);

Монгол Улсын засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоолоор шинээр болон шинэчлэн боловсруулах 18 нэрийн техникийн зохицуулалтын жагсаалтыг баталсан. Тэдгээр жагсаалтад өмнө дурдсан таван техникийн зохицуулалтын гурвыг нь дахин хянах, мөн импортын худалдаанд хамаарах дараах техникийн зохицуулалтыг боловсруулж, батлуулахаар заажээ. Үүнд:

- Агаар, ус, хөрсөн дэх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээг тогтоох техникийн зохицуулалт;
- Ойн хортон шавжтай тэмцэх бэлдмэлийн химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох техникийн зохицуулалт;
- Барилга байгууламжийн материал бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт;
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох зориулалттай хэмжих хэрэгслийн техникийн зохицуулалт;
- Тамхи, тамхин бүтээгдэхүүний техникийн зохицуулалт;
- Хувийн хамгаалах хэрэгслийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт;
- Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт;

Мөн ХХААХҮЯ-аас “Ямааны ноолуурын үйлдвэрлэл, худалдаанд тавих техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулж, холбогдох судалгаа, нөлөөллийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ болон эдийн засгийн тооцоог хийж, зохицуулалтын төслийг ДХБ-д мэдэгдсэн байна.

ДХБ-ын тарифын бус арга хэмжээний мэдээллийн санд Монгол Улс доорх 3 техникийн зохицуулалтыг ашиглаж байна гэжээ. Үүнд:

- БТКУС-ын 841311, 8423, 850421, 9016, 9028 бүлгийн бүтээгдэхүүнд хамаарах хаяг, шошготой холбоотой техникийн зохицуулалт;
- БТКУС-ын 41 бүлгийн бүтээгдэхүүнд хамаарах арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт;
- Бүх бүтээгдэхүүнд хамаарах ТВТ зохицуулалт буюу 2017 онд батлагдсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль” гэсэн байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд техникийн зохицуулалт нь импортын бүтээгдэхүүний урсгалыг зохицуулах, хязгаарлах *гол шийдэл* бөгөөд Монгол Улсын техникийн зохицуулалтын тоо, ашиглалт *хангалтгүй* түвшинд байна. Техникийн зохицуулалтын ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд:

- Хүчин төгөлдөр үйлчилж буй техникийн зохицуулалтыг чанд мөрдүүлэх;
- ❖ Бусад улсад хамгийн их техникийн зохицуулалт хийж буй бүтээгдэхүүнийг судалж, тэдгээрийг туршлага болгох авч хэрэгжүүлэх;
- ❖ Шинээр баталж хэрэгжүүлэх техникийн зохицуулалтыг ДХБ-ын зарчим, шаардлагын хүрээнд боловсруулах шаардлагатай байна.

Техникийн зохицуулалтыг шинээр баталж хэрэгжүүлэхдээ ДХБ-ийн холбогдох хэлэлцээрийн дараах шаардлагыг хангасан ёстой. Үүнд:

- Тухайн зохицуулалт нь хууль ёсны, нийгмийн ач холбогдолтой, тохиромжтой, зохистой, уялдаа холбоотой байх;
- Шударга, ойлгомжтой, энгийн, үнэн зөв байх;
- Ёс зүйтэй, хариуцлагатай, олон улсын түвшинд харьцуулагдахуйц байх;
- Ил тод, нээлттэй байх;
- Үндэслэлтэй, хэрэгцээтэй, эдийн засгийн үр ашигтай, уян хатан байх.

Дүгнэлт

Тарифын бус зохицуулалтын талаар баримтлах бодлого, эрх зүйн орчны талаар доорх гурван чиглэлээр авч үзэхэд дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

Төрийн бодлогын хүрээнд:

- Монгол Улсын урд, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тарифын бус зохицуулалтыг гадаад худалдааны бодлогод ашиглах талаар тодорхой бодлого, зорилго тусгагдаагүй байна.
- Монгол Улс ДХБ-ын гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, гадаад худалдааг хөнгөвчлөх бодлого баримталж байгаа ч зайлшгүй шаардлагатай тохиолдолд зохих үндэслэл, шаардлагыг нотолсноор тарифын бус зохицуулалтыг ашиглах нь нээлттэй юм. Иймд тарифын бус зохицуулалтыг ямар хүрээнд, хэрхэн ашиглах, тарифын бус зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах шаардлагатай байна.

Хууль, дүрэм журмын хүрээнд:

- Монгол Улс гадаад худалдааны хуульгүй, тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх тусгайлсан зохицуулалтгүй ба тэрхүү харилцааг эрүүл ахуй, хүнсний эрүүл ахуй, стандартчилал, тохирлын үнэлгээ болон төрийн хяналт, шалгалтын хууль, дүрэм, журмуудаар зохицуулж байна.
- Тарифын бус зохицуулалтыг тодорхой бодлого, зорилтыг хангах хэрэгсэл болгон ашиглах, тооцсон үр нөлөөг гаргахын тулд тусгайлсан зохицуулалт буюу тухайлбал гадаад худалдааны хууль шаардлагатай юм. Ингэснээр тарифын бус арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээх зохистой тогтолцоо бүрдэх болно.

Стандарт, техникийн зохицуулалтын хүрээнд:

- Монгол Улсад хангалттай тооны стандарт бүртгэлтэй байгаа ч түүнийг мөрдөх, хэрэгжилтэд үнэлгээ хийх байдал хангалтгүй байна. Иймд стандартын чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй (евро стандартыг нэвтрүүлэх гэхмэт) зорилтуудаа хэрэгжүүлэхийн зэрэгцээ олон нийтэд сурталчлан таниулах, мөрдүүлэх шаардлагатай байна.
- Нөхцөл байдлаас дүгнэхэд техникийн зохицуулалт нь импортын бүтээгдэхүүний урсгалыг зохицуулах, хязгаарлах гол шийдэл бөгөөд Монгол Улсын техникийн зохицуулалтын тоо, ашиглалт *хангалтгүй түвшинд* байна.
- Импортын бүтээгдэхүүнд тавих шалгуур, шаардлагыг өндөрсгөх замаар нэг талаар эрүүл ахуй, аюулгүй байдал, хүрээлэн буй орчноо хамгаалах, нөгөө талаар импортыг хязгаарлах боломжийг техникийн зохицуулалт олгох юм. Иймд техникийн зохицуулалт хийх бүтээгдэхүүнийг нэр төрлийг тодорхойлох, эрсдэл өндөртэй бүтээгдэхүүнийг олж тогтоох, эрсдэлийн үнэлгээ хийх, улмаар түүнд үндэслэн техникийн зохицуулалтыг боловсруулах шаардлагатай байна.

Техникийн зохицуулалтын ашиглалтыг нэмэгдүүлж, чанд мөрдүүлэхийн тулд дараах 2 чиглэлд анхаарах шаардлагатай. Үүнд:

1. ДХБ-ын хэлэлцээр, дүрэм журмын хүрээнд техникийн зохицуулалтаа боловсруулах;
2. Стандарт болон техникийн нөхцлийг мөрдүүлэх техник, технологи, хүний нөөц, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

3.2.2. Чанарын дэд бүтэц

Дэлхийн улс орнуудын туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжид тарифын бус зохицуулалтын эрх зүйн хүрээ, шаардлага, шалгуурыг тодорхойлж, тэдгээрийг практик дээр мөрдүүлэх асуудлыг баталгаажуулах чанарын гэрчилгээ олгох эрх бүхий бүтэцтэй байх нь нэн чухал гэж заасан

байдаг. Энэхүү дэд бүтцийн үндэс суурь нь дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр хүчин чадалтай, итгэмжлэгдсэн лабораториуд, тэдгээрийн хүрэлцээ юм.

2019 оны байдлаар Монгол Улсад төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын дэргэд 311 лаборатори үйл ажиллагаа явуулж байгаагийн 164 лаборатори дотоодын магадлан итгэмжлэл хийгдсэн байна. Тэдгээрээс:

- СХЗГ-ын Бүтээгдэхүүний баталгаажуулалтын газар;
- МХЕГ-ын Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Лавлагаа Лаборатори (ХАБҮЛЛ);
- ГЕГ-ын Гаалийн төв лаборатори;
- МЭЕГ-ын Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв лаборатори зэрэг итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагууд нь хүчин чадлын хувьд томоохонд тооцогдож, импортын бүтээгдэхүүнд чанарын баталгаажуулалт хийх боломжтой байна.

МХЕГ-ийн ХАБҮЛЛ нь хими, хор судлал, нян судлал, эмийн хяналт, таримал ургамлын үр, хорио цээр, цацрагийн хяналт, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, шинжилгээний төв, ур чадварын сорилтын лаборатори гэсэн бүтэцтэйгээр ажилладаг.

Нийслэлийн МХЕГ-ийн 2020 оны эхний хагас жилийн тайланд⁶⁹ “Давхардсан тоогоор 5757 аж ахуйн нэгжийн 7295,8 тн, 13,827,500 ширхэг мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бүх төрлийн боловсруулсан хүнс, химийн хортой болон аюултай бодис, тос тосолгооны материал, эм, эмийн хэрэгсэл, эм биобэлдмэл, биологийн идэвхт бодис, урвалж, сав баглаа боодол, хуучин хувцас, хүүхдийн тоглоом, ахуйн хэрэглээний бараа, гоо сайхны бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийсэн байна. Импортын мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан хууль, тогтоомжийн хэрэгжилт 1,5 хувь дээшилж, 76,5 хувь, ургамал, хорио цээрийн хууль, тогтоомжийн хэрэгжилт 74,5 хувьд хүрсэн” гэж дүгнэжээ.

ГЕГ-ийн Гаалийн төв лаборатори нь СХЗГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн эрхтэйгээр, хар тамхи, мансууруулах бодис, төрөл бүрийн химийн бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, малын гаралтай түүхий эд, хайлуур жонш, эрдэс түүхий эд, хүдэр баяжмал, нэхмэл болон сүлжмэл даавуу, утас ээрмэл зэрэг бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийдэг⁷⁰. Гаалийн төв лабораторид сорилт, шинжилгээ хийдэг бүтээгдэхүүний нэр төрлийг харахад Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглодог, эсвэл тусгай зөвшөөрөлтэй нэвтрүүлдэг, мөн экспортод гаргадаг харьцангуй цөөн нэр төрлийг хамруулан шинжилгээ хийж байна.

⁶⁹ <http://inspection.gov.mn/new/ulaanbaatar/wp-content/uploads/sites/7/2020/07/NMHG-2020-hagas-jil-MHYG-t.pdf>

⁷⁰ <https://customs.gov.mn/2012-03-14-03-21-37/inspection/laboratory/152-2014-04-03-06-54-24>

Монгол Улсын итгэмжлэлийн байгууллага СХЗГ нь Олон улс, бүс нутгийн лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC/APLAC), Номхон Далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (PAC)-ын хэлэлцээрт нэгдэж, БНХАУ-ын Итгэмжлэлийн байгууллага (CNAS)-тай хамтран ажиллаж, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний үр дүнг олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх, худалдааг хөнгөвчлөх, үндэсний үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Дүгнэлт

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй үндэсний хэмжээний, итгэмжлэгдсэн лабораториуд нь тодорхой хүрээнд сорцуудад шинжилгээг хийж байгаа ч гэсэн шинжилгээний үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөх эсэх тодорхойгүй байна. Тарифын бус зохицуулалтын цар хүрээг өргөжүүлэхийн тулд үндэсний лабораториудын сорьц, дээжид шинжилгээ хийх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай өндөр нарийвчлалтай шинжилгээ хийхэд зориулагдсан техник технологи, ур чадвар бүхий боловсон хүчин дутагдалтай байна.

Мөн импортын бүтээгдэхүүнд тавих өндөр түвшний нөхцөл, болзол, шаардлага, шалгуур, стандарт болон техникийн зохицуулалтыг батлах мөрдүүлэх, хянах эрх бүхий чанарын бүтэц дутагдаж байна. Иймд чанарын бүтцийг байгуулахын тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүчирхэг лабораториудтай болох хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал, амьтны болон ургамлын гаралтай уураг, тосны хүчлийн бүрдэл, химийн болон байгалийн гаралт үүслийг тогтоох шинжилгээ хийх, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим, нөхцөлийг нарийвчлан судлах, мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэх, үндэсний лабораториудыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Нөгөө талаас заавал хүчирхэг лаборатори, тоног төхөөрөмж шаардахгүйгээр тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой юм. Үүний тулд тарифын бус зохицуулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагын бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай багаж, техник хэрэгсэлийн (хэмжилтийн багажууд, зөөврийн компьютер, зургийн аппарат, диктафон, бусад) хангамж, хүчин чадал, хүрэлцээг сайжруулах хэрэгтэй байна.

3.2.3. Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоо

Монгол Улс тарифын бус зохицуулалтын тодорхой тооны дүрэм журам, стандарт, техникийн зохицуулалтыг батлан мөрдүүлж, үндэсний хэмжээнд итгэмжлэгдсэн лабораториудад зохих сорилт, шинжилгээг хийж байна. Гэвч тарифын бус зохицуулалтаар дамжуулан гадаад худалдааг, импортыг зохицуулах оролдлого үр дүн багатай байна. Үүний шалтгааныг төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, тарифын болон тарифын бус

бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх гадаад худалдааны бодлогын асуудал хариуцсан бие даасан бүтэцгүй байгаатай холбон тайлбарлаж болно.

Өнөөгийн байдлаар тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд техникийн зохицуулалт боловсруулах, ДХБ-д мэдээлэх үүргийг СХЗГ хариуцах бол ДХБ-ын гишүүн орнуудаас санал болгож буй техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг ЗГ-т оруулах үүргийг ГХЯ хариуцахаар зохицуулсан байна. Харин тэрхүү зохицуулалтад хяналт тавих үүргийг МХЕГ болон ГЕГ гүйцэтгэж байна.

Стандарт, техникийн зохицуулалт, сав баглаа боодлын шаардлага зэрэг хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, хорио цээр, аюулгүй байдал, хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбоотой зохицуулалтын шаардлагыг тодорхойлох, дүрэм журам, бичиг баримтыг боловсруулах, эрх бүхий байгууллагуудаар батлуулах үүргийг СХЗГ голчлон хариуцаж, МХЕГ, ГЕГ, МЭЕГ, ШӨХТГ-ууд хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллаж байна.

Экспорт, импортын квот, лиценз, зөвшөөрөл олгох (тухайлбал стратегийн хүнсний), хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний болон хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны асуудлыг ХХААХҮЯ, дотоод зах зээлээ хамгаалах, гадаад худалдааны бодлого хэрэгжүүлэх асуудлыг ГХЯ тус тус хариуцаж байна. Харин валютын зохицуулалт, валютын ханшийн бодлогыг Монголбанк хариуцаж байна.

Эдгээр байгууллагаас ГХЯ-аас бусдынх нь үндсэн чиг үүрэгт гадаад худалдааны бодлогын асуудал хамаардаггүй. Тэдгээр байгууллагууд тус тусын үндсэн чиг үүрэгт хамаарах хүрээнд асуудалд хандаж, гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх зорилт хамаарах харьяалалгүй үлдэж байна.

Хил, гаалиар нэвтэрч буй экспорт, импортын бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж буй МХЕГ-аас⁷¹ экспорт, импортын бүтээгдэхүүнд тавих, хяналт шалгалтыг сайжруулахын тулд дараах саналыг дэвшүүлсэн бөгөөд саналыг судалгааны баг бүрэн дэмжиж байгаа юм. Үүнд:

- Хяналт шалгалт хийх чиглэлийг тодорхой болгож, төлөвлөгөөг гаргахдаа бусад төрийн байгууллагатай уялдуулан **давхардалгүй, боловсронгуй** болгох;
- Хил, гүний хяналт, шалгалтын мэдээллийн нэгдсэн программыг улсын хэмжээнд шинэчлэн боловсруулж, нэгдсэн нэг программаар гаалийн байгууллага болон лабораториуд сүлжээнд холбож, мэдээллээ солилцох;
- Хүнсний бүтээгдэхүүний иж бүрэн судалгаа шинжилгээ хийх лабораторийг бий болгох, хүнсний аюулгүй байдалд судалгаа дүн шинжилгээ хийх, мэдээлэл харилцан солилцдог хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны институтийг байгуулах;

⁷¹ <http://inspection.gov.mn/new/ulaanbaatar/wp-content/uploads/sites/7/2020/07/NMHG-2020-hagas-jil-MHYG-t.pdf>

- Байцаагчдад шалгалт хийхэд шаардлагатай гүний болон зайнаас хэмжих термометр, чийглэг хэмжигч, рН метр, индикаторууд зэрэг үйлдвэрийн орчин, бүтээгдэхүүний шинж байдлыг газар дээр нь тодорхойлох сүүлийн үеийн дэвшилтэт технологитой, өндөр мэрдэмжтэй хэмжих хэрэгслүүдээр хангах;
- Гүний гаалийн хяналтын талбайд ажиллаж байцаагчдын ажиллах нөхцөл, сорьц авах зориулалтын сав, дээж, түр хадгалах хөргөгч, компьютер, техник төхөөрөмжөөр хангах;
- Боловсон хүчнийг гадаад, дотоодын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаа, техник технологийн хөгжилтэй танилцуулах, туршлага судлуулах;
- Импортын бодис, бараа бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан тохиолдолд шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд түр битүүмжлэн хадгалах стандартын шаардлага хангасан хяналтын байгууллагын агуулахтай болох шаардлагатай байна.

Тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тус тусын чиг үүрэг бүхий дээрх төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах шаардлага гарах ба үүнийг гадаад худалдааны асуудал хариуцсан бүтэц, алба нэгж хариуцах боломжтой. Улс орнуудын туршлагаас тэрхүү бүтэц нь тарифын бус зохицуулалттай холбоотой дараах үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- *Тарифын бус зохицуулалтын мэдээллийн сан үүсгэх.* Тарифын бус зохицуулалтын онцлогоос хамаарч нэг нэр төрлийн бүтээгдэхүүнд хамаарах олон төрлийн шаардлага, зохицуулалт өөр өөр эрх зүйн бичиг баримт, хууль, дүрэм журамд тусгагдсан байдаг. Иймд тэдгээр бүх зохицуулалт, шаардлагыг нэгтгэн нэгдсэн мэдээллийн сан үүсгэснээр, нэг талаар худалдаа эрхлэгчдэд тодорхой байдал бүрдүүлж, худалдааг хөнгөвчлөх үүргээ биелүүлэх бол, нөгөө талаар бүх шатны хяналт, шинжилгээний байгууллагууд тухайн бүтээгдэхүүнд бүх талаас нь хяналт тавих нөхцөл бүрддэг. Түүнчлэн давхардсан, зөрчилтэй, хэрэгцээгүй, үр дүнгүй зохицуулалт, шаардлагыг олж тодорхойлох, засаж сайжруулах боломж олгодог.
- *Тарифын бус зохицуулалтыг өөрчилж, шинэчилэх.* Нөхцөл байдалтай уялдуулан тарифын бус зохицуулалт, түүний шаардлагыг өөрчилж байх шаардлагатай. Тухайлбал, эдийн засгийн орчинд гарсан өөрчлөлт, эрүүл ахуй, аюулгүй байдал, өвчин, тахлын шинэ эрсдэл, олон улсын худалдааны шинэ хандлага, шинжлэх ухаан, технологийн дэвшил зэрэг олон нөхцөл байдлын улмаас тарифын бус зохицуулалтын шаардлагыг өөрчлөх хэрэгцээ үүсдэг. Мөн тухайн улсын эдийн засгийн чадавх сайжрахын хэрээр эрэлт, хэрэгцээ илүү олон төрөл, хувилбартай болж, бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих чанарын шаардлага өндөрсдөг. Үүнтэй уялдуулан эрүүл ахуй, аюулгүй байдал, өндөр чанарыг дэмжсэн зохицуулалтын шаардлагыг батлах хэрэгтэй болно. Цаашилбал

хэрэгцээгүй, ач холбогдолгүй, үр дүнгүй зохицуулалтыг хүчингүй болгодог байх шаардлагатай.

- *Хориглох, хязгаарлах, зохицуулах бүтээгдэхүүнийг тодорхойлох систем.* Европын Холбоо, Австрали зэрэг улс бүтээгдэхүүний яаралтай сэрэмжлүүлгийн системийг ашигладаг. Энэ системийн тусламжтайгаар хүн, амьтан, ургамлын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд хор хохирол учруулах магадлалтай бүтээгдэхүүний мэдээллийг тогтмол цуглуулж, хориглох, хязгаарлах, зохицуулах үндэслэлийг судалж, тогтоодог.

Дүгнэж хэлэхэд гадаад худалдааны тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагааг нэгтгэн зангидах, уялдуулах, хариуцан ажиллах бие даасан бүтцийг байгуулах шаардлагатай байна. Энэхүү байгууллага нь гадаад худалдааны бодлогыг хариуцан зангидах бөгөөд дараах чиг үүргийг биелүүлэх боломжтой юм. Үүнд:

- Гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагууд хоорондын ажил, үүргийн *уялдааг хангах*;
- Олон талт судалгаа, шинжилгээ хийж, дотоод зах зээлээ хамгаалах, импортыг хязгаарлах, экспортыг дэмжих үндэслэл, хэрэгцээ байгааг тодорхойлох;
- Бүтээгдэхүүнд тавих эрүүл ахуй, аюулгүй байдал болон бусад шаардлагыг холбогдох байгууллагаар *үнэлүүлж*, техникийн зохицуулалт, нөхцөл шаардлагыг *тодорхойлуулах*;
- Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тарифын бус зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн тооцоолол хийх;
- Бүтээгдэхүүнд тавих шаардлага, зохицуулалтын талаарх мэдээллийг *нэгтгэх*, мэдээллийн сан үүсгэх, гадаад худалдаа эрхлэгчдэд *мэдээлэх*;
- Тарифын бус зохицуулалтын хэрэгжилтийг хангахад анхаарч, чанарын дэд бүтцийг бүрдүүлэх, гаалийн байгууллагыг *чадавхжуулах, дэмжих, сургах*, тоног төхөөрөмжөөр *хангахад* дэмжлэг үзүүлэх;
- Тарифын бус зохицуулалтын талаар ДХБ болон бусад олон улсын байгууллагад *мэдээлэх*, тэдний дүрэм, журамд *нийцүүлэх*;
- Шаардлагатай тохиолдолд ДХБ-ын хэлэлцээр, олон улсын дүрэм, журамд нийцүүлэн гомдол маргаан үүсгэх;
- Эрх мэдлийн хүрээнд олон улсын байгууллагууд, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай гэрээ хэлэлцээр хийх зэрэг үүргийг гүйцэтгэх юм.

ДҮГНЭЛТ

Дэлхийн улс орнуудын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын туршлагаас дүгнэхэд ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хэрэгжилт, худалдааг хөнгөвчлөх, чөлөөлөхөд чиглэсэн бүс нутгийн болон хоёр талт

хэлэлцээрүүдийн нөлөөгөөр гадаад худалдааг тарифаар зохицуулах боломж хумигдаж, эсрэгээр *тарифын бус зохицуулалтын хэрэглээ* нэмэгдсэн ерөнхий төлөв ажиглагдаж байна.

Тарифын бус арга хэмжээ нь олон хэлбэр төрөлтэй, тэдгээрийг олон улсын хэм хэмжээгээр нэгбүрчлэн зохицуулахад төвөгтэй, улс орон бүр харилцан адилгүй зорилго, үндэслэл шалтгаанаар тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлдгийн зэрэгцээ дотоодын хууль, дүрэм журамд нуугдмал байдлаар тусгах боломжтой зэрэг нь энэ төрлийн зохицуулалтыг *өргөн хүрээтэй ашиглах* боломжийг олгож байна.

2019 оны байдлаар дэлхийн нийт *импортын 80* орчим хувь, нийт *экспортын 40* гаруй хувь нь тарифын бус зохицуулалтад өртөж, *импортын барааны нэр төрөл* тутамд дунджаар 3, экспортын бараанд дунджаар 1,3 ТБАХ ногдож байна.

Тарифын бус зохицуулалтыг *хөгжингүй орнууд* илүү түлхүү хэрэгжүүлдэг бол тарифын бус арга хэмжээний хэлбэрүүдээс *TBT, SPS* арга хэмжээг хамгийн түгээмэл ашиглаж байна.

Ковид19 цар тахлын үед нэг талаас хүн амын нэн хэрэгцээт бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийг тасалдуулахгүй байх, нөгөө талаар өвчин, халдвар хил дамнан тархахаас сэргийлж гадаад худалдааг тарифын бус арга хэмжээгээр зохицуулах байдал эрс нэмэгдсэн нь эдийн засаг, нийгмийн олон талт зорилтыг биелүүлэхэд тарифын бус зохицуулалт *чухал ач холбогдолтойг* нотлон харуулж байна.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш гадаад худалдааг либералчлах, худалдааг хөнгөвчлөх бодлогыг тууштай хэрэгжүүлж байгаа ч улс орны эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлж төлөвлөх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжлийн дараагийн шатанд гаргах, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлээс хэт хараат байдлаас сэргийлэх, хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг илүү найдвартай хангахын тулд импортын бүтээгдэхүүнд тавих стандарт, шалгуурыг өндөрсгөх *бодит шаардлага* тулгарч байна. Нийгэм, эдийн засгийн эдгээр зорилтыг хэрэгжүүлэх нэг гарц нь гадаад худалдааг тарифын бус арга хэмжээгээр зохицуулах явдал юм.

Монгол Улс гадаад худалдааны хуульгүй, гадаад худалдааны асуудал хариуцсан бие даасан *яам, агентлаггүй*, тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой *бодлого, зохицуулалт, дүрэм журамгүй* байгаа нь тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд *сөрөг нөлөө* үзүүлж байна.

Монгол Улсад хилээр нэвтэрч буй бараанд хяналт тавих, экспорт, импортын зөвшөөрөл олгох, дотоод зах зээлээ хамгаалах, хэрэглэгчийн эрхийг хангах, шударга өрсөлдөөний орчинг бүрдүүлэх, эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг мөрдүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг тарифын бус арга хэмжээгээр зохицуулах

боломжтой чиг үүргийг ГХЯ, ХХААХҮЯ, СХЗГ, ГЕГ, МХЕГ, МЭЕГ, ШӨХТГ зэрэг төрийн байгууллагууд тус тусын чиг үүргийн хүрээнд хариуцан ажиллаж байна. Эдгээрээс ГХЯ-аас бусад байгууллагын үндсэн чиг үүрэгт гадаад худалдааны бодлогын асуудал хамааралгүй тул байгууллага бүр зөвхөн тус тусын үндсэн чиг үүрэгт хамаарах зорилтын хүрээнд асуудалд хандаж, гадаад худалдааг зохицуулах зорилт *харьяалалгүй* үлдэж байна.

Монгол Улс тарифын бус зохицуулалтыг *үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд*: (1) тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох; (2) батлан гаргасан аливаа зохицуулалтын хэрэгжилтийг хангахад шаардлагатай чанарын дэд бүтцийг (*хүний нөөц, лаборатори, тоног төхөөрөмж*) бүрдүүлэх; (3) тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн байгууллагууд хоорондын ажил, үүргийг уялдуулах, үүний тулд гадаад худалдааны асуудал хариуцсан бие даасан бүтэц, байгууллага бий болгох шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

Тарифын бус зохицуулалтын талаар хийсэн судалгааны үр дүнд үндэслэн тарифын бус зохицуулалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр дараах бодлого, үйл ажиллагаанд анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

Тарифын бус зохицуулалтын талаар баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар тодорхой бодлого, зорилго тусгагдаагүй байна. Иймд тарифын бус зохицуулалтыг гадаад худалдааны бодлогын хэрэгсэл болгон ашиглах талаар *хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах* шаардлагатай бөгөөд ингэснээр тэрхүү зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө гарч, төрийн байгууллагууд тухайн асуудалд анхаарлаа хандуулах нөхцөл бүрдэх юм.
- Монгол Улс гадаад худалдааны хуульгүй, тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгайлсан зохицуулалтгүй. Иймд *гадаад худалдааны хуулийг* батлах, түүнд гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулсан зүйл заалт тусгах, улмаар хуулийн хэрэгжүүлэхтэй холбоотой *дүрэм, журмыг* боловсруулах шаардлагатай байна.
- Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах хэд хэдэн хууль хэрэгждэг ч *хүнсний бус бүтээгдэхүүний* аюулгүй байдал зохицуулалтгүй явсаар ирсэн. Иймд төсөл, хэлэлцүүлгийн шатанд байгаа тус хуулийг батлах нь хүнсний бус импортын бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд үнэлгээ хийж,

хяналт тавих эрх зүйн хэм хэмжээг тодорхой болгож, тэрхүү чиг үүргийг хариуцсан төрийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх юм.

Тарифын бус зохицуулалтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх чиглэлээр:

- ДХБ болон бусад олон улсын байгууллагууд тарифын бус арга хэмжээг худалдаанд аль болох саад тотгор учруулахгүй, худалдааг гажуудуулахгүй байх нөхцөлөөр ашиглахыг зөвлөдөг. Иймд ТБАХ-г хэрэгжүүлэх *зайлшгүй үндэслэлийг* оновчтой илэрхийлснээр аливаа эсэргүүцэл, худалдааны маргаанаас сэргийлж чадна. Тухайлбал:
 - ДХБ тарифын бус зохицуулалтыг олон улсын худалдаанд сөрөг нөлөөтэй гэж үздэг ч *“гишүүн орны засгийн газар эдийн засаг, нийгмийнхээ хөгжлийг дэмжих зорилгоор дотооддоо бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх орон зайг үлдээсэн”* байдаг.
 - Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх (*хүн амыг ядууралд өртөхөөс сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг урамшуулах гэхмэт*) үндэслэлээр гадаад худалдааг, тэр тусмаа импортын урсгалыг хязгаарлах боломжтой.
 - Тарифын бус зохицуулалтаар дамжуулан чанарын баталгаа, хөдөлмөрийн стандарт, хүрээлэн буй орчны зохицуулалт, шударга худалдааны тогтолцоог бүрдүүлэх боломжтой.
 - ДХБ-ын гишүүн орнууд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТБАХ-г ДХБ-д мэдэгдэж, хянуулах үүрэгтэй ч онцгой тохиолдолд шууд хэрэгжүүлэх уян хатан боломжийг олгодог.

ДХБ-ын холбогдох хэлэлцээрт зааснаар ТБАХ-г хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг зөрчихгүй байх шаардлагатай. Үүнд:

- Аливаа зохицуулалт, зохицуулалтын шаардлага нь шинжлэх ухааны үндэстэй байх;
- Тарифын бус зохицуулалт нь худалдааг гажуудуулах, худалдааны зардлыг өсгөх зорилгогүй байх;
- Тарифын бус зохицуулалтын талаарх мэдээллийг нээлттэй, ил тод байлгах;
- Тарифын бус зохицуулалтыг ялгаварлан гадуурхсан байдлаар хэрэгжүүлэхгүй байх;
- Тарифын бус зохицуулалт зохих үр дүнд хүрч, зорилгоо биелүүлсэн бол зохицуулалтын шаардлагыг суллах, үйлчлэлийг цуцлах ёстой.

Түүнчлэн тарифын бус зохицуулалтын аливаа шаардлага, шалгуур, түүнийг илэрхийлэх тоон үзүүлэлт нь олон улсын хэм хэмжээнээс хэтэрсэн, хэт хатуу чанга тогтоох нь худалдааны түнш орнуудын эсэргүүцэлтэй тулгарах магадлалтай тул олон улсын стандартыг баримтлах, нутагшуулах шаардлагатай.

Тарифын бус зохицуулалт хариуцсан бүтэц бий болгох хүрээнд:

Тарифын бус зохицуулалтаар дамжуулан гадаад худалдааг, тэр тусмаа импортыг зохицуулах оролдлого үр дүн багатай байгаа нь гадаад худалдааны бодлогын асуудал хариуцсан бие даасан бүтэцгүй байгаатай холбоотой юм. Иймд гадаад худалдааны асуудал хариуцсан бүтэц, алба нэгжийг байгуулж, дараах чиг үүргийг хариуцуулах боломжтой юм. Үүнд:

- Төрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд гадаад худалдааны зохицуулалтыг ашиглах санал боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагууд хоорондын ялангуяа ТБАХ-г хэрэгжүүлэгч байгууллагуудын ажил, үүргийн уялдааг хангах, нэгтгэн зангидах, удирдан чиглүүлэх;
- Олон талт судалгаа, шинжилгээ хийж, дотоод зах зээлээ хамгаалах, импортыг хязгаарлах, экспортыг дэмжих үндэслэл, хэрэгцээг судалгаанд үндэслэн тодорхойлох;
- Яаралтай сэрэмжүүлэх системийг бүрдүүлж, түүгээр дамжуулан хориглох, хязгаарлах, зохицуулах шаардлагатай бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхой болгох;
- Бүтээгдэхүүнд тавих эрүүл ахуй, аюулгүй байдал болон бусад шаардлагыг холбогдох байгууллагаар үнэлүүлж, техникийн зохицуулалтад тусгах шалгуур, шаардлагыг тодорхойлох;
- Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тарифын бус зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн тооцоолол хийх;
- Нөхцөл байдалтай уялдуулан тарифын бус зохицуулалт, түүний шаардлагыг өөрчилж, шинэчилж байх;
- Бүтээгдэхүүнд тавих шаардлага, зохицуулалтын талаарх мэдээллийг нэгтгэх, мэдээллийн сан үүсгэх, гадаад худалдаа эрхлэгчдэд мэдээлэх;
- Тарифын бус зохицуулалтын хэрэгжилтийг хангахад анхаарч, чанарын дэд бүтцийг бүрдүүлэх, гаалийн байгууллагыг чадавхижуулах, дэмжих, сургах, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх;
- Тарифын бус зохицуулалтын талаар ДХБ болон бусад олон улсын байгууллагад мэдээлэх, тэдний дүрэм, журамд нийцүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд ДХБ-ын хэлэлцээр, олон улсын дүрэм, журамд нийцүүлэн гомдол маргаан үүсгэх;
- Эрх мэдлийн хүрээнд олон улсын байгууллагууд, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай гэрээ хэлэлцээр хийх.

Нэн тэргүүнд анхаарч хэрэгжүүлэх тарифын бус арга хэмжээний тухайд:

- Гадаад худалдаа, импортыг зохицуулах олон төрлийн тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой ч хэрэгжүүлэгч байгууллагын

боломж, хүчин чадлаас хамааран төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх эрсдэлтэй. Иймд хамгийн тулгамдсан асуудлыг шийдсэн, өнөөгийн боломж, нөхцөлд тохирсон арга хэмжээг сонгон тодорхойлж, түүнд төвлөрөн ажиллах нь оновчтой юм.

- Судалгааны хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой ТБАХ-г нэн тулгамдсан байдал, зохицуулалтын хамрах хүрээ, зохицуулалт хийх шаардлага, хэрэгжүүлэх боломж зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан ангилж (4.2.1-ээс үзнэ үү), (а) импортын бүтээгдэхүүнд тавих шаардлага, (б) дотоод зах зээлээ хамгаалах зохицуулалт гэсэн ангилалд хамруулсан арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэх чанарын дэд бүтэц, стандарт, техникийн зохицуулалтын хүрээнд:

- Тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн зохицуулалтын аливаа шаардлага, шалгуур хангагдсан эсэхийг үнэлэх, баталгаажуулах, нотлох хүчин чадал бүхий, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, итгэмжлэгдсэн лаборатори, чанарын дэд бүтэцтэй байх шаардлагатай. Чанарын дэд бүтцийг бүрдүүлэхийн тулд:
 - Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүчирхэг лабораториудтай болох;
 - Хүнсний бүтээгдэхүүний иж бүрэн судалгаа шинжилгээ хийх лабораторийг бий болгох, хүнсний аюулгүй байдалд судалгаа дүн шинжилгээ хийх, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;
 - Түүнд ажиллах мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэх;
 - Хил, гүний хяналт, шалгалтын мэдээллийн нэгдсэн программыг улсын хэмжээнд шинэчлэн боловсруулж, нэгдсэн нэг программаар гаалийн байгууллага болон лабораториуд сүлжээнд холбож, мэдээллээ солилцох;
 - Хилийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай (*гүний болон зайнаас хэмжих термометр, чийглэг хэмжигч, рН метр, индикаторууд зэрэг бүтээгдэхүүний шинж байдлыг газар дээр нь тодорхойлох дэвшилтэт технологитой, өндөр мэрдэмжтэй хэмжих хэрэгслүүд гэхмэт*) багаж, техник хэрэгслийн хангамж, хүрэлцээг сайжруулах; Гүний гаалийн хяналтын талбайд ажиллаж байцаагчдын ажиллах нөхцөл, сорьц авах зориулалтын сав, дээж, түр хадгалах хөргөгч, компьютер, техник төхөөрөмжөөр хангах;
 - Боловсон хүчнийг гадаад, дотоодын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаа, техник технологийн хөгжилтэй танилцуулах, туршлага судлуулах;
 - Импортын бодис, бараа бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан тохиолдолд шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд түр

битүүмжлэн хадгалах стандартын шаардлага хангасан хяналтын байгууллагын агуулахтай болох шаардлагатай.

- Импортын бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын шалгуур, шаардлагыг чангатгах, түүгээр дамжуулан импортыг хязгаарлах нэг шийдэл нь техникийн зохицуулалт юм. Техникийн зохицуулалтын ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд:
 - Хүчин төгөлдөр үйлчилж буй техникийн зохицуулалтыг чанд мөрдүүлэх;
 - Бусад улсад хамгийн их техникийн зохицуулалт хийж буй бүтээгдэхүүнийг судалж, тэдгээрийг туршлага болгох авч хэрэгжүүлэх;
 - Шинээр баталж хэрэгжүүлэх техникийн зохицуулалтыг ДХБ-ын зарчим, шаардлагын хүрээнд боловсруулах шаардлагатай байна.
- ❖ Техникийн зохицуулалтыг шинээр баталж хэрэгжүүлэхдээ ДХБ-ийн холбогдох хэлэлцээрийн дараах шаардлагыг хангасан ёстой. Үүнд:
 - Тухайн зохицуулалт нь хууль ёсны, нийгмийн ач холбогдолтой, тохиромжтой, зохистой, уялдаа холбоотой байх;
 - Шударга, ойлгомжтой, энгийн, үнэн зөв байх;
 - Ёс зүйтэй, хариуцлагатай, олон улсын түвшинд харьцуулагдахуйц байх;
 - Ил тод, нээлттэй байх;
 - Үндэслэлтэй, хэрэгцээтэй, эдийн засгийн үр ашигтай, уян хатан байх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

4.1. Европын холбооноос үзүүлж байгаа GSP+ системийн онцлог

Хураангуй: Европын Холбооноос өөрийн зах зээлд хөгжиж буй эмзэг эдийн засагтай улс орнуудын барааг гаалийн татвар ногдуулаагүй нийлүүлэх боломжийг олгож ирсэн. Энэ нь хөгжиж буй орнуудыг ядуурлаас бууруулах, олон улсын зарчимд үндэслэсэн ажлын байр бий болгох, түүний дотор хөдөлмөр, хүний эрхийг хамгаалахад дэмжлэг болно.

Европын Холбоо 1971 оноос хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжил, экспортыг дэмжих үүднээс гаалийн тарифын хөнгөлөлт олгох систем буюу “Хөнгөлөлтийн ерөнхий систем” (Generalized Scheme of Preferences (GSP))-ийг нэвтрүүлж, гурван жил тутам бараанд ногдуулах гаалийн тарифын хувь хэмжээг тууштай бууруулж, шинэчлэх бодлого баримталж ирсэн. Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг 2011 онд танилцуулж, 2012 оноос уг систем үйлчилж эхэлсэн.

Монгол Улс хөгжиж буй орны хувьд 1991 оноос Хөнгөлөлтийн Ерөнхий Системд хамрагдаж, импортын гаалийн тарифын хөнгөлөлт эдэлж байсан ч тус

улсаас экспортолсон ихэнхи гол нэрийн бараа нь гаалийн албан татвараас бүрэн чөлөөлөгдөж байгаагүй юм.

Монгол Улс Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP+)-д нэгдэн орсноос хойш 8 жил өнгөрч байгаа ч ашиглалтын хувь төдийлэн нэмэгдэхгүй байгаа бөгөөд Европын Холбооноос тавьж буй стандартын шаардлагыг хангасан бараа үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн чадавх дутмаг, аж ахуйн нэгж, иргэдийн мэдлэг ойлголт сул байгаатай холбоотой юм.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем, түүний онцлог, Монгол Улсын ашиглалтыг сайжруулах боломжийн талаар судлан үзлээ.

Түлхүүр үг: Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем, гаалийн тариф, гадаад худалдаа, хөнгөлөлттэй тариф гэх мэт.

Дэлхийн эдийн засгийн нөлөө бүхий өндөр хөгжилтэй улс орнууд буурай хөгжилтэй болон хөгжиж буй эмзэг эдийн засагтай оронд өөрийн улсад импортын барааны гаалийн тарифыг бууруулах, эсвэл ногдуулахгүйгээр бараагаа экспортлох боломжийг олгож ирсэн⁷². Түүнчлэн Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын гишүүн орнууд хоорондоо чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, эсвэл эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах замаар хөнгөлөлттэй гаалийн тарифын хувь хэмжээг эдлэх боломжтой билээ.

Европын Холбоо Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг нэвтрүүлснээс хойш бараг 50 жил өнгөрч байна. Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн үзэл баримтлалын хүрээнд "Сайн засаглал, Тогтвортой хөгжил"-ийн болзлыг хангасан эмзэг эдийн засагтай орныг хамруулж, 6,000 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх шинэ хөнгөлөлтийг бий болгосон ба олон улсын хэмжээнд "GSP+" хэмээн нэрлэдэг. Европын Холбооны GSP+ системийн бүтцийг зураг 15-аас харна уу. (МҮХАҮТ, 2019).

Зураг 15. Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн бүтэц

⁷² Одоогоос 50 гаруй жилийн өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурлаас эдийн засгийн хөгжлөөр эмзэг, буурай улс оронд дэлхийн зах зээлд нэвтрэх боломж олгох зорилгоор өндөр хөгжилтэй орнууд туслахыг уриалсан байдаг (Union, 2020).

Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн Журам (GSP+)	I Бүлэг: Нийтлэг зүйл
	II Бүлэг: Ерөнхий зохицуулалт
	III Бүлэг: Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалт
	IV Бүлэг: Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалт
	V Бүлэг: Түр цуцлалт ба нийтлэг бүх зохицуулалт
	VI Бүлэг: Хамгаалалтын арга хэмжээний тухай зүйл
	VII Бүлэг: Нийтлэг заалт
	VIII Бүлэг: Төгсгөлийн заалт
Хавсралт I-V	

Эх сурвалж: (Council, 2012)

Европын Холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Систем нь Дэлхийн Худалдааны Байгууллагын шаардлагууд, ялангуяа 1979 онд Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээр (ТХЕХ)-ийн хүрээнд батлагдсан гишүүн орнууд, хөгжиж буй орнуудад илүү таатай ялгавартай нөхцөл олгох, харилцан хамаарал, оролцооны тухай зохицуулалтын заалтуудтай нийцэх ёстой.

Евро Парламент болон Европын Холбооны Комиссийн 2012 оны 978/2012 дугаар тогтоолоор “Хөнгөлөлтийн ерөнхий системийг хэрэгжүүлэх тухай журам”-ыг баталсан ба уг журам 2023 оны 12 дугаар сарын 31 хүртэл үйлчилнэ. Энэхүү журамд (Зүйл 1.2):

- a) Ерөнхий хөнгөлөлт;
- b) Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлт;
- c) Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай хөнгөлөлт (зэвсгээс бусад бараа) гэсэн гурван тарифын хөнгөлөлтүүдийг зохицуулсан байна.

Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг хэрэгжүүлэх тухай журмын хавсралтаар холбогдох зүйлийн хүрээнд хөнгөлөлт эдлэх орнуудын жагсаалтыг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- ✓ Хавсралт I: 3 дугаар зүйлийн дагуу хөнгөлөлт эдлэх орнуудын жагсаалт (153+2⁷³ улс);
- ✓ Хавсралт II: Зүйл 1.2 Ерөнхий хөнгөлөлтөд хамрагдсан улсууд (89+1⁷⁴ улс);
- ✓ Хавсралт IV: Зүйл 1.2-ын “с” заалт. Тусгай хөнгөлөлтөд хамрагдсан нэн буурай хөгжилтэй улсууд (89+1⁷⁵ улс);
- ✓ Хавсралт V: Хамтын нийгэмлэгийн тарифын хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдах улсууд болон нутаг дэвсгэр (178 улс, нийгэмлэг).

⁷³ Беларусь, Бурма/ Мьянмар (бүхэлдээ болон зарим нэр төрлийн барааны үечилсэн тарифын бууралттай орон).


⁷⁴ Бурма/ Мьянмар (үечилсэн тарифын бууралттай ерөнхий хөнгөлөлтөд хамрагдсан орон).

⁷⁵ Бурма/ Мьянмар (үечилсэн тарифын бууралттай нэн буурай хөгжилтэй орон).

Хөнгөлөлт эдлэх улсын эдийн засгийн хөгжлийн түвшин болон Европын Холбооны дотоодын зах зээлийг хамгаалах зорилгоор зарим нэр төрлийн барааг сонгон хөнгөлөлт эдлүүлэх жагсаалтыг гаргасан байна.

Монгол Улс Европын Холбооноос батлан гаргасан дээрх Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дээрх хавсралтад бүгдэд нь хамрагдсан. Энэхүү хөнгөлөлтийг гарал үүслийн гэрчилгээний үндсэн дээр эдэлж байна. Хөнгөлөлтийн Ерөнхий систем эдлэхэд холбогдох шаардлагыг хангасан байх ёстой.

Зураг 16. Европын Холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн гол шаардлага



Европын Холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу:

- ✓ Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (Generalised Scheme of Preferences GSP): 6,200 гаруй нэр төрлийн барааны тарифыг бууруулсан;
- ✓ Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP+): 6,000 гаруй нэр төрлийн бараа гаалийн тарифыг тэглэсэн;
- ✓ Зэвсгээс бусад бүх бараа (Everything but Arm EBA): Зэвсгээс бусад бүх бараа нь татвар, квотгүй Европын Холбооны 25 улсын зах зээлд нэвтрэх боломж бүрдсэн.

Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн шалгуурыг дараах байдлаар тодорхойлсон байдаг:

- Бага болон дундаас доош орлоготой орон (Үндэсний нийт орлого 4,036 ам. доллар);
- Европын Холбооны өөр хөнгөлөлтийн санаачилгад хамрагдаагүй;
- Хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, сайн засаглалтай холбоотой 27 олон улсын хэлэлцээрт нэгдэн орсон байх.

Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем нь 6,000 гаруй нэр төрлийн барааны гаалийн тарифыг “тэг”-лэсэн бөгөөд үүний үр дүнд 500 сая хэрэглэгчид зах зээлээ өргөтгөн олон улсын худалдаанд оролцож, дэлхийн импорт, экспортын 16 хувийг эзлэх эдийн засгийн үр ашиг бий болгосон. Мөн олон талт худалдааны системийн тогтолцоонд нэгдэх, улмаар эдийн засгийн тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих үр дүнг үзүүлнэ.

Европын Холбооноос энэхүү шинэ системийг хэрэгжүүлэхэд Холбооны Гаалийн Хуулийн 70 дугаар зүйлд “Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг зохих ёсоор ашиглахын тулд ашиг хүртэгч орнууд дараах зүйлсийг хэрэгжүүлнэ:

- Дүрмийг хэрэгжүүлэх, удирдахад шаардагдах захиргааны бүтэц, тогтолцоог бий болгож, тогтвортой ажиллуулах;
- Эрх бүхий байгууллагуудыг Европын Комисс болон гишүүн орнуудын гаалийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжоор хангах;
- Европын Комисс (эсвэл гааль) тухайн улсад Хөнгөлөлтийн ерөнхий системийн схемийг зохистой удирдлагаар хангаж буй эсэхийг шалган баталгаажуулах хүсэлт гаргасан тохиолдолд шаардлагатай Комисс, эсвэл гаалийн байгууллагыг газар дээр нь очиж шалгалт хийхэд шаардагдах дэмжлэг үзүүлэх” гэж заасан.

Уг системд хамрагдахад гаалийн байгууллага хяналт тавих, үйл ажиллагааг хөнгөвчлөхөд гол үүрэгтэйгээр оролцохыг дээрх хуулийн заалт тодорхойлсон. Иймд “Гаалийн байгууллагын эрх мэдэл, үүрэг хариуцлага”-ыг Холбооны гаалийн хуулийг хэрэгжүүлэх журмын 108 дугаар зүйлд “Европын Холбооны гишүүн орнуудын гаалийн байгууллагын хүсэлтээр бараа бүтээгдэхүүний гарал үүслийн байдлын баталгаажуулалтыг хийх (Норвеги, Швейцар); өөрийн санаачилгаар экспортлогчдод тогтмол хяналт тавих” гэж тусгасан байна.

Захиргааны хамтын ажиллагаанд “ашиг хүртэгч орнуудын эрх бүхий байгууллагын хамтын ажиллагаа, гарал үүслийн мэдүүлэг шалгах, хяналт тавих, баталгаажуулах” болон бусад асуудлууд багтсан. Энэ талаар хэрхэн ажиллах зарчмыг Европын Холбооны Гаалийн хуулийг хэрэгжүүлэх журмын 109 дүгээр зүйлд дэлгэрэнгүй тусгасан байна.

Шинэчилсэн системийн зорилгоор “Бүртгэгдсэн экспортлогчийн систем”- (Registered Exporter System/ REX)-ийн хяналтын төлөвлөгөө боловсруулж, ихэнх улс оронд энэхүү системийн хэрэгжилтийг гаалийн байгууллага, эсвэл төрийн эрх бүхий байгууллага хэрэгжүүлж байна. Бүртгэгдсэн экспортлогчийн системийн хэрэгжилт, хяналтыг төрийн эрх бүхий байгууллага хэмээн заасан боловч зарим улс орны зарим улс оронд Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон гаалийн байгууллага хамтран хэрэгжүүлж байна.

4.2. Монгол Улс Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системд хамрагдсан байдал, ирээдүйн боломж

Европын Холбооны зах зээлд Монгол Улсын худалдаа эрхлэгчид өөрийн барааг нийлүүлэх өргөн боломжийг Хөнгөлөлтийн ерөнхий систем олгосон. Энэхүү системийг олгож эхлээд 50 жил болж байгаа хэдий ч Монгол Улсын худалдаа эрхлэгчдийн хувьд 1991 оноос уг системд хамрагдаж эхэлсэн. Европын Холбооны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системээр Монгол Улсын худалдаа эрхлэгчдэд гаалийн тариф шингээгүй үнээр өөрийн барааг уг

зах зээлд гаргах өргөн боломж бүрдсэн. Өмнөх Хөнгөлөлтийн Системийн дагуу гаалийн тарифыг тэглээгүй. Харин тодорхой хэмжээгээр бууруулсан татвар ногдуулж байсан.


Монгол Улсын экспортын бараанаас голдуу нэхмэл, оёмол, сүлжмэл бараа Хөнгөлөлтийн ерөнхий системд 1991 оноос хамрагдаж 9.6 хувийн гаалийн тарифтай байсан. Мөн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт хэлэлцээр 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсон нь энэ салбарын үйлдвэрлэлийг бууруулахад хүргэсэн. Сайн тал нь Монголын худалдаа эрхлэгчид уг системд хамрагдах бага боловч мэдлэг, үйлдвэрлэл, технологи, стандартын талаарх туршлага хуримтлуулсан.

Европын Холбоо 2005 оноос олон улсын гадаад худалдааг чөлөөлөх ажлын хүрээнд дэлхийн томоохон зах зээлүүд БНХАУ-аас гаралтай оёмол, сүлжмэлийн бүтээгдэхүүнд ногдуулж байсан квотын системийг халсан. Энэхүү үйл явдлыг БНХАУ баяртайгаар хүлээн авч өөрсдийн экспортыг нэмэгдүүлэх, дэлхийд ноолууран бүтээгдэхүүн нийлүүлэлтээр тэргүүлэх зорилго тавин эрчимтэй ажиллаж байна. Нэг талаас олон улсад ийнхүү квотын системийг халсан явдал нь Монголын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд таагүй байсан ч нөгөө талаас Европын холбооны зүгээс манай улсыг хөнгөлөлттэй тарифаар үйлчлэх улс орнуудын тоонд оруулсан нь манай улсын ноолуурын салбарт таатай орчныг бүрдүүлж өгч байна. Өдгөө БНХАУ барааны үйлдвэрлэлийн дэлхийн үнийн сүлжээнд⁷⁶ зонхилох хувийг эзэлж байна.

Монгол Улс тус системд хамрагдаад өдгөө бараг 30 жил болж байна. Иймд сүүлийн 16 жил Европын Холбоотой хийсэн гадаад худалдааны мэдээлэл, ялангуяа тус холбооны гишүүн улсад экспортолсон барааны мэдээллийг харьцуулан судаллаа. Сүүлийн 16 жилд Монгол Улс Европын Холбоотой 13,09 тэрбум ам. долларын гадаад худалдаа эрхэлжээ. Үүнээс импорт 8,04 тэрбум ам. доллар (61,4 хувь), экспорт 5,05 тэрбум ам. доллар (38,6 хувь)-т тус тус хүрчээ. Европын Холбооны Улстай хийсэн гадаад худалдааны бараа эргэлтийг зураг 17-оос харна уу.

⁷⁶ Дэлхийн үнийн сүлжээ (ДҮС) нь аливаа нэг бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын дараах үйл ажиллагаа (эдгээрийг бараа нийлүүлэх сүлжээ гэдэг)-г газарзүйн түвшинд зохицуулах шаардлагатай тохиолдолд, тэдгээрт оролцсон хүмүүс болон үйл ажиллагааг тодорхойлдог. ДҮС нь үйлдвэрлэлийн түвшний үнийн сүлжээтэй адил боловч дэлхийн түвшний үйл ажиллагааг хамардаг. Барааг дотоодод болон гадаадад боловсруулах горимууд нь ДҮС-ний нэг хэсэг юм (Д.Баярсайхан, Э.Чинбат, 2020).

Зураг 17. Монгол Улсын Европын Холбооны гишүүн орнуудтай хийсэн гадаад худалдаа, сая, ам доллар



Эх сурвалж: Гадаад худалдаа, 2005-2020

Зураг 17–оос харахад Монгол Улсын Европын Холбооны гишүүн улсуудтай хийсэн гадаад худалдааны сүүлийн 16 жилийн мэдээллээс харахад 2020 оны гадаад худалдаа 2,28 тэрбум ам. долларт хүрсэн нь хамгийн өндөрт өсөлтөд тооцогджээ. Жил бүрийн гадаад худалдааны мэдээллээс харахад худалдааны хэмжээ жигд өсөлт байхгүй, өөрөөр хэлбэл тогтмол явагдаагүй, ялангуяа экспортын хувьд алтны экспортоос улбаалан гэнэт огцом өсөх, буурах байдал түгээмэл байна. Европын Холбооны гишүүн улсуудтай хийсэн жил бүрийн гадаад худалдааны хэмжээг өнгөрсөн оных нь мөн үетэй харьцуулахад харилцан адилгүй байгааг хүснэгт 18–аас харна уу.

Хүснэгт 18. Монгол Улсын Европын Холбоотой хийсэн гадаад худалдааны өсөлт, бууралт (2006-2020 он)

Он	Экспорт		Импорт		Нийт	
	Дүн (сая ам.долл.)	Өөрчлөлт, %	Дүн (сая ам.долл.)	Өөрчлөлт, %	Дүн (сая ам.долл.)	Өөрчлөлт, %
2006	108,2	82	121,7	100	229,9	91
2007	118,8	110	219,3	180	338,1	147
2008	434,4	366	293,2	134	727,6	216
2009	224,0	52	249,9	85	473,9	65
2010	128,7	57	313,4	125	442,1	93
2011	95,3	74	709,9	227	805,2	182
2012	66,9	70	706,8	100	773,8	96
2013	286,8	429	723,6	102	1010,5	131
2014	503,5	176	478,7	66	982,2	97
2015	403,5	80	372,6	78	776,1	79

2016	645,5	160	373,5	100	1019,1	131
2017	727,1	113	472,1	126	1199,2	118
2018	252,9	35	575,7	122	828,7	69
2019	362,5	143	586,5	102	949,1	115
2020	563,4	155	1724,4	294	2287,8	241

Эх сурвалж: Судлаачийн Үндэсний статистикийн хорооноос Гадаад худалдааны мэдээлэлээс хийсэн тооцоолол

Хүснэгт 18-аас харахад Монгол Улсаас Европын Холбооны гишүүн улсуудад экспортолсон барааны хэмжээ 2020 онд 1,72 тэрбум ам. долларт хүрсэн нь хамгийн өндөр өсөлтөд тооцогдсон ба өмнөх оных мөн үетэй харьцуулахад экспорт 294 хувиар өссөн байна⁷⁷. Барааны бүтцээр судлан үзэхэд 28,46 тонн, 1,6 тэрбум ам. долларын үнэ бүхий БТКУС-ийн 7108 зүйлийн түвшинд ангилагдах “Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт”-ыг Швейцар Улсад экспортолсонтой холбоотой юм.

Европын Холбооны гишүүн улсуудад 2015-2020 онд экспортолсон барааны бүтцэд дүн шинжилгээ хийхэд нэхмэл, сүлжмэл эдлэл экспортын 93 хувийг эзэлсэн нь ашиглалтын хувийг 84-д хүргэжээ (Алтны экспорт ороогүй).

Европын Холбооноос Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн ашиг хүртсэн Болив, Армен, Габо Верд, Киргизистан, Парагвай, Пакистан, Монгол, Филиппин, Шри Ланк Улсын гүйцэтгэлд шинжилгээ хийсэн байна.

Монгол Улсаас Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системд хамрагдан экспортолсон барааны хэмжээ ерөнхийдөө тогтвортой, 2018 онд 16,5 сая ам. долларт хүрсэн нь нийт экспортын 23 хувийг эзэлсэн. Энэхүү хөнгөлөлт эдэлсэн барааны 87 хувийг оёмол, сүлжмэл бараа эзэлжээ. Монгол Улс Шинэчилсэн Ерөнхий Системийн хэрэглээ буюу хөнгөлөлттэй худалдааны тарифын хэрэглээг 84 хувьтай, гэхдээ энэ нь нэг салбарын байгаа тул цаашид зарим чиглэлээр сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Бүртгэгдсэн экспортлогчийн систем

Европын холбоонд бараа бүтээгдэхүүнээ энэхүү нөхцөлөөр экспортлох аж ахуйн нэгж нь “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-ийг хэрэглэх болсон нь Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP+)-ийн гол онцлог юм. Монгол Улс 2020 оноос Европын Холбоо, Норвеги, Швейцар, Турк улсад бараа экспортлох зорилгоор Бүртгэгдсэн Экспортлогчийн Систем (REX)-ийг нэвтрүүлсэн.

Баримт бичгийн хүрээнд анхандаа гаалийн байгууллага Бүртгэгдсэн Экспортлогчийн Системд хяналт тавих, хэрэгжилтийг хангахаар тусгасан боловч улс орны үндэсний бодлогоос хамаарч, экспортлогчдыг бүртгэх, өргөдөл, үйлчилгээ хариуцах болон бусад ажлыг Худалдаа Аж Үйлдвэрийн

⁷⁷ Үүнтэй ижил байдлаар 2017 онд экспорт 727.16 сая ам. долларт хүрсэн нь дараагийн өндөр өсөлт байсан. Гэсэн хэдий ч 2018 онд энэ хэмжээ 65 хувь буюу 474 сая ам. доллараар буурч, 2019 оны экспортыг 2018 онтой харьцуулахад 43 хувиар өссөн байна.

Танхим хариуцан хамтран ажиллаж байна. Европын Холбооноос 2017-2021 онд хэрэгжүүлсэн “Монголын худалдааг дэмжих (Trade related assistance to Mongolia)” төслийн хүрээнд энэ чиглэлээр төрийн институцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор холбогдох албаны уулзалт, Европын Холбооны туршлагаас газар дээр нь суралцах, гадаад, дотоодын сургалт зохион байгуулах, гарын авлага, заавар гаргасан байдаг.

Монгол Улсын хяналт тавих эрх бүхий байгууллага болох Гадаад Хэргийн Яам, Гаалийн Ерөнхий Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гүйцэтгэх чиг үүргийг зураг 18–аас харна уу.


Зураг 18. Европын Холбооны Бүртгэгдсэн экспортлогчийн системд хяналт тавих Монгол Улсын эрх бүхий байгууллагын гүйцэтгэх үүрэг

<p>Гадаад харилцааны яам:</p> <ul style="list-style-type: none"> • Үндэсний хэмжээнд Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг нэвтрүүлэхтэй холбоотой бодлого, чиглэлийг удирдлага, чиглэлээр ханган ажиллах; • Европын Холбоотой харилцах эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага.
<p>Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим:</p> <ul style="list-style-type: none"> • Аж ахуйн нэгжүүдийн бүртгэл, үйлчилгээг хариуцах (Өргөдөл гаргах, бүртгэлд орсон мэдээ, барааны гарал үүслийн үнэн зөв эсэхийг шалгах, мэдээллийн санг шинэчлэх); • Экспортлогчдын бүртгэл (REX-ийн зориулалттай, ГХЯ-д Гаалийн Ерөнхий Газраас хүргүүлсэн тайлан)- д хяналт тавих, өөрчлөх, хүчингүй болгох) үүрэгтэй.
<p>Гаалийн ерөнхий газар:</p> <ul style="list-style-type: none"> • Бүртгэгдсэн экспортлогчийн хяналт; • Барааны гарал үүслийг хянах; • Гарал үүслийн мэдүүлгийн үнэн зөв эсэхийг шалган баталгаажуулах.

Бусад улс оронтой харьцуулахад Монгол Улсаас цөөхөн нэр төрлийн бараа экспортолдог тул Бүртгэгдсэн Экспортлогчийн Системд тавих хяналтын үйл ажиллагаанд ямар нэгэн томоохон хүндрэл бэрхшээл тохиолдоогүй байна.

Европын Холбооноос шинэ системийг нэвтрүүлэхдээ үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, мэдээллийг урьдчилан хянах, түүнчлэн “Итгэ, Хяна” гэсэн шинэ зарчмыг оруулж ирсэн. Энэ нь худалдааг хөнгөвчлөх арга хэмжээтэй уялдаж байна. Энэхүү шинэ системийг нэвтрүүлэхтэй холбоотой хяналтын үе шатыг зураг 19–өөс харна уу.

Зураг 19. Бүртгэгдсэн экспортлогчийн системийн хяналтын үе шат



Улс орнууд бэлтгэл үе шатаа сайтар хэрэгжүүлснээр дараагийн хоёр үе шат хялбар хэрэгжих боломжтой болно.

Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу бараагаа экспортлоход Бүртгэгдсэн Экспортлогчийн Системийн дагуу бүртгүүлэх гол зорилго нь барааны гарал үүслийг үнэн зөв тодорхойлохтой холбоотой.

Гарал үүслийг үнэн зөв тодорхойлох асуудал Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрт тусгагдсан байдаг. Барааны гарал үүслийг үнэн зөв тодорхойлох асуудал гадаад худалдаанд гол байр суурь эзэлдэг. Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу хөнгөлөлттэй тариф эдлэх барааны кодолсон жагсаалтыг ДГБ-ын Уялдуулсан системийн конвенцийн⁷⁸ дагуу гаргасан.

Гарал үүслийн дүрэм

ДХБ-аас гишүүн орнуудын хооронд ямар нэгэн худалдааны саад тотгоргүй худалдааг аль болох либералчлах бодлого баримтлан тус байгууллагын олон талт худалдааны системийн хэлэлцээрт үндсэн зарчмыг тусгасан байдаг. Эдгээрийн нэг нь нэн тааламжтай болон хөнгөлөлттэй гаалийн тарифыг гишүүн орнууд хоорондоо эдлэх боломж олгосон явдал юм. Иймд ДХБ-ын гишүүд хоорондоо хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх зорилгоор Эдийн засгийн түншлэл, эсвэл Чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна.

⁷⁸ ДГБ-ын Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенц нь олон улсын худалдааны барааг нэг мөр тодорхойлох, ангилал, кодлох замаар худалдаа болон мэдээлэл солилцоог хөнгөвчлөх зорилготой. Уялдуулсан системийг гаалийн тариф тогтоох, мөн гадаад худалдааны статистик мэдээлэл гаргах зорилгоор ашигладаг. Тус конвенцийн хэлэлцэн тохиролцогч талын тоо 2021 оны 8 дугаар сарын 25-ны байдлаар 158-д хүрсэн хэдий ч олон улсын худалдааны бараа эргэлтийн 98 хувь нь уг конвенцийн дагуу явагддаг (ДГБ, 1988) .

Монгол Улс Европын Холбоотой дээрх төрлийн хэлэлцээр байгуулаагүй боловч судалгааны ажлын гол тусгагдахуун болсон “Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем” (GSP+)-д гарал үүслийг үнэн зөв тодорхойлох асуудал чухал байр суурь эзлэх талаар өмнө дурдсан. Барааны гарал үүслийг дараах гурван нөхцөлөөр тодорхойлно:

1. Бүрэн үйлдвэрлэсэн;
2. Нийлүүлж угсарсан;
3. Үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэн⁷⁹.

Чадавхыг бэхжүүлэх: Европын холбооны комиссын Татвар, гаалийн яамны Бүртгэгдсэн Экспортлогчийн Систем хариуцсан нэгжээс “Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем, түүний үндэслэл, ач холбогдол, системийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, хэрэглэгчдийн удирдлага, эрх олгох, засвар оруулах, цуцлах болон эргэн сэргээх” талаар онол, практикийн мэдлэгийг хөтөлбөрт хамрагдах орны гаалийн байгууллагын албан хаагчдад олгох ажлыг 2017 оноос эхлэн хэрэгжүүлжээ.

Европын Холбооноос Монгол Улсын худалдаа эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх, уг системийг хэрэглэх боломж олгох зорилгоор янз бүрийн хугацаатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсээр ирсэн. Эдгээр санаачилгын хүрээнд дараах хоёр төсөл хэрэгжиж Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлжээ:

Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP+) механизмаар дамжуулан хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь төсөл

Глоб Интернэшнл төв ардчиллыг дэлгэрүүлэгч “Democracy Reporting International” олон улсын байгууллагатай хамтран 1,5 жилийн хугацаатай төслийг амжилттай хэрэгжүүлж 2019 онд төсөл хэрэгжиж дууссан байна. Төслийн хүрээнд “GSP+ механизмын Монгол дахь ашиглалт, бизнес ба хүний эрхийн уялдаа холбоо, Европын холбооноос олгож буй эдийн засгийн урамшууллын хариуд хүлээж буй үүрэг хариуцлага болон холбогдох зөвлөмж” боловсруулжээ. Төслийн гол зорилго нь GSP+ механизм буюу Европын Холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн талаар олон нийт, тэр дундаа төр, бизнес, иргэний нийгмийн салбарынхны мэдлэг ойлголтыг дээшлүүлж, ашиглалтын хэмжээг нь нэмэгдүүлэх замаар эдийн засаг, хүний эрх, хөдөлмөр

⁷⁹ а) тухайн улсын газрын гадаргуу, түүний хэвлий, нутаг дэвсгэрийн ус, түүний ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн; (b) тухайн улсад ургуулж, хураан авсан ургамал, хүнсний ногоо; (c) тухайн улсад төрсөн, бойжсон амьд амьтан; (d) тухайн улсын мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн; (e) мал амьтны мах, махан бүтээгдэхүүн; (f) тухайн улсын нутаг дэвсгэрт агнасан ан, загас агнуурын бүтээгдэхүүн; (g) тэнгисийн загас агнуурын бүтээгдэхүүн; (h) нутаг дэвсгэрийн усанд үл хамаарах далай, тэнгисийн ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн; уг бүтээгдэхүүнээр тухайн орны хөлөг онгоцон дээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн; (j) тухайн улсад гагцхүү түүхий эдийн зориулалтаар цуглуулсан хуучин эд зүйлс; (k) үйлдвэрийн хог, хаягдал; (l) тухайн улсын нутаг дэвсгэрийн усанд үл хамаарах далай, тэнгисийн ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн; (m) (a) - (l) -д заасан бүтээгдэхүүнээр үйлдвэрлэсэн бараа.

эрхийн чиглэлд тодорхой ахиц үзүүлэх явцыг хурдасгахад оршжээ. Төслийн хугацаанд Глобинтернэшнл төв нь Гадаад харилцааны яам; Хууль зүй, дотоод хэргийн яам; Нэгдсэн Үндэсний Байгууллага; Хүний эрхийн үндэсний комисс; Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим; Монголын хуульчдын холбоо; Хэвлэл мэдээллийн зөвлөл зэрэг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтын ажиллагаатай ажилласан байна. Үүний үр дүнд төслийн багаас иргэний нийгэм, хэвлэл мэдээллийг чадавхжуулах сургалт, сэтгүүлчдийн аюулгүй байдал эрх зүйн орчны мониторинг, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зурагт хуудас, дүрс бичлэг, нөлөөллийн уулзалтуудаас эхлээд Төв, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Увс аймаг болон Улаанбаатар хотноо тус тус Захиргааны танхимын уулзалтыг амжилттай зохион байгуулжээ.

Европын Холбооны Худалдааг дэмжих TRAM төсөл

Уг төслийн хүрээнд Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системтэй холбоотой дээр дурдсан 27 гэрээ, хэлэлцээр, тэр дундаа хүний эрх, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой 15 олон улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд Монгол улсыг дэмжин ажиллажээ. Төсөл нь “Худалдааны бодлогыг дэмжих, Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны чадавхыг бэхжүүлэх, Уул уурхайн бус гаралтай барааны экспортыг нэмэгдүүлэх” гурван бүрэлдэхүүнтэйгээр 2018 оны 3 дугаар сараас 2021 оны 7 дугаар сарыг дуустал хугацаанд амжилттай хэрэгжжээ.

Төслийн гуравдугаар бүрэлдэхүүний хүрээнд “Чацаргана, чацарганы тос, ботго, сарлагын ноос, ноолууран бүтээгдэхүүн, арьс ширэн эдлэл, органик гоо сайхны бүтээгдэхүүн”-ийг Европын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор евро стандарт, импорт, экспортын бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхыг дээшлүүлсэн байна. Түүнчлэн Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системд хамрагдах 6000 нэр төрлийн барааг гаалийн тарифгүй экспортлох үйл ажиллагааг сурталчлах, худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх, бодлогын баримт бичиг боловсруулах, гарын авлага, зөвлөмж гаргах зэрэг ажлыг амжилттай хэрэгжүүлжээ.

Төсөл эхэлсэн эхний жилд нэр бүхий 27 олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг Монгол Улсад хэрхэн ханган ажиллаж байгаа байдалд Европын холбооноос баг ирж мониторинг хийсэн байна. Үүний үр дүнд Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системээс Монгол Улс ямар үр дүн хүртэж байна, хэрэгжилт хэр байна зэргийг мэдэх боломжтой болжээ.

Дүгнэлт

Өнөө үед дэлхийн эдийн засагт нөлөө бүхий өндөр хөгжилтэй орон, эдийн засгийн бүс нутаг, гаалийн холбоод хөгжиж буй буурай хөгжилтэй орны эдийн

засгийн өрсөлдөх чадварыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, улмаар гадаад зах зээлд гарах боломж олгох чиглэлээр хэрэгжүүлж ирсэн олон санаачилгын нэг нь Европын Холбооны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий систем юм. Уг систем нь 50 жилийн өмнө эхэлсэн бөгөөд 2012 оноос системийг шинэчлэн Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий систем буюу дэлхийн хэмжээнд “GSP+” нэртэйгээр түгсэн.

Монгол Улс уг системийн дагуу оёмол, сүлжмэл эдлэлийг Европын зах зээлд гаргах боломж бүрдэн, БНХАУ уг системд хамрагдаагүй байсан үед буюу 1991-2004 онд бүрэн ашиглаж иржээ. Энэ үед БНХАУ, Хонг Конгын хөрөнгө оруулалттай олон тооны оёдлын үйлдвэрүүд ажиллан, гадаадын барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын дагуу Европын зах зээлд бараагаа гаргаж байсан. Эндээс энэ төрлийн хөнгөлөлтийн систем нь ажиллах хүчний зардал багатай хөгжиж буй орнуудад ажлын байр бий болгох, ядуурлаас гаргах, хүний эрхийг дээдлэх боломж олгосныг харж болно.

Европын Холбоо 2005 оноос олон улсын худалдааг чөлөөтэй явуулах ажлын хүрээнд дэлхийн томоохон зах зээлүүд БНХАУ-аас гаралтай оёмол, сүлжмэлийн бүтээгдэхүүнд ногдуулж байсан квотын системийг халсан. Нэг талаас дэлхийн хэмжээнд ийнхүү квотын системийг халсан явдал нь Монголын оёмол, сүлжмэл эдлэл үйлдвэрлэгчдэд таагүй байсан ч нөгөө талаас Европын холбооны зүгээс манай улсыг хөнгөлөлттэй тарифаар үйлчлэх улс орнуудын тоонд оруулсан нь манай улсын аж үйлдвэрийн салбарт таатай орчныг бүрдүүлжээ.

Сайн тал нь Монголын худалдаа эрхлэгчид уг системд хамрагдах бага боловч мэдлэг, үйлдвэрлэлийн туршлага хуримтлуулсан.

Дутагдалтай тал нь төрөөс нэгдсэн бодлого баримтлах ажил дутагдалтай байснаас 2005 оноос уг үйлдвэрүүд хаалга барьсан нь эргээд энэ салбарт хөлөө олсон хэдхэн ноос, ноолуурын үйлдвэр өнөөдөр хэвийн хэмжээнд үйлдвэрлэл эрхэлж байгаагаас харагдаж байна.

Уг системээр “Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалт”-ын үр дүнг сайжруулах зорилгоор хүний эрх, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан 27 олон улсын хэлэлцээрийн өнөөгийн хэрэгжилтийг хамтад нь авч үзэж, нэгдсэн мониторинг хийсэн үр дүнд хүрчээ. Мөн энэ чиглэлээр цаашид Монгол Улсад тулгараад байгаа “Унаач хүүхдүүдийн асуудал, Хүний эрхийн хамгаалагчдын байдал, Цаазын ялыг нэвтрүүлэхтэй холбоотой нийгмийн маргаанууд, Албадан хөдөлмөр зэрэг асуудлуудад мониторинг хийх” ажлыг төлөвлөсөн нь сайшаалтай байна.

Өөрөөр хэлбэл хүний эрхийг дээдлэх, хөдөлмөр эрхлэлтийг хөхиүлэн дэмжих (шинэ ажлын байр бий болгох), улмаар ядуурлыг бууруулах нь Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг хэрэгжүүлснээр гарах үр дүн байлаа.

Монгол Улс уг системийг ашиглаж байгаа боловч, уламжлалт ноос, ноолууран эдлэлээс хэтрэхгүй байгаа нь ашиглалт сайн гэж хэлэх боломжгүйг

илтгэсэн. Энэ тал дээр төрийн нэгдсэн бодлого баримтлан тодорхой салбарыг дэмжих шаардлага гарсаар байна.

Европын Холбооноос уул уурхайн бус гаралтай барааны экспортыг нэмэгдүүлэх, худалдааны бодлого, худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны чадавхыг бэхжүүлэх, сайн засаглалыг хөгжүүлэх чиглэлийн чадавхыг бэхжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлжээ. Эдгээр төслийн хүрээнд “Чацаргана, түүний тос, ботго, сарлагын ноос ноолууран бүтээгдэхүүн, органик гоо сайхны бүтээгдэхүүн”-ийг Европын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэ стандарт турших, экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, тариф, татварын бодлогын талаар чадавхийг бэхжүүлэх чиглэлээр ажилласан үр дүнд хүрчээ. Энэ нь үйлдвэрлэл эрхлэгч нарт, өөрийн техник, технологийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр Европын зах зээлд гарах томоохон боломж байгааг нотлон харуулжээ.

Санал, зөвлөмж

Монгол Улс Европын Холбоотой хамтын ажиллагааг өргөжүүлж, Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр олон ажлыг хэрэгжүүлсэн боловч, цаашид уг системийн ашиглалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна. Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем механизм аль аль талдаа дэмжлэг үзүүлж байгаа “хоёр хөлт” төсөл юм. Хэрэгжилтэд мониторинг хийх иргэний нийгмийн чадавхыг сайжруулах, хөдөлмөрлөх эрх зэрэг орсон нь иж бүрнээр хэрэгжих боломжийг бий болгожээ. Иймд Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр дараах санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хэрэгжилт 2023 оныг дуустал үйлчлэх тул Монгол Улсын сонгон авсан үйлдвэрлэлийн салбарыг хөрөнгө оруулалт, тариф, татварын бодлогоор дэмжих;
- Монгол Улсын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим уг системийг хэрэгжүүлэх, анхан шатанд “Бүртгэгдсэн Экспортлогч Систем”-ийг бүртгэх эрх бүхий байгууллагын хувьд экспортын мэдээг бараа тус бүрээр нарийвчлан гаргаж, худалдаа эрхлэгчдэд Европын зах зээлд гарах боломж байгааг сурталчлах, түгээх ажлыг эрчимжүүлэх;
- Монгол Улсад хэрэгжиж буй уул уурхайн бус гаралтай барааны экспортыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах ажлыг гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах;
- Европын Холбооны Гаалийн байгууллагатай “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр”-ийг харилцан хүлээн зөвшөөрөх ажлыг ДХБ-ын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, ДГБ-ын “Дэлхийн Худалдааг Аюулгүй Байлгах, Хөнгөвчлөх Багц Стандарт”-ын хүрээнд хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх;

- Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн “III бүлэг. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалт”-ын хэрэгжилтийг хангах, энэ чиглэлийн чиг үүрэг бүхий төрийн байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулах, олон нийтэд үр дүнг ил тод, нээлттэй, цаг тухайд нь түгээх;
- Европын Холбооноос хэрэгжүүлж буй хөгжлийн түншлэлийн хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдах боломжийг гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС, БНХАУ, ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

5.1. Монгол Улсын гадаад худалдааны бодлогыг хөрш орнуудтай харьцуулсан байдал

Хураангуй: Монгол Улс дэлхийн улс төр, эдийн засгийн нөлөө бүхий их гүрэн ОХУ, БНХАУ-тай зэрэгцэн оршдог орны хувьд хөрш орнуудтай улс төр, нийгэм, эдийн засгийн болон бусад бүх салбарт хамтран ажиллаж иржээ. Эдгээрийн нэг нь худалдааны салбар юм. Монгол Улсын өнөөгийн аж үйлдвэрийн хөгжлөөс харахад хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа боловч хүнд үйлдвэрийн бодлого давамгайлж байгаа нь өргөн хэрэглээний барааны дийлэнх хувийг импортолж байгаагаас харагдаж байна. Экспортын барааны бүтцэд нэмүү өртөг шингээгүй уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүн давамгайлж байна. Энэ нь дэлхийн үнийн сүлжээнд нэгдэн орох Монгол Улсын боломжийг алдагдуулж байна. Иймд ХАА-н салбар, хөнгөн үйлдвэрийн салбар, түүний дотор жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөн хэрэглээний барааг өөрийн улсдаа үйлдвэрлэх дорвитой шийдлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай юм. Аж үйлдвэр, ХАА-н салбарын хөгжлийн бодлоготой холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээг УИХ-аас 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичигт тусгасан.

Монгол Улс гадаад худалдаа, тээвэртэй холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон боловч тэдгээрийн үндсэн зарчмыг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Дэлхийн хэмжээнд улс орнууд гадаад худалдааны бодлого, гаалийн тариф, гаалийн хяналтын үйл ажиллагааг ижилтгэх, уялдуулах, стандартчлах зарчмыг баримталж ирсэн. Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын хөрш ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, чиглэл болон худалдааны үйл ажиллагаанд хяналт тавих гаалийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллах замаар худалдааны урсгалыг саадгүй нэвтрүүлэх, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх боломжийг харьцуулан судалсан.

БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдаанд гол байр суурь эзлэх тул тус улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг түлхүү авч үзсэн бол, ОХУ-ын дамжуулан өнгөрүүлэх тээвэрлэлтийн бодлого, гаалийн холбооны бодлого, чиглэлийг судалгаанд авч үзсэн. Түүнчлэн дэлхийн худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа, бодлого, чиглэлийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэх Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ), Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-аас гаргасан бодлогын баримт бичгийн хүрээнд хөрш орнуудтай хэрхэн хамтран ажиллах боломжийг өнөөгийн байдлыг харьцуулан судлахыг зорьлоо.

Түлхүүр үг: гадаад худалдаа, олон улсын худалдааны бараа нийлүүлэх сүлжээ, экспорт, импорт, худалдааг хөнгөвчлөх, гадаад худалдааны бодлого, дэлхийн үнийн сүлжээ, гаалийн хамтын ажиллагаа, чөлөөт худалдаа, гаалийн тариф гэх мэт.

5.1.1. Монгол улсын гадаад худалдааны өнөөгийн байдал

Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн орчинд 1990 онд томоохон өөрчлөлт орж, нэг намын системээс олон намын системд, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн. Энэ үеэс хойш дэлхийн улс орнуудтай найрсаг харилцааг хөгжүүлж, эдийн засгийг либералчлах, худалдааг хөнгөвчлөх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлд олон чухал алхмуудыг хэрэгжүүлж ирсэн билээ. Улмаар Монгол Улс 1991 онд ДГБ, 1997 онд ДХБ-ын гишүүнээр тус тус элсэн орж эдгээр байгууллагаас гадаад худалдаа, гаалийн чиглэлээр гаргасан бодлого, зохицуулалтуудыг баримтлан, гадаад худалдааны үйл ажиллагааг дэлхийн жишигт нийцүүлэн явуулах шаардлага бий болжээ. ДГБ-ын Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцид 2006 онд Монгол Улс нэгдэн орж, гаалийн горимыг хялбаршуулах, уялдуулах, стандартчлах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байдаг. Монгол Улс уг конвенцид 2006 онд нэгдэн орсноор Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2008 онд батлан гаргаж, түүнтэй уялдуулан холбогдох дүрэм, журам, зааврыг шинэчлэн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Ийнхүү бусад улсын нэгэн адилаар Монгол Улс хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэлт хийж, түнш орнуудын холбогдох байгууллагатай хамтран ажиллах замаар хил дамнасан худалдаа эрхлэн, түүнийг аюулгүй байлгах, хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлж иржээ. Монгол Улсын хувьд гадаад худалдааны хэмжээ жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байгаа. Сүүлийн 16 жилийн буюу 2005-2020 оны гадаад худалдааны гүйцэтгэлийг хүснэгт 19-өөс харна уу.

*Хүснэгт 19. 2005-2020 оны Монгол Улсын гадаад худалдааны гүйцэтгэл
(сая ам.долл.)*

Он	Гадаад худалдааны эргэлт	Экспорт	Импорт	Гадаад худалдааны тэнцэл
2005	2241,2	1063,9	1177,3	-113,4
2006	2977,0	1542,0	1435,0	107,0
2007	4009,3	1947,5	2061,8	-114,3
2008	5779,0	2534,5	3244,5	-710,0
2009	4023,1	1885,4	2137,7	-252,3
2010	6177,1	2899,2	3277,9	-378,7
2011	11415,9	4817,5	6598,4	-1780,9
2012	11123,0	4384,7	6738,4	-2353,7

2013	10626,9	4269,1	6357,8	-2088,7
2014	11011	5774,3	5236,7	537,6
2015	8466,8	4669,3	3797,5	871,8
2016	8274,5	4916,3	3358,1	1558,2
2017	10537,9	6200,6	4337,3	1863,3
2018	12886,6	7011,8	5874,8	1137,0
2019	13747,2	7619,80	6127,40	1492,4
2020	12875,2	7576,3	5298,9	2277,4


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл 2005-2020 (ГЕГ, 2005-2020)

Хүснэгт 19-өөс харахад Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2006, 2014-2020 онд ашигтай гарсан байна. Гадаад худалдааны өсөлт 2011 онд хамгийн өндөр буюу өмнөх оны 2010 онтой харьцуулахад 86 хувиар өсчээ. Харин гадаад худалдааны барааны бүтцийг харьцуулан судлахад Монгол Улсын экспортод уул уурхайн гаралтай бараа, харин импортод машин тоног төхөөрөмж, нефть, газрын тос, хүнс болон хэрэглээний бараа зонхилж байна (2019-2020 оны экспорт, импортын барааны бүтцийн харьцуулалтыг хавсралт 2-оос харна уу). Эндээс Монгол Улсад үйлдвэрлэл хөгжөөгүй тул хэрэглээний барааны дийлэнх хувийг импортлон, эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын түүхий эд зонхилж байгаа гэсэн дүгнэлт гаргаж байна. Хэдийгээр гадаад худалдааны тэнцэл ашигтай мэт харагдаж байгаа боловч экспортын барааны бүтцэд уул уурхайн салбарын нэмүү өртөг шингээгүй бараа (түүхий эд) гол хувийг эзэлж байна. Монгол Улс бусад салбарын, ялангуяа Хөдөө аж ахуйн салбарын гаралтай барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн хагас болон бэлэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын хэрэглээг ханган, цаашид экспортлох замаар эдийн засгийн хөгжлийг түргэтгэх боломжтой болох юм.

Дэлхий нийтийн хэмжээнд КОВИД-19 вируст халдвар гарч, цар тахлын хэмжээнд хүрч, улс орнууд хилийн хязгаарлалт тогтоосон нь дэлхийн хэмжээнд худалдаа, тээвэр, аялал жуулчлал, боловсрол, эдийн засаг болон бусад салбарын хөгжлийг бууруулахад хүргэсэн. Энэ нь Монгол Улсад мөн адил нөлөөлж, 2020 онд гадаад худалдааны гүйцэтгэл 12.87 тэрбум ам. долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0,87 тэрбум ам. доллар буюу 6,3 хувиар буурсан байна.

Монгол Улсын экспорт 2020 онд 7,576 сая ам. долларт хүрч 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 44 сая ам. доллар буюу 0,6 хувиар буурсан байна. Монгол улс 2020 онд дэлхийн 75 оронд бараа экспортолсон. Үүнээс 72,46 хувийг БНХАУ, 22,2 хувийг Швейцари, 2 хувийг Сингапур, 1,11 хувь Британи, 0,76 хувь нь ОХУ, үлдсэн 1,48 хувийг бусад 70 улс тус тус эзэлсэн байна. сүүлийн таван жилд Монгол Улсын экспортод гол хувь эзлэх зарим орны харьцуулалтыг зураг 20-оос харна уу.

Зураг 20. Монгол Улсын экспорт, улс орноор, (сая ам доллар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл 2016-2020

Зураг 20-оос харахад БНХАУ-д 2019 онд 6.77 тэрбум ам. доллар (нийт экспортын 88,89 хувь)-ын бараа гаргаж байсан бол 2020 онд 5,48 тэрбум ам. доллар (нийт экспортын 72,46 хувь)-ын бараа гарган 1,29 тэрбум ам. доллараар буюу 28 хувиар буурсан. Энэ нь КОВИД-19 вируст халдварын улмаас хилийн хорио тогтоосонтой шууд холбоотой.

Экспортын барааны бүтцийг БТКУС-ийн хэсгээр авч үзвэл 2020 оны хувьд өмнө гарч байгаагүй томоохон өөрчлөлт гарсан болохыг зураг 21-ээс харж болно.

Зураг 21. 2019-2020 оны Монгол Улсын экспортын барааны бүтцийн харьцуулалт (хувиар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл 2005-2019

Зураг 21–ээс харахад Монгол Улсын экспортын бүтцээс харахад 2020 онд уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспорт 14,3 хувь, нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспорт⁸⁰ хоёр хувиар тус тус буурсан байна. Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос хэсэгт багтах барааны экспортын дийлэнхийг алтны экспорт эзэлжээ. 2020 онд экспортолсон алтны хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад 21,4 тонноор, үнийн дүн 1369,3 сая ам. доллараар тус тус нэмэгдсэн байна. Нэг кг алтны үнэ 46132,0 ам. доллар байсан бол 2020 онд 58,628.8 ам. доллар хүртэл өсчээ. Алтны 3,1 хувийг Их британи Улс, 3,6 хувийг Сингапур Улс, 93,4 хувийг Швейцари Улсад тус тус экспортолсон байна (ГЕГ, 2020). Алтны экспортын нэмэгдсэн 2020 оны экспортод Швейцари Улсын эзлэх хувийг нэмэгдүүлжээ.

Монгол Улсаас экспортолсон эрдэс бүтээгдэхүүний 98,1 хувийг “Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть” зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлсэн байна. Уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний 2019 оны экспортыг тоо хэмжээ болон үнийн дүнгээр 2020 онтой харьцуулсан хэмжээг хүснэгт 20-оос харна уу.

⁸⁰ Нэхмэл материал болон нэхмэл эдлэлийн экспортын 99.4 хувийг мал амьтны үс, хялгас, хивс, сүлжмэл, оёмол эдлэлийн экспорт эзлэж байна. Самнасан ноолуурын экспорт 247,2 тонноор буурч, ямааны угаасан ноолуурын экспорт 651,1 тонноор өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад сүлжмэл эдлэлийн экспорт 13,1 сая ам.доллараар, оёмол эдлэлийн экспорт 1,7 сая ам.доллараар тус тус буурчээ.

Хүснэгт 20. Монгол Улсаас экспортолсон 2020 оны уул уурхайн бүтээгдэхүүний харьцуулалт (2020 оныг 2019 онтой харьцуулсан байдал)

Барааны нэр	2019 он			2020 он			Өөрчлөлт		
	Тоо хэмжээ (мян.тн)	Дундаж үнэ (тн. \$)	Үнийн дүн (сая.\$)	Тоо хэмжээ (мян.тн)	Дундаж үнэ (тн. \$)	Үнийн дүн (сая.\$)	Тоо хэмжээ	Дундаж үнэ (\$)	Үнийн дүн (сая.\$)
Чулуун нүүрс, мян.тн.	36,466.8	84.3	3,074.4	28,586.88	74.3	2,123.66	-7,879.9	-10.0	-950.7
Зэсийн баяжмал, мян.тн.	1,403.6	1,279.5	1,795.9	1,395.02	1,274.5	1,778.00	-8.6	-4.9	-17.9
Төмрийн хүдэр, мян.тн.	8,448.8	68.2	576.4	8,205.70	78.0	640	-243.1	9.8	63.6
Боловсруула агүй нефть, мян.барр.	6,545.2	56.0	366.7	4,070.53	37.1	150.85	-2,474.7	-19.0	-215.8
Жонш, мян.тн.	700.1	293.6	205.5	678.9	230.3	156.32	-21.2	-63.3	-49.2
Цайрын хүдэр, баяжмал, мян.тн.	134.8	1,402.3	189.0	134.06	1,250.8	167.68	-0.7	-151.5	-21.3
Молибдены хүдэр, баяжмал, мян.тн.	5.7	8,614.5	49.0	6.36	6,399.4	40.7	0.7	-2,215.1	-8.3
Дүн			6,256.9			5,057.2			-1,199.7
НИЙТ ЭКСПОРТ			7,619.6			7,576.31			-1,448.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл 2019, 2020 он.

Хүснэгт 20-оос харахад Монгол Улсаас экспортолсон уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 2019 онд 6,25 тэрбум ам. доллар байсан бол 5,05 тэрбум ам. долларт хүрч, 1,19 тэрбум ам. доллараар буурсан байна. Энэхүү экспортын бууралт нь уул уурхайн бүтээгдэхүүн 2019 оны нийт экспортод 82,1 хувийг эзэлж байсан бол 2020 онд 66,8 хувийг эзэлж, 15,36 хувиар буурахад нөлөөлжээ. Уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний 2020 оны экспортын 96,2 хувийг чулуун нүүрс, зэсийн баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайрын хүдэр болон боловсруулаагүй нефтийн экспорт эзэлсэн ба то хэмжээ, үнийн дүн, дундаж үнийг 2019 онтой харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Чулуун нүүрс:* 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулахад чулуун нүүрсний экспорт 7879,9 мянган тонноор, үнийн дүн нь 950,7 сая ам. доллараар, хилийн дундаж үнэ нь 10,0 ам. доллараар тус тус буурчээ. Чулуун нүүрсний 2020 оны экспортын 95,2 хувийг БНХАУ эзэлжээ.
- *Зэсийн баяжмал:* 2019 онтой харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 8,6 мянган тонноор, хилийн дундаж үнэ нь 4,9 ам. доллараар, үнийн дүн

нь 17,9 сая ам. доллараар тус тус буурчээ. Зэсийн баяжмалыг 2020 онд зөвхөн БНХАУ-д экспортолсон байна.

- *Молибдений баяжмал:* 2020 онд молибдены баяжмалын экспортын тоо хэмжээ 675,5 тонноор өсч, үнийн дүн нь 8,3 сая ам. доллараар буурсан байна. Хилийн дундаж үнэ 8614.5 ам. доллараас 6394,9 ам. доллар хүртэл буурчээ. Молибдены баяжмалын экспортын 85,1 хувийг БНХАУ, 14,9 хувийг БНСУ тус тус эзэлжээ.
- *Хайлуур жонш:* 2020 онд хайлуур жоншны экспорт өнгөрсөн оны мөн үеэс 21,2 мянган тонноор, үнийн дүн нь 49,2 сая ам.доллараар тус тус буурчээ. 2019 онд нэг тонн хайлуур жоншны экспортын дундаж үнэ 293,6 ам. доллар байсан бол 2020 онд 230,3 ам. доллар болон буурчээ. Хайлуур жоншны 23,2 хувийг ОХУ, 76,6 хувийг БНХАУ-д тус тус экспортолжээ.

Гаалийн ерөнхий газраас хийсэн судалгаанд Монгол Улсаас экспортолсон уул уурхайн барааны дундаж үнийг нийт хэмжээнд харьцуулан гаргадаг байна. Гаалийн тариф, гаалийн татварын тухай Монгол Улсын хуулийн дагуу экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох талаар тусгасан байдаг. Энэхүү хуулийн дагуу экспортын барааны гаалийн үнэ нь Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлөөр тодорхойлогдоно. Хэрэв экспортын хэлцэл нь гаалийн үнийг тодорхойлох боломжгүй нөхцөлөөр хийгдсэн бол экспортын барааны гаалийн үнэлгээний аргыг дэс дараалуулан хэрэглэнэ. Өнөөгийн Монгол Улсын жишгээс харахад экспортын барааны гаалийн үнэлгээний дөрөвдүгээр арга буюу “Зах зээлийн мэдээлэл, судалгааны арга”-аар гаалийн үнийг тодорхойлох тохиолдолд олон улсын худалдааны практик, уул уурхайн барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээний үнэ, тухайн үеийн дэлхийн зах зээлийн үнийн мэдээлэлд үндэслэнэ. Үүнтэй уялдуулан сар бүр Сангийн яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, хувийн хэвшил, бусад төрийн байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг тухайн сарын “Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн мэдээлэл”⁸¹-ийг гаргадаг. Өөрөөр хэлбэл Монгол Улсад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дээрх үнийн мэдээллийг үндэслэн дотоодод ногдуулдаг байна.

Монгол Улсын импорт нийт 5298,9 сая ам. долларын бараа, түүхий эд импортолсон нь 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 828,6 сая ам. доллар буюу 13,5 хувиар буурсан байна. Импортолсон барааны 94.6 хувийг валютын төлбөртэй худалдаа, 1,4 хувийг гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 0,9 хувийг гадаадын тусламжийн бараа, 2,6 хувийг гадаадын хөрөнгө


⁸¹ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2019 оны 342, 465 дугаар тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн мэдээллийг нийтэд мэдээлдэг.

оруулалтаар нийлүүлсэн бараа, 0,1 хувийг боловсруулалтын бараа эзэлж байна.

Импортын хэмжээ 2020 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан шалтгаан нь өмнө өгүүлсэн дэлхий нийтийн хэмжээнд гарсан КОВИД-19 вируст халдварын улмаас хилийн хязгаарлалт тогтоосонтой шууд холбоотой. Харин импортын барааны бүтцээр авч үзвэл БТКУС-ийн эрдэс бүтээгдэхүүн; авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги; машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг бүлэгт хамаарах барааны импортын бууралт голлон нөлөөлсөн байна.

Монгол Улс дэлхийн 142 орноос гарал үүсэлтэй бараа импортолсон ба ОХУ 26,4 хувь, БНХАУ 35,7 хувь, АНУ 4,6 хувь, Япон 7,7 хувь, БНСУ 4,4 хувь, ХБНГУ 3,5 хувийг тус тус эзэлж байгаа нь нийт импортын дүнгийн 82,3 хувийг эзэлж байна.

Импортын барааны бүтцийг БТКУС-ийн хэсгээр авч үзвэл 10 хэсгийн барааны импорт өсч, 11 хэсгийн барааны импорт буурсан байна. Импортын бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, хүнсний бэлэн бүтээгдэхүүн болон үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт давамгайлсан хэвээр байгаа ба эдгээр төрлийн бараа нийт импортын 77,7 хувийг эзэлжээ.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл 2019, 2020 он.

Зураг 22–оос харахад Монгол Улсын импортын өөрчлөлтийг БТКУС-ийн барааны хэсгээр авч үзвэл, эрдэс бүтээгдэхүүн 365 сая ам. доллар; авто,

агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, ангийн импорт 313.9 сая ам. доллар; машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн импорт 180,1 сая ам.доллар; хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; резин болон түүгээр хийсэн зүйлсийн импорт 37,1 сая ам.доллараар тус тус буурчээ. Харин чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүний импорт 23,0 сая ам. доллар; ургамлын гаралтай бүтээгдэхүүний импорт 29,4 сая ам.доллар; сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт метал, гоёлын зүйлс, зоосны импорт 11,3 сая ам.доллараар тус тус өсчээ. (Хавсралт 3;4-өөс харна уу).

5.1.2. Гадаад худалдаатай холбоотой үйл ажиллагааны гүйцэтгэл

Гадаад худалдааны бодлогыг харьцуулан судлахын тул өнөөгийн гүйцэтгэл буюу худалдааг хэмжих хил дамнасан үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзсэн. ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бараа эргэлтийн хэмжээг Монгол Улстай харьцуулахад харилцан адилгүй байгаа нь хүн амын тоо, газар зүйн байрлал, хөгжлийн түвшинтэй шууд холбоотой. Иймд хөрш орнуудтай хийсэн гадаад худалдааны эргэлтийг харьцуулан судлахаас гадна гурван орны гадаад худалдааны эргэлт, түнш орон, барааны тоог ДГБ-ын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн конвенцийн 6 орны түвшинд харьцуулан хүснэгт 21-д үзүүллээ.

Хүснэгт 21. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны статистик, түнш орон, барааны тоогоор (2016-2020 он, тэрбум ам. доллар)

Он		2016	2017	2018	2019	2020	
Монгол Улс							
Экспорт	Статистик дүн	1	4,9	6,2	7,0	7,6	
	Түнш орон	2	68	67	75	75	
	Барааны тоо (БТКУС 6 орон)	3	880	892	896	765	709
Импорт	Статистик дүн	4	3,36	4,33	5,87	6,12	
	Түнш орон	5	135	145	141	153	
	Барааны тоо (БТКУС 6 орон)	6	3385	3497	3527	3403	3255
Худалдааны тэнцэл		7 (1-4)	1,6	1,9	1,1	1,5	2,3
Нийт худалдаа		8 (1+4)	8,3	10,5	12,9	13,7	12,9
ОХУ							
Экспорт	Статистик дүн	1	285,5	357,1	449,4	422,8	337,1
	Түнш орон	2	194	193	192	193	212
	Барааны тоо (БТКУС 6 орон)	3	4735	4780	4772	4,817	4,827
Импорт	Статистик дүн	4	182,26	226,97	238,15	243,78	231,66
	Түнш орон	5	200	217	202	209	227
	Барааны тоо (БТКУС 6 орон)	6	4889	4968	4961	4950	4937

	орон)						
Худалдааны тэнцэл		7 (1-4)	103,2	130,1	211,2	179,0	105,4
Нийт худалдаа		8 (1+4)	467,8	584,1	687,5	666,6	568,8
БНХАУ							
Экспорт	Статистик дүн	1	2119,0	2271,8	2494,2	2498,6	2590,6
	Түнш орон	2	213	214	215	215	216
	Барааны тоо (БТКУС 6 орон)	3	4851	4999	4990	4423	4964
Импорт	Статистик дүн	4	1588,7	1841,0	2135,0	2069,0	2055,6
	Түнш орон	5	212	215	216	215	217
	Барааны тоо (БТКУС 6 орон)	6	4,881	5,010	5,001	4,425	4,978
Худалдааны тэнцэл		7 (1-4)	530,3	430,8	359,2	429,6	535,0
Нийт худалдаа		8 (1+4)	3707,7	4112,8	4629,2	4567,5	4646,2

Эх сурвалж: The World Integrated Trade Solution software (Software, 2020); Олон улсын худалдааны төв (ИТС, 2020)

Хүснэгт 21–ээс харахад аль нэг улсын давуу байгааг харьцуулахаас илүүтэй эдгээр гурван улсын гадаад худалдааны цар хүрээг ерөнхий байдлаар үзүүлэхийг зорьсон⁸². БНХАУ-ын 2020 оны гадаад худалдааг 2019 онтой харьцуулахад 1,72 хувиар өссөн байна (БНХАУ-ын экспортын хувьд 92 тэрбум ам. доллараар өсч, импорт нь 13,36 тэрбум ам. доллараар буурчээ). Монгол Улсын гадаад худалдаа 2020 онд 6,5 хувь, ОХУ-ын гадаад худалдаа 14,67 хувиар өмнөх оных нь мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарчээ.

Улс орнуудын эдийн засаг, түүний дотор гадаад худалдааны өсөлтөд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, ялангуяа татварын бодлого гол байр суурь эзэлнэ. Буурай хөгжилтэй, хөгжиж байгаа орны хувьд илүү тогтвортой бодлого баримтлан гадаадын хөрөнгө оруулагчийг татахыг эрмэлздэг бөгөөд энэ нь сайтар нягтлаагүй тохиолдолд эргэн эрсдэл үүсэх, эдийн засагт дарамт нэмэх боломжтой байдаг. Харин өндөр хөгжилтэй орны хувьд дотоодын зах зээлийг хамгаалсан, алслагдмал бүс нутгийн хөгжлийг дэмжсэн ялгаатай бодлого баримталж иржээ.

Гадаад худалдааны үйл ажиллагаанд гаалийн байгууллага гол үүрэгтэй оролцдог тус байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой. Үүнтэй уялдуулан ДГБ-ын жилийн тайланд⁸³ тус байгууллагын гишүүн орнуудын гүйцэтгэлийг харьцуулан үзүүлдэг. ДГБ-ын 2019/2020 оны үйл ажиллагааны тайланд тусгасан гурван улсын гадаад худалдаа, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг харьцуулсан судалгааг хүснэгт 22–оос харна уу.

⁸² Олон Улсын Валютын сангаас гаргасан мэдээллээр 2019 онд БНХАУ-ын ДНБ 15.54 триллион ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ 10,747 ам. доллар, дэлхийн улс орнуудаас 2 дугаар байр, ОХУ-ын ДНБ 1.67 триллион ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ 11,426 ам. доллар, дэлхийн улс орнуудаас 12 дугаар байр, Монгол Улсын ДНБ 14.96 тэрбум ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ 4,563 ам. доллар, дэлхийн улс орнуудаас 126 дугаар байранд тус эрэмбэлэгджээ (IMF, 2019).

⁸³ ДГБ-ын санхүүгийн жил нь жил бүрийн 7 дугаар сараас дараа жилийн 6 дугаар сар дуустал 12 сарын хугацаанд үргэлжилнэ.

Хүснэгт 22. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээлэл (2019/2020)

№	Гүйцэтгэлийн үзүүлэлт, бусад мэдээлэл	Монгол Улс	ОХУ*	БНХАУ
1	Гадаад худалдааны бараа эргэлт (тэрбум ам. доллар)	12,9	568,8	4646,2
	Үүнээс: Импорт (тэрбум ам. доллар)	5,3	231,7	2055,6
	Экспорт (тэрбум ам. доллар)	7,6	337,1	2590,6
2	Импортын гаалийн мэдүүлгийн тоо (мян.шир.)	263,8	777,05	22097,8
3	Экспортын гаалийн мэдүүлгийн тоо (мян.шир.)	522,5	1089,9	55715,4
4	Улсын төсвийн орлогод гаалийн орлогын эзлэх хувь	32,3	-	20,9
5	Гаалийн албан хаагчийн тоо	1,407	43,669	93,000
6	Импорт, экспортын зөвшөөрөл холбогдох баримт бичиг олгох эрх бүхий байгууллагын тоо	11	16	14
7	Нэг цонхны системд холбогдсон үйл ажиллагаа	-	13	25

Эх сурвалж: ДГБ-ын 2020/2021 оны үйл ажиллагааны тайлан (ДГБ, 2021), Олон улсын худалдааны төв <http://www.intracen.org/itc/market-info-tools/statistics-import-country-product/>

*Тайлбар: *ОХУ-ын Холбооны гаалийн албаны гаалийн мэдүүлгийн тоо 2018/2019 оны гүйцэтгэлээр.*

Хүснэгт 22–оос харахад Монгол, Орос, Хятад улсын гаалийн байгууллагын зарим гүйцэтгэлийг өндөр, бага гэж харьцуулахыг зорилго болгоогүй. Харин гадаад худалдааны хөгжил нь төрийн тогтвортой бодлогоос гадна гаалийн байгууллагын хил дамнасан зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд өөрийн үйл ажиллагааг уялдуулж, стандартчилж, гадаад худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлж, илүү ухаалаг хяналт тавих бодлого шууд нөлөөлөх боломжтойг харуулахыг зорьсон. Иймд энэхүү хөрш орнуудын худалдааны бодлогыг харьцуулан судлах энэхүү судалгааны ажилд гаалийн байгууллагын гүйцэтгэл, чиг үүрэг, шинэ санаачилга, боломжийг авч үзсэн.

Орчин үеийн гаалийн байгууллага үйл ажиллагаандаа хууль сахиулах болон худалдааг хөнгөвчлөх гэсэн эрс тэрс хоёр чиг үүргийг тэнцвэртэйгээр хангахдаа эрсдэл тооцох арга зүйд суурилсан гаалийн хяналтыг нэвтрүүлж байна. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үндсэн үзэл баримтлал нь өндөр эрсдэл бүхий ачилтыг шалган, бага, эсвэл хүлээн зөвшөөрөх эрсдэл бүхий ачилтыг бүрдүүлэлтийн дараа болон өмнө шалгах боломжийг олгосон. Эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар нэвтрүүлэх нь худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний чухал бүрэлдэхүүн хэсэг тул ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт тусгагдсан байдаг (ДХБ, 2013).

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” дүгнэлтийн “Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт” нь гадаад худалдааны үйл ажиллагаа хил дээр хэрхэн хэрэгжиж байгааг харуулсан гол шалгуур болдог билээ.

Хүснэгт 23. Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт 2020, гурван улсын харьцуулалт


Үзүүлэлт	Монгол Улс (143)	ОХУ (99)	БНХАУ (56)
Экспортын хугацаа: Хилийн үйл ажиллагаа (цаг)	134	66	21
Экспортын зардал: Хилийн үйл ажиллагаа (USD)	225	580	256
Экспортын хугацаа: Бичиг баримт бүрдүүлэх (цаг)	168	25	9
Экспортын зардал: Бичиг баримт бүрдүүлэх (USD)	64	92	74
Импортын хугацаа: Хилийн үйл ажиллагаа (цаг)	48	30	36
Импортын зардал: Хилийн үйл ажиллагаа (USD)	210	520	241
Импортын хугацаа: Бичиг баримт бүрдүүлэх (цаг)	115	43	13
Импортын зардал: Бичиг баримт бүрдүүлэх (USD)	83	153	77

Эх сурвалж: Дэлхийн банк, Бизнес эрхлэхүй дүгнэлт 2020, Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт (WB, 2020)

Хүснэгт 23-аас харахад Хилийн үйл ажиллагааны зардал ОХУ-д хамгийн өндөр 520-590 ам. долл., бичиг баримт бүрдүүлэх хугацаа нь Монгол Улсад хамгийн өндөр, БНХАУ-д бага байна. Эндээс төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, давхардал, мэдээллийн технологи, дэд бүтцийн хөгжил зэрэг худалдаанд нөлөөлөх гол хүчин зүйлийн түвшин харагдаж байна.

“Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт”-ийн сүүлийн таван жилийн дүгнэлтэд гурван улсын зэрэглэл дараах байдалтай байна.

Зураг 23. Дэлхийн банкны "Бизнес эрхлэхүй" дүгнэлт, Монгол, Орос, Хятадын хил дамнан худалдаа хийх үзүүлэлт



Эх сурвалж: Дэлхийн банк, Бизнес эрхлэхүй дүгнэлт 2016-2020, Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт (WB, 2020)

Зураг 23–аас харахад “Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт”-ээр Монгол Улсын зэрэглэл буурсаар, харин хөрш орнуудын үйл ажиллагаа сайжирсаар байгаа нь харагдаж байна. Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт 2020 тайланд БНХАУ ачилтын мэдээллийг урьдчилан авах үйл ажиллагааг нэмэгдүүлсэн, боомтын дэд бүтцийг сайжруулсан, гаалийн байгууллага үйл ажиллагаагаа сайжруулсан, хураамжийн хэмжээг ил нийтлэх болсон нь энэ үзүүлэлтэд ахиц гаргахад нөлөөлжээ.

Харин Монгол Улсын үзүүлэлт яагаад ийнхүү буурсныг харьцуулан үзэхэд импортын бүрдүүлэлттэй холбоотой цаг хугацаа, зардлын өөрчлөлт гарсан нь ийнхүү 190 орноос 143-т ороход нөлөөлсөн байна. Хил дамнан худалдаа хийх үзүүлэлтийг бууруулахад хилийн хяналтын, түүний дотор гаалийн хяналтын үйл ажиллагааг стандарчлах, хялбаршуулах, уялдуулах шаардлагатай. Иймээс худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний нэг болох эрсдэлийн удирдлага нь гадаад худалдаанд оролцогч нэг байгууллагаар хязгаарлахгүй нэгдсэн байдлаар эрсдэлээ тооцох хэрэгцээ шаардлага бий болгодог. Хэдийгээр ачилтад хамрагдах барааны төрөл, тоо, шинж чанараас шалтгаалан гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа нь харилцан адилгүй боловч эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар барааг экспортлох болон импортлох хугацааг богиносгох боломжтой юм.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” дүгнэлтийн “Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт” нь экспорт, импорт тус бүрд зөвхөн нэг барааг сонгон түүний гүйцэтгэлээр ийнхүү улс орнуудын зэрэглэлийг гаргадаг. Гэхдээ тухайн бараа

нийт экспорт болон импортыг төлөөлөх эсэхийг үл харгалзан тухайн улсыг эрэмбэлж байгаа энэхүү судалгааны аргачлал хэт өрөөсгөл тул ДГБ-ын гишүүн орны Гаалийн байгууллагууд үүнтэй санал үл нэгдэн, судалгааны аргачлалыг сайжруулахын тулд ДБ ба ДГБ хооронд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Үүнтэй уялдан сүүлийн гурван жилийн судалгаанд зөвхөн хувийн хэвшлээс гадна гаалийн байгууллага оролцох болсон.

5.2. ОХУ-ын гадаад худалдааны бодлого, хоёр улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа

ОХУ-ын газар зүйн байрлал, үйлдвэрлэлийн онцлог, давуу тал зэргээс хамаарч дэлхийн улс орнуудтай гадаад худалдааг хөгжүүлж байна. ОХУ ДХБ-д 2011 онд нэгдэн орсон бөгөөд үүнээс өмнө тус улсын худалдааны бодлого нь үндэсний бодлого, зорилготой уялдаж байсан. Харин ДХБ-д нэгдэн орсноор олон талт худалдааны бодлого, зохицуулалтыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Мөн энэ үед үндэсний эдийн засаг болон гадаад худалдааны хооронд багагүй зөрчилдөөн гарч байсан байна. Гэсэн хэдий ч ОХУ-ын дэлхийн улс төрийн тавцан дахь байр суурь, газар зүйн байршил, байгалийн баялгийн нөөц, уламжлалт аж үйлдвэрийн хөгжил зэрэг нь олон талт худалдааны харилцаанд мэргэшин ажиллах боломжийг бүрдүүлсэн. Үүнтэй уялдан дэлхийн эдийн засаг, нийгмийн бодлого, чиглэлийг тодорхойлох олон улсын байгууллагад тус улсын эзлэх байр суурь өндөр байсаар байна. ОХУ-ын гадаад худалдааны бодлогыг Эдийн засгийн хөгжил, Гадаад хэрэг болон Аж үйлдвэр, худалдааны яам тодорхойлж, хэрэгжүүлдэг байна.

Тус улсын гадаад худалдааны бодлогын гол зорилго нь *“Эдийн засгийг шинэчлэн дэлхийн хэмжээнд өрсөлдөх; тасралтгүй, тогтвортой өсөлтийн нөхцөл бий болгох; тогтвортой, инновацийг дэмжсэн эдийн засгийг хөгжүүлэх; худалдаа, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох; дэлхийн интеграцид нэгдэх процессыг түргэтгэх; ОХУ-ын бараа, үйлчилгээний худалдааны импортлогч, экспортлогч, үйлдвэрлэгч болон хэрэглэгч нарт тааламжтай нөхцөлийг бий болгох⁸⁴”*-д оршино. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд ОХУ газрын тос, байгалийн хийн салбараас ангид байдлаар эдийн засгаа шинэчлэх, төрөлжүүлэх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хууль дүрэм журмын зохицуулалтыг 2020 он гэхэд 40 хувиар бууруулах; дэлхийн цөмийн технологийн зах зээлд манлайллаа хадгалах; сансрын технологи, мэдээлэл, харилцаа холбооны үйлдвэрлэлийг дэмжих замаар сансрын орон зайг судлахад улс орны гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх; мэдээллийн технологи (МТ), програм хангамж, эмнэлгийн технологи, эмийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулах ажлыг нэмэгдүүлэхийг тэргүүлэх чиглэлээ болгожээ. Түүнчлэн аж үйлдвэр, ХАА-н салбар, түүний дотор жижиг, бичил аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлэх; барилга, автомашин, хөнгөн болон

⁸⁴ WTO, Trade Policy Review of Russian Federation, 2016.

төмөр замын машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх; бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх технологийн шинэчлэлийг сайжруулах; бага орлоготой иргэдийг дэмжих хөтөлбөр; төсвийн орлого, макро эдийн засгийн тэнцвэртэй байдал, санхүүгийн бие даасан байдлыг хангах; бизнесийн орчин, Төр-Хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх богино хугацааны тэргүүлэх чиглэлийг бий болгон ажиллаж байна.

Гадаад худалдааны бодлогод улс төрийн хүчин зүйл ихээхэн нөлөөлдөг болохыг Украиныг (Крым) тойрсон асуудал нотолж байна. Үүнээс улбаалан АНУ, Европын холбооны улсууд ОХУ-д эдийн засгийн хориг тавьж, энэ нь тус улсын гадаад худалдаанд томоохон өөрчлөлт авч ирсэн болохыг бид мэдэх билээ. Гэсэн хэдий ч ОХУ энэхүү эдийн засгийн хориг тавьсан хүндхэн сорилтуудыг 2018 онд амжилттай даван туулж, эдийн засаг, нийгэм, улс төрийн хувьд “эерэг” жил болсон билээ. Энэ төрлийн улс төрийн орчинд буюу гадаад харилцаанд “ганцаардуулах, түгжигдмэл” байдлаас гарах томоохон алхмууд хийсэн нь ОХУ-аас Европын Холбооны Гишүүн орнуудын үйлдвэрлэгч, фермерүүдийн эсрэг тавьсан худалдааны хориг нь тэднийг хямралд оруулахад хүргэсэн.

ОХУ-ын гадаад худалдаанд нефть бүтээгдэхүүн, байгалийн хий, газрын тосны олборлолт багагүй хувь эзлэх бөгөөд АНУ болон бусад орнуудад энэ төрлийн барааны олборлолт нэмэгдэх нь дэлхийн зах зээлийн нийлүүлэлтээс илүү гарах эрсдэлтэй тулгарч болзошгүй юм. Иймд ОХУ гадаад худалдаанд гол байр эзлэх барааны худалдааны бодлого, зохицуулалтад улс төр, эдийн засагтай холбоотой гэнэтийн өөрчлөлт гарч ирж болзошгүй хүлээн зөвшөөрч, байнгын хяналтдаа байлгахыг эрмэлздэг байна. ОХУ 2018 онд дотооддоо хийсэн тэтгэврийн шинэтгэл, нэмүү өртгийн албан татварын өөрчлөлт, инфляцын өсөлт зэрэг нь тус улсын 2019 оны эдийн засаг, нийгэм, улс төр, аюулгүй байдлын чиг хандлагад бага боловч нөлөөлсөн. Дэлхий нийтэд тархсан Ковид-19 вируст халдварын цар тахлын улмаас гадаад худалдааны бодлогод өөрчлөлт орох нь дамжиггүй, ялангуяа эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн импорт, байгалийн хий, газрын тосны экспортын бодлогод ихээхэн өөрчлөлт орохоор байна.

Тус улсын гадаад худалдааны бодлогод Евразийн эдийн засгийн холбоо (ЕЭЗХ) гол үүрэг гүйцэтгэнэ. ЕЭЗХ⁸⁵ нь бүс нутгийн эдийн засгийн интеграцийг бэхжүүлэх хууль ёсны олон улсын байгууллага, таван Гишүүн Улсаас бүрдсэн (Бүгд Найрамдах Армен Улс, Бүгд Найрамдах Беларус Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Кыргыз Улс, ОХУ). Холбоо бүс нутгийн хэмжээнд бараа, үйлчилгээ, хөрөнгө, ажиллах хүчний хөдөлгөөн чөлөөтэй байх боломжийг бүрдүүлэхэд гишүүн орнуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг

⁸⁵ Тус холбоо нь ЕЭЗХ-ны 2014 оны 5 дугаар сарын 24-нд батлагдсан гэрээгээр байгуулагдсан. ЕЭЗХ нь үндэсний хэмжээнд эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, иж бүрнээр нь хөгжүүлэх чиглэлээр хоорондоо хамтран ажиллаж, тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих, Гишүүн улсуудын хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх зорилготой.


бэхжүүлэх, нэгдсэн нэг бодлого баримтлахыг ЕЭЗХ-ны гэрээ болон олон улсын хэлэлцээрээр зохицуулсан. ЕЭЗХ-ны Гаалийн кодекс (Customs Code of the Eurasian Economic Union)-д тодорхойлсны дагуу дамжуулан өнгөрүүлэх ачилтад тавих гаалийн хяналт нь бүс нутгийн хэмжээнд Дамжуулан өнгөрүүлэх гаалийн хяналтыг зохион байгуулах журмын дагуу явагдана. Ерөнхийдөө ЕЭЗХ-ны нутаг дэвсгэрт гадаад худалдаа, гаалийн ижил дүрэм, журам, горим үйлчилнэ. Иймд ОХУ-ын Засгийн газраас 2020 онд баталсан “Холбооны гаалийн албаны 2030 он хүртэлх урт хугацааны хөгжлийн стратеги”-д ОХУ-ын гадаад худалдаа, тээврийн бодлого дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

- Гадаад худалдааг хөгжүүлэхдээ экспортын чиг баримжаатай салбарын өрсөлдөх чадварын давуу талыг ашиглахад, түүхий эдээс бусад бүтээгдэхүүний экспортын нэр төрөл болон цар хүрээг өргөжүүлэхэд, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөшүүрэг болдог гаалийн бүрдүүлэлтийн горимыг практикт өргөнөөр хэрэглэх;
- ОХУ-ын үндэсний язгуур эрх ашигт нийцсэн гадаад худалдааны болон хөрөнгө оруулалтын газар зүйн байршлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Евразийн эдийн засгийн холбооны гишүүн бус орнуудаас ирэх барааны хөдөлгөөнийг хялбаршуулах;
- ОХУ-д (-аас) оруулсан (гаргасан) бараа, дамжуулан өнгөрөх бараа болон эрсдэлгүй барааны гаалийн бүрдүүлэлтийг 2030 он гэхэд үе шаттайгаар бүрэн цахимжуулах замаар худалдааны урсгалыг нэмэгдүүлэх;
- Гадаад худалдаанд оролцогчдод тулгарах төрийн байгууллагын хяналт, захиргааны арга хэмжээний дарамтыг багасгах;
- Гадаад худалдаа эрхлэгч хууль бус практик ажиллагаанд оролцохгүй байх болон гадаад дотоодын худалдааг ил тодоор хийх нөхцөл боломжтой байхаар гаалийн байгууллагын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэх.

ОХУ-ын Холбооны гаалийн алба нь дотоодын төрийн яам, агентлагуудтай, ЕЭЗХ-ны эрх бүхий байгууллагатай хамтран олон улсын худалдааны бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг ханган, хууль ёсны худалдааг хөнгөвчлөхийг зорьж байна. Үүний нэг жишээ нь Кыргыз Улсын Үндэсний аюулгүй байдлын улсын хороотой хамтран Евразийн эдийн засгийн холбооны нутаг дэвсгэрээр дамжин “Алтан хавирган сар” бүс нутгийн орнууд (Афганистан, Иран, Пакистан)-аас Баруун Европ руу хууль бусаар “героин” бодисыг транзитаар тээвэрлэдэг байсан сувгийг таслан зогсоох зорилгоор тусгай ажиллагааг удаа дараа амжилттай зохион байгуулсан байна. Дүгнэж хэлэхэд, гадаад худалдааны болон үндэсний аюулгүй байдлыг хамгаалах бодлого зэрэгцэн явагдах хэрэгцээ шаардлага хэдийнээ бий болжээ.

5.2. Монгол Улс, ОХУ-ын гадаад худалдаа, хамтын ажиллагаа

Монгол Улс, ОХУ-тай уламжлалт сайн хөршийн харилцаатай. Монгол Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд найрсаг харилцаа тогтоох тухай Гэрээг 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр байгуулан, 2015 оны байдлаар Боловсрол, шинжлэх ухаан, соёл, технологи, эдийн засаг, Худалдаа, эдийн засаг, Хил, хилийн дэглэм, Төмөр зам, Геологийн салбар, Зээлийн хэлэлцээр, тусламж, Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ, Батлан хамгаалах зэрэг 40 төрлийн 257 баримт бичгийг байгуулсан байна⁸⁶.



Эх сурвалж: Монгол Улс ОХУ-ын харилцааны лавлах⁸⁷ (ГХЯ, 2015)

Зураг 24-өөс харахад хоёр орны Засгийн газар хооронд “Боловсрол, шинжлэх ухаан, соёл, технологи, эдийн засаг” төрлөөр байгуулсан баримт бичиг хамгийн их буюу 18 хувийг эзэлсэн ба үүний дараа “Худалдаа, эдийн засаг” төрөл 13 хувийг эзэлжээ. Худалдаа, эдийн засагтай холбоотой баримт бичгийн хэрэгжилт нь тээвэр, төмөр зам, зээл, тусламжтай холбоотой байгуулсан хамтын ажиллагааны баримт бичигтэй харилцан уялдаатай.

Сүүлийн жилүүдэд хоёр орны Засгийн газар хоорондын хамтын ажиллагаанд бага гэлтгүй ахиц, дэвшил гарсаар байна. Эдгээрийн нэг тод жишээ нь Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн ОХУ-д 2021 оны 6 дугаар хийсэн айлчлал юм. Энэхүү албан ёсны айлчлалын үеэр хоёр улсын Гадаад харилцааны сайд нар 6 дугаар сарын 1-нд хэлэлцээр хийж, хоёр талын

⁸⁶ Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас гаргасан мэдээлэлд зөвхөн тус яамны олон улсын гэрээ, хэлэлцээр хариуцсан нэгжид бүртгүүлсэн Засгийн газар хооронд байгуулсан баримт бичгийг багтаажээ.

⁸⁷ 2015 оны 4 дүгээр сараас хойш хоёр орны Засгийн газар хооронд байгуулсан баримт бичиг ороогүй.

харилцаа, бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны өргөн хүрээний асуудлаар санал солилцжээ. Мөн айлчлалын үед хоёр орны Гадаад харилцааны Сайд нар Монгол, Оросын харилцааны өнөөгийн явцыг дүгнэж, харилцааны хөгжлийн цаашдын төлөвлөлтийн талаар, тэр дундаа ойрын хугацаанд хэрэгжүүлэх өндөр, дээд түвшний харилцан айлчлал, тэргүүлэх чиглэлүүдэд хэрэгжүүлж буй томоохон арга хэмжээ, төслүүдийг урагшлуулах талаар санал солилцжээ. Гадаад харилцааны сайд нар хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг улам бүр хөгжүүлэх боломж, түүний дотор ОХУ, БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолойг барих төслийн судалгааны ажил цар тахлын нөхцөлд ч амжилттай урагшилж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэв.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ гол байр суурь эзэлж байсан. Сүүлийн 16 жилийн байдлаар хоёр улсын хооронд хийгдсэн гадаад худалдааны эргэлтийг хүснэгт 24-өөс харна уу.

Хүснэгт 24. 2005-2020 оны Монгол Улс ОХУ-тай хийсэн гадаад худалдааны нийт эргэлт (сая ам. долл.)

Он	Нийт эргэлт	Экспорт	Импорт	Тэнцэл ба алдагдал
2005	445,2	27,2	417,9	-390,7
2006	592,9	45,1	547,8	-502,7
2007	803,5	58,5	745,0	-686,5
2008	1328,6	86,3	1242,3	-1156,0
2009	841,0	68,2	772,8	-704,6
2010	1129,4	82,7	1046,7	-964,0
2011	1721,0	96,3	1624,7	-1528,4
2012	1927,0	79,6	1847,4	-1767,8
2013	1623,6	61,8	1561,9	-1500,1
2014	1610,9	61,6	1549,3	-1487,7
2015	1097,9	76,9	1021,0	-944,1
2016	936,2	55,8	880,4	-824,6
2017	1284,9	67,7	1217,3	-1149,6
2018	1796,3	85,9	1710,3	-1624,4
2019	1798,0	68,1	1729,9	-1661,8
2020	1457,2	57,3	1400,0	-1342,7

Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (ГЕГ, Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2020)

Хүснэгт 24-өөс харахад хоёр улсын хооронд хийсэн гадаад худалдааны эргэлт харилцан адилгүй байна. Сүүлийн 15 жилд Монгол – Оросын хооронд

20,39 тэрбум ам. долларын гадаад худалдаа хийсэн ба нийт худалдааны 95 хувийг импорт, түүний дотор газрын тосны бүтээгдэхүүний импорт эзэлжээ. Монгол Улсын гадаад худалдаанд 2005 оноос хойш ОХУ-ын эзэлсэн хувийг дараах хүснэгт 25-аас харна уу.

*Хүснэгт 25. Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ-ын эзлэх хувь
(2005-2020 он)*

Он	Гадаад худалдааны эргэлт	Экспорт	Импорт
2005	19,9	2,6	35,5
2006	19,9	2,9	38,2
2007	20,0	3,0	36,1
2008	23,0	3,4	38,3
2009	20,9	3,6	36,1
2010	18,4	2,8	32,7
2011	15,0	1,9	24,6
2012	17,3	1,8	27,4
2013	15,3	1,4	24,5
2014	14,6	1,0	29,6
2015	12,9	1,6	26,8
2016	18,8	1,1	26,2
2017	12,2	1,1	28,1
2018	13,9	1,2	29,1
2019	13,0	0,9	28,2
2020	11,3	0,8	26,4

Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (ГЕГ, Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2020)

Хүснэгт 25-аас харахад сүүлийн 16 жилийн дунджаар Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ 16,34 хувийг эзэлжээ. Монгол Улсаас ОХУ-д экспортолсон барааны нэр төрөл, статистик дүнд багахан хэмжээний өөрчлөлт оржээ. Харин тус улсаас импортолсон бараа 2005 онд 0,4 тэрбум ам. доллар байсан бол 2020 онд 1,4 тэрбум ам. долларт хүрч нэмэгдсэн ба импортын хамгийн өндөр өсөлттэй жил нь 2019 он байна (Импорт 1,72 тэрбум ам. доллар). Импортын хэмжээ нэмэгдсэн хэдий ч барааны бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй, харин нефть бүтээгдэхүүний импорт өссөнтэй холбоотой.

5.3. БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, хоёр улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа

БНХАУ өөрийн орны гадаад худалдааны бодлогод байнга анхаарч, дэлхийн зах зээлд тэргүүлэгч болох бодлого баримталж иржээ. Тус улсаас

нэмүү өртөг шингэсэн барааг экспортлох, энэ нь дотооддоо жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, үндэсний үйлдвэрлэл дэмжих зэрэг өндөр ач холбогдолтой. Харин импортын хувьд өөрийн үндэсний үйлдвэрлэлийг тарифын бодлогоор дэмжих, өндөр технологийн болон эко бүтээгдэхүүний импортыг дэмжих, түүнчлэн гадаад улс оронтой байгуулсан хөнгөлөлттэй гаалийн тарифын хувь хэмжээ мөрдөх улсын барааг импортлох, гадаадын хөрөнгө оруулалтыг сонгон авсан салбарт дэмжих бодлого баримталж иржээ. БНХАУ-ын гадаад худалдаа “Дэлхийн үнийн сүлжээ”-д гол байр суурь эзлэх болсон. Сүүлийн жилүүдэд байгуулсан эдийн засгийн болон чөлөөт худалдааны хэлэлцээрт зөвхөн барааны худалдаа гэлтгүй хөрөнгө оруулалт, боловсрол, ажиллах хүчний солилцоо, оюуны өмч, гаалийн хамтын ажиллагаа болон бусад асуудал орж ирж байна.

Дэлхийн худалдааны 80 орчим хувь нь Дэлхийн үнийн сүлжээ (ДҮС)-ээр дамжин явагдаж байгаа бөгөөд үүнд “Барааг дотоодод болон гадаадад боловсруулах” гаалийн горим гол үүрэг гүйцэтгэж байна. ДҮС-ний торон хэлхээг дурандан харах нэг өвөрмөц тал нь боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) юм. Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа гэдэг нь компаниуд түүхий эдээ өөр өөр улсаас авч, өөр нэг улсад угсарч, эцсийн бүтээгдэхүүнийг гуравдагч орны зах зээлд гаргах процесс юм. БНХАУ-ын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа нь тус улсад өөрчлөлт, шинэчлэлт хийгдэж, нээлттэй бодлого явуулсан цагаас эхлэн ийнхүү хурдацтай өссөн нь дээрх статистикаас харагдаж байна. Түүнчлэн БНХАУ-ын аж үйлдвэржилтийн процессыг хурдасгах, аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөн шинэчлэх ажлыг идэвхжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, БНХАУ-ын эдийн засгийг дэлхийн эдийн засагтай нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Зураг 25. БНХАУ-ын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдааны бодлогын систем

<p>Нэгдүгээрт,</p> <ul style="list-style-type: none"> • Гаалийн горим (баталгаат агуулах, үйлдвэрийн газар, тусгай бүс, чөлөөт бүс гм.)-ын бодлогын хүрээнд эд анги, материал боловсруулахаар оруулж ирэхэд гаалийн татвар, НӨАТ-өөс чөлөөлөх; • Зөвхөн тэдгээрийн заримыг дотоодын зах зээл дээр борлуулсан тохиолдолд л татвар ногдуулах.
<p>Хоёрдугаарт,</p> <ul style="list-style-type: none"> • Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-нд хяналтын уян хатан бодлого мөрдөх; • Цөөн тооны эмзэг (хориглосон, хязгаарласан) барааг эс тооцвол импортын материалд холбогдох зөвшөөрөл (лиценз) шаардахгүй; • Тийм зөвшөөрөл (лиценз)-ийг зөвхөн зарим материалыг дотоодын зах зээлд борлуулах
<p>Гуравдугаарт,</p> <ul style="list-style-type: none"> • Гадаадын талаас дотоодод үнэ төлбөргүй өгсөн боловсруулах тоног төхөөрөмжийг гаалийн татвар, лицензээс чөлөөлөх.

Эх сурвалж: ДГБ, Дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай ДГБ-ын гарын авлага, 2017 он.

Дэлхийн үнийн сүлжээ нь сүүлийн 10 жилд, ялангуяа Хятадын экспортод чухал үүрэг гүйцэтгэж байна. БНХАУ-ын 1979-2016 оны хооронд боловсруулах горим ашиглан хийсэн худалдааны нийт импорт, экспортын үнийн дүн 235 сая ам.доллараас 1,11 их наяд ам.доллар болж өссөн бөгөөд энэ горимын тус улсын гадаад худалдаанд эзлэх хувь 1,5-30,2 хувь хүртэл нэмэгдсэн байна. Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдааны үр дүнд шууд байдлаар 40 сая, шууд бус байдлаар 60 сая ажлын байр бий болгожээ.

Хэдийгээр үнэ төлбөргүй өгсөн боловсруулах тоног төхөөрөмжийг гаалийн болон бусад татвар, лицензээс чөлөөлдөг боловч энэхүү бодлого нь үндэсний хууль тогтоомжийн дагуу цөөн тооны бараанд үл хамаардаг байна. Эдгээр бодлогыг үндэслэн, боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны хувьд дагаж мөрдөх өөр хоорондоо харилцан хамаарал бүхий (гаалийн) баталгаат горимын бодлогын тогтолцоо бий болж тогтсон байдаг. Үүнд дараах зүйлс хамаарна:

- Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны бүртгэл тооцооны хуудас (буюу данс бүртгэлийн дэвтэр) нээж, хасалт хийх систем;
- Материал зарцуулалтын менежмент;
- Дотоодод борлуулах үйл ажиллагааны менежмент;
- Автоматжуулсан хяналт;
- Гаалийн хяналт, шалгалт ба хорио цээрийн хяналт; гаалийн татвар хураан авах ба түүнээс чөлөөлөх систем; мөн
- Гадаад валютын тооцооны хаалт гэх мэт.

БНХАУ-ын гадаад худалдааны гол түнш орон бол АНУ юм. Сүүлийн жилүүдэд АНУ-ын томоохон корпорациуд үйлдвэрээ БНХАУ-ын нутаг дэвсгэрт нүүлгэж байгаа нь тус улсад хөдөлмөрийн хөлс хямд, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлоготой шууд холбоотой юм. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг сайжруулах чиглэлээр томоохон алхамуудыг хэрэгжүүлнэ гэсэн хүлээлт дэлхийн хэмжээнд үүсээд байна.

Гадаадын хөрөнгө оруулалт нь аливаа улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч аж үйлдвэр өндөр хөгжсөн орны хувьд өөрийн орны эдийн засгийн гол салбарыг хамгаалах бодлогыг татварын хууль тогтоомжоор дамжуулан баримталдаг. БНХАУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд “Нэмэгдсэн өртгийн албан татвар; Хэрэглээний татвар; Бизнесийн татвар; Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн орлогын албан татвар; Хувь хүний орлогын албан татвар; Нөөцийн татвар; Газрын татвар; Хотын үл хөдлөх хөрөнгийн татвар; Тээврийн татвар; Ашиглалтын татвар; Тэмдэгтийн татвар; Хөдөө аж ахуйн татвар; Гаалийн татвар” гэх мэт олон шатлалт татварыг эдгээр хууль тогтоомжийн дагуу

ногдуулдаг байна.

БНХАУ-д 2008 оноос хүчин төгөлдөр болсон Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулиар (Corporate Income tax law) гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн орлогын татварыг 25 хувь болгосон ба 2007 оны 3 дугаар сарын 16-аас өмнө үйл ажиллагаагаа эхэлсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд нь 15 хувийн албан татвар төлөхөөр заажээ. Мөн хуулиар газар зүйн байршил, өндөр технологи, салбарын хөрөнгө оруулалтад дараах таатай орчинг бүрдүүлжээ. Үүнд:

- Газар зүйн байршлаар нь гадаадын хамтарсан аж ахуйн нэгж 33 хувийн албан татвар төлж байсан бол 2008 оны 1 дүгээр сарын 1-ээс 25 хувийн татвар төлөх болсон.
- Эдийн засгийн тусгай бүс, өндөр технологийн үйлдвэрлэлийн бүс, улсын түвшний эдийн засаг, технологийн хөгжлийн бүсэд байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь 15 хувь, БНХАУ 2017 онд байгуулсан нэмэлт чөлөөт бүсийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 24 хувьд хүргэсэн байна.

БНХАУ-д хувь хүний орлогын татварыг 3-45 хувийн албан татвар ногдуулж байна. Жижиг компаниуд тодорхой тохиолдолд 20 хувийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөг. Компаниуд тодорхой бүс нутгуудад 10 хувийн албан татвар, өндөр технологийн компаниуд 15 хувийн албан татвар төлдөг байна.

Гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ногдуулах албан татварын эрх зүйн зохицуулалтад 2016 онд шинэ журам нэвтрүүлжээ. Импорт, экспортын барааны нэр төрлөөс хамаарч ногдуулах албан татвар, хураамжийг ялгаатай зохицуулсан. Тухайлбал, БНХАУ-д импортолсон бүх бараанд 13 хувийн гаалийн албан татвар, бүх бараанд нэмэгдсэн өртгийн албан татвар 17 хувиар ногдуулж байна. Ерөнхийдөө дэлхийн ихэнх улсууд өөрийн экспортыг дэмжих зорилгоор экспортын албан татвар ногдуулах бодлого баримталдаггүй. Үүнтэй нэг ижил БНХАУ мөн ийм төрлийн бодлогыг баримталдаг байна. Засгийн газарт төлөх ёстой ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 10 хувь, уул уурхай, олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 25 хувиар тооцож ногдуулж байна. БНХАУ-ын худалдааны хориглолт, хязгаарлалтад хамаарах салбарыг зураг 26-аас харна уу.

Зураг 26. БНХАУ-ын худалдааны хориглолт, хязгаарлалт

Хязгаарласан салбар:
•Ховор, үнэ цэнэтэй ашигт малтмалын нөөцийн хайгуул, олборлолтын салбар.
Хориглосон салбар:
<ul style="list-style-type: none"> •Үндэсний аюулгүй байдал, Улсын батлан хамгаалахын аюулгүй байдалд халдсан; •Хүрээлэн буй орчин, Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй; •Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлэх; •Хятадын ховор уламжлалт технологийг хэрэглэх; •Радио идэвхт бүтээгдэхүүний хайгуул, олборлолт; •Ерөнхий боловсролын салбар.

Хориглосон салбар нь бусад улс оронтой ижил боловч, өөрсдийн уламжлалт технологи, радио идэвхт бүтээгдэхүүний хайгуул, олборлолт, боловсролын салбарт хөрөнгө оруулахыг хориглосон нь тус улсын үндэсний аюулгүй байдлын бодлоготой холбоотой юм.

Өмнө өгүүлсэнчлэн БНХАУ-ын баруун бүс, зүүн хойд хэсгийн бүс нутагт хөрөнгө оруулалтыг татахын тулд “Баруун бүсийг хөгжүүлэх ба Хоцрогдсон аж үйлдвэрийн суурийг дахин сэргээх стратеги” (Develop China’s West at Full Blast and Strategy of Reviving Rusty Industrial Bases) гэсэн хоёр бодлого гаргажээ. Иймд энэ бүс нутагт гадаадын хөрөнгө оруулалтыг татах илүү ялгаатай, таатай орчинг бүрдүүлсэн байна.


Бусад улс оронтой харьцуулахад гадаадын хөрөнгө оруулагчид тус улсын дотоод зах зээлээс зээл авах боломжийг олгосон нь давуу тал болжээ. Иймд БНХАУ-ын дотоодын зээл, хадгаламжийн хүү макро эдийн засгийн нэг чухал үзүүлэлт байж болох талтай. Хэдийгээр эдийн засгийн олон салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах болон хориглох бодлого баримталсан боловч БНХАУ-ын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг тус улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг хүлээн зөвшөөрдөг.

БНХАУ-д боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зээлийн хүү нь бусад салбараас харьцангуй өндөр буюу 6.5 хувь байна. Харин зээлийн хүү хамгийн бага салбар нь худалдаа, үйлчилгээний салбар байна. Эндээс төр нь худалдаа, үйлчилгээний салбарыг дэмжиж, уян хатан зээлийн хүүг энэ салбарт тогтоосныг харж болно. Үйлчилгээний гадаад худалдаанд хамаарах салбарт ногдуулах албан татварын хэмжээ нь хамгийн бага буюу 6 хувь байна. Үйлчилгээний худалдаа нь аялал жуулчлалын салбарыг дэмжих томоохон хөшүүрэг болдог. Харин гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын импортод хатуу хяналт тавьж өндөр албан татвар ногдуулж байна. Тухайлбал, хөрөнгө оруулж үйл ажиллагаа эрхэлж байгаа салбар, бүс нутгаас нь хамаарч, гадаадын компанийн импортод 11-100 хувийн татвар ногдуулж байна.

5.3.1. Монгол Улс, БНХАУ-ын гадаад худалдаа, хамтын ажиллагаа

Монгол Улс нь БНХАУ-тай 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон ба гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг тус улс сүүлийн 14

жил тэргүүлж байна⁸⁸. Хоёр улсын Засгийн газар хооронд 2015 оны байдлаар 41 төрлийн 132 баримт бичгийг байгуулсан байна.



Эх сурвалж: Монгол Улс, БНХАУ-ын харилцааны лавлах (ГХЯ, 2015)

Зураг 27-оос харахад хоёр орны Засгийн газар хооронд байгуулсан баримт бичигт “Худалдаа, эдийн засаг”-ийн чиглэл 11 хувийг эзэлсэн ба “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” нь хоёр орны худалдааг хөгжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн. Монгол Улс нь БНХАУ-тай эдийн засаг, худалдааны харилцааг шинэ агуулга хэлбэрээр баяжуулан хөгжүүлж, 2020 он гэхэд худалдааны нийт эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг 2014 онд⁸⁹ байгуулсан “БНХАУ болон Монгол Улсын иж бүрэн стратегийн түншийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаг”-т дэвшүүлсэн. Монгол – Хятад улсын 2005-2020 онд хийсэн гадаад худалдааны нийт эргэлтийг хүснэгт 28-аас харна уу.

Хүснэгт 28. 2005-2020 оны Монгол Улс БНХАУ- тай хийсэн гадаад худалдааны нийт эргэлт (сая ам. долл.)

Он	Нийт эргэлт	Экспорт	Импорт	Тэнцэл
2005	816,4	513,2	303,2	210,0
2006	1414,4	1049,4	364,9	684,5

⁸⁸ 1990-2013 оны байдлаар Монгол Улсад БНХАУ-ын 3,8 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна.

⁸⁹ БНХАУ-ын Ши Жиньпин дарга 2014 оны 8 дугаар сард Монгол Улсад айлчлах үед талууд Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтсоныг зарлан 2020 он гэхэд худалдааны хэмжээг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилт дэвшүүлжээ.

2007	1980,2	1411,3	568,9	842,4
2008	2534,6	1635,8	898,7	737,1
2009	1932,4	1393,9	538,5	855,4
2010	3437,3	2466,3	970,9	1495,4
2011	6463,7	4439,8	2023,8	2416,0
2012	5933,1	4059,7	1873,4	2186,3
2013	5528,9	3706,3	1822,6	1883,7
2014	6841,3	5073,4	1767,9	3305,5
2015	5300,0	3910,1	1389,9	2520,2
2016	4962,7	3901,6	1061,1	2840,5
2017	6737,1	5307,4	1429,6	3877,8
2018	8537,6	6542,8	1994,8	4548,0
2019	8850,5	6789,7	2060,7	4729,0
2020	7382,70	5489,9	1892,7	3597,2

Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (ГЕГ, 2005-2020)

Сүүлийн 16 жилд Монгол – Хятадын гадаад худалдааны эргэлт 78.65 тэрбум ам. долларт хүрсэн бөгөөд эдгээр хугацаанд 2019 онд 8,85 тэрбум ам. долларт хүрсэн нь хамгийн өндөр өсөлтөд тооцогдож байна. Дээрх хугацаанд хийсэн гадаад худалдааны 73,34 хувийг импорт, үлдсэн 26,66 хувийг экспорт эзэлжээ. Монгол Улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзэлсэн хувийг хүснэгт 27–оос харна уу.

Хүснэгт 27. Монгол Улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх хувь (2005-2019 он)

	Гадаад худалдааны эргэлт	Экспорт	Импорт
2005	36,4	48,2	25,8
2006	47,5	68,1	25,4
2007	49,4	72,5	27,6
2008	43,9	64,5	27,7
2009	48,0	73,9	25,0
2010	56,2	84,7	30,3
2011	56,6	92,1	30,6
2012	53,2	92,5	27,6
2013	52,0	86,8	28,6
2014	62,1	87,9	33,8
2015	62,6	83,7	36,6
2016	59,9	79,4	31,6
2017	63,9	85,6	32,9
2018	66,3	93,3	33,5
2019	64,1	88,8	33,2

2020	50,0	72,5	35,7
------	------	------	------

Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (ГЕГ, Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2020)

Хүснэгт 27-оос харахад БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд 2010 оноос хойш 50-иас дээш хувь, экспортод 80-аас дээш хувийг эзлэх болжээ. Сүүлийн 10 жилд Монгол Улсын гадаад худалдааны эргэлт БНХАУ-аас шууд хамаарч байна.

Судалгааны ажлын эхний бүлэгтэй уялдуулах зорилгоор хөрш орнуудтай ДХБ, ДГБ-аас баталсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон гурван талт, хоёр талт хамтын ажиллагааг зохицуулсан баримт бичгийн хүрээнд гадаад худалдааны бодлого, зохицуулалт, гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаагаа уялдуулах боломжийг дараах бүлэгт авч үзлээ.

5.4. Гурван улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдааны бодлого, чиглэлийг уялдуулах боломж

Судалгааны ажлын үндсэн хэсгийн энэхүү сүүлийн бүлэгт Монгол Улс хөрш орнуудтай ДХБ, ДГБ-аас батлан гаргасан гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хүрээнд хэрхэн хамтран ажиллах боломжийг авч үзлээ. НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын судалгаанд гадаад худалдааны бодлогод нөлөөлөх хүчин зүйлийг зураг 28-аас харна уу.

Зураг 28. Гадаад худалдааны бодлогод нөлөөлөх хүчин зүйл

<p>Гаалийн тариф:</p> <ul style="list-style-type: none"> •0-10 хувь (нэн тааламжтай, хөнгөлөлттэй гаалийн тарифын хувь хэмжээ).
<p>Бодлого, зохицуулалттай холбоотой "Тарифын бус хориг саад"</p> <ul style="list-style-type: none"> •60-90 хувь: <ul style="list-style-type: none"> •Хил дээрх зардал: 1 хувь; •Мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдал (Хил, гаалийн цахим үйлчилгээ, цахим худалдаа): 6-7 хувь; •Бизнесийн орчин (дүрэм, журам, зохицуулалт): 6-7 хувь; •Дамжин өнгөрөх болон далайн боомтын дамжуулан өнгөрүүлэх чадавх: 16-18 хувь; •Худалдааны бусад зардал: 52-57 хувь; <ul style="list-style-type: none"> •Стандарт, техникийн нөхцөлүүд (SPS, TBT)"; •Худалдааны дүрэм журмын шууд бус зардал; •Валютын ханш; •Бусад тарифын бус саад.
<p>Газар зүйн байршилтай холбоотой хүчин зүйл:</p> <ul style="list-style-type: none"> •30 хувь.

Эх сурвалж. НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс

Зураг 28–аас харахад гадаад худалдааны бодлогод зөвхөн тариф, татварын бодлого нөлөөлөхгүй болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл гадаад худалдааны бодлогод *“Гаалийн тариф 0-10, Бодлого зохицуулалт 60-90 хувь, Газар зүйн байршил 30 хувь”* нөлөөлөх боломжтойг улс орнуудын бодлогыг харьцуулан судалсан судалгаа харуулжээ. Гадаад худалдааны бодлого, чиглэлийг тодорхойлоход улс төрийн эрх мэдэл чухал. Гэтэл шийдвэр гаргагчид худалдааны бодлого ярихдаа ихэнх тохиолдолд чөлөөт худалдааны, эсвэл эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулснаар эдийн засгийн хөгжил түргэсэх мэт өрөөсгөл байдлаар ойлгодог ойлголтыг НҮБ-ын АНДЭЗНК-ын судалгаа няцааж байна.

Гаалийн тариф нь ДХБ-д нэгдэн орохдоо улс орнуудын авсан үүрэг амлалт буюу тааз тарифын хэмжээнээс хамаарна. Энэ бүлэгт ДГБ-аас батлан гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг харьцуулан судалсан гол зорилго нь улс хооронд хийгдэх хил дамнасан худалдаанд хяналт тавих үндсэн чиг үүргийг гаалийн байгууллага хэрэгжүүлдэг. Иймд гурван улсын гаалийн үйл ажиллагааг⁹⁰ уялдуулснаар худалдааны эргэлтийг түргэсгэх, худалдааг хөнгөвчлөх боломж бүрдэх юм. Өөрөөр хэлбэл гаалийн байгууллагын чиг үүрэгт худалдааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлого хамаарах тул эдгээр байгууллагын үйл ажиллагааг уялдуулснаар Монгол Улсын гадаад худалдаа өсөн нэмэгдэх, мөн гаалийн зарим горимын тусламжтай (Тухайлбал, гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс, барааг дотоодод болон гадаадад боловсруулах гаалийн горим) эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Гаалийн үйл ажиллагааг уялдуулахад ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийн хүрээнд хамтран ажиллахад үр дүн гарах нь дамжиггүй. Гадаад худалдаатай холбоотой ДГБ, ДХБ-аас гаргасан гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон огноог харьцуулан хүснэгт 27-д үзүүллээ. *(Монгол Улсын соёрхон баталсан гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаатай холбоотой олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрүүдийг хавсралт 5-аас харна уу).*

*Хүснэгт 27. ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс, ОХУ, БНХАУ нэгдэн орсон байдал**

№	Баримт бичгийн нэр	Монгол Улс	ОХУ	БНХАУ
1	ДГБ-ын “Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц” (ДГБ байгуулах тухай Конвенц)	1991	1991	1983

⁹⁰ ДГБ-ын “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай” конвенцид “Гаалийн хуулийн хэрэгжилтийг хангуулах, гаалийн болон бусад татварыг хураан авах, мөн импорт, экспорт болон барааны хадгалалт, хөдөлгөөнтэй холбоотой бусад хууль, журмуудыг мөрдөх чиг үүрэг бүхий Засгийн газрын үйлчилгээний албыг хэлнэ” гэж тодорхойлсон.

2	ДГБ-ын “Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенц”	1993	1997	1993
3	ДГБ-ын “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц”	2006	2002	2001
4	ДГБ-ын “Дэлхийн худалдааг аюулгүй байлгах хөнгөвчлөх багц стандарт”	2005	2005	2005
5	ДХБ-ын “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр” (Дэлхийн Худалдааны Байгууллагын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр)	1997	2012	2011
6	ДХБ-ын “ТХЕХ-ийн 1994 оны VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр” (Үнэлгээний Хэлэлцээр)	1997	2012	2011
7	ДХБ-ын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”	2016	2016	2015

Эх сурвалж: ДГБ (ДГБ, 2019), ДХБ-ын албан ёсны цахим хуудас (ДХБ, 2019)

*Тайлбар: *гэрээ хүчин төгөлдөр болсон огноо*

Хүснэгт 27–оос харахад гэрээ, хэлэлцээр, стандартын хүрээнд гурван улсын хооронд гадаад худалдааны бодлого, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах боломж олон улсын түвшинд бүрдсэн болох нь тодорхой байна.

Монгол Улс өөрийн гадаад худалдааны гол түнш орнуудтай зөвхөн хоёр талт хамтын ажиллагаагаар хязгаарлагдахгүй, олон улсын түвшинд хамтран ажиллах боломжтой. Гэсэн хэдий ч эдгээр баримт бичгийн хүрээнд тодорхойлсон боломжийг бүрэн дүүрэн ашиглахгүй байгаа нь өнөөгийн гадаад худалдааны бодлого, түнш орнуудтай хэрэгжүүлж буй төрийн бодлогоос ажиглагдаж байна. Тухайлбал, Монгол Улс анх ДХБ-д анх элсэн орохдоо импортын барааны гаалийн тарифын хэмжээг бага хэмжээгээр тогтоосон болохыг хүснэгт 28-аас харна уу.

Хүснэгт 28. 2020 оны байдлаар БНХАУ, ОХУ, Монгол Улсын импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээ

Импортын тарифын хувь хэмжээ, хувиар	БНХАУ	ОХУ	Монгол
Хамгийн өндөр тариф	695,50	100	40
Энгийн дундаж тариф	7,56	4,92	5,04
Худалдааны жигнэсэн дундаж тариф	3,39	3,51	5,26

Эх сурвалж: *The World Integrated Trade Solution software (Software, 2020)*

Хүснэгт 28-аас харахад Монгол Улсын гадаад худалдааны түнш орнуудад мөрдөж буй импортын гаалийн тарифын хувь хэмжээ нь харилцан адилгүй байна. Өөрөөр хэлбэл тарифын бодлогоор үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг өндөр түвшинд байна гэж үзэж болно. Тэгвэл импортын

барааны хамгийн өндөр гаалийн тариф нь БНХАУ-д 695,5 хувь, ОХУ-д 100 хувь, Монгол Улсад хамгийн бага буюу 40 хувь байна. БНХАУ-ын гаалийн энгийн дундаж тариф нь манай улсынхаас 2,52 хувиар өндөр байхад ОХУ-ынх манай улсынхаас 0,12 хувиар бага байна. Тэгвэл Монгол Улсын гадаад худалдааны жигнэсэн дундаж тариф нь БНХАУ-ынхаас 1,87 хувь, ОХУ-ынх 1,75 хувиар өндөр байна. Ийм байдал нь БНХАУ нь дэлхийн эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг, хүн амын тоогоор дэлхийд тэргүүлэгч, худалдааны бодлого нь үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ба зах зээлээ хамгаалахад чиглэсэн байдаг, дэлхийн үнийн сүлжээнд гол байр эзэлдэг учир импортын энгийн дундаж тариф нь Монгол Улс, ОХУ-ынхаас өндөр байна. Монгол Улсын зарим албан татварын хувь хэмжээг хөрш орнуудтай харьцуулсан судалгааг хүснэгт 29–өөс харна уу.

Хүснэгт 29. Монгол Улсын зарим албан татварын хувь хэмжээг хөрш орнуудтай харьцуулсан харьцуулалт, хувиар

Татварын төрлүүд	Хятад	ОХУ	Монгол
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	10-25	15,5-20	10-20
НӨАТ	17	20	10
Рояльти	10	20	2,5
Нийгмийн хандив, дэмжлэг	Сайн дурын	Заавал шаардлагатай	Сайн дурын

Эх сурвалж: <https://www.pwc.com/gx/en/energy-utilities-mining/publications/pdf/pwc-gx-miining-taxes-and-royalties.pdf>

Хүснэгт 29–өөс харахад үзүүлсэн гурван улсын зарим албан татварын хувь хэмжээнээс харахад ОХУ-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, Рояльти өндөр байна. БНХАУ-д аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрлөөс хамаарч 10-25 хувь, НӨАТ 17 хувь байна. Монгол Улсад эсрэгээрээ хөрш орнуудтай харьцуулахад харьцангуй бага албан татвар ногдуулжээ. Аж ахуйн нэгжээс нийгэмд үзүүлэх хандив, дэмжлэг нь ОХУ-ын хувьд заавал өгөх шаардлагатай бол БНХАУ, Монгол Улсад сайн дурын үндсэн дээр явагддаг байна.

БНХАУ, ОХУ нь ДХБ-д Монгол Улстай харьцуулахад хожуу элсэн орсон. Түүнчлэн аж үйлдвэр өндөр хөгжсөн тул, өөрсдийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд татварын бодлогод тун болгоомжтой ханддаг байна. Хэдийгээр ДХБ-ын гишүүнээр хожуу нэгдэн орсон хэдий ч тус байгууллагаас гаргах бодлогын баримт бичигт гол байр суурь эзэлж, өөрийн үзэл бодлыг нээлттэй илэрхийлэх, түүнчлэн хөгжиж буй орнуудад техникийн туслалцаа үзүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа талаар ДХБ-ын тайланд тусгажээ.

Зөвхөн БНХАУ төдийгүй дэлхийн эдийн засгийн нөлөө бүхий улс орнууд ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэгдэн орохдоо өөрийн

импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээг өндөр тодорхойлдог байна. Өөрөөр хэлбэл, тухайн улс өөрийн үндэсний үйлдвэрлэл, түүний дотор ХАА, аж үйлдвэрийн салбараа хамгаалан ийнхүү тарифын хэмжээг өндөр тогтоожээ.

ДХБ⁹¹-ын гадаад худалдаа, үйлчилгээний худалдаа, гарал үүслийн дүрэм, оюуны өмч, худалдааг хөнгөвчлөх зэрэг чиглэлээр гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг олон улсын хэмжээнд нэгдсэн стандартаар мөрдүүлэх, уялдуулах чиглэлийг ДГБ тодорхойлдог гэж хэлж болно. Иймд тус хоёр байгууллагын үйл ажиллагаа нэг зоосны хоёр тал шиг уялдаатай явагддаг болох нь олон улсын худалдааны бодлого, чиглэлээр хийсэн судалгаа, дүгнэлтээс тод харагдана.

Гарал үүслийн дүрэм ДХБ-аас гишүүн орнуудын хооронд ямар нэгэн худалдааны саад тотгор байхгүй, худалдааг аль болох либералчлах бодлого баримтлан тус байгууллагын олон талт худалдааны системийн хэлэлцээрт үндсэн зарчмыг тусгасан байдаг. Эдгээрийн нэг нь нэн тааламжтай болон хөнгөлөлттэй гаалийн тарифыг гишүүн орнууд хоорондоо эдлэх боломж олгосон явдал юм. Иймд ДХБ-ын гишүүд хоорондоо хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх зорилгоор Эдийн засгийн түншлэл, эсвэл Чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна. БНХАУ 16⁹² бүс нутгийн болон хоёр талт (Өнөөдрийн байдлаар 8 улстай эдийн засгийн болон чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлсэн), ОХУ⁹³ 5 бүс нутгийн болон хоёр талт Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг тус тус байгуулан ажиллаж байна. Мөн Иран, Энэтхэг, Египет, Сингапур Улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг ОХУ 2016 онд эхлүүлжээ.

Монгол Улс Япон болон АПТА-тай чөлөөт худалдааны хэлэлцээр болон эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулсан. Монгол Улсын гааль олон улсын Конвенцид заасны дагуу гарал үүслийн улсыг тодорхойлох 2 шалгуур (“Барааг бүрэн үйлдвэрлэсэн улс” – барааг нэг улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх, “Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийх” - барааг хоёр буюу түүнээс дээш улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх)-ыг мөрдөхөөр 2008 оны Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд тусгажээ. Тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар “4.5. *Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтыг*

⁹¹ Гаалийн тарифаас гадна худалдааны гажилтыг зохицуулах “Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу авах демпингийн эсрэг арга хэмжээ; Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах саармагжуулах арга хэмжээ; Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах хамгаалалтын арга хэмжээ” гэсэн гурван арга хэрэгслийг ДХБ-аас тодорхойлсон байдаг.

⁹² БНХАУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан түнш орон: ASEAN, Сингапур, Пакистан, Шинэ Зеланд, Чили, Перу, Коста Рика, Исланд, Швейцарь, Малдив, Гүрж, Хонг-Конг, Макао, Тайван, БНСУ, Австрали.

⁹³ ОХУ- Беларус- Украин- Молдав- Тажикистан- Армен- Казахстан- Кыргыз- Узбекистан, ОХУ- Украин, Евроазийн эдийн засгийн холбоо (ОХУ- Казахстан- Беларусь- Армен- Кыргыз), Евроазийн эдийн засгийн холбоо- Вьетнам, Евроазийн эдийн засгийн холбоо- Серб.

Засгийн газар батлах бөгөөд уг жагсаалтад хамаарах улсын гарал үүсэлтэй бараа нь гарал үүслийг нотлох баримт бичигтэй байна.; “31.8.Гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батална.” гэж заасан байна. Харин Эдийн засгийн түншлэлийн болон Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан улс орны хувьд уг хэлэлцээрт гарал үүслийн дүрмийг хэрхэн тодорхойлохыг тусгасан байдаг.

Дүгнэлт

Монгол Улс далайд гарцгүй, эдийн засгийн хөгжлөөр сул дорой орны хувьд гадаад худалдаанаас үлэмж хамааралтай билээ. Иймд гадаад худалдааны бодлого, чиглэлийг зөв тодорхойлох, ялангуяа худалдааны гол түнш болсон хөрш орнуудын гадаад худалдааны бодлого, чиглэл, тээврийн дэд бүтцийн чиг хандлага, хөгжилтэй уялдуулах, хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байсаар байна. Энэхүү судалгааны ажлаар гурван орны гадаад худалдааны өнөөгийн байдал, бодлого чиглэл, ДХБ, ДГБ-ын бодлого, чиглэлийг уялдуулах, худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа, гаалийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийн талаар судаллаа. Судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Гадаад худалдаа нь тухайн улсын хүн ам, газар зүйн байршил, эдийн засгийн хөгжил, гадаад худалдааны бодлого зэргээс хамаарч гадаад худалдааны бараа эргэлтийн хэмжээ, төрөл нь харилцан адилгүй байна. Тухайлбал, Дотоодын нийт бүтээгдэхүүнээр БНХАУ 2, ОХУ 12, Монгол Улс 126 дугаарт тус тус жагссан. Дэлхийн эдийн засагт манай хөрш орнуудын гүйцэтгэх үүрэг үлэмж их бөгөөд зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхийн бүх улс орны гадаад худалдаанд гол түнш оронд тооцогддог.

Тээврийн салбар, бусад хүчин зүйлийн нөлөөлөл: Дэлхий нийтийн хэмжээнд КОВИД-19 вируст халдвар тархан хилийн хязгаарлалт тогтоож, хязгаарлагдмал хүрээнд гадаад худалдаа эрхэлсэн хэдий ч том орнууд нийлүүлэлтээ улам бүр бэхжүүлж, жижиг орны худалдааны хэмжээ буурч байна. Үүнээс улбаалан БНХАУ-тай хийх худалдаа 2020 онд 1,2 тэрбум ам. доллар, ОХУ-тай хийсэн худалдаа 0,4 тэрбум ам. доллараар буурахад нөлөөлсөн.

Түүнчлэн гадаад худалдаа нь *тээврийн салбартай нягт уялдаатай* тул Монгол Улсад орох болон гарах худалдааны урсгал түүнээс үлэмж хамааралтай болохыг БНХАУ-ын Тяньжин боомт, Эрээн боомтод үүссэн Монгол Улс руу орох ачааны бөөгнөрөл харуулж байна. Мөн ОХУ-аас экспортлох нефть бүтээгдэхүүний нийлүүлэлт багассанаар Монгол Улсад шатахууны үнэ өссөн. Улмаар Монгол Улсын дотоодын зах зээлд барааны нийлүүлэлт буурч, үнэ өсөх үр дагаварт хүргэж байна.

Иймд энэ мэт гадаад худалдаа, тээврийн салбарт үүсч буй нөхцөл байдлаас харахад гадаад худалдааны бодлогод улс орнуудын улс төр, гадаад

хамтын ажиллагаа, урт хугацааны хөгжлийн бодлого, холбогдох салбарыг хамтын ажиллагаа чухал болохыг судалгаа харууллаа.

Монгол Улсын экспортод 2005 онд БНХАУ 48 хувь эзэлж байсан бол 2020 онд 72,46 хувь эзэлжээ. Сүүлийн таван жилийн дунджаар нийт гадаад худалдааны эргэлтэд БНХАУ 63,4 хувь эзэлсэн бөгөөд түүний дотор экспортод 85 хувийг эзэлж байгаа нь нэг улсаас гадаад худалдаа үлэмж ихээр хараат болохыг харуулж байна. Барааны бүтцийг харьцуулан судлахад Монгол Улсын экспортод уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүн эзлэн, хэрэглээний барааны дийлэнх хэсгийг импортолдог. Монгол Улсын аж үйлдвэрийн хөгжил, тээврийн дэд бүтцийн хөгжил сул байгаа нь гадаад худалдааны барааны бүтцэд онц гойд өөрчлөлт сүүлийн жилүүдэд ороогүй байгаагаас харагдаж байна.

Монгол Улс далайд гарцгүй улс тул БНХАУ-ын нутаг дэвсгэрээр Монгол Улсад ирэх болон гарах бараа, тээврийн хэрэгсэл дамжин өнгөрдөг. Иймд тээврийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

ОХУ-тай хийсэн худалдаанд томоохон хэмжээний өөрчлөлт ороогүй. Сүүлийн таван жилийн дунджаар нийт гадаад худалдааны эргэлтэд ОХУ 12,7 хувь эзэлсэн бөгөөд, түүний дотор импортод 27,7 хувийг эзэлж байна. Тус улсад экспортолсон бараа нь уул уурхайн эрдэс бүтээгдэхүүн, малын гаралтай бараа, түүхий эд эзэлжээ. Импортын бүтцээс харахад нефть бүтээгдэхүүн гол байр суурь эзэлсэн хэвээр байна. ОХУ Монгол Улсад экспортлох нефть бүтээгдэхүүний хэмжээг бууруулснаар дотоодод хомсдол үүсч, шатахууны үнэ өсч, улмаар дотоод зах зээлд бусад барааны үнэ нэмэгдэх эрсдэлийг дагуулсан.

Гадаад худалдааны бодлого чиглэлийг ДХБ, ДГБ-аас гаргасан бодлогын баримт бичиг, хоёр орны хооронд болон бүс нутгийн хэмжээнд байгуулсан, байгуулахаар төлөвлөсөн баримт бичгийн хүрээнд хамтран ажиллах боломж өргөн хүрээнд байгааг гурван улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр харуулж байна. Монгол Улсын хувьд олон улсын гэрээ, хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрмэлзэж ирсэн боловч өөрийн байр суурийг гадаад худалдаа, тээврийн салбарын бодлогод илэрхийлэх чадамж дутагдалтай байна. Үүний нэг тод илрэл нь хилийн хамтын ажиллагаа, дамжин өнгөрөх эрх чөлөөг⁹⁴ эдлэх боломжтой боловч хөрш орнуудын нутаг дэвсгэрээр дамжин Монгол Улсад ирэх, мөн Монгол Улсаас гарах ачаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн удааширсаар өнөөгийн бараа нийлүүлэлтийн хомсдолд нөлөөлжээ.

Монгол Улс, ОХУ, БНХАУ гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан олон улсын түвшний 7 баримт бичигт нэгдэн орсон ба тэдгээрт олон улсын гэрээ, хэлэлцээр, стандартад нийцүүлэн гадаад худалдааг

⁹⁴ ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Зүйл 11. Дамжин өнгөрөх эрх чөлөө, Зүйл 8. Хилийн хамтын ажиллагаа.

хөнгөвчлөх, худалдааны мэдээлэл солилцох, хөнгөлөлттэй гаалийн тарифын хувь хэмжээ мөрдөх, гаалийн үйл ажиллагааг хялбарчлах, уялдуулах боломжууд багтсан. Гэхдээ дан ганц гаалийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь учир дутагдалтай, тээврийн салбартай хамтдаа хөгжих хэрэгцээ шаардлага байгааг өнөөгийн гадаад худалдааны орчинд үүсээд байгаа нөхцөл байдал харуулж байна.

ДХБ-аас тус байгууллагын гишүүн орнууд импортын гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх болон эдийн засгийн түншлэл байгуулах хоёр талт, эсвэл бүс нутгийн хэлэлцээр байгуулах боломжийг олгосон. Монгол Улс “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр”-т 2019 онд нэгдэн орсон бөгөөд 2021 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хэлэлцээрт БНХАУ нэгдэн орсон. “Евразийн Эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Монгол Улс БНХАУ, ОХУ-тай Засгийн газар хооронд болон байгууллага хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тээврийн салбарыг хөгжүүлэх олон төрлийн баримт бичиг байгуулжээ. ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого нь өөр олон салбарыг хөгжүүлэх бодлого, Тухайлбал, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тээврийн салбарыг хөгжүүлэх, технологи, инновацийг дэмжих, бэхжүүлэх, мэдээллийн технологийн хөгжлийг дээшлүүлэх, олон талт, бүс нутгийн болон хоёр талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, худалдаа эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх, төрийн давхардсан хяналт, дүрэм, журмын шаардлагыг бууруулах зэрэг бодлоготой зэрэгцэн хөгжсөн байна. Эндээс салбар хоорондын уялдаа холбоо Монгол улсад дутмаг байгаа нь гадаад худалдааны хөгжлийг бууруулсан гэж хэлж болно.

Санал, зөвлөмж

Монгол Улсын худалдаа, эдийн засгийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх гадаад худалдааны бодлого, чиглэлийг хөрш орнууд, худалдаа, тээврийн чиглэлийн олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг харьцуулан судалж, **дараах санал, зөвлөмжийг гаргаж байна:**

Нэг. Худалдаа, эдийн засаг, хилийн хяналт, хорио цээр, тээвэр, дэд бүтцийн чиглэлээр байгуулсан баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх:

- ОХУ, БНХАУ-тай хоёр орны Засгийн газар хооронд худалдаа, эдийн засаг, дэд бүтцийн чиглэлээр байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хамтын ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичгийн нэгдсэн жагсаалтыг гарган гүйцэтгэлийг гаргаж, давхардсан баримт бичгийг уялдуулах, нэгтгэх боломжийг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулах.
- ОХУ, БНХАУ нь Монгол Улсын мөнхийн хөрш, стратегийн гол түнш орнууд юм. Сүүлийн 5 жилийн дунджаар Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд ОХУ, БНХАУ нийлээд 76,1 хувийг эзэлсэн. Харин хөрш орнуудын

гадаад худалдаанд Монгол Улсын эзлэх хувийн жин 1 хувьд ч хүрэхгүй байна. Энэ талаар гадаад худалдааны судлаачид⁹⁵ "...чөлөөт худалдааны хэлэлцээр нь түнш улсуудын хувьд "худалдааны бус агуулга"-тай (tradeless)" тухай бодлогын судалгааны тайланд өгүүлсэн байдаг. Хөрш орнуудын гадаад худалдаанд бид маш бага хувь эзэлж байгаа нь хэдийгээр эдгээр орнуудтай худалдааны олон төрлийг хөгжүүлэх тухай баримт бичиг байгуулсан боловч хэрэгжилтийг Монгол Улсын талаас санаачилга гаргаагүй тохиолдолд хөрш орнууд түрүүлж санаачилга гаргахгүй байдаг.

- Хэдийгээр олон төрлийн худалдаа, эдийн засаг, хилийн хяналтын чиглэлийн баримт бичгийг байгуулсан боловч тунхаглалын шинжтэй, зөвхөн уулзалтаас уулзалтад, цаасан дээр хамтын ажиллагаа үлдсэн гэж хэлж болохоор байна. Иймд Монголын тал өөрсдөө идэвх санаачилга гаргаж ажиллах нь зүйтэй.

Хоёр. Гадаад худалдаа, хилийн хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах төрийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх:

- Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын хооронд худалдааны хөгжлийг дэмжихийн тулд таатай нөхцөл бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, ОХУ-ын Холбооны гаалийн алба, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын Санамж бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, барааны нэр төрлийн сонголтыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны механизмыг бий болгох.
- Гурван улсын эдийн засгийн коридорын хөгжлийг түргэтгэх, гадаад худалдааг тээврийн дэд бүтэцтэй уялдуулан хөгжүүлэх бодлого баримтлах.
- ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлогод, тариф, татварын бодлогоос гадна, үйл ажиллагааг уялдуулах, хялбаршуулах, стандартчлах чиглэл давамгайлж байна. Иймд гаалийн хяналтыг харилцан хүлээн зөвшөөрөх, хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны горимоо ижилтгэж, гадаад худалдаанд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах.
- Нэмүү өртөг шингэсэн барааны экспортыг нэмэгдүүлэхдээ "Барааг дотоод, гадаадад боловсруулах", "Гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс"-ийн гаалийн

⁹⁵ МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетинг, Олон улсын худалдааны тэнхимийн I багийн 2012 онд гүйцэтгэсэн "Худалдааны гол түнш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж болон эрсдэл" сэдэвт бодлогын судалгаанд "Худалдааны гол түнш эдгээр улсууд Монгол Улсын гадаад худалдаанд 80 гаруй хувийг эзэлж байгаа ба манай гадаад худалдаа хоёр хөрш улсаас, ялангуяа БНХАУ-аас үлэмжхэн хамааралтай байна. Харин эсрэгээр эдгээр улсуудын гадаад худалдаанд Монгол Улс өчүүхэн бага буюу экспортод 0,02-0,3 хувь, импортод 0,0005-0,2 хувийг эзэлж байгаа юм. Эндээс харахад бидний байгуулахыг зорьж буй чөлөөт худалдааны хэлэлцээр нь түнш улсуудын хувьд "худалдааны бус агуулга"-тай (tradeless) болох нь харагдаж байна" гэж Монгол Улсын өнөөгийн нөхцөлийг тоон мэдээлэлд үндэслэн судалсан байна.

горимыг ашиглах. Барааг дотоодод болон гадаадад боловсруулах гаалийн горимын дагуу уул уурхайн бус гаралтай барааны экспортыг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэгч нарт хөрш орнуудын зах зээлд бараагаа экспортлоход дэмжлэг үзүүлэх.

Үүнтэй уялдуулан тодорхой нэг салбарыг сонгон, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. Тухайлбал, Монгол Улсад үйлдвэрлэхэд түүхий эд элбэг салбарын (Мал аж ахуй, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн салбар: дулааны аргаар боловсруулсан мах, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн, ноос, ноолууран бараа, гоо сайхан, эмийн ургамал гэх мэт) үйлдвэрлэлийг үе шаттай дээрх гаалийн горимыг ашиглан хөгжүүлэх. Энэ нь нэмүү өртөг шингэсэн барааг дотооддоо үйлдвэрлэн, ажлын байр бий болгож, гадаад зах зээлд Монголын барааг худалдаалах, өөрөөр хэлбэл экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой болно.

- БНХАУ, Монгол Улсын гаалийн байгууллага хооронд байгуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх” хэлэлцээрийн цар хүрээг нэмэгдүүлэн, нэн тэргүүнд итгэмжлэгдсэн экспортлогч, тээвэрлэгчийн хөтөлбөрийг нэвтрүүлэхэд стратегийн түвшний дэмжлэг авах ажлыг зохион байгуулах. Энэ нь Монголын Улсын тус улсаар дамжин өнгөрөх болон бусад тээвэр хугацаа хүлээхгүйгээр түргэн шуурхай нэвтрэх боломжтой болох юм.
- ОХУ-ын Холбооны гаалийн албатай “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх” хэлэлцээр байгуулах ажлыг судлах.
- Түүнчлэн Монгол Улс дотооддоо гадаад худалдааны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч төрийн байгууллагын хяналтын давхардлыг бууруулах, нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх, цаасгүй, дижитал худалдааг хөхиүлэн дэмжих, гадаад худалдааны нэг цонхны системийг нэвтрүүлснээр өнөөгийн байгуулсан баримт бичгийн хэрэгжилтэд дэмжлэг болох юм.

Гурав. Хөрш орнуудын гадаад худалдааны бодлого, чиглэлтэй өөрийн үйл ажиллагааг уялдуулах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, худалдаанд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах:

- Гадаад худалдааны бодлогод нөлөөлөх бодлого, зохицуулалттай холбоотой “Тарифын бус хориг саад”-ыг хэрхэн хэрэгжүүлдэг туршлагыг хөрш орнуудаас суралцан нэвтрүүлэх. Тухайлбал, мал, амьтны гаралтай барааны стандарт, хориг саадыг хэрэгжүүлж буй бодлого.
- БНХАУ-ын нэмүү өртөг шингэсэн барааны үйлдвэрлэлийг дэмжих “Боловсруулах горим”-ыг хөгжүүлж Дэлхийн үнийн сүлжээнд оролцож буй туршлага, хөрөнгө оруулалтын бодлогыг экспортын дэмжлэг үзүүлэх салбартай уялдуулсан туршлагаас суралцан, үндэсний онцлогт тохирсон бодлого бий болгох.

- Хөрш орнууд Монгол Улсын гадаад худалдаанд гол байр суурь эзлэх тул гааль, худалдааны төлөөлөгч (атташей)-ийг Монгол Улсаас БНХАУ, ОХУ-д суух ЭСЯ-нд ажиллуулах боломжийг Засгийн газраар шийдвэрлүүлэх. Ингэснээр худалдааны үйл ажиллагаатай холбоотой гарах хүндрэлтэй асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, гааль, хилийн хяналтыг түргэвчлэх, худалдаа, эдийн засгийн чиглэлээр олон салбарт хэрэгжүүлж буй санаачилгыг хооронд нь уялдуулах боломж бүрдэнэ.
- ОХУ, БНХАУ-тай хиллэх хилийн боомтын дэд бүтцийг сайжруулах ажлыг Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт, АХБ-ны хөнгөлөлттэй зээл, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хийгдэж байна. Иймд гадаад худалдааг саадгүй нэвтрүүлэхтэй холбоотой төрийн захиргааны, түүний дотор хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай.
- Хөрш орнуудын эрх бүхий байгууллага (гааль, хорио цээр)-тай хилээр нэвтрэх барааны хяналтыг ижилтгэх, түргэн шуурхай нэвтрүүлэх, цахим мэдээлэл солилцох, худалдааны нэгдсэн бичиг баримттай болох ажлыг шат дараалалтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг дээд түвшний уулзалтын үеэр санал тавьж шийдвэрлүүлэх арга замыг эрэлхийлэх.
- Дамжин өнгөрөх эрх чөлөөний талаар ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд тусгасан байдаг. Практикт хөрш орнуудаар дамжин өнгөрч буй ачилт удаашрах, олон цагаар хүлээх, давхардсан хяналтаар дамжих, аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй зэрэг асуудал байсаар байна. Иймд хэлэлцээрийн дагуу ижил боломж эдлэх асуудлын Зам, тээвэр хөгжлийн яам, Гадаад харилцааны яамнаас хөрш орнуудын ижил түвшний байгууллагад хүсэлт тавьж, харилцан санал солилцож, олон улсын хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.
- Монгол Улс өнгөрсөн дөрвөн жилд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор тодорхой нэр төрлийн бараатай холбоотой тарифын бус зохицуулалт хийсэн байдаг. Энэ нь ДХБ-ын өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлээгүй гэсэн үндэслэлээр ОХУ-ын талаас ДХБ-д энэ асуудлыг тавьж тус байгууллагын гишүүн зарим орон Монголын шийдвэрийг буруутгаж, өнөөг хүртэл гомдол үргэлжилсээр байна. Эндээс бид олон сургамж авч байна. *Нэгд*, олон улсын гэрээ, хэлэлцээр, хоёр талт баримт бичгийн хэрэгжилтийг ижил байдлаар мөрдөх боломжийг нөгөө талдаа тавих боломжтой. *Хоёрт*, дээрх жишээтэй ижил байдлаар хилийн хяналтыг түргэвчлэх чиглэлээр байгуулсан баримт бичгийг хэрэгжилтийг хангах ажлыг ОХУ-д байнга тавих нь зүйтэй.
- Худалдаа, үйлдвэрлэлд тавих төрийн хяналтын хувьд БНХАУ энгийн, хялбар, стандарт үйл ажиллагааны бодлого хэрэгжүүлдэг. Иймд БНХАУ-ын үйлдвэрлэл, худалдааг дэмжих бодлогоос суралцахыг зөвлөж байна.

- БНХАУ чөлөөт худалдааг дэмжин 16 хэлэлцээр байгуулж, 8 хэлэлцээр хэлэлцээний түвшинд байна. Иймд Ази, номхон далайн худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлж зөвхөн БНХАУ гэлтгүй уг хэлэлцээрийг хэлэлцэн тохиролцогч Бангладеш, Энэтхэг, Лаос, БНСУ, Шри Ланка Улсуудтай худалдаагаа нэмэгдүүлэх, тарифын хөнгөлөлт эдлэх барааны мэдээллийг худалдаа эрхлэгч нарт түгээх ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулах нь зүйтэй.
- Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахтай холбоотой ажлыг эрчимжүүлэх. Евразийн гаалийн нутаг дэвсгэрт хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх барааны үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг хэлэлцээрт нэгдэн орох хэлэлцээр хийх явцад зэрэгцүүлэн эхлүүлэх. Мөн энэхүү хэлэлцээрт тээврийн салбарын хамтын ажиллагааг оруулах.
- Монгол Улс хөрш орнуудын зах зээлд дагнасан барааны үйлдвэрлэлээр өрсөлдөх боломжтой. Мөн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, түүний дотор аялал жуулчлал, мэдээллийн технологи, боловсролын салбарыг тэргүүлэх чиглэлээ болговол Монгол Улсад нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж бүрдэн, улмаар худалдаа, эдийн засгийн хөгжилд дэмжлэг болно.

Монгол Улс хөрш орнуудтай олон чиглэлээр, түүний дотор худалдаа, эдийн засаг, тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой хамтран ажиллах олон төрлийн баримт бичиг байгуулжээ. Гэхдээ яг ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй, зөвхөн жил бүр, эсвэл түүнээс ч ойр хугацаанд уулзалт зохион байгуулж ярилцдаг байдал ихэнх байгуулсан баримт бичгийн хэрэгжилттэй танилцахад харагдлаа. Товчхондоо төр нэгдсэн бодлогоор гадаад худалдаанд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай.

ДХБ-аас худалдааг чөлөөтэй болгох чиглэлээр олон ажлыг хэрэгжүүлсэн боловч худалдаанд тавих төрийн хяналтын байгууллагын хүнд суртал, давхардсан хяналт худалдааны эргэлтэд саад учруулж байгаа талаар ярьсаар ирсэн. Энэ ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор хэрэгжүүлсэн ажил нь биеллээ олж ДХБ-ын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр” 2017 оноос хэрэгжиж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар хэлэлцээр хөрш орнуудын хувьд бүрэн хэрэгжсэн ба Монгол Улсын хэрэгжилт 56,3 хувьтай байна. Иймд арга хэмжээ тус бүрээр хөрш орнуудтай хамтран ажиллах ажлыг стратегийн түншлэлийн хүрээнд байгуулсан баримт бичигт оруулах нь зүйтэй.

Хөрш орнуудаас суралцан гадаад худалдааны бодлогыг үндэсний хэмжээний хөтөлбөр, аж үйлдвэр, технологи, тээвэр, хөрөнгө оруулалтын салбартай уялдуулан тэргүүлэх чиглэлээ тодорхойлох. Эдгээрийг хэрэгжүүлэхэд ихээхэн цаг хугацаа шаардагдах тул эхний ээлжинд худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг нэвтрүүлэн, институци хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, цахим технологи, түүний дотор хиймэл оюун ухаан, интернэт, цахим

сургалт, их өгөгдөлийн (big data) мэдээлэл боловсруулах технологийг хөгжүүлэх нь зүйтэй байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

6.1. Бүгд Найрамдах Солонгос улсын гадаад худалдааны үндсэн хүчин зүйлс

Хураангуй: Бүгд Найрамдах Солонгос улсын (БНСУ) эдийн засаг, нийгэм, улс төр, гадаад худалдааны бүтэц, экспорт, импорт, хөрөнгийн хуримтлал, боловсон хүчний бодлого, технологийн дэвшил, байгал орчин, газар зүйн байршил, нийгмийн сэтгэл зүй зэрэг хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн талаарх тойм судалгааг бичсэн. БНСУ-ын гадаад худалдааны бодлогын өөрчлөлтүүдийг үечлэн хувааж үзэхийн сацуу чөлөөт худалдааны хэлэлцээр хийх болсон шалтгаан, арга барил түүний үр нөлөөг харуулахыг зорив. БНСУ-ын гадаад худалдааны бодлогын улс төр, эрх зүйн зохицуулалт, дэмжиж буй зарим бодлого, техникийн саад тотгор, ургамал амьтны хорио цээрийн талаарх товч дурдах болно.

Түлхүүр үгс: БНСУ, гадаад худалдаа, бодлого, зохицуулалт, олон улсын худалдааны бараа нийлүүлэх сүлжээ, экспорт, импорт, худалдааг хөнгөвчлөх, гадаад худалдааны бодлого, чөлөөт худалдаа гэх мэт.

Дэлхийн түүхэн хөгжлийн замналаас харахад хүн төрөлхтөн олон зууныг дамнан янз бүрийн хэв маягаар амьдран өнөөг хүрчээ. Хүн төрөлхтний ахуй амьдралын соёл, иргэншлийг суурин ба нүүдлийн гэж хоёр хувааж авч үздэг. Нүүдлийн соёл иргэншлийн хөгжлийн хурд нь суурин соёл иргэншлээс удаан байна. Хэдэн зуун жил өнгөрсөн боловч монголчуудын нүүдлийн соёл иргэншил нь хадгалагдан үлдсэн байна. БНСУ-ын хувьд суурин соёл иргэншилтэй, газар тариалан эрхэлдэг бөгөөд ялангуяа цагаан будаа тариалж амь зуусаар иржээ. Цаг агаарын янз бүрийн зовлон бэрхшээлийн эсрэг сөрөн зогсож, амьдрахын тулд ямар ч хүнд нөхцөл байдлыг тухайн амьдарч буй газартаа давж гарах хэрэгтэй болдог. Харин нүүдлийн соёлтой манай орны хувьд эрс тэс уур амьсгалыг эс тооцвол цаг агаарын бэрхшээлээс холдон оторлож нүүдэл хийдэг. Энэ нь монголчуудыг бэрхшээлийг давах чадварын тодорхой хэмжээгээр бууруулдаг байж болно. Мөн Солонгосын түүхэнд Солонгос улс нэг ч удаа гадагшаа дайн хийж үзээгүй байхад гаднаас 900 гаруй удаа эх орны дайн хийж, харийн түрэмгийлэгчдийн гарт орон зарим үед бүр дагаар орж байсан тохиолдол ч цөөнгүй байдаг. Солонгосын түүх судлаач эрдэмтэд “Солонгосчууд дэлхийд хамгийн их зовлон үзсэн ард түмэн” гэж тодорхойлдог. Тиймээс Солонгосын ард түмэн амьдралын хатуу хүтүүг туулах чадвартай, өлсгөлөн, харийн дарлал, мөлжлөг, ядуу зүдүү ямар ч хэцүү үед өөдрөг сэтгэлтэй байж, амьдралын хат суусан хөдөлмөрч хүмүүс хэмээдэг. Энэхүү түүхэн соёлын үндэс суур нь орчин үеийн худалдаа, эдийн засгийн загвартай сайн зохицсон

байна. Харин үүнд нөлөөлсөн зарим голлох хүчин зүйлсийг бид мэдэж байх нь чухал юм. Үүнд:

Эдийн засгийн хүчин зүйлс

1960-аад оны эхээр БНСУ нь хоцрогдсон буурай орны нэг байсан. Тэр үед Солонгосчууд ядуу тарчиг амьдралаасаа болж турж үхэж, гудамжин дахь гуйлгачдын тоо ихсэж, хувцас, хоол хүнс ховор, толгой хорогдох орон байр гэх мэт олон зүйлээр гачигдаж дутагдсан ард түмэн байв. Идэх зүйл байхгүйгээс хүмүүс өвсний үндэс түүж иддэг байсан тухай мөн бичигддэг. Галдаа хийх модгүйн улмаас хөдөө тосгодынхон түлшинд хэрэглэхийн тулд ой модыг огтлон авснаас орон даяар ургаа модгүй нүцгэрч байсан гашуун түүх ч бий.

Гэвч энэ байдлаас хурдан хугацаанд гарсныг илтгэх Дэлхийн Банкнаас гаргасан мэдээгээр, Өмнөд Солонгосыг сүүлийн 60 жилийн хугацаанд дэлхийн 197 орны дундаас хамгийн хурдан эдийн засгийн өсөлттэй бөгөөд Өмнөд Солонгосын эдийн засгийн багтаамж нь Африк тивийн нийт 42 улсын эдийн засгийн хэмжээнээс илүү буюу Зүүн Өмнөд Азийн зургаан улсын хүчин чадалтай адил улс юм гэж тодорхойлжээ.

БНСУ-ын 1 хүнд ногдох үндэсний орлого нь 70 жилийн өмнө 100 ам.доллар байсан бол 1997 оны Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн хямрал болохоос өмнө буюу 1996 онд 11385 ам.доллар болтлоо өссөн ба экспорт 100 сая ам.доллараас 80 тэрбум доллар болж 800 дахин өссөн. Мөн ДНБ 80 тэрбум ам.доллараас 520 тэрбум ам.доллар болтлоо өсжээ. Тиймээс БНСУ-ын эдийн засгийн өсөлтийг “Солонгосын эдийн засгийн гайхамшиг”, “Хан мөрний гайхамшиг” гэх мэтээр нэрлэдэг. БНСУ-ын эдийн засгийн загвар нь сүүлийн үед дэлхий нийтийн анхаарлыг татсаар байна. Ялангуяа дайны дараа дэлхийн хамгийн ядуу улсын нэг байсан бол 30 гаруйхан жилийн хугацаанд шинээр үйлдвэржиж байгаа улс орнуудыг аль хэдий нь гүйцэж хөгжингүй орны босгон дээр гарч ирсэн нь дэлхий нийтийн анхаарлыг өөрийн эрхгүй татсан юм. Одоогоор Солонгосын эдийн засгийн загварыг дэлхийн хөгжиж буй 176 улс өөрийн эдийн засгийн загвар болгон ашиглаж байна.

Дайнаас хойших 25 жилд ДНБ-ийн жилийн дундаж өсөлт 8,5 хувь, түүнд эзэлэх экспортын хувийн жин 42,5 хувьд хүрч, энэ талаараа дэлхийд 11-р байранд орж улмаар технологийн илүү өндөр хөгжилтэй дэлхийн 10 орны эгнээнд багтах боломжтой болсон. БНСУ нь цулгүй хоосноос ийм үсрэлт хийсэнгүй. Газар тариалан, аж үйлдвэрийн салбарт уг дэвшлийн хөрс суурь болсон түүхэн урьдчилсан нөхцөлүүд 1950-аад он хүртэл ямар нэг хэмжээгээр бүрдсэн байжээ.

Азийн шинээр үйлдвэржсэн орнууд 1980-1985 онд 44 тэрбум ам.долларын зээл авсны 51 хувь нь Ази, Номхон Далайн орнуудад ногдож, Японы хөрөнгө оруулалтын 51,6 хувь (1-р байр), АНУ-ын 28,6 хувь (2-р байр) нь БНСУ-д ногдож байсанаас харахад тус улс нь шинээр үйлдвэржсэн орнуудын дундаас хамгийн их гадаадын хөрөнгө оруулалтыг авсан орны нэг

болж байна. Мөн тусламжийн хэлбэрээр багагүй хөрөнгө оруулжээ. Онцлог нь гадаадын хөрөнгө оруулалтыг үндэсний эдийн засгийн өвөрмөц байдалдаа тохируулан шаардлагатай салбарт туйлын өгөөжтэй ашиглаж чадав.

Мөн Азийн шинээр үйлдвэржсэн орнуудын хувьд нэлээд ирээдүйтэй байгаа цахилгаан хэрэгсэлээр эхний, Швейцарын эрдэм шинжилгээний байгууллагын аргачлалаар гаргасан өрсөлдөх чадвараар Франц, Итали, Испани, Португали, Малайзаас дээгүүр, мөн Азийн шинээр үйлдвэржсэн орнуудаас Хонконг, Сингапур, Тайваны дараа, хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөр (1970-1986) Азийн шинээр үйлдвэржсэн орнууд дотор тэргүүн байранд байна. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт ийм өндөр түвшинд хүрэхэд хамгийн сүүлийн үеийн техник, технологи ашигласан, үйлдвэрлэлийн автоматжуулалт өндөр түвшинд хүрсэн, нарийн мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, үйлдвэрлэлийн хөтлөн удирдах оновчтой аргуудыг ашигласан нь нөлөөлжээ. 1980-аад онд шинжлэх ухаан техникийн ололтыг үр өгөөжтэй ашиглах суурь бааз нь хангах, боловсруулах үйлдвэрлэлээс экспортын үйлдвэрлэл давамгайлах чиглэл рүү шилжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Хөгжиж буй орнуудтай шинээр үйлдвэржсэн орнууд, түүний дотор БНСУ-ын хамтын ажиллагаа өргөжиж байна. Гадаад худалдааг голлосон хамтын ажиллагааны уламжлалт хэлбэрээ худалдаа үйлдвэрийн эздийн хөрөнгийг оруулах, техник, технологи нийлүүлэх, эдийн засаг, санхүүгийн туслалцаа үзүүлэх, шинжлэх ухаан техникийн болон хөгжиж буй орнуудын гадаад худалдааны бараа гүйлгээний эргэлт 1970-1985 онд 13 дахин өсөж нийтдээ 92,3 тэрбум долларт хүрчээ. Шинээр үйлдвэржсэн орнуудын гадаад худалдаанд хөгжиж буй орнуудын эзлэх хувь 20-25 болж байна. Усан цахилгаан станц, зочид буудал, иргэний болон албаны барилга, автомашин, төмөр зам зэрэг барилга байгууламжийн томоохон төсөл хэрэгжүүлэх талаар

БНСУ, Бразил хоёр улс шинээр үйлдвэржсэн орнуудыг тэргүүлж байна. 1980 аад оны дундуур БНСУ-ын засгийн газар экспорт, импорт банкны дэргэд хөгжиж буй орнуудад ядуу буурай улс орнуудад санхүү эдийн засгийн тусламж үзүүлэх тусгай сан байгуулсаны үр дүнд энэ үзүүлэлтээр Тайваний дараа орох болсон. 1987-1988 онд нийт 150 сая долларын тусламжийг хөгжиж буй орнуудад зээлийн шугамаар үзүүлсний ихэнхийг АСЕАН-ы орнуудад зориулсан байна. Үүнээс гадна тус улс бүс нутгийн эдийн засгийн байгууллагуудаар дамжуулан тусламж үзүүлдэг.

Шинжлэх ухаан дээр суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар БНСУ мөн л Азийн шинээр үйлдвэржсэн орнуудыг тэргүүлж улсын болон хувийн өмчийн шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагааг аж үйлдвэрийн салбар дахь эрдэм шинжилгээний ажилд чиглүүлсэн. Томоохон хувийн компаниудын эрдэм, шинжилгээ, судалгаа ажилд гарч байгаа техник, технологийн ололт, дэвшлийг хөхүүлэн дэмжихэд засгийн газар нь идэвхтэй үүрэг гүйцэтгэж байна. Гадаадаас техник технологи худалдан авахын зэрэгцээ үндэсний техник технологийг боловсруулахад ихээхэн анхаарч байна.

Эдийн засгийн өсөлт нь хөрөнгө оруулалт, экспорт, импорт, хэрэглээ, үйлдвэрлэлийн түүхий эд зэрэг эрэлтийн хүчин зүйлс, хөдөлмөр, хөрөнгө, техникийн дэвшил зэрэг нийлүүлэлтийн хүчин зүйлс, мөн улс төр, эдийн засгийн бүтцийн, байгаль орчны зэрэг олон хүчин зүйлсийн харилцан хамаарлын үндсэн дээр явагдаж байна.

Эдийн засгийн бүтцийн хүчин зүйл

БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн суурь нь хувийн өмчийг хамгаалж байгууллагын эрх чөлөө ба өрсөлдөх чадварыг чухалчилсан зах зээлийн эдийн засгийн загварыг сонгож, үүндээ тохирсон хууль эрх зүйн орчин сайн бүрдүүлж өгсөн. Үндсэн хуулиараа хувийн өмчтэй компани, байгууллага түүний үйл ажиллагааны эрх чөлөөг хамгаалаад зогсохгүй монополийн эсрэг хууль, шударга худалдааны хууль, газрын тухай хууль, орон нутгийг удирдах хууль, хөдөлмөрийн хууль, аж үйлдвэрийн хөгжлийг хурдасгах хууль гэх мэт эрх зүйн хэм хэмжээгээр дамжуулан засгийн газар нь эдийн засгийн өсөлтийн суурийг сайн тавихыг хичээж байжээ. Мөн түүнчлэн эдийн засгийн төлөвлөгөөний хүрээлэн, гадаад худалдааны байгууллага, шинжлэх ухаан, техник технологийн хүрээлэн, үндэсний хөгжлийн хүрээлэн гэх мэт байгууллагуудыг байгуулж тэдгээр нь эдийн засгийн өсөлтийг хангахад шаардлагатай олон чухал судалгаа, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Засгийн газраас эдийн засгийн үйл ажиллагаанд харьцангуй их оролцож байсан боловч тэр оролцоо нь зах зээлийн эдийн засгийн бүтцэд маш сайн нөлөө үзүүлэв.

Улс төрийн хүчин зүйлс

БНСУ-ын эдийн засгийн бодлого нь голдуу төрийн зохицуулалтаар хэрэгжсэн байдаг ба Солонгосын эдийн засгийн өсөлтийг “Төрийн зохицуулалтын хэлбэртэй” гэж нэрлэдэг. Солонгосын засгийн газрын бодлого нь эдийн засгийн өсөлтөд яаж нөлөөлснийг дараах хэдэн зүйлд хувааж авч үзье.

1. Хурдан өсөлтийн бодлогыг баримталж үйлдвэр, гадаад худалдааны бодлогыг аль болох эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд чиглэж байв. Эдгээр бодлогуудыг боловсруулж хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн компани, байгууллагууд нь засгийн газартайгаа хамтарч ажилласан. Мөн эдийн засгийн өсөлтөд хамгийн их амжилт авч ирсэн 5 жилийн төлөвлөгөөг 7 удаа хэрэгжүүлсэн. Хурдан өсөлтийн бодлого нь 1960-1970 аад онд Өмнөд Солонгосыг ядуу байдлаас нь гаргаж улмаар Умард Солонгосыг гүйцэж түрүүлэхэд нь ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Энэ төлөвлөгөөнүүд дундаас зарим зүйлийг сонгон авч үзье.

- Юуны өмнө дотоод гадаадаас нефть, нүүрс, цахилгаан зэрэг эрчим хүчний нөөцийг ихээр хуримтлуулсан.
- Хүн амын ихэнх нь хөдөө байдаг учраас хөдөө аж ахуйн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн.
- Дэд бүтцээ сайжруулах үүднээс усан онгоцны боомтууд, засмал зам, гүүр, төмөр зам зэргийг байгуулсан. Ялангуяа манай улсаас ялгаатай

нэг тал нь цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэх үүднээс хоёр урсгалтай төмөр замыг тавьсан байна.

- Улсын үндсэн суурь үйлдвэрүүдийг байгуулж эхэлсэн. Үүнд цементийн үйлдвэр, химийн үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг хүнд үйлдвэрүүд багтана.
- Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, хөдөөгийн ажилгүй залуучуудыг хот суурин газар уруу явуулж ажиллах хүчийг бүрэн дүүрэн ашигласан.
- Экспортыг нэмэгдүүлэхийн тулд олон төрлийн судалгааны хүрээлэнг байгуулж технологийг сайжруулсан.
- Хоол хүнсний бараа, бүтээгдэхүүнийг импортоор авалгүй өөрсдөө үйлдвэрлэж улсынхаа дотоод хэрэгцээг бүрэн хангах зорилго тавьсан.
- Автомашины болон төмөрлөгийн үйлдвэр байгуулсан ба одоо төмөрлөг боловсруулах үйлдвэрлэлээрээ дэлхийд эхний байранд явж байна.
- Хүн амын төрөлтийг багасгах бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- Иргэдийн амьдралыг зөвхөн цагаан будаанаас хамаарахгүй байлгахын тулд олон төрлийн хүнсний ногоо тариулж нэр төрлийг нь олшруулсан.
- Ард түмний боловсролыг сайжруулан хүний нөөцийг бүх талаар хөгжүүлсэн.
- Том гол мөрнүүд дээрээ үерээс хамгаалах далан байгуулж усан цахилгаан станцуудыг барьсан.
- Өөрийн улсын өрсөлдөх чадвартай бараануудыг ихээр үйлдвэрлэж, дэмжиж байсан.

Солонгосын эдийн засгийн төлөвлөгөөнөөс харахад улсынхаа аюулгүй байдал, тусгаар тогтнолыг бэхжүүлэх, бусдын хараат бус байх, улмаар олон улсад нөлөөгөө ихэсгэх улс төр эдийн засгийн чухал бодлого баримталж байжээ.

2. Солонгосын эдийн засгийн ихэнх бодлого төлөвлөгөө нь хэрэгжилт үр дүн сайтай байсан нь улсынхаа хөгжлийн төлөө Солонгосын удирдагчид бүх оюун ухаан, сэтгэл санаа, амь амьдралаа зориулсантай холбоотой. Америкийн нэрт судлаач эрдэмтэн Ирма Аделман, Морис нар “Хөгжиж буй орны эдийн засгийн өсөлт ба нийгмийн байдал” номдоо буурай хөгжилтэй орны эдийн засгийг доош нь татаж байгаа зүйлийн нэг гол шалтгаан нь “Улсынхаа төлөө амиа зориулсан удирдагч байхгүй байгаатай холбоотой” гэжээ. Харвардын их сургуулийн багш Эдвард Мейсон “Солонгосын удирдагчид улсынхаа төлөө амиа зориулж чаддаг учраас ингэж сайн хөгжсөн” гэжээ. Энэтхэг улс нь нийгмийн олон салбарт дэлхийн төвшинд хүрсэн мэргэжилтэн ихтэй, эдийн засгийн бодлого, төлөвлөгөө нь дэлхийн төвшинд хүрсэн сайн боловч ахиц

байдаггүйн учир нь удирдагчид нь улс орныхоо төлөө амиа зориулж, үнэнч ажиллаж чаддаггүй. үнэндээ ихэнх буурай хөгжилтэй орнуудын хөгждөггүйн учир нь энэ юм гэжээ.

3. Засгийн газар ба байгууллагын хамтын ажиллагаа. Америкийн засгийн газар ба компаниуд нь хоорондоо хамтарч аж үйлдвэрийн бодлого явуулдаггүй. Харин Солонгост засгийн газар ба кампаниуд нь хамт нэг онгоцонд суусан хувь заяа нэгтэй нэг бие гэж үзэж, харилцан зөвшилцөл дээр үйлдвэрлэлийн бодлого боловсруулан эдийн засгаа босгон байгуулахын төлөө хичээж байна. Ийм учраас Солонгосын эдийн засгийг “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэж нэрлэдэг ба Солонгосын эдийн засаг гэдэг хөлөг онгоцонд сэлүүрчид нь компаниуд биш харин засгийн газар юм гэж гадаадын судлаачид үздэг.

4. Эдийн засгийн хөгжилд улс орны ажиллах хүчийг бүрэн дүүрэн ашиглахын тулд ард түмний сонирхлыг төрүүлснээр улсын хүчийг эдийн засгийн өсөлтөд төвлөрүүлж чадсан. Солонгос эдийн засгийн төлөвлөгөөгөөрөө дамжуулан ард түмний хөрөнгийг нэг дор хуримтлуулж. эв нэгдлийг хангаж чадсан нь том ололт болж чадсан.

Экспортын хүчин зүйл

Юуны өмнө Солонгос улс нь байгалийн баялаггүй учраас ард түмний амьдрал болон аж үйлдвэрт хэрэгтэй байгалийн баялгийг гадаадаас импортоор авах хэрэгтэй болсон ба үүнд хэрэгтэй гадаад валютыг экспортоор дамжуулж авах учраас экспортыг хүчтэй өргөжүүлэх бодлого баримталж эхэлсэн. Экспортыг хөгжүүлэхийн тулд компаниудад засгийн газраас дэмжлэг үзүүлсэн ба эдгээр компаниуд нь бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд гаргахын тулд хөгжингүй орнуудаас илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай болсон. “Гүн нь ялгаатай хоёр өөр цөөрмийн хоорондох бөглөөг авбал усны төвшин адил болно” гэдэг нь тэдний экспортын талаарх баримталсан философи юм.

Хөрөнгийн хуримтлал

Хөрөнгө оруулалт хийхгүй бол шинэ техник технологи орж ирэхгүй нь мэдээж бөгөөд техник технологи шинэчлэгдэхгүй бол тухайн улс өрсөлдөх чадвараа алдана. Америкийн нийт хүн амын 5 хувь нь ХАА эрхэлдэг бөгөөд тэд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсын нийт хэрэгцээг хангаад зогсохгүй бусад олон орон руу экспортлож байна. Энэ нь ХАА-н салбар руу их хөрөнгө оруулалт оруулсантай холбоотой юм. Хөрөнгийн хуримтлалыг бий болгохын тулд Япон улс өөрийн улсын хадгаламжаа ашигласан байхад улсын хадгаламж байгаагүй Солонгосын хувьд гадаад капиталаас хуримтлалаа бүрдүүлэхээс өөр аргагүй байсан. Харин буурай хөгжилтэй улс орнуудад гадаадын хөрөнгө оруулалт сөрөг нөлөө үзүүлдэг. Гэвч Солонгосчууд энэ хөрөнгийг зөвөөр өөрийн орны хөгжилд нийцүүлж ашиглаж чаджээ. Мөн гадаадын хөрөнгө оруулалтад ард түмний дургүйцэл харьцангуй бага, засгийн газраас ч үүнийг

сайн дэмжсэн учир гадаадын хөрөнгө оруулагчид богино хугацаанд ихээр татагдан капиталын хуримтлал бий болоход үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Боловсон хүчний бодлого

Солонгосын өндөр боловсролын систем нь сайн удирдагч, менежер, үйлдвэрлэгч ажилтнуудыг төрүүлж эдийн засгийнх нь өсөлтийг хурдасгасан. 1970-аад он бол Солонгосын эдийн засгийн өсөлтийн чухал үе юм. Энэ үед хөгжингүй орнуудад боловсрол эзэмшсэн үндэсний мэргэжилтнүүд их бэлтгэгдсэн байсан учраас хөгжингүй орнуудын техник технологийг улсдаа шууд нэвтрүүлж байжээ. Өнөөдөр ч Солонгосчууд боловсролын үнэ цэнийг мэдэрч олон мэргэжилтнүүдийг гадаад дотоодод ихээр бэлтгэж байна. Солонгосын оюутнууд нь мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд цаг их зарцуулдаг гэж Геннисийн номд орсон нь боловсролын талаарх сэтгэлгээ ямар байгааг илтгэж байна.

Технологийн дэвшил

Япон, Герман зэрэг хөгжингүй орнуудад техник технологи хөгжихийн хэрээр эдийн засгийн өсөлт нь тэр хэмжээгээр явагдаж байгааг тэд гярхай ажиглаж чадсан байна. Америкийн олон улсын зах зээл дээрх өрсөлдөх чадвар нь Японд аль хэдийн гүйцэгдсэн учир нь техник технологийн дэвшил, үйлдвэрлэлийн өсөлт бага байгаатай холбоотой. Жишээ нь: Нэг өнгөт телевизорыг үйлдвэрлэхэд Америкт 4 цаг зарцуулдаг бол Японд 1,8 цаг зарцуулж байна. Солонгосчууд эхний ээлжид хөгжингүй орнуудын техник технологийг шууд хуулбарлаж, дараа нь өөрийнх нь бараа бүтээгдэхүүн олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай болмогц техник технологио өөрсдөө сайжруулан боловсруулж үйлдвэрлэл явуулж ирсэн байна.

Орчны хүчин зүйлс

Солонгосын ард түмэн эрт дээр үеэсээ Хятадын соён гэгээрүүлэгч Кунзын сургаалыг баримталсаар иржээ. Энэхүү сургаалд хүмүүсийн боловсрол мэдлэгийг түрүүнд тавьж боловсролтой болохыг хүн бүрд уриалж байсан. Мөн ихэс дээдэс, аав ээж, ах дүү, багш шавийн гэх мэт босоо хэлбэрийн харилцааг хатуу мөрдөж байснаараа ард түмэн нь захирах захирагдах ёсыг сайн баримталдаг болсон бөгөөд удирдагч нартайгаа нэг санаагаар хамтарч ажиллахад, хүчээ нэгтгэхэд нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

Газар зүйн байршил

Газар зүйн байршлын хувьд дэлхийн хамгийн том хүчирхэг гүрнүүд болох АНУ, Японтой хөршийн харилцаатай оршиж байсан нь тэдэнтэй олон талт харилцаа байгуулж харилцан ашигтай ажиллах бололцоог бүрдүүлсэн. Түүнчлэн Зөвлөлт, Хятад, Умард Солонгос зэрэг социалист орнуудтай хил залгаа оршдог нь тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө ард түмнүүд нь нэг сэтгэлтэй нэгдмэл байх нөхцөл болсон.

Нийгмийн сэтгэл зүй

Улс орны худалдааг богино хугацаанд хөгжүүлэхэд нөлөөлсөн өөр нэг чухал хүчин зүйл бол нийгмийн сэтгэл зүйн бэлтгэл зайлшгүй мөн болох нь

БНСУ-ын хөгжлийн замналаас харагдаж байна. Ийм сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн улс төр, үзэл суртал, эдийн засгийн бодлогыг эх оронч, үндэсний уламжлал, бахархалтай зөв хослуулан тууштай явуулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа хуваарилалтын оновчтой арга барилыг бүрдүүлэхэд онцгой анхаарал тавьж ирэв. “Ажилсаг зөгий” буюу “ажлын чөтгөр” гэж дэлхийд нэрлэгддэг японы ажилчид 1985 онд (30 үйлдвэрийн газрын судалгаагаар) сард 21,8 өдөр ажиллахдаа 175,8 цаг (илүү ажилласан цаг 14,8) ажилласан бол БНСУ-ын 10 үйлдвэрийн газар гаргасан судалгаагаар солонгос ажилчид сард 24,8 өдөр ажиллахдаа 225,5 цаг (илүү ажилласан 3,8) ажиллажээ.

Дээр дурдсан аргуудыг уян хатан байдлаар хэрэгжүүлсний үр дүнд боловсруулах үйлдвэр, аж ахуйн тэргүүлэх салбар болж экспортын 91,9 хувийг эзлэхэд хүргэсэн.

Жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэл, хөрөнгийг төвлөрүүлснээр үндэсний томоохон хөрөнгөлөг нэгдлүүд үүсэж хөгжсөн юм. 1961 онд 140 гаруй томоохон үйлдвэрүүд байсан бол 1984 онд тэдгээрийн тоо 1128-д хүрч тус бүр нь 1000-аад ажилчинтай болжээ. Эдгээр үндэсний хөрөнгөлөг нэгдлүүд зөвхөн дотооддоо төдийгүй дэлхийн капиталист аж ахуйд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж буй бөгөөд хөгжиж буй орнуудын ийм үүрэгтэй 600-н томоохон нэгдлийн 1/3 орчим нь Азийн шинээр үйлдвэржсэн орнуудад байгаа ба түүний 100 гаруй нь БНСУ-ын аж ахуй нэгжүүд байна.

Томоохон нэгдлүүдийн хүрээний тэлэлт нь банкны оролцоог өргөжүүлэн санхүү, үйлдвэрийн бие даасан бүлэглэлүүд үүсгэн, тэдгээр нь 1980-аад онд улам идэвхжих хандлагатай болсныг 1955 онд 5-н банкаар эхлэл нь тавигдсан бол 1988 он гэхэд 100-д хүрч тэдгээрт 1983 онд 400, 1988 онд 820 компани, нэгдэл хамрагдсан байна.

Эдгээр бүлэглэлүүдэд дулдуйдан БНСУ-ын Засгийн газар Японы жишээгээр 13 томоохон худалдаа үйлчилгээний иж бүрэн пүүсүүд байгуулсан бөгөөд үндэсний иймэрхүү төрөлжсөн буюу иж бүрэн санхүү үйлдвэр, худалдаа үйлчилгээний нэгдэл, бүлэглэлүүд гадаадад үйлдвэрлэлийн хөрөнгө гаргах эрмэлзэл алхам, алхмаар нэмэгдэж эхэлжээ.

1989 оны эхэнд БНСУ 50 гаруй оронтой 1,2 тэрбум ам долларын хөрөнгө оруулалтыг 500-аад төсөл байгуулж, хэмжээ, газар зүйн, хүрээгээрээ Азийн шинээр үйлдвэржсэн орнууд дотор тэргүүлэх байранд явж байна. Хөрөнгө гаргалтын 32,5 хувь нь Америк тив, 12,5 хувь Латин Америк, 41 хувь нь зүүн өмнөд Ази, Номхон далайн сав нутагт, 7,4 хувь нь Ойрхи, Дундад дорнод, 4,2 хувь нь Африк тивд, 2,4 хувь нь Өрнөд Европт ноогдож буй бөгөөд энэ ажлыг “Чобэл”, “Девү”, “Самсунг”, “Хөндөй”, “Лаккиголдстар”, “Хесонг”, зэрэг худалдаа үйлдвэрийн 200 гаруй томоохон пүүс нэгдлүүд үндсэнд нь гүйцэтгэж байна. Үйлдвэрлэлийн хөрөнгийн голыг барилга байгууламжийн салбарт зориулж, эдүгээ өөрийн техник, технологи, ажиллах хүчийг ашиглан тус улсын 60 гаруй пүүс дэлхийн 30 гаруй оронд үйлдвэр, иргэний барилга байгууламж барьж буйн

сацуу мод боловсруулах, загас агнуур, тээвэр худалдааны объектуудын чиглэлээр мөн хөрөнгө гаргаж байна.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэж үзэхэд дараах гурван хүчин зүйлийг онцлон тэмдэглэмээр байна. Үүнд:

- БНСУ-ын эдийн засгийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой тэргүүний технологийг гадаадаас импортлох замаар нэвтрүүлсэн.
- Хөгжлийн Англи-Саксоны загвараас ялгагдах гол онцлог нь төрийн зохицуулалт чухал ач холбогдолтой байсан. 1960 оноос БНСУ-ын засгийн газар эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөнүүдийг боловсруулан хэрэгжүүлж ирсэн. Одоо ч тийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.
- Солонгосын ард түмэн бол их хөдөлмөрч хүмүүс. Ямар ч үед, ямар ч нөхцөлд, нэр их зүтгэлээр хичээнгүй хөдөлмөрлөх сэтгэл зүйн үндсийг сайн тавьсан. Энэ бол БНСУ-ын хөгжлийн нэг чухал хүчин зүйл юм.

6.2. БНСУ-ын худалдааны бодлого

БНСУ-ын гадаад эдийн засгийн харилцааны чухал хэлбэр бол гадаад худалдаа юм. Экспортын хэмжээгээр 1980-аад оны дундуур Азийн шинээр үйлдвэржсэн орнууд дотор Тайван, Хонконгийн дараа орж дэлхийн 20 том бараа нийлүүлэгчдэд багтаж байна.

Гадаад зах зээл дэх байр сууриа хөгжүүлэх, гадаадын хөрөнгө, Үндэстэн дамнасан корпорацын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Экспорт-үйлдвэрлэлийн бүс (ЭҮБ) байгуулахад тус улс шинээр үйлдвэржсэн бусад орноос илүү идэвхтэй оролцож тэр чанараараа экспортын нийт орлогын 20 гаруй хувийг энэ бүсээс олж байна.

Экспорт-үйлдвэрлэлийн бүс бол сүлжмэл бөс бараа, гутал, хувцас, цахилгаан бараа зэрэг өргөн хэрэглээний, түүнчлэн электрон техник, автомашин, суурь машин, аж үйлдвэрийн бусад салбарын зориулалттай бүтээгдэхүүн экспортлох дэлхийн шинэ төв болоод байна. БНСУ нь хөлөг онгоц үйлдвэрлэлтээр Японы дараа, телевиз гаргалтаар өрнөдийн орнууд дотор эхний байр эзэлж буй бөгөөд 1990 онд суудлын автомашиныг 2 сая экспортолж, одоо сансрын пуужин хөөргөөд байгаа билээ.

БНСУ нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт 1968 оны 07 сарын 02 өдөр элссэн байна.⁹⁶ Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан 2015 оны тайланд 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын дараагаар БНСУ-ын экспорт давамгайлсан эдийн засаг маш хурдан хугацаанд сэргэсэн нь гадаад худалдаагаа эрчимжүүлж, түүнийг дэмжих макро эдийн засгийн болон санхүүгийн олон талын бодлого хэрэгжүүлсний үр дүн байсан гэж дүгнэжээ. Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагын (OECD) орнуудын

⁹⁶ <http://www.wcoomd.org>

дотроос эдийн засгаа сэргээх хамгийн их дүнтэй уян хатан мөнгөний бодлого, сангийн бодлого хэрэгжүүлсэн нь БНСУ байсан.

БНСУ-ын засгийн газар Олон улсын худалдаатай холбоотой хууль дүрмийг өөрчлөх нэмэлт оруулахыг тэр бүр хүсдэггүй байсан ч АНУ, болон олон улсын байгууллагуудын шахалтын улмаас 1957 оны хуулийг хүчингүй болгож “Худалдааны үйл ажиллагааны тухай хууль”-ийг 1967 онд батлан 1986, 1996 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.⁹⁷

Харин “Гадаад худалдааны тухай хууль” нь 1986 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийгдсэн байна. Худалдаа гэдэгт экспорт, импортын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болон биет бус буюу цахим бараа бүтээгдэхүүнийг хамруулж ойлгоно гэжээ. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх гол байгууллага нь Аж үйлдвэр, худалдаа, ашигт малтмал, эрчим хүчний яам юм. БНСУ нь өөрийн гэсэн байгалийн баялаг хомс тул Худалдааны салбарыг ашигт малтмал, эрчим хүчний салбартай холбож хөгжүүлэх нь үр дүнтэй гэж үзсэнтэй холбоотой болов уу.

БНСУ-ын Гадаад худалдааны тухай хуулийн 2 дугаар бүлэгт жил бүр ирэх жил худалдааны салбарт хэрэгжүүлэх бодлогыг баталдаг нь хөрвөх чадвар сайтай, тухайн цаг үедээ зохицсон үйл ажиллагаа явуулахад үр дүнгээ өгдөг ажээ. Гадаад худалдаа эрхэлсэн яам нь гадаад худалдаа эрхлэгчдээс мэдээлэл шаарддаг бөгөөд энэхүү мэдээллийн үндсэн дээр шаардлагатай тохиолдолд зөвлөгөө өгөх, мөнгө болон эд материалын тусламж үзүүлдэг. Мөн энэхүү хуулийн нэг сонирхол татаж буй заалт нь худалдаа эрхлэгч өөрийн барааг өөрийн дураар үнэлэхийг хориглосон заалт юм.⁹⁸ Үүний цаана хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах гэсэн чухал бодлого явагдаж байна.

БНСУ нь 1967 онд ТХЕХ-д нэгдэж Кеннедигийн хэлэлцээрт оролцсон нь худалдааны бодлогын чиглэлд нэлээд өөрчлөлт оруулсан бөгөөд худалдаа, эдийн засгийн нээлттэй бодлого баримталсан нь олон улсын өрсөлдөөнд оролцох, дотоодын зах зээлийг өргөжүүлэхэд хүргэжээ. Энэ нь өнөөгийн БНСУ-ын хөгжлийн үндэс болсон гэж үздэг байна.

Мөн эдийн засаг нь том эсвэл байгалийн баялаг арвин улсуудтай Чөлөөт худалдааны гэрээ байгуулж гадаад худалдааг эрчимжүүлсэн байдаг. 2008 онд дэлхийд 12-т эрэмбэлэгдэж байсан улс өнөөдрийн байдлаар 7 дахь том экспортлогч улс болсон нь эдийн засгийн экспорт ямар хурдан хугацаанд сэргэж хөгжсөнийг харуулж байна.⁹⁹

БНСУ дахь худалдааны бодлогын үечлэл

Улс орноо ийнхүү богино хугацаанд үйлдвэржүүлсэн явц нь шинээр үйлдвэржсэн бусад орны нэгэн адил дараах 3 үе шатыг дамжсан юм. Үүнд:

⁹⁷ Paul Krugman, Maurice Obstfeld, *International Economics: Theory and Policy*, 2006

⁹⁸ БНСУ-ын туршлага, Судалгааны эмхэтгэл, УИХ-ын тамгын газар, 2018 он, 116 дугаар тал.

⁹⁹ Дэлхийн худалдааны байгууллагын тайлан. БНСУ-ын гадаад худалдааны бодлого. 2015 он.

Эхний шатанд, импортын бүтээгдэхүүнийг орлох аль болох дотооддоо үйлдвэрлэх бодлого явуулж хэрэгжүүлсэн. Эл зорилгоор 1962-1966 оны анхдугаар 5 жилийн төлөвлөгөөнд аж ахуйн ийм салбаруудыг түлхүү хөгжүүлэх, үүнтэй уялдуулан үйлдвэрлэлийн дэд бүтцээ өөрчлөх, ажиллах хүчийг нэмэгдүүлэх, эрдэс түүхий эд их хэмжээгээр гаргахыг хязгаарлах, үндэсний болон гадаад хөрөнгө оруулалтын үндсэн хэсгийн энэ салбарт зориулах зэрэгт гол анхаарлаа төвлөрүүлсэн. Эдгээр асуудлыг шийдвэрлэсний дүнд гаднаас оруулдаг бүтээгдэхүүнийг орлох өөртөө үйлдвэрлэх явдал аажим аажмаар нэмэгдэн, улмаар зонхилох шинжтэй болжээ. Үүний дараагаар үндэсний томоохон компаниуд экспортын чиглэлээр хөнгөн үйлдвэрүүд хөгжүүлж ирсэн.

Хоёр дахь шатанд, экспортын хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн суурь салбаруудыг хөгжүүлэхэд анхаарал тавив. 1967-1970 оны 2 дугаар таван жилийн төлөвлөгөөнөөс эхэлж, 1970-аад оны сүүлч хүртэл үргэлжилсэн энэ үеийн үндсэн зорилт нь эхний шатанд олсон ололт амжилтаа бататгангаа экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн төмөрлөг, хими, машины үйлдвэрлэлийг өсгөн нэмэгдүүлэх явдал байв. Эдгээр гол зорилтуудыг хэрэгжүүлснээр эдийн засагт экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг голлон хөгжүүлсэн бөгөөд импортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дагалдуулан хөгжүүлж чадсан юм.

Гуравдах шатанд, оюуны багтаамж бүхий үйлдвэрлэлийн салбарыг 1980-аад оноос илүү хурдацтай хөгжүүлж эхэлсэн. Хамгийн товчоор тоймлон үзэхэд энэ бүх шатны явцад үндэстэн дамнасан корпорациуд болон гадаадын хөрөнгийг их хэмжээгэр оруулж хөдөлмөр, хөрөнгө төвлөрүүлсэн аж ахуйн салбаруудынхаа дэд бүтцийг өөрчилж, хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг тогтвортой ханган, шинэ техник технологийг өргөн нэвтрүүлсэн зэрэг эдийн засгийн гол гол арга хэлбэрийг ашигласан юм.

БНСУ-ын гадаад худалдаанд гарсан томоохон өөрчлөлтүүдийг дараах байдлаар хувааж болно. Үүнд:

- 1953-1961 оны хооронд импортыг орлох бодлого баримтлан хүнсний болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг ханган, тэдгээрийн орц болох гурил, сахар, даавуу зэргийг ихээр нийлүүлсэн байна. Эдгээрийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь өндөр тариф, импортын зөвшөөрөл, гадаад валютын олон талт систем, бага хүүтэй санхүүгийн зах зээлийн бодлогууд байжээ. Энэ үед ДНБ-ийн 2 хувийг экспорт эзэлж, экспортын барааны 90 гаруй хувь нь анхдагч бүтээгдэхүүн байсан. Энэ үед үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнийг дотоодын зах зээл шингээж чадахгүй болсон төдийгүй валютын хэрэгцээ өссөн зэрэг сөрөг үр дагаврууд гарч эхэлсэн.
- 1962-1972 оны хооронд Экспортыг дэмжих бодлого болгон өөрчилж Экспортын аж үйлдвэрийн комплекс, Экспортын чөлөөт бүсүүд байгуулсан ба үр дүнд нь эдийн засгийн бүтцэд онцгой өөрчлөлт гарсан. Өөрөөр хэлбэл ХАА бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс Аж

үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болсон байна. Мөн үүнд санхүүгийн салбарын шинэчлэл (Хөрөнгийн зах зээлийг өргөжүүлэх, зээлийн хүү бууруулах, үйлдвэрлэлийн бүтцийг химийн хүнд үйлдвэрээс мэдээллийн технологи, харилцаа холбоо, программ хангамжийн үйлдвэрт зоригтой шилжүүлж чадсан), бодлого, оновчтой арга замууд ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн байдаг.

- 1973-1979 оны Хүнд болон химийн үйлдвэрийн хөгжлийг дэмжих бодлого баримталж ирсэн төдийгүй эдийн засгийг илүү аюулгүй болгох, хөгжлийн шинэ шатанд гарч, олон улсын хэмжээний өрсөлдөхүйц орон болох зорилтын хүрээнд хийгдсэн байна.

Голлох үйлдвэрүүдээс дурдвал: ган, машин механизм, петрохимийн бүтээгдэхүүн, усан онгоц үйлдвэрлэл, цахилгаан бараа зэрэг багтдаг. Харин үйлдвэрлэлийн хүчин чадлын хэтрэлт, инфляцын өсөлт, нөөцийн хомсдол, авлигал, хээл хахууль нэмэгдэж, гадаад зах зээлээс зээл авахад засгийн газар нь баталгаа гаргаж байсан тул улсын өр их хэмжээгээр нэмэгдсэн.

1980-1994 оны Импортын либералчлал болон аж үйлдвэрийн салбарын тэнцвэржүүлэх бодлогын хүрээнд өөрийн орны зах зээлийг нээн бараа үйлчилгээ, гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн салбарууд дээр хэрэгжүүлж эхэлсэн. Энэ үеэс хоёр талт болон олон талт Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг хийж эхэлсэн байна.

Тэнцвэржүүлэх бодлогын хүрээнд даавуу, ган, автомашин, хөлөг онгоц, хүнд цахилгаан тоног төхөөрөмж болон бордооны үйлдвэрүүдийн гадаад болон дотоодын нэмэлт хөрөнгө оруулалтуудыг хязгаарлаж эхэлжээ. Үр дүнд нь 1980 онд 17,5 тэрбум ам.доллар байсан экспортын хэмжээ 2009 онд 363,5 тэрбум ам.доллар болон даруй 21 дахин нэмэгджээ.

1995 оноос өнөөг хүртэл илүү нээлттэй худалдаа руу чиглэсэн бодлого баримтлах болж хамгийн анх удаа буюу 2004 онд Чили улстай Чөлөөт худалдааны гэрээ байгуулав. БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээрийг чухам яагаад хийх болов гэсэн асуултад дараах хариултыг өгч болох юм.

6.3. БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээр хийх болсон шалтгаан

БНСУ нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ) ба ДХБ-аар төлөөлүүлэх Олон талт худалдааны системийн хамгийн том орон бөгөөд эдийн засгийн хөгжил нь гадаад худалдаагаар дамжин өсөж байдаг онцлогтой. Мөн гадаад худалдаа голлодог улсын хувьд тогтвортой эдийн засгийн хөгжлийн төлөөх арилжааны өсөлт зайлшгүй хэрэгтэй юм. Сүүлийн үеийн дэлхийн гадаад худалдааны орчныг харвал Чөлөөт худалдааны хэлэлцээрийг тойрсон Регионализм¹⁰⁰ хүчтэй дэлгэрч байна. Регионализмийн нөлөө нь ТХЕХ-ээс илүүтэйгээр ДХБ-ын системд гүнзгий нөлөө үзүүлэх боллоо. Улс бүрийн Чөлөөт

¹⁰⁰ Бүс нутгийн үзэлд үндэслэх бодлого. Бүс нутгийн үзэлд үндэслэх бодлого нь дэлхийн зах зээлийг бүс нутгаар удирдах арга юм.

худалдааны хэлэлцээр байгуулах өрсөлдөөн нь одоогийн хэрэгжиж буй Дохагийн¹⁰¹ хөгжлийн хөтөлбөрөөр зөвшилцөлд хүрч, олон улсад хоёр улсын хоорондох хэлэлцээрт суурилсан үзэл баримтлал илүү тодорч байна.

Энэхүү нөхцөл байдалд БНСУ нь идэвхтэйгээр Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах шалтгааныг хоёр хэсэгт хувааж үзэж болно. Юуны түрүүнд 1992 онд Европын холбоо байгуулагдсан, 1994 онд Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр бүс нутгийн хөгжлийн үзэл (регионализм) хүчээ авч чөлөөт худалдааны хэлэлцээрийн сүлжээ дэлхий даяар тархсан. Ялангуяа БНСУ-ын гадаад эдийн засгийн хэмжээ нь ДНБ-ий 80 хувийг эзэлдгийг тооцож үзвэл одоогийн экспортын зах зээлийг хадгалж үлдэх, шинэ зах зээлд нэвтрэхэд Чөлөөт худалдааны хэлэлцээр нь стратегийн ач холбогдолтой аж.

Худалдааны том гүрнүүд Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулаад эхэлбэл Солонгосын бүтээгдэхүүн үнийн өрсөлдөөнд ялагдаж зах зээлээ алдахаас өөр аргагүйд хүрнэ. Тиймээс Солонгосын бүтээгдэхүүнийг экспортын өрсөлдөөнийг хадгалах, аюулгүй гадаад зах зээлийг тэлэхийг төлөө худалдааны том гүрнүүдтэй Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах нь зайлшгүй юм.

Хоёрт нь бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлт өндөртэй төлбөрийн чадвартай зах зээлийг илрүүлэх, чөлөөт худалдаагаар дамжуулан улс орны бүх салбаруудыг тэнцвэртэй хөгжүүлэх, эдийн засгийн тэлэлтийг нэмэгдүүлэхэд Чөлөөт Худалдааны Хэлэлцээр хэрэгтэй аж. Солонгосын эдийн засгийг зөвхөн тоо хувьд бус чанарын хувьд өсгөхийн тулд гадаад худалдааны бодлогод Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийг идэвхтэй ашиглах шаардлагатай гэж үзсэн. Аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар ба улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого нь Чөлөөт Худалдааны Хэлэлцээр ба үүнийг дагасан гадаад худалдааны либералчлах нь чухал гэж үзэж Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийн хүрээг өргөтгөсөөр байна.

БНСУ-ын засгийн газар нь 2003 оноос хойш Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийг идэвхтэй байгуулж ирсэн. Ялангуяа том зах зээлтэй, байгалийн баялаг ихтэй, стратегийн байрлал сайтай орнуудтай Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулахад анхаарч ирсэн. Үүгээр дамжуулан компаниудын дэлхийн зах зээлд гарахад дэмжээд зогсохгүй Зүүн Азийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээр -ийн Хааб¹⁰² улс болох зорилт тавьжээ.

Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах үр дүнг өсгөхийн тулд бүтээгдэхүүний гаалийн тарифыг чөлөөлөхийн зэрэгцээ үйлчилгээ, хөрөнгө оруулалт, засгийн газрын худалдан авалт, оюуны өмч, технологийн стандарт зэргийг багтаасан иж бүрэн Чөлөөт Худалдааны Хэлэлцээр хийж байна.

¹⁰¹ Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын сайд нарын 2001 оны 11 дүгээр сарын 9-11-ний өдрүүдэд Катарын Дохад болсон бага хурлаас худалдааны олон талт Доха үе шатны хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн.

¹⁰² Олон улсын худалдааны сүлжээний нэгдсэн төв.

Хүснэгт 30. БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээр хийсэн улсууд

Улс	Он	Чиглэл
Чили	2004	Өмнөд Америкийн зах зээлд гарахад бэлэн бүтээгдэхүүний экспорт, зөрүүлээд түүхий эдийн импорт
Сингапур	2005	АСЕАН-ы зах зээл гарахад бэлэн бүтээгдэхүүний экспорт, зөрүүлээд түүхий эдийн импорт
Европын ЧХХ	2006	Европын зах зээлд гарах гүүр бэлэн бүтээгдэхүүний экспорт, зөрүүлээд өндөр технологи, түүхий эдийн импорт
АСЕАН	2007	Азийн хамгийн том эдийн засаг руу бэлэн бүтээгдэхүүний экспорт
Энэтхэг	2010	BRICs, Том зах зээл рүү бэлэн бүтээгдэхүүний экспорт
Европын холбоо, 28 улс	2011	Дэлхийн хамгийн том эдийн засгийн блок бэлэн бүтээгдэхүүний экспорт, зөрүүлээд өндөр технологийн импорт
Перу	2011	Байгалийн баялаг ихтэй
АНУ	2012	Том бөгөөд хөгжингүй эдийн засаг
Турк	2013	Төв азийн зах зээлд нэвтрэх
Канад	2015	Хойд Америкийн хөгжингүй улс
Хятад	2015	Хамгийн том худалдааны түнш
Шинэ Зелланд	2015	Далайн орнуудын гол зах зээл
Вьетнам	2015	3 дахь том хөрөнгө оруулсан улс
Колумба	2016	Төв Америкийн зах зээлд гарах гүүр

Эх сурвалж: <http://www.fta.go.kr/main/situation/kfta/psum/>

Хүснэгт 30-аас харахад БНСУ нь нийтдээ 15 ЧХХ байгуулсан бөгөөд үүнд 52 улс хамрагдаж байна. Европын ЧХХ (4 улс): Швейцар, Норвеги, Исланд, Лихтенштейн. АСЕАН (10 улс): Бруней, Камбожи, Индонез, Лаос, Малайз, Мьянмар, Филлипин, Сингапур, Вьетнам, Тайланд. Бүс нутгийн иж бүлэн эдийн засгийн түншлэл (Regional Comprehensive Economic Partnership): БНСУ, АСЕАН, Хятад, Япон, Энэтхэг, Австрали, Шинэ Зелланд зэрэг улсууд багтаж байна.

2004 оны 6 дугаар сард Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах дүрмийг баталсан. Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийг дэмжих ажлыг ил тод болгож, мэргэжилтэн ба мэргэжлийн байгууллагын чадварыг өсгөсөөр байна. БНСУ-ын засгийн газар нь холбогдох мэргэжилтнүүдийн саналыг сонсож, үүнийг нь хэлэлцээрт ашиглаж байна.

Ерөнхийдөө өөрийн орны зах зээлд гадаад зах зээлийг нэвтрэх үүд хаалгыг нээж, бүс нутгийн болон олон улсын эдийн засаг, худалдааны

интеграцид нэгдэх эхлэлүүд тавигдан нээлттэй болж эхэлсэн. Энэ бодлогын үр дүнд экспорт улам бүр нэмэгдэж дэлхийн зэх зээлд тэргүүлэгч салбаруудтай том улс болсон боловч нийлүүлэлтийн илүүдэл, санхүүгийн салбарын гажуудал, төр, хувийн хэвшлийн хуйвалдаан хүчээ авч, нийгэмд үндсэрхэг үзэл гаарч, гадаадын бүтэгдэхүүний дотоодын зах зээл дээрх өрсөлдөөн үгүй болсон зэрэг сөрөг үр дагаврууд ч гарч байлаа. Дээрх бодлогын өөрчлөлтийн үр дүнд БНСУ-ын гадаад худалдаа ихээхэн өргөжиж, даяарчлагдаж буй дэлхий ертөнцөд өөрийн гэсэн байр суурийг олжээ.

6.4. БНСУ-ын гадаад худалдааны төлөв


Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, нефть болон бусад ашигт малтмалын үнэ унасан нь ихэнх түүхий эдээ гадаадаас импортоор авдаг БНСУ-ын худалдааны тэнцэл нь ашигтай ч юм шиг эсвэл алдагдалтай ч юм шиг харагдаж байдаг онцлогтой. Тухайлбал, БНСУ-ын усан онгоц үйлдвэрлэлийн салбар дахь гол захиалагчид болох Саудын Араб, АНЭУ зэрэг томоохон захиалагчид гэрээгээ цуцалсаныг дагаад усан онгоцны үйлдвэрлэлийн уналтыг дагаад бүх салбар уналтад орсон. Энэ байдлыг 2014 оноос ярьж эхэлсэн бөгөөд “БНСУ-ын эдийн засагт харанхуй шөнө айсуй” тухай багагүй бичиж байсан. Мөн автомашины дэлхийн зах зээлийн эрэлт багассантай холбоотой энэ салбар дахь үйл ажиллагаа доголдоход хүрээд байна. Маш олон үйлдвэрүүд хаалгаа барьж орон даяар газар, үйлдвэр, оффисын байруудыг түрээслэх тухай хаяг, рекламууд харах боллоо. Эдгээрийг дагасан олон мянган иргэд ажилгүй болж нийгэм дахь бухимдал, тодорхойгүй байдал газар авлаа. Гэвч өнөөгийн байдлаар эдгээр асуудлын шийдвэрлэх оновчтой бодлого, санал, санаачлага хараахан гараагүй байна.

БНСУ-ын ДНБ 1630 тэрбум ам.доллар, нэг хүнд ногдох ДНБ 31431 ам.доллар, ДНБ-д гадаад худалдаа 40,8 хувийг эзлэж байна. 2019 оны байдлаар БНСУ нь 542 тэрбум ам.долларын экспортоор дэлхийд 7-д, 503 тэрбум ам.долларын импортоор 9-д жагсаж, дэлхийн нийт экспортын 2,87 хувь, нийт импортын 2,62 хувийг эзэлж байна.

Тус улсын барааны нийт экспортын 2,2 хувийг ХАА, 87,5 хувийг аж үйлдвэр, 10,1 хувийг уул уурхай, 0,2 хувийг бусад бүтээгдэхүүн эзэлж байгаа бол нийт импортын 7,2 хувийг ХАА, 58,5 хувийг аж үйлдвэр, 34 хувийг уул уурхай, 0,3 хувийг бусад бүтээгдэхүүн эзэлж байна. Мөн газар зүйн байршлын хувьд нийт экспортын 25,1 хувийг Хятад, 13,6 хувийг АНУ, 8,9 хувийг Вьетнам, 8,7 хувийг ЕХ, 5,9 хувийг Хонг Конг, бусад 37,8 хувь, нийт импортын 21,3 хувийг Хятад, 12,3 хувийг АНУ, 10,3 хувийг ЕХ, 9,5 хувийг Япон, 4,3 хувийг Саудын Араб, 42,3 хувь нь бусад улсад ноогддог.

Тус улсын ХАА-н экспортын бүтээгдэхүүнд хүнс, тамхи, гоймон, ундаа, далайн ургамал гол үүрэг гүйцэтгэдэг бол импортын бүтээгдэхүүнд эрдэнэ шиш, мах, боловсруулсан хүнс, гурил гол үүрэг гүйцэтгэж байна. ХАА-н бус экспортын бүтээгдэхүүнд цахилгаан бараа, тээврийн хэрэгсэл, шатах тослох

материал гол үүрэг гүйцэтгэдэг бол импортын бүтээгдэхүүнд шатах тослох материал, цахилгаан бараа, байгалийн хий зэрэг бүтээгдэхүүнүүд гүйцэтгэж байна. БНСУ-ийн худалдааны үзүүлэлтийг зураг 29-өөс харна уу.



Эх сурвалж: <http://stat.kita.net/>

Зураг 29-өөс харахад БНСУ-ын гадаад худалдаа нь 2007 оны Дэлхийн эдийн засгийн хямралын дараа 13,2 тэрбум ам.долларын алдагдалтай байсан бол 2017 оны байдлаар 95 орчим тэрбум ам.долларын ашигтай гарсан нь 2008 оноос хойш тус улсын гадаад худалдааны бодлого амжилттай хэрэгжсэний үр дүн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл БНСУ-ын үйлдвэрлэл сэргэн, өрсөлдөх чадвар олон улсын тавцан дээр нэмэгдэж байгаа юм. Ийнхүү тус улсын эдийн засаг, аж үйлдвэрийн өсөлт, амжилт нь экспортыг дэмжих төрийн үр дүнтэй бодлоготой салшгүй холбоотой юм.

2019 оны байдлаар БНСУ-ын ДНБ нь 1,4 их наяд ам.доллартой тэнцэж байсан бол бараа бүтээгдэхүүний импорт нь 36,9 хувь буюу 406 тэрбум ам.долларт хүрчээ. Өөрөөр хэлбэл улсын нийт хэрэглээний 63,1 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 36,9 хувийг гадаадаас худалдан авдаг гэсэн үг. Нөгөө талаар нийт үйлдвэрлэлийн 43,8 хувь буюу 495 тэрбум ам.долларын бүтээгдэхүүн үйлчилгээг экспортод гаргадаг.¹⁰³ Нийт үйлдвэрлэлийн бүтцийг хүснэгт 31-ээс харна уу.

Хүснэгт 31. БНСУ-ын Үйлдвэрлэлийн бүтэц


Он	1 шат	2 шат	3 шат
2019	2,3	38,1	59,6

¹⁰³http://kosis.kr/eng/statisticsList/statisticsList_01List.jsp?vwcd=MT_ETITLE&parmTabId=M_01_01#SubCont

2020	2,3	38	59,7
------	-----	----	------

Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв- <http://kosis.kr/>

Хүснэгт 31-ээс харахад 1 дүгээр шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуй, газар тариалан, загас агнуур, 2 дугаар шатны үйлдвэрлэлд уул уурхай, аж үйлдвэр, барилга, эрчим хүч, газ, 3 дугаар шатны үйлдвэрлэлд 1, 2 шатнаас бусад бүх салбар багтах бөгөөд ихэвчлэн үйлчилгээний салбар багтдаг. Тухайн улсын худалдааны хамгийн гол хэмжүүр нь экспорт, импортын үзүүлэлтүүд юм. БНСУ-ын албан ёсны статистикийн мэдээллийн байгууллагаас авсан тоо баримтыг зураг 30-аас харна уу.



Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв- <http://kosis.kr/>

Зураг 30-аас харахад БНСУ-ын нийт импорт 406 орчим тэрбум ам.доллар байгаа нь манай улсаас даруй 123 дахин их үзүүлэлт юм. Хамгийн ихийг буюу 21 хувь нь Хятадаас импортлогдож байна.

Зураг 31. 2019 оны БНСУ-ын импорт (мянган ам.доллар)


Зураг 31. 2019 оны БНСУ-ын импорт, мянган ам доллар



Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв-<http://kosis.kr/>

Зураг 31–ээс харахад нийт импортын 81 тэрбум ам.доллар буюу 20 хувийг 27 дугаар бүлгийн бүтээгдэхүүн болох эрдэс түлш, нефть, 75 тэрбум ам.доллар буюу 18 хувийг 85 дугаар бүлгийн бүтээгдэхүүн болох цахилгаан машин, тэдгээрийн эд анги, 11 хувийг 84 дүгээр бүлгийн бүтээгдэхүүн болох машин механизм, тоног төхөөрөмж эзэлж байна.

Зураг 32. 2019 оны БНСУ-ын экспорт, мянган ам доллар



Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв- <http://kosis.kr/>

Зураг 32–оос харахад Монгол Улсын бүтээгдэхүүн, үйлчилгээний импортын дүн 258 сая ам.доллартай тэнцэж БНСУ-ын нийт бараа, үйлчилгээний экспортод 0,04 хувийг эзэлж байна. БНСУ нь 124 тэрбум ам.доллартай тэнцэх бүтээгдэхүүн, үйлчилгээг БНХАУ-д экспортод гаргадаг бөгөөд 36 хувь нь цахилгаан бараа, 13 хувь нь мэргэжлийн багаж хэрэгсэл, 11 хувь нь цөмийн реактор, бойлер болон бусад тоног төхөөрөмж ордог. Харин БНСУ-ын экспортын бүтцийг бүтээгдэхүүний бүлгээр зураг 33-аас харна уу.




Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв- <http://kosis.kr>

Зураг 33–аас харахад нийт экспортын 58,7 хувь буюу 134 тэрбум ам.долларыг машин механизм, 19 хувь буюу 96 тэрбум ам.долларыг электрон бараа, 12,6 хувь буюу 62 тэрбум ам.долларыг зам тээврийн хэрэгсэл эзэлж байна. Ихэвчлэн 84, 86, 83 дугаар бүлгийн нарийн технологи, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг экспортолж байгааг харж болно.

БНСУ-ын үйлчилгээний худалдаа

БНСУ-ын үйлчилгээний худалдаа 2019 онд нийт 202 тэрбум ам.доллар байгаа нь өмнөх онуудаас буурсан үзүүлэлт юм. Үйлчилгээний импортын жилийн дүн 2019 онд 113 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 115 тэрбум ам.дол. болж өссөн нь 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараах анхны сэргэлт байв. Үйлчилгээний нийт экспорт импорттой харьцуулахад буурсан үзүүлэлттэй бөгөөд 2019 онд 112,1 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 97,8 тэрбум ам.доллар болж буурсан байна. Энэхүү бууралт нь 5,7 тэрбум ам.доллараар буурсан тээврийн үйлчилгээтэй холбогдох бууралт бөгөөд үр дүнд нь 3,6 тэрбум ам.доллар байсан үйлчилгээний худалдааны алдагдал 2019

онд 15,7 тэрбум болж өссөн байна. Тээврийн үйлчилгээний худалдааны тэнцэл мөн хугацаанд буюу нэг жилийн хугацаанд 6,1-3,0 тэрбум ам.доллар болж буурсан. Далайн тээврийн үйлчилгээ, үүнд далайн болон бусад тээвэр, ачаа тээвэр импортын томоохон хувийг эзэлж байгаа нь барааны худалдаанд Солонгос улс ихээхэн оролцоотой болохыг илтгэнэ. Гэсэн ч тээврийн үйлчилгээний салбарын өсөлт бүхий бусад дэд салбаруудын хурдыг гүйцэхгүй байна. Тухайлбал, техникийн болон худалдааг дэмжих зэрэг бизнесийн үйлчилгээний нийлүүлэлт сүүлийн 10 жилд 2 дахин өссөн байна. Үйлдвэрлэлийн орцтой холбогдох үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголт, судалгаа шинжилгээний зардлууд улам хурдацтай өссөн байна. БНХАУ болон Вьетнам зэрэг Зүүн Азийн орнуудтай үйлдвэрлэлийн хуваарилалтыг улам бүр өргөн хийх болсон тул үйлчилгээний худалдаанд гарсан бүтцийн дээрх өөрчлөлтийн санаандгүй өөрчлөлт гэж үзэхгүй. Бизнес хоорондын худалдаа идэвхэжсэн нь бизнесийн үйлчилгээ, технологийн худалдаа эрчимжихэд мөн нөлөөлсөн. БНСУ-ын үйлчилгээний импортыг зураг 34-өөс харна уу.



Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв- <http://kosis.kr/>

Зураг 34-өөс харахад БНСУ-ын үйлчилгээний импорт нийт 110 тэрбум ам.доллар байгаагаас 109 тэрбум ам.доллар нь арилжааны үйлчилгээ багтдаг. Ер нь БНСУ-ын хувьд үйлчилгээний худалдааны тэнцэл нь ихэвчлэн алдагдалтай гардаг. Гэвч энэхүү үйлчилгээ нь эргээд экспортын дэмжигч хүч болж нягт уялдаатай ажиллаж байдаг тул тус улс үйлчилгээний худалдааны алдагдал хүлээхдээ төдийлөн санаа зовдоггүй.

Зураг 35. 2019 оны БНСУ-ын үйлчилгээний экспорт, үйлчилгээний төрлөөр, (мянган ам доллар)



Эх сурвалж: БНСУ-ын статистик мэдээллийн төв- <http://kosis.kr/>

Зураг 35–аас харахад тус улсын үйлчилгээ экспорт 92 тэрбум ам.доллар байгаагаас 91 тэрбум нь арилжааны үйлчилгээ багтдаг. Үйлчилгээний худалдааны тэнцэл 10 орчим тэрбум ам.долларын алдагдалтайг тооцвол Монгол Улсаас БНСУ-д энэ талын үйлчилгээг үзүүлэх боломжийн судалгааг цаашид үргэлжлүүлэх нь сонирхолтой санагдаж байна. Үйлчилгээний экспортод арилжааны үйлчилгээний дараа орох чухал хэсэг бол тээвэр юм. Үүнд далайн тээвэр, үүнд дотроо ачаа тээвэр, иргэний агаарын тээвэр голлох үүргийг гүйцэтгэдэг.

Аялал жуулчлал болон бизнесийн бусад үйлчилгээний худалдааны тэнцэл сайжирсан бол үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээ болон оюуны өмчтэй холбогдох зардлууд буурах хандлагатай байна. Худалдааны тэнцлийн хамгийн өндөр ашгийг тээвэр болон барилга угсралтын үйлчилгээ бүрдүүлсэн байна. Үйлдвэрлэлийг дэмжих болон аялал жуулчлал зэрэг бизнесийн бусад үйлчилгээ нь бизнесийн үйлчилгээний худалдааны алдагдалд хамгийн их үүргийг гүйцэтгэсэн байна. 2019 оны байдлаар Солонгос улсын гадаад худалдааны тэнцэл 15 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан.

6.5. БНСУ-ын худалдааны зохицуулалт

БНСУ нь ядуу буурай байдлаас богино хугацаанд үсрэнгүй хөгжиж, орчин үеийн техник технологи, эдийн засгийн өндөр хүчин чадалтай орны тоонд багтаж чадсан. Эдийн засаг, технологийн өндөр хөгжлийн үндсэн шалтгаан нь төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих төрийн оновчтой зөв бодлого, мөн төрөөс хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж өгсөн явдал юм.

БНСУ нь чөлөөт эдийн засаг бүхий ардчилсан орон боловч зах зээлийн эдийн засагт төрийн оролцоо харьцангуй өндөр, мөн төр хувийн хэвшил нь харилцан үр ашигтай хамтран ажилладаг гэдгээрээ зах зээлийн эдийн засаг бүхий Америк болон барууны орнуудаас ялгаатай. Ерөнхийлөгч Пак Жон Хигийн үед буюу 1960 онд засгийн газраас эдийн засгийг хөгжүүлэх анхдугаар 5 жилийн төлөвлөгөөг гарган мөрдөж эхэлсэн байдаг. Тухайн үед БНСУ нь ардчилсан орон бус цэргийн диктатур ноёрхож байсан тул асуудлыг ганц төрийн тэргүүн дангаар шийдэж байсан гэхэд хилсдэхгүй. Давуу тал нь асуудлыг шийдэхэд цаг алдахгүйгээс гадна газар, санхүүжилтийг саадгүй олгоход төрөөс онцгой анхаарч байв¹⁰⁴. Засгийн газрын зүгээс хувийн хэвшлийнхэнтэй харилцан тохиролцох, санал зөвлөлдөх, тодорхой нөхцөл дээр хамтран ажилладаг. Жишээ нь 1998 оны Азийн эдийн засгийн хямралын үед хямралыг гэтлэн давахын тулд БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жун Самсунг, Хюндэй, Элжи, Эс Кей зэрэг эдийн засгийн гол ачааг үүрдэг томоохон бүлэглэлүүдийн удирдлагыг хүлээн авч уулзахдаа тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааг эрс шинэчлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр холбогдох хууль гаргах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэхийн сацуу бүтцийн өөрчлөлт хийхтэй холбогдсон хэдэн зүйл тохиролцоонд хүрсэн. Тэдгээр корпорацууд ч Ерөнхийлөгчтэй тохиролцсоны дагуу санхүүгийн тайлан мэдээгээ гаргаж нийтэд зарлах, салбар доторх компаниуд хоорондоо зээлийн баталгаа гаргах явдлыг зогсоох, өрийг багасгаж шаардлагагүй салбаруудыг татан буулгаж бүтцээ сайжруулах, жижиг дунд үйлдвэрүүдтэй харилцаагаа идэвхжүүлэх зэргээр тохиролцоогоо биелүүлж эдийн засгийн хямралыг амжилттай давж байсан¹⁰⁵.

БНСУ-ын засгийн газар нь дотоодын үйлдвэрүүдийг түүхий эд материалын тогтвортой, аюулгүй эх үүсвэрээр хангах, дотоодын нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний экспортыг дэмжих, үндэсний үйлдвэрүүдийг гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх үүднээс гадаад худалдааны бодлогыг тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан өндөр ач холбогдол өгч жил бүр шинэчлэн гаргадаг. Худалдааны бодлогыг БНСУ-ын Гадаад худалдааны хууль болон бусад хуулийн хүрээнд Үйлдвэр, худалдааны нөөцийн

¹⁰⁴ ГХЯ-ны төв архив ХД-112, НД-184, Хуудас 200.

¹⁰⁵ ГХЯ-ны төв архив ХД-112, НД-34, Хуудас 64.

яам хариуцаж гаргадаг. Худалдааны бодлого гаргахад, мөн уг бодлогыг хэрэгжүүлэхэд БНСУ-ын засгийн газар болон худалдаа эдийн засгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд нь хувийн хэвшлийнхэнтэйгээ нягт уялдаа холбоотой хамтран ажилладаг. Засгийн газраас худалдааны бодлого гаргахдаа дотоодын болон хилийн чанад дахь үндэсний аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас чухал хэрэгтэй мэдээллүүдийг шаардан авах, зөвлөгөө авах, мэдээлэл солилцох эрхийг, мөн хамтран ажиллах хэлбэрүүдийг хуульчилж өгсөн байдаг нь оновчтой бодлого гаргахад үр дүнгээ өгдөг.

БНСУ-ын Гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтууд¹⁰⁶

БНСУ-ын “Гадаад худалдааны хууль”-аас гадаад худалдааны бодлого тодорхойлох зарчим, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлбэр, мөн экспорт импортын хориг хязгаарлалт, үндэсний үйлдвэрээ хамгаалах, экспортын үйлдвэрлэлийг дэмжих, барааны экспортод дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зарим зүйл заалтууд, мөн 2020 оны худалдааг дэмжих бодлогын тухай товч мэдээлэл орчуулан орууллаа. Мөн БНСУ-ын гадаад худалдаа, эдийн засгийн холбогдолтой хууль, төрийн бодлогыг гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд шууд оролцдог, хэрэгжүүлдэг зарим байгууллагуудын зорилго, гүйцэтгэх үүрэг, бүтэц зохион байгуулалтын тухай товч мэдээллүүдийг орууллаа.

Бодлого боловсруулалт

1. Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн сайд (ҮХНС) нь худалдааг үр ашигтай явуулахын тулд жил бүр худалдааг дэмжих бодлого гаргах ёстой.
2. БНСУ-ын гадаад худалдааны хуульд зааснаар худалдааг дэмжих бодлого нь дараах чиг үүрэгтэй байх ёстой.
 - Худалдааг дэмжих бодлогын үндсэн чиглэлийг гаргах
 - Олон улсын худалдааны нөхцөлийн судалгаа, чиг хандлагыг тогтоох
 - Худалдааны зөвшилцлийг дэмжих мөн корпорацын гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлийг гаргах
 - Худалдааг дэмжих үүднээс корпорацуудад зөвлөх, чиглүүлэх, гадаадад сурталчлах, үзэсгэлэн явуулах, ярилцлага хийх, мэргэжилтний дэмжлэг өгөх зэргээр гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх чиглэлийг боловсруулах
 - Худалдаатай холбоотой мэдээлэл цуглуулах, боловсруулах болон ашиглах арга замыг тогтоох
 - Түүхий эд материалын хангалттай нөөц бүрдүүлэх үүднээс дотоод болон гадаад хамтын ажиллагааг дэмжих чиглэл гаргах
 - Мөн бусад Ерөнхийлөгчийн тогтоосон зүйлүүд.

¹⁰⁶ БНСУ-ын эрх зүйн мэдээллийн төв-<https://www.law.go.kr/>

3. ҮХНС нь хуульд заасны дагуу худалдааг дэмжих бодлого гаргахын тулд шаардлагатай материал цуглуулах үүднээс худалдааны түнш орны худалдааны бүтэц-уламжлал, онцлог зэрэг корпорац гадаад зах зээлд гарахад тулгардаг бэрхшээлүүдийг судална.
4. ҮХНС нь гадаад зах зээлд нэвтрэн үйл ажиллагаа явуулж буй корпорацаас хуульд заасан худалдааг дэмжих бодлого гаргахад шаардлагатай мэдээлэл, материалыг шаардан авах, шаардлага гарвал хамтран ажиллах эрхтэй.
5. ҮХНС нь хуульд заасан худалдааг дэмжих бодлогыг гаргахдаа нийслэлийн захирагч, бусад хот, мужийн засаг дарга нарын саналыг сонсох ёстой бөгөөд худалдааг дэмжих бодлогоо гаргасны дараа, мөн засвар оруулбал тэдгээр дарга нарт мэдэгдэх ёстой.
6. Хуульд заасны дагуу худалдааг дэмжих бодлогыг мэдэгдсэний дараа хот аймгийн дарга нар өөрийн харьяаллын бүс нутгийн онцлогт тохирсон худалдааг дэмжих бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ёстой.
7. Хот аймгийн захирагч нар нь хуульд заасан орон нутгийн онцлогт тохируулсан худалдааг дэмжих бодлогыг боловсруулаад түүнийгээ ҮХНС-д мэдэгдэх ёстой.

Иргэд байгууллагатай хамтран ажиллах

1. Худалдааны чиглэлийн улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд нь хамтрагч орны засгийн газар, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагатай худалдаа, үйлдвэрлэл, технологи, эрчим хүч зэрэг салбаруудад хамтран ажиллаж байгаа үед ҮХНС нь Ерөнхийлөгчийн тогтоосны дагуу шаардлагатай тусламж үзүүлж хамтран ажиллаж болно.
2. ҮХНС нь корпорацын гадаад зах зээлд нэвтрэхийг дэмжих үүднээс худалдааны үйл ажиллагаа хийдэг улсын болон хувийг хэвшлийн байгууллагаас мэдээллийг шат дараалалтай цуглуулж боловсруулалт хийн байгууллага, корпорацуудад өгч болно.
3. ҮХНС нь хуульд заасан мэдээлэл цуглуулахын тулд шаардлагатай гэж үзвэл холбоотой орон нутгийн удирдах байгууллагын дарга, хот аймгийн дарга, гадаад худалдаа эрхэлдэг корпорац, байгууллагуудаас тоон баримт мэдээллийг шаардан авах эрхтэй.
4. ҮХНС нь корпорацын гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжих ярилцлага, зөвлөгөө, сурталчилгаа, судалгаа зэрэг ажлуудыг нэгдсэн байдлаар зохион байгуулахын тулд “Солонгосын худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг”-ын “Гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх төв”-д хариуцуулан хийлгэнэ.
5. Хуульд заасан “Гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх төв”-ийн бүтэц, үйл ажиллагаа хяналт зохион байгуулалт зэргийг Ерөнхийлөгч тогтооно.

Экспорт импортын хориг

1. Үйлдвэрлэл худалдааны нөөцийн сайд (ҮХНС) нь дараах 6 зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай гэж үзвэл түүхий эд, материалын экспорт болон импортыг хязгаарлах буюу хориглох эрхтэй.
 - Үндсэн хуулийн дагуу батлагдсан тодорхой журам болон онцгой зорилгын дагуу батлагдсан олон улсын хууль тогтоомжийн дагуу
 - Эрдэс түүхий эдийн нөөцийг хамгаалах зорилгын үүднээс
 - Худалдааны түншийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор
 - Улсын аюулгүй байдлын үүднээс түүхий эдийн эрэлт нийлүүлэлтийг хэвийн хангах зорилгоор
 - Шинжлэх ухаан технологийн хөгжлийн зорилгоор
 - Бусад худалдаа-үйлдвэрлэлийн бодлогод шаардлагатай Ерөнхийлөгчийн тогтоосон журам зааврын дагуу
2. Экспорт болон импорт нь хязгаарлагдсан бараа бүтээгдэхүүнийг экспортлох болон импортлохоор болбол Ерөнхийлөгчийн тогтоосон журмын дагуу ҮХНС-ын зөвшөөрлийг авах ёстой. Зөвхөн Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр тодорхой нэр заасан зүйлсийг онцгой шаардлагын үүднээс хялбар нөхцөлөөр экспортлох юм уу импортолж болно.
3. Экспорт импортын зөвшөөрөлд заасны дагуу экспортын зөвшөөрөл авснаар хүчинтэй хугацаа нь 1 жил байна. Зөвхөн дараах нөхцөлд буюу ҮХНС дотоодын барааны үнийн тогтвортой байдал, эрэлт нийлүүлэлтийн байдал, бараа хүлээлгэн өгөх нөхцөл зэрэг худалдааны онцлогийг харгалзан Ерөнхийлөгчийн тогтоосны дагуу хүчинтэй хугацааг өөрөөр тогтоож болно.
4. Экспорт импортын зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь Ерөнхийлөгчийн тогтоосны дагуу 1 жилээс хэтрэхгүй бөгөөд үйлдвэрлэл худалдааны сайдын зөвшөөрлөөр сунгаж болно.
5. Зөвшөөрлийг авсан этгээд зөвшөөрөгдсөн зүйлсийн дунд Ерөнхийлөгчийн тогтоосон чухал зүйлийг өөрчлөхөөр болбол үйлдвэрлэл худалдааны сайдын зөвшөөрлийг авах ёстой бөгөөд, түүнээс бусад жижиг зүйлийг өөрчлөх бол ҮХНС-д мэдэгдэх ёстой.
6. ҮХНС нь шаардлагатай гэж үзвэл зөвшөөрөл олгох зүйлсийн нэр төрлөөрх тоо, үнэ, стандарт, мөн экспорт болон импортлох бүс нутгийг хязгаарлах эрхтэй.
7. ҮХНС нь хязгаарлалт-хориг, зөвшөөрөл, зөвшөөрлийн хугацааг тогтоох болон сунгах, мэдэгдэх, хязгаарлах зэрэг нэгдсэн журмыг тогтоосон үед түүнийг зарлан мэдэгдэх ёстой. (Хавсралт 6;7-оос харна уу)

Гадаад валютын орлого олох зорилго бүхий “экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн” түүхий эд, материалын импортыг баталгаажуулах тухай

1. ҮХНС нь экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн түүхий эд, сэлбэг, материалын импортын тухайд уг хуулийн импортын хязгаарлалтыг мөрдөхгүй байж болно. Зөвхөн дотоодын түүхий эд, материалын

хэрэглээг дэмжих зорилгоор шаардлагатай тохиолдолд хязгаарлаж болно.

2. ҮХНС нь түүхий эд, сэлбэг хэрэгслийн хэмжээ, төрөл зүйл болон тоо ширхгийг тогтоон, зарлах эрхтэй.
3. Түүхий эд, сэлбэг хэрэгслийг импортлох юм уу худалдан авсан этгээд импортын үнэд дүйцэх гадаад валютын орлого олох ёстой. Зөвхөн ҮХНС-ын зөвшөөрснөөр үүнийг мөрдөхгүй байж болно.
4. Гадаад валютын орлого олох хил хязгаар, хугацаа, валютын орлого олсныг баталгаажуулах арга зам болон бусад шаардлагатай нөхцөлийг Ерөнхийлөгч тогтооно.

Экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн түүхий эд, материалыг зорилгын бус зориулалтаар ашиглах

1. Түүхий эд, материалыг импортлосон этгээд нь тухайн түүхий эд материалаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортын бус зорилгоор ашиглах болбол Ерөнхийлөгчийн тогтоосны дагуу ҮХНС-ын зөвшөөрлийг авах ёстой.
2. Импортлосон түүхий эд, сэлбэр хэрэгсэл, мөн түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үндсэн зорилгын дагуу ашиглах юм уу экспортлох гэж буй этгээдэд хүлээлгэн өгөхдөө хүлээн авч буй тал болон хүлээлгэн өгч буй тал аль аль нь ҮХНС-ын зөвшөөрлийг авах ёстой. Зөвхөн Ерөнхийлөгчийн зөвшөөрсөн түүхий эд сэлбэр хэрэгсэл, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувьд дээрхийг мөрдөхгүй байж болно.

Экспортын гэрээний баталгаа болон зарчим

1. Засгийн газар нь үндэсний корпорацын гадаад орны засгийн газартай экспортын гэрээг саадгүй байгуулахад туслах үүднээс Ерөнхийлөгчийн тогтоосон баталгаа-даатгалын байгууллагаар дамжуулан экспортын гэрээнд баталгаа гаргуулж өгч болно.
2. Засгийн газар нь экспортын гэрээнд дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан ямар ч үед ашиг авахгүй, мөн өрийн баталгаа зэрэг эдийн засгийн хариуцлага хүлээхгүй.

Импортын хязгаарлалт

1. ҮХНС нь тодорхой барааны импортын өсөлтөөс үүдэлтэй ижил төрлийн бараа болон зах зээлд шууд өрсөлдөх бараа үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэгчид ноцтой хохирол учрах юм уу хохирол учруулах нөхцөл бүрдсэн нь “Шударга бус худалдааны хяналт болон үйлдвэрийн хохирлын тухай” хуулийн 27 дугаар зүйлд заасан “Худалдааны хороо”-ны шалгалтаар батлагдсан ноцтой хохирлыг барагдуулах нөхцөл бүрдэх, тухайн дотоодын үйлдвэрлэгчийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл тухайн барааны дотоод үйлдвэрлэгчийн ноцтой хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс, мөн үйлдвэрийг хэвийн үйл ажиллагаанд оруулахын тулд тодорхой хүрээнд бараа бүтээгдэхүүний импортыг хязгаарлах эрхтэй.

2. ҮХНС нь Худалдааны хорооны чиглэл, дотоодын үйлдвэрийг хамгаалах шаардлага, олон улсын худалдааны харилцаа болон импортын барааны хязгаарлалтын журмын дагуу нөхөн төлбөрийн хэмжээ болон ард иргэдийн эдийн засагт нөлөөлөх нөлөө зэргийг хянан үзээд импортын барааны хязгаарлалт тавих эсэхээ шийднэ.
3. Засгийн газар нь импортын барааны хязгаарлалтыг хэрэгжүүлэх болбол импортод холбоотой улс болон импортын барааны хязгаарлалтын сөрөг нөлөөтэй холбоотой худалдааны нөхөн төлбөрийн тухай зөвшилцөх эрхтэй.
4. Импортын барааны хязгаарлалт нь зарласан өдрөөс хойш импортолсон бараанд үйлчилнэ.
5. Импортын барааны хязгаарлалт нь 4 жил хүчинтэй байна.
8. ҮХНС нь импортын хязгаарлалтад орсон барааны нэр, тоо ширхэг хүчинтэй хугацааг зарлана. (Хавсралт 8-аас харна уу)

6.6. БНСУ-ын худалдааг дэмжих бодлого ¹⁰⁷

2020 оны БНСУ-ын худалдааг дэмжих бодлого нь 2019 оны худалдааг дэмжих бодлогын үр дүнд үндэслэн 2020 оны худалдааг дэмжих бодлогын үндсэн чиглэл, гол агуулга, мөн бодлогыг хүрээнд төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх ажлын танилцуулга зэрэг дараах үндсэн 5 бүлгээс бүрдсэн 400 нүүр бүхий гарын авлага бэлтгэсэн байна. Бүлэг тус бүрийн агуулга нь дараахтай адил байна.

1. Сүүлийн үеийн экспортын чиг хандлага болон дүгнэлт
2. Бодлогын үндсэн чиглэл
3. Гол гурван арга хэмжээ
4. Цаашдын төлөвлөгөө
5. Байгууллага тус бүрийн хэрэгжүүлэх ажлууд

Бодлогыг хэрэгжүүлэх засгийн газрын харьяа байгууллагууд

1. Үйлдвэрлэл худалдааны нөөцийн яам
2. Жижиг дунд үйлдвэрийн яам
3. Төлөвлөлт санхүүгийн яам
4. ШУ, мэдээллийн технологийн яам
5. Гадаад хэргийн яам
6. Соёл спорт аялал жуулчлалын яам
7. ХАА яам
8. Байгаль орчны яам
9. Далай загас агнуурын яам
10. Гаалийн газар
11. Тусгай зөвшөөрлийн газар

¹⁰⁷ БНСУ-ын худалдааны мэдээллийн төвийн веб хуудас www.tradenavi.com (Нийт 400 хуудас материалыг төрийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл болох гарын авлага гаргажээ)

Бодлогыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд

1. Солонгосын үзэсгэлэн худалдааны бизнесийг дэмжих хороо
2. Солонгосын худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг
3. Солонгосын худалдааны даатгалын агентлаг
4. Солонгосын худалдааны холбоо
5. Солонгосын худалдааны мэдээллийн технологийн компани
6. Дэлхийн солонгосчуудын худалдааны нийгэмлэг
7. Солонгосын импортын холбоо
8. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих холбоо
9. Жижиг дунд үйлдвэрийн нэгдсэн холбоо
10. Экспорт импортын банк
11. Мэдээллийн технологийн бизнесийг дэмжих холбоо, мөн нийслэл болон бусад хотын захиргаа, аймгийн захиргаанууд.

Худалдааг дэмжих бодлогын хүрээнд төрийн байгууллагуудын хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөөний жишээ болгох “Солонгосын худалдааны даатгалын агентлаг” болон шинжлэх ухаан, мэдээллийн технологийн яамны 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг орууллаа. Солонгосын худалдааны даатгалын агентлаг нь экспорт импортын худалдаа эрхэлдэг корпорацуудад дараах үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Экспортын үйлдвэрийн хөрвөх чадварыг дэмжих экспортын санхүүгийн даатгал
2. Экспортын төлбөр тасалдах эрсдэлээс хамгаалах богино хугацааны экспортын даатгал
3. Үйлдвэрийн төсөл\Plant\ болон усан онгоцны экспортод санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулсан дунд, урт хугацааны экспортын даатгал
4. Тогтвортой импортыг дэмжих импортын даатгал
5. Валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах даатгал зэрэг таван төрлийн даатгалын үйлчилгээ, тэдгээр даатгалын зориулалт, хамрагдах нөхцөл шалгуур, гол агуулга, зөвлөгөө авах арга зам, холбогдох утасны дугаар гэх зэрэг дэлгэрэнгүй тайлбар мэдээллүүдийг оруулж өгсөн байна.

Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн яам нь “Мэдээллийн технологийн бизнесийг дэмжих төв”-өөр дамжуулан тухайн чиглэлийн бизнес эрхлэгчдэд гадаад зах зээлд гарахад дараах 2 хэлбэрээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаар төлөвлөсөн байна.

1. Мэдээлэл технологи, холбооны бизнесийн гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх. Үүнд:
 - ICT/SW, контенттой холбоотой дотоодын жижиг дунд, томоохон хэмжээний үйлдвэрүүдийн гадаад зах зээлд гарахад засгийн газартай хамтран ажиллах, гадаад зах зээлийн мэдээлэл өгөх, маркетингийн дэмжлэг

үзүүлэх зэргээр засгийн газартай хувийн хэвшил хамтран гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжинэ.

- Мэдээллийн технологи холбооны салбарын гадаад зах зээлд нэвтрэхэд засгийн газартай хамтран ажиллах, дотоодын корпорацын гадаад зах зээлд шинээр нэвтрэхэд зуучлах, ICT бизнес-контент түншлэл зэргээр хувийн хэвшилд маркетингийн дэмжлэг үзүүлнэ.
- 2. Программ хангамжийн үйлдвэрлэлийн гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх
 - Программ хангамжийн чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг дэмжих: Дотоодын шилдэг SW системийн гадаад зах зээлийн борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, өмнөх амжилт олсон жишээг танилцуулна. Технологийн чадварыг сурталчлах замаар SW үйлдвэрийн дэлхийн зах зээлд гарахад тусална.
 - Жижиг дунд үйлдвэрийн SW-ийн дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх: ЖДҮ-ийн SW экспортыг дэмжих зорилгоор чанарыг сайжруулах, бүтээгдэхүүнийг нутагшуулах, суваг нээх зэргээр дэмжлэг үзүүлж дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг өргөтгөнө.

Мөн дээрх ажлуудын товч агуулга, дэмжлэгийн хэлбэр, бүртгүүлэхэд анхаарах зүйлс, бүрдүүлэх материал, бизнесийн процесс, үргэлжлэх хугацаа зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулж өгсөн байна.

Солонгосын худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг (КОТРА)¹⁰⁸

КОТРА нь дотоод, гадаадын корпорацуудын хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэлийн технологийн хамтын ажиллагааг дэмжих, гадаадаас мэргэжилтэн урьж ажиллуулах болон жижиг дунд үйлдвэрийн гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх, засгийн газар хооронд экспортын гэрээ хийхэд дэмжлэг үзүүлэх зорилготой төрийн байгууллага юм.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах ажлуудыг хийдэг

1. Худалдааг дэмжих болон гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд гадаад зах зээлийн судалгаа хийх, шинэ орон зай илрүүлэх зэргээр мэдээлэл цуглуулж түүний үр дүнг мэдээлэх
2. Дотоодын үйлдвэрлэл-бүтээгдэхүүн болон хөрөнгө оруулалтын орчныг гадаадад таниулах, үндэсний брэндийг сайжруулахад туслах
3. Худалдааны харилцаа, дотоод гадаадын корпорацуудын хооронд хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа болон технологи солилцоог дэмжих
4. Худалдаа хөрөнгө оруулалтын үзэсгэлэн яармаг зохион байгуулж оролцох болох оролцуулах
5. ҮХНС-ын тогтоосон экспорт импортыг дэмжих

¹⁰⁸ БНСУ-ын хуулийн мэдээллийн төв www.law.go.kr

6. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих болон дотоодын корпорацын гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих
7. Олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд гадаадын мэргэжилтнийг урьж ажиллуулахад дэмжих болон дотоодын мэргэжилтнийг гадаадад ажиллуулах, ажиллахад дэмжлэг үзүүлэх
8. Батлан хамгаалахын бүтээгдэхүүний экспортыг дэмжих
9. Гадаад худалдааны хуулийн 32.3.2-т заасан засгийн газар хоорондын экспортын гэрээтэй холбоотой ажил, гадаад дахь Солонгос бизнесменүүдийн сүлжээг байгуулж, удирдаж зохион байгуулах гэх мэт. (Хавсралт 9-өөс харна уу)

Солонгосын эрдэс баялгийн корпорац (KORES)¹⁰⁹

Солонгосын эрдэс баялгийн корпорац (КОРЕС) нь дотоодод болон хилийн чанадад байгалийн эрдэс баялгийн олборлолт болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих үйл ажиллагааг үр ашигтайгаар явуулж түүхий эдийн нөөцийн тогтвортой эрэлт нийлүүлэлтийг хангах зорилготой төрийн байгууллага юм. КОРЕС нь дээрх зорилгыг биелүүлэхийн тулд БНСУ дахь төв болон хилийн чанад дахь албан ёсны салбаруудаар дамжуулан дараах үйл ажиллагааг явуулдаг.

1. Байгалын ашигт малтмалын хайгуул, олборлолт хийхийн тулд судалгаа, тандалт, техникийн зөвлөгөө, үр ашгийн үнэлгээ болон ашигт малтмалын шинжилгээ;
2. Ашигт малтмал олборлолт, ашигт малтмал худалдан авалтын төлбөрийн баталгаа гаргах;
3. Ашигт малтмал нөөцлөх;
4. Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, экспорт импорт болон түрээс;
5. Уул уурхайн аюулгүй байдлын сургалт, зөвлөгөө болон тоног төхөөрөмж нийлүүлэлт;
6. Уул уурхай менежмент
7. Ашигт малтмалын хайгуул, олборлолт болон үүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг дотоод гадаадын хуулийн этгээдэд хөрөнгө оруулалт хийх;
8. 1-7-д заасан үйл ажиллагаатай холбоотой хүний нөөц, судалгаа болох туслах үйл ажиллагаа;
9. Бусад засгийн газар болон орон нутгийн удирдах байгууллагаас итгэмжлэн олгосон ажил;

КОРЕС нь дараах орнуудад албан ёсны салбар нэгжүүдтэй үйл ажиллагаа явуулж байна¹¹⁰.

¹⁰⁹ Солонгосын хуулийн мэдээллийн төв [국가법령정보센터 \(law.go.kr\)](http://law.go.kr)

¹¹⁰ КОРЕС <https://www.kores.or.kr/>.

1. БНХАУ-д Хятад болон түүний орчмын орнуудын ашигт малтмалын судалгаа, хөрөнгө оруулалт хариуцсан салбар
2. Шууд хөрөнгө оруулалттай бизнесийг удирдах, Австралийн хөрш орны шинэ бизнесийг удирдах, мөн эрдэс баялгийн судалгаа хариуцсан Австрали дахь салбар
3. Хойд Америкт бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, ашигт малтмалын мэдээлэл цуглуулах, хөрөнгө оруулалтын ирээдүйтэй бизнес илрүүлэх зорилго бүхий Канад дахь салбар
4. Өмнөд Америкийн ашигт малтмалын мэдээлэл цуглуулах, хөрөнгө оруулалтын ирээдүйтэй бизнес илрүүлэх зорилго бүхий Чили дэх салбар

БНСУ-ын худалдааны хороо¹¹¹

Худалдааны хороо нь “БНСУ-ын Шударга бус худалдааны үйл ажиллагааг шалгах, үйлдвэрлэлийн хохирлыг арилгах тухай хууль”-ийг хэрэгжүүлдэг байгууллага юм. Худалдааны хороо нь шударга бус худалдаа болон импортын өсөлтөөс шалтгаалан дотоодын үйлдвэрлэгчдэд учирсан хохирлыг судлах-барагдуулах үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэг. Мөн шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлж дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах зэрэг худалдаатай холбоотой олон улсын гэрээ хэлцлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг төлөвлөдөг. Худалдааны хороо нь шударга бус худалдааны үйл ажиллагаа, түүнээс хамгаалах ажиллагааг хариуцсан Худалдааны судалгааны төвийг удирдан ажиллуулдаг. Худалдааны судалгааны төв нь дараах хэлтсүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Худалдааг дэмжих бодлогын хэлтэс;
2. Үйлдвэрийн хохирлыг судлах хэлтэс;
3. Хязгаараас доод үнийн судалгааны хэлтэс;
4. Шударга бус худалдааны судалгааны хэлтэс.

Худалдааны хороонд шударга бус худалдааны тухай гомдол ирсний дагуу судалгааны явцад шударга бус худалдаа хийгдсэн нь тодорхой болбол хорооны зүгээс дараах түр арга хэмжээг авах эрхтэй. Үүнд:

1. Тухайн бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдаа болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоох;
2. Тухайн бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийг зогсоох;
3. Тухайн бараа бүтээгдэхүүний зар сурталчилгааг зогсоох;
4. Бусад шаардлагатай гэж үзсэн түр арга хэмжээ.

Хүсэлт гаргасан этгээд шударга бус худалдааны үр дүнд хохирсон нь тогтоогдвол гарсан хохирлыг хохироогч этгээдээр төлүүлэх, хэвийн үйл ажиллагаанд оруулах зэрэг үндсэн арга хэмжээ авдаг.

БНСУ-ын Олон улсын эдийн засгийн судалгааны хүрээлэн (KIEP)¹¹²

¹¹¹ Солонгосын хуулийн мэдээллийн төв [국가법령정보센터 \(law.go.kr\)](http://law.go.kr)

Олон улсын эдийн засгийн судалгааны хүрээлэн нь БНСУ-ын худалдаа, эдийн засаг, улс төрийн бодлого тодорхойлоход голлон оролцдог, АНУ, Хятад, Зүүн Өмнөд Азид салбартай судалгаа, эрдэм шинжилгээний томоохон байгууллага юм. КИЕР нь дараах бүтцээр ажилладаг.

Бүс нутаг судлалын газар

- Хятадын эдийн засгийн алба;
- Хөгжингүй орнуудын эдийн заагийн алба;
- Шинэ Өмнөдийн бодлогын алба (Зүүн Өмнөд Ази, Номхон далай, Энэтхэг, Африк);
- Шинэ Умардын бодлогын алба (ОХУ, ЕвроАзи);

Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны газар

- Судалгаа төлөвлөл, зохицуулалтын алба
- Олон улсын макро эдийн засаг санхүүгийн алба
- Олон улсын худалдааны алба
- Их хорийг хариуцсан туслах алба

БНСУ-ын худалдааны зохицуулалттай холбогдох зарим жишээ

“Цалингийн гүдгэр систем”-ийг нэвтрүүлснээр нас ахих тусам цалинг нь багасгаж, тэтгэвэрт гарах насыг нь устгаснаар 8000 ажлын байрыг нэмэгдүүлж чаджээ. Мөн ажилтай хүмүүсийн нийгмийн урамшууллыг нэмэгдүүлж, гэрээт ажилчдын нөхцөлийг сайжруулж, Засгийн газрын бүхий л санхүүгийн үйлчилгээнүүдийг мэдээлэл, технологид суурилуулан “нүүр нүүрээ харахгүй үйлчилгээ үзүүлдэг байх” зарчмыг баримтлах болов. Боловсролын хувьд зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд тохируулж оюутнуудын тоонд хязгаарлалт тогтоож өгсөн. Зохицуулалтын шинэчлэлийн хүрээнд “cost in cost out” системийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь нэгж бүтээгдэхүүн нэмэгдэхэд нийт зардал өөрчлөгдөхгүй байх зарчим юм.

Худалдааны хэлэлцээр хийх эрх бүхий байгууллага нь 2017 оны 7 дугаар сарын БНСУ-ын засгийн газрын зохион байгуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Эрчим хүч, худалдаа, аж үйлдвэрийн яам байгуулагджээ. Тус яам нь бусад улсуудтай худалдаа хийх, худалдааны хэлэлцээр байгуулах, гадаад хөрөнгө оруулалтыг зохицуулах, худалдааны хэлэлцээрийг хянах, зохицуулах үүргийг хүлээдэг бөгөөд худалдааны хэлэлцээрийн үргэлжлэх хугацаа нь тухайн тохиолдол бүрд өөр өөр байдаг. Харин хэлэлцээрийг шатандаа явж буй тохиолдолд ДХБ-ийн гишүүн орны хувьд ДХБ-ийн үндсэн дүрмийг хэрэгжүүлдэг.

¹¹² БНСУ-ын Олон улсын эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн албан ёсны веб хуудас-
www.kier.go.kr

БНСУ нь 2012 оны 7 дугаар сараас эхлэн худалдаан дахь үйлчилгээний хэлэлцээрт нэгдэн орж 2013 оны 7 дугаар сараас эхлэн хэлэлцээрт оролцох худалдааны хуулийн дотоод журмууд дууссан.

БНСУ-ын санхүүгийн үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, жижиглэн худалдаа дараах зохицуулалтын хүрээнд хэрэгждэг байна. Үүнд: Санхүүгийн үйлчилгээ (Банкны тухай хууль, Бизнесийн даатгалын тухай хууль, Санхүүгийн хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлийн тухай хууль, Мэргэшсэн зээл санхүүгийн үйлчилгээний тухай хууль, Санхүүгийн электрон шилжүүлгийн тухай хууль, хуулиудтай холбогдох дүрэм, журмууд багтдаг), холбогдох олон улсын дүрэм (ДХБ-ийн Үйлчилгээ дэх худалдааны ерөнхий хэлэлцээр-GATS, ЧХХ дэх санхүүгийн үйлчилгээний өөр өөр бүлэг) багтдаг.

БНСУ-д санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд: БНСУ-д хуулийн этгээд байгуулах, шаардлагатай зөвшөөрлүүдийг авсан байх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид нь БНСУ-ын албаны хүмүүсийн хяналтын дор үйл ажиллагаа явуулна. Гэхдээ GATS, FTA-ийн хүрээнд захирагдаж байдаг.

Эрх зүйн хүрээнд мэргэжлийн ур чадвар, стандартыг хангаж буй харилцан хүлээн зөвшөөрөх хууль эрх зүйн хэлэлцээр одоогоор алга байна. Гэсэн хэдий ч гадаадын хуульч нарыг солонгосын хуулийн шаардлагыг хангаагүй ч Хууль зүйн яамаар батлуулж, БНСУ-ын өмгөөлөгч нарын холбоонд бүртгүүлсэн бол хүлээн зөвшөөрдөг. Гадаадын хуульчид дараах эрхийг эдэлдэг. Үүнд: Өөрийн авсан тусгай зөвшөөрлийн дагуу хууль, зохицуулалтын зөвлөгөө өгөх, өөрийн улсын нэгдэн орсон гэрээ, олон улсын хилийн хууль эрх зүйн талаар зөвлөгөө өгөх, олон улсын арбитрын хэрэгт талуудыг төлөөлөх зэрэг болно. Хуульч нь БНСУ-д хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн сургуулийг төгссөн байх, 6 сарын турш дадлага хийсэн байх шаардлагатай.

Жижиглэн худалдааны хувьд голлох хууль нь Жижиг бизнес ба том франчайз дах шударга худалдааны тухай хууль (Act on Fair Transactions in Large Franchise and Retail Business) юм. Жижиглэн худалдааг хэрэгжүүлэх олон улсын хуульд ДХБ-ын Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр, ЧХХ багтдаг. Хотын захиргаа нь тодорхой өдрүүдэд франчайз болон жижиглэн худалдааны бизнест хязгаарлалт тогтоодгийг анхаарах ёстой.

Ерөнхий тарифын хувь хэмжээг Гаалийн тухай хуулийн хуваарьт жагсаасан байдаг. Харин гаалийн хөнгөлөлт нь Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хилийн ерөнхий тариф, хөгжиж буй орнуудын хоорондох хилийн тариф, 1975 оны Ази, номхон далайн орнуудын тариф, Хөгжиж буй орнуудын Худалдааны Хөнгөлөлтийн Глобал Системийн тариф, тарифын хэлэлцээрийн үр дүнд тухайн улстай тогтоосон тариф, ЧХХ-тэй орнуудтай тогтоосон тарифаар илэрхийлэгдэнэ.¹¹³

¹¹³ <https://uk.practicallaw.thomsonreuters.com/>

Худалдааны хамгаалалтын талаар мөн зохицуулалтад аж үйлдвэрийн хохирлын эсрэг хамгаалалт ба Олон улсын худалдааны шударга бус үйл ажиллагааг мөрдөн шалгах хууль, Гаалийн тухай хууль багтдаг. Эдгээр хууль нь ДХБ-ын Дэмпингийн эсрэг хэлэлцээр, Татаас нөхөн төлбөрийн арга хэмжээний тухай хэлэлцээртэй нийцдэг.

Олон улсын энхтайван аюулгүй байдлыг хангах үүднээс хувь хүн, аж ахуй нэгж, үйлдвэрийн газруудад тодорхой барааны хувьд худалдааны хязгаарлалт тогтоодог. Энэхүү хязгаарлалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Энхтайван аюулгүй байдлыг хангахад чиглэсэн Худалдааны тусгай арга хэмжээний талаарх баримт бичигт¹¹⁴ бичигдсэн байдаг. Стратегийн ач холбогдолтой багаа бүтээгдэхүүнийг экспортлоход олон улсын хяналтын системийн зарчмын дагуу экспортын зөвшөөрөл шаардагдаж магад. Стратегийн барааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл Солонгосын Стратегийн Худалдааны Хүрээлэнгээс эрхэлдэг Стратегийн барааны менежментийн системээс¹¹⁵ авах боломжтой.

6.7. БНСУ-ын худалдаа дахь техникийн зарим саад тотгор

Архины шошго

2016 оны 7 дугаар сарын 29-ны өдрөөс эхлэн архины төрлийн бүтээгдэхүүн дээр эрүүл мэндэд аюултай тухай бичсэн байхыг шаардаж эхэлсэн. Согтууруулах ундаа хэрэглэх нь эрүүл мэндэд ямар эрсдэлтэй болохыг харуулсан шошгыг заавал нааж өгөх шаардлага тавьсан. Согтууруулах ундаан дээр ийм шошгыг анх удаа дэлхийд тавихаар хуульчилсан улс бол Солонгос юм.

Үхрийн мах

30 сараас хэтрээгүй настай үхрийн махыг импортоор авах шаардлага тавьдаг. Харин үхрийн махны зах зээлд одоо хүртэл АНУ /жилд дунджаар 1 тэрбум ам.долларын үхрийн мах БНСУ-д экспортолдог/, Австрали зэрэг өндөр хөгжилтэй орнууд өрсөлддөг. Мөн үхрийн махны импортын эсрэг дотоодын бослого хөдөлгөөн их гардаг тул анхааран үзвэл зохистой.

Үлдцийн дээд хязгаар

Хүнсний бүтээгдэхүүнийг удаан хадгалах бодисуудын стандартыг өндөр тавих шаардлагыг БНСУ-ын талаас ДХБ-д 2014 онд тэмдэглүүлснээс үзвэл шинэ “эерэг жагсаалт”-ыг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн бөгөөд 2016 оноос халуун орны жимс, үр, самар, 2018 оноос ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 2020 оноос амьтны гаралтай бүтээгдэхүүнд тус тус төлөвлөжээ. БНСУ нь одоогоор дэлхийд шинээр нээгдсэн удаан хадгалах бодис хэрэглэж болох тухай бүртгэл үүсгээгүй байгаа нь олон улсын зүгээс шүүмжлэл дагуулсаар байна.

Засгийн газрын худалдан авалт

¹¹⁴ [www.motie.go.kr/motie/ms/nt/gosi/bbs/bbsList.do ? bbs_cd_n = 5](http://www.motie.go.kr/motie/ms/nt/gosi/bbs/bbsList.do?bbs_cd_n=5)

¹¹⁵ www.yestrade.go.kr/user/main.do?method=main.

Хэрэв бид БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хийхээр бол Засгийн газрын худалдан авалтад Монгол Улсын аж ахуй нэгжүүд нээлттэй оролцох боломжоор хангаж өгөх нь чухал байна. Ялангуяа босго хэмжээ, хилээр нэвтрүүлэх үйлчилгээний стандарт гэх мэт монгол компаниудад дарамт учрахааргүй нөхцөлийг тохирох хэрэгтэй байна.

Ургамал, амьтны хорио цээр

Худалдааг хязгаарлах ургамал, амьтны хорио цээрийн хууль, эрх зүй нь дараах үндсэн 4-н хуулиар зохицуулагддаг. Үүнд:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
2. Ургамлын хяналтын тухай хууль
3. Усны бүтээгдэхүүний өвчлөлийг хянах тухай хууль
4. Импортын хүнсний аюулгүй байдлын зохицуулах тусгай хууль.

Газар тариалан, ой, МАА, хүнсний яам, Далай, загасны аж ахуйн яамнаас импортоор оруулахыг хориглосон ургамал, амьтан болон холбогдох бараа бүтээгдэхүүний жагсаалтыг гаргасан байдаг. Энэхүү жагсаалтад маш олон бүтээгдэхүүн байх бөгөөд ерөнхий бүтцийг нь харвал анхаарал татах зүйл байна. Тухайлбал, Төмс, улаан лоолийг импортоор оруулахыг хориглосон. Гэхдээ хориглосон муж, улсыг нэрлэсэн төдийгүй ямар учраас хориглосон тухайгаа мөн тайлбарласан. Үүнийг хүснэгт 32-д үзүүлээ.

Хүснэгт 32. БНСУ-ын импортлохыг хориглосон бүтээгдэхүүнүүд

Бүтээгдэхүүний нэр	Хориглосон бүс нутаг	Шалтгаан
Төмс, Улаан лооль	Ази: Афганистан, Хятад (Хэйлунжан, Жансү, Чинхай), Энэтхэг Европ: Беларус, Герман, Польш, ОХУ, Англи Африк: Египет, Нигер Хойд Америк: АНУ (Канзас, Мерилэнд, Мичиган, Меносота, Небраска)	Төмсний төрөл бүрийн өвчин
Гурил	Иран, Турк, Сири Европ төв	Хортон ялааны тархалтын бүс
Лууван	Испани, Франц, Герман, Швед, Норвеги	Хортон шавжийн тархалтын бүс

Дүгнэлт

Дэлхийн хамгийн ядуу буурай орноос эхний 10-т багтах том эдийн засагтай орон болоход БНСУ-д ердөө 30 жил хангалттай байлаа. БНСУ-ын гадаад худалдаа нь эдийн засгийн хөгжлийн чиглүүлэгч луужингийн үүрэг гүйцэтгэж байв. Худалдааг хөгжүүлэх, гадаад валют олох, улс орны баялаг бүтээх сэдэл төрүүлэх гол хүчин зүйл нь экспорт бөгөөд харин импорт нь

экспортыг дэмжих, экспортод хэрэгтэй түүхий эдээр хангах нийлүүлэлтийн үүрэгтэй аж. Эдийн засгийн өсөлт нь экспорт, хөрөнгө оруулалт, импорт, хэрэглээ, үйлдвэрлэлийн түүхий эд гэх мэтийн эрэлтийн хүчин зүйлс, хөдөлмөр, капитал, техникийн дэвшил зэрэг нийлүүлэлтийн хүчин зүйлс, мөн олон улсын харилцаа, улс төрийн, бүтцийн, орчны зэрэг олон хүчин зүйлийн харилцан хамаарлын үндсэн дээр явагдсан. Хэрэгтэй хуулиудыг цаг алдалгүй боловсруулсны дараа хууль хэрэгжүүлэх байгууллагуудыг байгуулж, оновчтой бүтцийг боловсруулж чадсан байдаг. Түүнчлэн АНУ, Япон зэрэг улсаас гадаадын хөрөнгө оруулалтыг татаад зогсохгүй, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэрээр хангахын тулд уян хатан нөхцөлтэй зээл болон хөрөнгийн зах зээл дээрээс мөнгө босгох бололцоог олгосон. Экспортыг нэмэгдүүлэхийн тулд олон төрлийн судалгааны хүрээлэн, байнгын ажиллагаатай институт олноор байгуулан далайцтай үйл ажиллагаа хэрэгжүүлсээр иржээ.

Улс орныг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөнүүд үр өгөөжтэй байсан. Төлөвлөлт, байгууллага хоорондын уялдаа холбоо, экспортыг дэмжих бодлогын хэрэгжилтийг бүх яам, агентлаг, газар, хэлтсүүд нэгэн төлөвлөгөөний дагуу, хоорондын нягт уялдаан дор үйл ажиллагаа явуулж байгаагийн нэг жишээ гэвэл 2020 оны гадаад худалдааг дэмжих бодлого хэмээх 400 хуудас материалаас харж болохоор. Мөн муж жижиг хотуудад гадаад худалдааг өргөжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг өргөнөөр хэрэгжүүлдэг.

Хүнд аж үйлдвэрийн салбараас Орчин үеийн технологид суурилсан Мэдээлэл, харилцаа холбооны салбар руу зоригтой шилжсэн нь ирээдүйг угтсан зөв шийдвэр болж чадсан. Экспортын бараа, бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргахад 1990-ээд онд ДХБ-ын хөнгөлөлттэй нөхцөлүүдийг ашиглан 30-100 хувь байсан бусад улсын тарифыг 15 хувь хүртэл багасгаж чадсан бол 2003 оноос хойш Чөлөөт худалдааны хэлэлцээр эхлүүлснээр тарифыг 10 жилийн дотор “0” хувийн тарифтай болох бололцоог нээсэн. Мөн гадаад худалдааг дэмжих зорилгоор гадаад улсууд, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлсээр байна. Гол зорилго нь БНСУ-ын бараа бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд илүү өрсөлдөх чадвартай, илүү их хэмжээгээр экспортод гарах нөхцөл бүрдсэн. Тус улсын эдийн засаг болон аж үйлдвэрийн хөгжилд хүрэхэд солонгос хүний хурд, хөдөлмөр, хугацаа хэмээх гурван хүчин зүйл нь гайхамшигтай үүрэг гүйцэтгэж чадсан гэж үзэж байна.

Санал, зөвлөмж

Гадаад худалдааг сайжруулахад өгөх санал

1. “Гадаад худалдааны үзэл баримтлал”-д үндэслэсэн “Гадаад худалдааны хууль”-тай болох.
2. “Гадаад худалдааны хууль”-ийг хэрэгжүүлэх засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг байгуулах. Ингэхдээ яам тус бүр дээр гадаад худалдааг дэмжих хуулийг хэрэгжүүлэх тусгай хөтөлбөр боловсруулах.

3. Гадаад худалдааг хэрэгжүүлэх эрх бүхий агентлаг, гадаад худалдааны бодлого боловсруулах тусгай судалгааны байгууллага байгуулах. Ингэхдээ ШУА, МУИС, МҮХАҮТ зэрэг судалгааны байгууллагууд, ТББ, хувь судлаачид, ард иргэд, аж ахуй нэгжүүдийн оролцоог хангах, тэдний дуу хоолойг сонсох бололцоог хангах.
4. Гадаадад суугаа элчин сайдын яамдуудаас жил бүр гадаад худалдааг сайжруулах санал, зөвлөмж хүлээн авч нэгтгэн, нэгдсэн тайлангийн хурал, зөвлөгөөн зохион байгуулах.
5. Гадаадад Монгол улсын бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, хөрөнгө оруулалт татах үзэсгэлэн худалдаа, хурал, зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж, үр дүнг танилцуулж байх.
6. Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг худалдах нэгдсэн цахим портал сайтыг хөгжүүлэх.
7. Гадаад худалдааны статистикийн мэдээллийг төрөлжүүлэх, үнэн бодитой итгэл төрүүлэхүйц тоон үзүүлэлтийг боловсруулах.

БНСУ-тай худалдаа хөгжүүлэхэд анхаарах зөвлөмж

1. Гадаад худалдаанд итгэл алдахгүй байх талаар бүх арга хэмжээг авах. /юу, хэзээ, хаана, яаж, хэн, яагаад хэмээх 6-н асуултад товч тодорхой, ойлгомжтой хариулахуйц байх/
2. Гадаад худалдаа хийж буй түншүүдийн хүсдэг зүйл нь хурд юм. Хичнээн сайхан санаа, ашигтай төсөл байгаад удаан, хойрго байвал сонирхол татахгүй, ашигтай ажиллаж чадахгүй гэж гаднынхан, ялангуяа солонгосчууд үзэж байна.
3. Өөрийн ашиг сонирхлыг солонгосчуудад ойлгуулахыг хичээх бус харин солонгосчууд юу хүсэж байгааг ойлгох нь худалдаа хийх арга замыг зөв зааж өгнө.
4. БНСУ-ын хөнгөлттэй зээлээр төсөл хэрэгжүүлэхэд Солонгосын засгийн газрын баталгааг гаргуулж авах хэрэгтэй. Ингэж чадаагүйн улмаас Даланзадгадын дулааны цахилгаан станц, говийн төмөр замын суурь бүтэц болон бусад олон том төслүүдийг чанаргүй хийгээд орхисон туршлага бий.
5. Дорнод аймагт Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах. Ингэхдээ өмнөд солонгосын хөрөнгө оруулалт, технологи, хойд солонгосын ажиллах хүчийг ашиглан ХАА, аж үйлдвэрийн кластерын төсөл боловсруулах. Ингэхдээ хоёр солонгосын хамтарсан Гайсоны аж үйлдвэрийн паркийн загварыг сайтар судалж үзэх ёстой.
6. Дорнод аймагт хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх. Ингэхдээ олон улсын онгоцны буудал байгуулан, ачаа тээвэр, иргэний жижиг онгоцуудыг нисгэдэг байх. Цаашлаад ЗХА-ийн эдийн засгийн интеграцийг манай улс эхлүүлж болох юм.

Эцэст нь хэлэхэд БНСУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх төрийн байгууллагын бүтэц бий болгох зүйлшгүй

шаардлагатай гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Үүний тул “Солонгос төв”-ийг байгуулан ажиллуулах саналыг солонгосчууд ч гэсэн 100 хувь дэмжиж байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

7.1. Монгол Улсад гадаад худалдааны тухай хуулийг батлаж хэрэгжүүлэхийн ач холбогдол

Монгол Улсын гадаад худалдааг үр ашигтай болгох чухал шийдэл бол гадаад худалдаанд тарифын бус арга хэмжээг нэвтрүүлэх явдал юм. Өнөөдөр Монгол Улс гадаад худалдааны хуульгүй, гадаад худалдааны асуудал хариуцсан бие даасан төрийн захиргааны төв байгууллага байхгүй, тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой бодлого, зохицуулалт, дүрэм журам байхгүй байгаа нь тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Өнөөдөр Монгол Улсад гадаад худалдаа дахь тарифын бодлого, зохицуулалт буюу гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн орлого бүрдүүлэх зэрэг чиг үүргийг Гаалийн ерөнхий газар, түүний харьяа алба нэгжүүд хэрэгжүүлж байгаа бол тарифын бус бодлого, зохицуулалт буюу монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх орчинд хяналт тавих, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, төрийн мэргэжлийн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх, улсын болон орон нутаг дахь хилийн лабораториудад бараа, үйлчилгээний бүтэц, найрлагад шинжилгээ хийх, дүгнэлт бичих зэрэг чиг үүргийг Улсын мэргэжлийн хяналтын байгууллага, түүний харьяа лабораториуд хэрэгжүүлж байна.

Тэгвэл экспортын барааны гарал үүслийн гэрчилгээг Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим олгож, Нийгмийн эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, техник технологи, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, сургалт, судалгаа, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх үүрэгтэй ажиллаж байна.

Стандартчлал хэмжил зүйн газар нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хэмжил зүй, стандартчилал, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Өнөө үед олон улсын зах зээл дээр стандартчлагдсан, чанарын болон эрүүл ахуйн шаардлагыг хангасан сертификатгүй нэг бараа, бүтээгдэхүүн арилжаагдахгүй байгаа үед Монгол Улсын Стандартчлал хэмжил зүйн газрын үндсэн чиг үүрэгт гадаад улсын гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүний стандартыг өөрийн оронд нутагшуулах замаар сертификат олгох, үндэсний бараа, бүтээгдэхүүний стандартыг бусад улсаар хүлээн зөвшөөрүүлж олон улсын сертификатыг олж

авах, хоёр улсын стандартуудыг харилцан хүлээн зөвшөөрөх тал дээр хамтран ажиллах чиг үүргийг нэмэлтээр хамааруулах шаардлагатай байна.


Өнөөдөр олон улсын зах зээл дээр арилжаалж байгаа бараа, бүтээгдэхүүнүүдэд чанарын болон тохиролын гэрчилгээтэй байх ёстой гэсэн шаардлагыг тавьж байна. Нөгөө талаас дэлхийн ихэнхи томоохон үйлдвэрлэгч компаниуд өөрийн гэсэн компаний болон барааны нэр, тэмдэг, лого буюу оюуны өмчийн гэрчилгээтэй байна.

Гэтэл Монгол Улсын Оюуны өмчийн газар нь зөвхөн аж үйлдвэрийн өмчийн эрх, зохиогчийн эрхийг хамгаалах, эрхийн бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох, бүтээлийн мэдээллийн санг үүсгэх, хяналт, шалгалт гэсэн чиг үүргийг л хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл манай улсын бизнес эрхлэгчид болон экспортын үйл ажиллагаа эрхлэж байгаа компаниудад чанарын болон тохиролын гэрчилгээ олгох, тэдний компаний болон барааны нэр, тэмдэг, лого зэрэг оюуны өмчийг хамгаалах олон улсаар хүлээн зөвшөөрүүлсэн гэрчилгээ олгох ажлыг хийхгүй байна.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, үнэ, ханш тогтоож байгаа байдал болон зүй ёсны монополь болон давамгайл байдалтай компаниудад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна. Иймд Улсын мэргэжлийн хяналтын газар нь бусад төрийн хяналтын байгууллагуудтай хамтран дотоодын зах зээл дээр арилжаалагдаж байгаа импортын барааны үнэ ханшинд хяналт тавьж, демпингийн үнийг мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

Харин аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс өөрийн нутгаар дамжин өнгөрч байгаа импортын бараанд татвар ногдуулах замаар тарифын бус арга хэрэгсэлүүдийг ашиглах асуудал олон улсын практикт ихээхэн түгээмэл үзэгдэл болсон байгааг анхаарах шаардлагатай юм.

Зураг 39. Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын институцийн тогтолцоо



Ийнхүү олон улсын туршлагыг харгалзан үзэж Монгол Улсын түвшинд гадаад худалдааны тарифын бодлого зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг Гадаад худалдааны яам дээр төвлөрч Гадаад хэргийн яам, ХЗДХЯ, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгал орчин, аялал жуулчлалын яаманд гадаад худалдаатай холбоотой зарим чиг үүргийг ногдуулж эдгээр төрийн захиргааны төв байгууллагуудын бодлого, үйл ажиллагаа харилцан уялдаатай байхаас гадаад худалдааны бодлого, зохицуулалтын үр ашиг шалтгаалж байна.

Тэгвэл тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг ХХААХУЯ, МХЕГ, ШӨХТГ, Нийгмийн эрүүл мэндийн төв, Оюуны өмчийн газар, Стандартчлал хэмжил зүйн газар, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимд (МУХАУТ), Үндэсний лабораториуд, аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага зэрэг төрийн байгууллагуудын чиг үүрэг гадаад худалдаа дахь тарифын бус зохицуулалтад хамааралтай боловч тэдгээр нь хоорондоо давхардсан эсвэл тодорхой бус, зарим нь өөрийн чиг үүргээ мэдэхгүй, тарифын бус зохицуулалтын нэгдсэн тогтолцоо байхгүй учир бие биендээ хамааралгүй тус тусдаа үйл ажиллагаа явуулж иржээ.

Монгол Улсад гадаад худалдааны хууль эрх зүйн нэгдсэн орчин хараахан бүрдээгүйгээс шалтгаалан дараах хор хохиролууд үндэсний үйлдвэрлэгчид болон хэрэглэгчид учирч байна. Үүнд:

- Монгол хүний эрүүл мэндэд аюултай, чанаргүй, хямд, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн импортоор орж ирэх эрсдэлтэй байдаг.
- Төрийн зүгээс үндэсний үйлдвэрүүдийн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээг зохицуулах боломжгүй болгодог учир тэдний өрсөлдөх чадвар болон хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Демпингийн үнээр барааг манай улс руу экспортлсон тохиолдолыг тогтоох, мөрдөн шалгах, гомдолыг ДХБ-д гаргах эрхээ хамгаалуулах төрийн тусгай бүтцийн байгууллагын үйл ажиллагааны хууль эрх зүйн орчин тодорхой бус байна.
- Импортын барааны хэрэглээнд хяналт тавьж үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх боломжгүй тул импортын тоон хязгаар квот тогтоох боломжгүй болгодог байна.
- Зах зээлээ хамгаалах импортын нэгдсэн бодлого, зохицуулалтыг үр дүнгүй болгож байна.
- Импортод тарифын бус хориг арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болгодог.
- Мал амьтаны тусгай зориулалтын барааны (эм эмийн бэлдмэл, химийн болон цацраг идэвхитэй бодис гэх мэт) импортод хяналт тавих боломжгүй болдог.
- Зах зээл хэтэрхий нээлтэй учир ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг үр дүнгүй болгодог.
- Монгол Улс шиг харьцангуй нээлттэй зах зээл дээр гадаадын хөрөнгө оруулалтай компаниудын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн нь импортын бага татвар төлсөн бараатай өрсөлдөхөд хүндрэлтэй болдог учир тэдний хувьд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор биш харин түүхий эдийг худалдан авах зорилгоор хөрөнгө оруулдаг.
- Ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх эрсдлийг бий болгодог
- Дотоодын үйлдвэрлэлд шаардлагатай дотоодын түүхий эдийн экспортыг хянах боломжгүй болгодог.
- Мал ургамлын гаралтай ховор нандин бараа, бүтээгдэхүүний экспортын хянахад төвөгтэй болгодог.

Монгол Улсын гадаад худалдааны хуулийг боловсруулж хэрэгжүүлсэнээс дараах давуу талууд, ач холбогдол бий болно. Үүнд:

- Гадаадын худалдааны бодлого, зохицуулалтыг төрийн захиргааны нэг субъектэд хариуцуулсанаар бодлого нэгдмэл болно.
- Гадаад худалдааны бодлого ойлгомжтой, уяан хатан хоорондоо уялдаатай болсоноор гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, түүнийг

дагаж шинэ техник, технологи, шинэ менежмент орж ирэх боломж бүрдэнэ.

- Импортын бараанд гарал үүсэл (хөгжингүй орон, хөгжиж байгаа орон, ЧХХ-тэй улс, худалдааны уламжлалт сайн харилцаатай улс, харилцаагүй улс гэх мэт), ашигласан түүхий эдийн химийн найрлага, шинж чанараас шалтгаалан ялгавартай тарифыг ногдуулах боломж бүрдэнэ. Ингэснээр
- Үндэсний үйлдвэрүүд сэргэнэ.
- Улсын төсвийн орлого нэмэгдэнэ.
- Ажлын байрыг шинээр бий болгох, хадгалах, хамгаалах боломууд бүрдэнэ.
- Эдийн засгийн болон экспортын бүтэц сайжирч солонгорно.
- Манай улсын эдийн засаг нэг улс, цөөхөн түүхий эдээс хараат байдал арилна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш гадаад худалдааг либералчлах, худалдааг хөнгөвчлөх бодлогыг тууштай хэрэгжүүлж байгаа ч одоогийн гадаад худалдааны бодлого, зохицуулалт нь үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг дэмжих, зах зээлээ хамгаалах, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, үндэсний эдийн засгийн гадаад зах зээлээс хэт хараат байдлыг багасгах, хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, аюулгүй байдлыг найдвартай хангах зэрэг үүргийг биелүүлж чадахгүй байна.

Монгол Улс ДХБ-д гишүүнээр элсэхдээ авсан амлалт, хүлээсэн үүрэг, уг байгууллагын худалдааны олон талт хэлэлцээрүүдтэй нийцүүлэх гадаад худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, түүнийг хариуцах төр, засгийн бүтцийг бий болгоход хойрго хандаж байна. Монгол Улс ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгохдоо ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг зөрчихгүй, хөгжиж буй орнуудад олгодог бусад хөнгөлөлтэй нөхцөлийг ашиглах, тарифын дээд хязгаарын энгийн дундаж тарифыг өсгөх боломжийг ашиглах шаардлагатай байна. Монгол Улсын гаалийн тарифын түвшин маш доогуур байгаа нь импортын дийлэнх бараанд гаалийн 5 хувийн тариф ногдуулж байгаатай холбоотой ба импортын тарифыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох нэгдсэн аргачлал, тогтолцоо одоогоор байхгүй байгаа учир Япон улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрээс бид үр ашиг хүртэхгүй байна.

ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдааг тарифаар зохицуулах боломж улам хумигдаж, харин *эсрэгээр тарифын бус зохицуулалтын ач холбогдол* нэмэгдэх төлөв байдал ажиглагдаж байна. Дэлхийн улс орнуудын гадаад худалдааны бодлого, зохицуулалтдаа тарифын бус арга хэмжээнүүд нь олон хэлбэр төрөлтэй, тэдгээрийг олон улсын хэм хэмжээгээр нэг бүрчлэн зохицуулахад төвөгтэй, улс орон бүр өөрийн зорилго, үндэслэл шалтгаанаар дотоодын хууль, дүрэм журамд нуугдмал байдлаар тусгаж ашиглаж байна. Тарифын бус зохицуулалтыг хөгжингүй орнууд илүү түлхүү хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2019 онд дэлхийн нийт *импортын 80* орчим хувь, нийт *экспортын 40* гаруй хувь нь тарифын бус арга хэмжээнд (ТБАХ) өртөж байна. Энэ арга хэмжээг *хөгжингүй орнууд* илүү түлхүү ашиглаж байгаа бол тарифын бус арга хэмжээний хэлбэрүүдээс (худалдаан дахь техникийн саад) (эрүүл ахуйн хорио цээр) арга хэмжээг хамгийн түгээмэл ашиглаж байна.

Гадаад худалдаа дахь тарифын бус арга хэмжээнд хүрээлэн буй орчныг хамгаалах, дотоод зах зээлээ хамгаалах, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах, шударга өрсөлдөөний орчинг бүрдүүлэх зорилгоор улсын хилээр нэвтэрч буй бараа, бүтээгдэхүүний хяналт, экспорт, импортын зөвшөөрөл, ургамал, амьтаны эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагын чанар, стандартуудыг хамааруулдаг.

Иймд Монгол Улс тарифын бус зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, тарифын бус арга хэрэгсэлүүдийг хэрэгжүүлэх эрх бүхий чанарын бүтцийг (хүний нөөц, лаборатори, тоног төхөөрөмж) бий болгох, түүнд оролцох төрийн байгууллагуудын хоорондын ажил, үүргийг уялдуулах, үүний тулд гадаад худалдааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулах шаардлагатай байна.

Бидний хийсэн судалгааны үр дүнд Монгол Улс өнөөгийн хөгжлийн нөхцөл байдалд тохирсон өөрийн гэсэн гадаад худалдааны бодлогыг боловсруулах, мөн түүнийг хэрэгжүүлэх төр, засгийн бүтэц, түүний үйл ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох, зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зайлшгүй шаардлага байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Тарифийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар:

1. УИХ-аас Монгол Улсыг ДХБ-д элсэж байгаатай холбогдуулан авах арга хэмжээний тухай 1996 оны 71 тоот тогтоолын дагуу Монгол Улсын хууль тогтоомжийг ДХБ-ын Олон талт худалдааны хэлэлцээрүүдэд нийцүүлэх ажлыг хариуцан ажиллах орон тоог ГХЯ-ны бүтцэд бий болгож, бүтцийг өөрчлөх;
2. ДХБ-д элсэхдээ Монгол Улсын хүлээсэн үүрэг, авсан амлалтыг хэрэгжүүлэх асуудлыг Гадаад худалдааны хуулиар зохицуулж, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг шинээр байгуулах; Энэхүү төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Тарифын зохицуулалт, үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;
 - ДХБ-ын худалдааны олон талт зохицуулалтын хүрээнд гишүүдэд олгосон эрх зүйн таатай орчныг ашиглах, тухайлбал демпингийн эсрэг арга хэмжээ, хамгаалах, саармагжуулах, татаасын арга хэмжээг хэрэглэх,
 - Худалдааны бодлогын ил тод байдлыг бэхжүүлж, гишүүн орнуудаас олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийн асуудлаар гаргах тайланг гаргах;
 - Үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн гаалийн тарифын бодлогын үр нөлөөллийн судалгааг зайлшгүй хийх; Жишээ нь: бидний хийсэн судалгаагаар хэрэв Монгол Улс бүх барааны импортын гаалийн тарифын хувь, хэмжээг ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаарт хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд боловсруулах аж үйлдвэрлэлийн голлох салбарууд болох арьс шир, мах, сүү, ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын хэмжээ аль аль нь нэмэгдэх үр дүн гарсан.

- Гаалийн тарифыг ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаарт хүргэх, түүнчлэн гадаад худалдааны бодлогын хүрээнд хамгаалах салбарын жагсаалтыг гаргах; Өөрөөр хэлбэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг ямарч оронтой байгуулсан хамгаалах салбарын барааны импортын гаалийн тарифыг чөлөөлөхгүй байх.
- Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх буюу барааны боловсруулалтын түвшин, технологийн насжилт болон түвшин, дотооддоо үйлдвэрлэх боломжтой эсэх, үйлдвэрлэлийн орц, гарц, кластер, эдийн засгийн салбар зэргийг хамааруулан тарифын хувь, хэмжээг ялгаатай тогтоох;
- Гаалийн тарифын хувь, хэмжээг тогтоохдоо тухайн эдийн засгийн салбар, барааны хувьд тарифын оновчтой түвшин буюу үндэсний үйлдвэрийн хамгаалахуйц тарифын түвшин тогтоох; Жишээ нь бидний хийсэн судалгаагаар улаан буудайн гурилын гаалийн тариф 21 хувь (тооцоо хийх үед 5 хувь байв) байж дотоодын үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж чадах буюу дотоодын хэрэгцээг 100 хувиар хангах хэмжээнд хүргэх. Гэтэл гурилны хувьд ДХБ-д элсэхдээ үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаар 15 хувь учраас энэхүү 21 хувийг шууд хэрэгжүүлэх боломжгүй. Иймд гурилын импортын тарифыг улирал, боомт харгалзахгүйгээр 15 хувь болгож, хүлээсэн үүрэг амлалтын хүрээнд дотоодын үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх замаар дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих;
- Гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох төрийн байгууллагын хүний нөөцийн чадавхийг сайжруулах гэх мэт.

3. Тарифийн бус зохицуулалтыг боловсронгуй болгох талаар:

- Тарифын бус зохицуулалтыг гадаад худалдааны бодлогын хэрэгсэл болгон ашиглах талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах;
- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх (хүн амыг ядууралд өртөхөөс сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг урамшуулах гэх мэт) үндэслэлээр гадаад худалдааг, импортыг хязгаарлах;
- Тарифын бус зохицуулалтаар дамжуулан чанарын баталгаа, хөдөлмөрийн стандарт, байгаль орчны зохицуулалт, шударга худалдааны тогтолцоог бүрдүүлэх;
- Тарифын бус зохицуулалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажил, үүргийн уялдааг хангах, нэгтгэн зангидах, удирдан чиглүүлэх, яаралтай сэрэмжүүлэх системийг бүрдүүлж, түүгээр дамжуулан хориглох, хязгаарлах, зохицуулах шаардлагатай бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхой болгох;

- Бүтээгдэхүүнд тавигдах эрүүл ахуй, аюулгүй байдал болон бусад шаардлагыг холбогдох байгууллагаар үнэлүүлж, техникийн зохицуулалтад тусгах шалгуур, шаардлагыг тодорхойлох;
- Бүтээгдэхүүнд тавих шаардлага, зохицуулалтын талаарх мэдээллийг нэгтгэх, мэдээллийн сан үүсгэх, гадаад худалдаа эрхлэгчдэд мэдээлэх;
- Тарифын бус зохицуулалтын хэрэгжилтийг хангахад анхаарч, чанарын дэд бүтцийг бүрдүүлэх, гаалийн байгууллагыг чадавхижуулах, дэмжих, сургах, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Тарифын бус зохицуулалтын арга хэрэгсэлүүдийг авч хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Тарифын арга хэрэгсэлүүд нь шинжлэх ухааны үндэстэй байх,
- Гадаад худалдааг гажуудуулах, худалдааны зардлыг өсгөх зорилго агуулаагүй байх,
- Худалдаанд ялгаварлан гадуурхсан шинж чанаргүй байх гэх мэт.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. “Гаалийн тариф, гаалийн татварын хууль”, УИХ, Улаанбаатар: (2008), Төрийн мэдээлэл;
2. “Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, УИХ.Улаанбаатар: (2016). Төрийн мэдээлэл сэтгүүл;
3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ, УБ, (2020);
4. Алекс Инклаар, Техникийн зохицуулалт: Боловсруулах болон хэрэгжүүлэх зөвлөмж, ИТС (2009);
5. Д.Баярсайхан, Э.Чинбат. 2020. Олон улсын худалдааны болон гаалийн нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар хот: Адмон принтинг ХХК, 2020;
6. Д.Баярсайхан. Монгол Улсын гаалийн холбогдолтой олон улсын гэрээний тойм, Улаанбаатар хот, (2011).;
7. Н.Отгонсайхан (2013). Пополнение бюджета Монголии на основе тарифного регулирования внешней торговли, кандидатская диссертация, Байкальский государственный университет экономики и права, Россия;
8. Н.Отгонсайхан, Ш.Энхбаяр Монгол улсын импортын гаалийн тарифын шинэчлэл, Улаанбаатар, (2020);
9. Н.Отгонсайхан. Олон улсын бизнес. Сурах бичиг. – Улаанбаатар.: Соёмбо принтинг, 2009. – Х.568;
10. Н.Отгонсайхан. Состояние таможенно-тарифного регулирования внешней торговли зарубежных стран. Проблемы регулирования внешнеэкономической деятельности в условиях вступления России в ВТО: сб. статей науч.-практ. конф., (23-24 мая 2012г.) – Иркутск: Изд-во БГУЭП, 2012.– С. 133-139;
11. Н.Отгонсайхан. Импортын тарифын оновчтой хувь хэмжээг тогтоох асуудалд. Үндэсний аюулгүй байдал – даяаршсан сүлжээт гааль сэдэвт ОУЭШ хурлын эмхтгэл (2012.10.19). –УБ 2012. – Х.78-80;
12. Б.Санжмятав, “Олон улсын худалдаа”, Улаанбаатар.: 2015;
13. Ш.Цогтоо. Гаалийн эрхзүй. Сурах бичиг. – Улаанбаатар.: Хөх судар, 2003. – Х.206;
14. Дэлхийн санхүү, эдийн засгийн тойм, Монгол банк, Улаанбаатар хот, 2005;
15. Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенц, Дэлхийн Гаалийн байгууллага, Брюссель, 1988;
16. Европын Холбооны Шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн Танилцуулга, МҮХАҮТ, Улаанбаатар, "Эрдэнэзул" ХХК, 2019;

17. Төв, Глоб Интернэшнл. 2019. “GSP + механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” Үндэсний чуулган боллоо. УБ хот, 2019;
18. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо,. 2005-2019. Гадаад худалдаа. Улаанбаатар хот, 2005-2019.
19. Техникийн зохицуулалт боловсруулах заавар, Стандарт, Хэмжил Зүйн Газар, (2018);
20. “Үндэсний Чанарын Хөтөлбөр”-ийг тайлагнах хүснэгт, 2020 оны эхний хагас жил Стандарт, Хэмжил Зүйн Газар;
21. Европын Холбооны Гаалийн хуулийг хэрэгжүүлэх журам 108 дугаар зүйл. Европын Гаалийн Холбоо, 2012;
22. ОХУ-ын Холбооны гаалийн албаны газар, “2030 он хүртэлх урт хугацааны хөгжлийн стратеги”. Москва хот, (2020);
23. Гадаад худалдааны статистик мэдээлэл Гаалийн Ерөнхий газар, Улаанбаатар хот, (2005-2020);
24. Хөрш орнууд: Гадаад харилцааны яам, 2015, <http://www.mfa.gov.mn/?p=28018>;
25. Гадаад харилцааны яамны цахим хуудас. (2015 оны 4 дүгээр сар). <http://www.mfa.gov.mn/?p=28020>;
26. Монгол Улс, ОХУ-ын харилцаа, ГХЯ, (2016), http://www.mfa.gov.mn/?page_id=19050-ээс Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровтай хэлэлцээр хийв. Гадаад харилцааны яам, (2021 оны 06 дугаар сарын 01). <http://mfa.gov.mn/>;
27. Дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай ДГБ-ын гарын авлага ДГБ, Брюссель (2017);
28. Олон улсын гэрээ, хэлэлцээр. ДГБ-ын цахим хуудас, ДГБ. (2019 оны 12 01), <http://www.wcoomd.org/en/about-us/legal-instruments/conventions.>;
29. “ДГБ-ын 2018/2019, 2019/2020 оны үйл ажиллагааны тайлан”, ДГБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын хэвлэлийн газар, Брюссель, (2021);
30. “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”, ДХБ, Бали (2013).;
31. “Олон улсын гэрээ, хэлэлцээр”, ДХБ-ын цахим хуудас: ДХБ. (2019 оны 11 25). https://www.wto.org/english/tratop_e/tradfa_e/tradfa_e.htm;
32. “Холбооны гаалийн албаны 2030 он хүртэлх урт хугацааны хөгжлийн стратеги” ОХУ-ын Холбооны гаалийн алба, Москва (2020);

Олон улсын байгууллагын судалгааны тайлан:

1. Ha Thi Thanh Doan, Samuel Rosenow, (2019). Non-Tariff Measures in ASEAN, Economic Research Institute for ASEAN and East Asia;
2. Hank Lim, Anika Widiana, (2016). Non-Tariff Measures in Singapore;

3. Luisa Kinzuis, Erdal Yalchin, (2019). Trade Protection and the role of non-tariff barriers;
4. Madhi Ghodsi, Payam Elhani and Robert Stehrer, (2021). Quality of Goods Imports: Which role for non-tariff measures;
5. Nikolay Mizulin, Huijian Zhu, (2010). Non-Tariff Barriers and Private Conduct: The Case of Labeling;
6. Roman Vakulchuk, Alexander Knobel, (2018). Impact of non-tariff barriers on trade within the Eurasian Economic Union;
7. Seul Lee, Divya Prabhakar, (2021). COVID19 Non-tariff measures: The good and bad, through a sustainable development lens. UNCTAD Research Paper No.60;
8. Sudip Ranjan Basu, Hiroaki Kuwahara, Fabien Dumesnil, (2012), Evolution of Non-Tariff Measures: Emerging cases from selected developing countries. Policy issues in International Trade and Commodity study series No52.;
9. Asian Trade Center, (2019). Non-Tariff Barriers in ASEAN and their elimination from a business perspective;
10. European Commission, On Trade and Investment Barriers, (2019);
11. European Commission, The Food and Beverage Market Entry Handbook: Japan, (2016);
12. ITC and European Commission, Navigating Non-Tariff Measures: Insight from a business survey in the EU, (2016);
13. UNCTAD TRAINS, Guidelines for the collection of data on official non-tariff measures, (2021);
14. UNCTAD TRAINS, The Global Database on Non-Tariff Measures, (2017);
15. UNCTAD, (2019). International Classification of Non-Tariff Measures, 2019 version;
16. UNCTAD, Key Statistics and Trends in Trade Policy 2019;
17. UNCTAD, Non-Tariff Measures: Economic Assessment and Policy Options for Development, (2018);
18. UNCTAD, Non-Tariff Measures to Trade: Economic and Policy Issues for Developing Countries, (2013);
19. US Trade Representative, National Trade Estimate Report on Foreign Trade Barriers, (2021);
20. Trade Policy Review, report by Mongolia. WT/TPR/G/406, WTO, (2021);
21. Trade Policy Review, report by Secretariat. WT/TPR/S/406, WTO, (2021);
22. The WTO Agreements Series: Technical Barriers to Trade, WTO;
23. The WTO Agreements Series: Sanitary and Phytosanitary regulation, WTO;
24. Dispute Settlement: Safeguard Measures, WTO;
25. ITC, and UNCTAD, (2021). World Tariff Profiles 2021, WTO;
26. Council, The European Parliament and of the. 2012. Applying a scheme of generalised tariff preferences and repealing Council Regulation (EC) No 732/2008. c.n. : EU , 2012.

27. EU. 2016. EU Customs code. Brussels : с.н., 2016.
28. Union, European. 2020. Trade HelpDesk. [Холбогдсон] 2020 оны June 14. <https://trade.ec.europa.eu/tradehelp/rules-origin-generalised-scheme-preferences>.

Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn
2. <https://estandard.gov.mn/>
3. www.wto.org
4. www.worldbank.org
5. IMF. (2019). World Economic Outlook database;
6. ITC. (2020 оны June 10). International Trade Centre. Market Info & Tools: <http://www.intracen.org/itc/market-info-tools/trade-statistics>;
7. Software, T. W. (2020 оны January 31). Trade statistics by country. The World Integrated Trade Solution Software: <https://wits.worldbank.org/countrystats.aspx?lang=en>;
8. WB. (2020). Doing Business 2020. Washington: WB;
9. WCO. (2005). The SAFE Framework of Standard. WCO;
10. WCO. (2019). WCO Annual Report 2018/2019. Brussels;
11. WTO. (2016). Trade Policy Review of Russian Federation. Geneva;
12. WTO. (2020 оны January 31). International Trade Centre. Trade statistic database: http://www.trademap.org/tradestat/Product_SelCountry_TS.aspx?tariff=profile
13. WTO tariff profile 2019. https://www.wto.org/english/res_e/booksp_e/tariff_profiles19_e.pdf
14. Key Statistics and Trends in Trade Policy 2019, https://unctad.org/en/PublicationsLibrary/ditctab2019d9_en.pdf

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Монгол Улсын нэгдсэн, худалдааны чиглэлийн олон талт хэлэлцээр, конвенциуд

Гэрээний нэр	Байгуулагдсан огноо	Хүчин төгөлдөр болсон	Монгол Улсын нэгдэж орсон огноо
а. Олон улсын худалдааны салбарт			
Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр	1994.04.15	1995.01.01	1996.12.26
Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны үр дүнг тусгасан төгсгөлийн баримт бичиг	1994	1995	1996
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр	1994.04.15	1995.01.01	1996.12.26
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1(b) дэд хэсгийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 17 дугаар зүйлийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалтын тухай харилцан ойлголцох баримт бичиг			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 24 дүгээр зүйлийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг			

1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөх тухай харилцан ойлголцох баримт бичиг			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 28 дугаар зүйлийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн тухай Марракешийн протокол			
Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр			
Эрүүл ахуй, ургамалын хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр			
Сүлжмэл нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээр			
Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр			
1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр			
Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр			
Гарал үүслийн дүрэмийн тухай хэлэлцээр			
Импортын тусгай			

зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр			
Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр			
Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр			
Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээр			
Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр			
Маргаан шийдвэрхлэх асуудлыг зохицуулах дүрэм, хурмын тухай харилцан ойлголцлын баримт бичиг			
Худалдааны бодлогыг хянах механизмын тухай			
Нэн буурай хөнгжилтэй орнуудын талаар авах арга хэмжээний тухай шийдвэр			
Глобал эдийн засгийн бодлого болдовсруулалтын уялдаа холбоог сайжруулахад ДХБ-ын гүйцэтгэх үүргийн тухай тунхаглал			
Мэдэгдэл өгөх журмын тухай шийдвэр			
ДХБ-аас ОУВС-тай харилцах харилцааны тухай тунхаглал			
Нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний цэвэр импортлогч хөгжиж буй орнуудын хувьд шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд учирч			

болох болзошгүй сөрөг үр дагаврын хувьд авах арга хэмжээний тухай шийдвэр			
Сүлжмэл, нэхмэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дагуу хийсэн интеграцийн эхний шатны талаарх мэдэгдлийн тухай шийдвэр			
Худалдаан дахь техникийн саад тиотгор: ДХБ-ҮУСБ2ын стандартын мэдээллийн системийн талаар санал болгож буй тохиролцооны тухай шийдвэр			
ОУСБ/ОУЦТК-ын мэдээллийн төвийг Хэвлэлийг хянан үзэж байх тухай шийдвэр			
Тойрч гарахтай холбогдсон шийдвэр			
1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг хянан үзэх тухай шийдвэр			
1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, эсвэл Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн V хэсгийн дагуу маргаан шийдвэрлэх тухай			

тунхаглал			
1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт холбогдсон шийдвэрүүд			
Гаалийн байгууллагад мэдүүлсэн үнэлгээний үнэн, зөв эсэхэд эргэлзэх үндэслэл байгаа тохиолдолтой холбогдсон шийдвэр			
Онцгой төлөөлөгч, дистрибьютор болон концесс эзэмшигчийн хэрэгжүүлж буй импорт болон доод үнэлгээний холбогдох эх бичвэрийн тухай шийдвэр			
Хувь этгээдийн шилжих хөдөлгөөний тухай хэлэлцээрийн талаарх шийдвэр			
Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн зохион байгуулалтын тохиролцооны тухай шийдвэр			
Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу маргаан шийдвэрлэх зарим журмын тухай шийдвэр			
Үйлчилгээний худалдаа болон хүрээлэн буй орчны тухай шийдвэр			
Санхүүгийн үйлчилгээний тухай хэлэлцээр			
Усан замын тээврийн үйлчилгээний тухай хэлэлцээрийн талаарх шийдвэр			

Үндсэн цахилгаан холбооны талаарх хэлэлцээрийн тухай шийдвэр			
Мэргэжлийн үйлчилгээний тухай шийдвэр			
Засгийн газрын хангалтын тухай хэлэлцээрт нэгдэн орох тухай шийдвэр			
Маргаан шийдвэрлэх дүрэм, журмын талаарх тохиролцоог хэрэглэх болон хянан үзэх тухай шийдвэр			
ДХБ байгуулах тухай хэлэлцээрийг батлах болон түүнд нэгдэж орох тухай шийдвэр			
Худалдаа болон хүрээлэн буй орчны тухай шийдвэр			
ДХБ байгуулах тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн зохион байгуулалтын болон санхүүгийн үр дагаврын тухай шийдвэр			
ДХБ-ын Бэлтгэл хороо байгуулах тухай шийдвэр			
Санхүүгийн үйлчилгээний талаарх үүрэг, амлалтын тухай харилцан ойлголцлын баримт бичиг			
1947 оны тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр			
Олон улсын худалдааны мэдээлэл, хамтын ажиллагааны агентлагийг Засгийн газар хоорондын	2004		2005

байгууллага болгон байгуулах тухай хэлэлцээр			
Б.Дэлхийн гаалийн байгууллагын шугамаар байгуулагдсан хэлэлцээрүүд			
Гаалийн хамтын ажиллагааны холбооны тухай Брюсселийн конвенц	1953		1992
Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системын тухай Брюсселийн Хэлэлцээр	1988	1988.01.01	1993
ТИР Карнейг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц	1975		2001
Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр	2004		2005
Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай ОУ-ын конвенц	1973		2006
Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц	1982		2007
Даацын тэмдэглэгээний тухай 1966 оны олон улсын конвенцийн 1988 оны протокол	1988		2007
Транс Азийн төмөр замын сүлжээний тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай			2007
Барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенц	1990		2007
Гаалийн хамтын ажиллагааны холбооны тухай Брюсселийн	1953		1992

конвенц			
Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай ОУ-ын конвенц	1973		2006
Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр	1994		1997
Бүтээгдэхүүний загварын олон улсын тухай Локарнийн хэлэлцээр		1960	1997
Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, түүнийн протокол		1989	2000
Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай Ниццийн хэлэлцээр	1957	1967	2000
Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц	1982		2007
Барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенц	1990	1993	2007
Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай Брюсселийн Хэлэлцээр	1988	1988	1993
В. НҮБ, бусад ОУБ-ын шугамаар байгуулагдсан конвенци, хэлэлцээрүүд			
Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын дүрэм	1944		1989
Дэлхийн аялал, жуулчлалын байгууллага	1970		1990
Олон улсын цахилгаан холбооны дүрэм	1992		1994
Дэлхийн оюуны өмчийн	1967		1979

байгууллагын дүрэм			
Дэлхийн шуудангийн холбооны дүрэм	1964		1973
Шуудангийн санхүүгийн үйлчигээний хэлэлцээр	2004		2006
Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц	1969	1980	1988
Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц	1965	1967	1966
Олон улсын бараа худалдахад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц	1974	1988	1974
Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц	1958	1959	1994
Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц	1965	1966	1996
Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц	1980	1988	1997
Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц	1883	1979	1984
Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр	1891	1979	1984
Патентын хамтын ажиллагааны гэрээ	1970	2001	1991
Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр	2004		2005

Их далайн тухай Женевийн конвенц	1958	1962	1976
Далайн тээврийн тухай конвенц	1958		1996
Далайн эрх зүйн тухай конвенц	1982	1994	1996
Далайн олон улсын байгууллагын тухай конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлт	1991		2007
Олон улсын иргэний агаарын тээврийн тухай Чикагогийн конвенц	1944	1947	1986
Олон улсын агаарын тээврийн зарим дүрмийг нэгтгэх тухай Варшавын конвенц	1929	1933	1962
Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц	1989	1992	1997
Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц	1970	1972	1991
Маргааныг шийдвэрлэх чиглэлээр			
Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны харилцаанаас үүссэн иргэний эрх зүйн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай конвенц	1975		1975
Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц	1958	1959	1994
Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө	1965	1966	1996

оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай Вашингтоны конвенц			
Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц	1954	1957	1999
Хоёр талын шугамаар байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрүүд			
Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	1999		
Монгол, Кубын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	2001		
Монгол, АНУ-ын Засгийн газар холорондын Худалдааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын харилцааны тухай,	2004		
Монгол, АНУ-ын Засгийн газар ихоорондын Худалдаа, хөрөнгө оруулалтын салбар дахь ил тод байдлын асуудлаарх хэлэлцээр	2013	2017	
Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр	2016		
АПТА-Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр		2021	2020

Хавсралт 2. Экспорт, импортын барааны бүтэц, Уялдуулсан системийн хэсэг (2019, 2020 оны харьцуулалтаар)

Барааны нэр	Экспорт				Импорт			
	2019		2020		2019		2020	
	Үнэ (мян.ам.долл)	Хувь	Үнэ (мян.ам.долл)	Хувь	Үнэ (мян.ам.долл)	Хувь	Үнэ (мян.ам.долл)	Хувь
01 Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	97,610.5	1.3	52,915.3	0.7	76,806.8	1.3	77,696.4	1.5
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	12,463.3	0.2	11,029.2	0.1	90,725.2	1.5	120,176.2	2.3
03 Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	654.9	0.0	620.5	0.0	28,679.7	0.5	35,800.8	0.7
04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	61,856.4	0.8	70,206.0	0.9	444,313.6	7.3	434,368.3	8.2
05 Эрдэс бүтээгдэхүүн	6,377,586.4	83.7	5,256,037.3	69.4	1,372,298.0	22.4	1,007,247.8	19.0
06 Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	2,260.5	0.0	575.4	0.0	365,905.9	6.0	370,771.8	7.0
07 Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	1,280.9	0.0	630.9	0.0	260,252.4	4.2	223,141.5	4.2
08 Арьс ширэн түүхий эд болон боловруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	14,119.8	0.2	7,433.7	0.1	7,088.2	0.1	5,029.9	0.1
09 Мод, модон эдлэл	604.1	0.0	305.9	0.0	43,504.8	0.7	43,384.8	0.8
10 Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	43.2	0.0	47.2	0.0	56,413.5	0.9	58,051.1	1.1
11 Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	434,672.3	5.7	279,484.6	3.7	84,986.3	1.4	85,790.6	1.6
12 Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2,543.9	0.0	1,869.8	0.0	19,859.1	0.3	17,894.3	0.3
13 Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	138.7	0.0	140.6	0.0	142,861.4	2.3	165,825.4	3.1
14 Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	419,075.8	5.5	1,789,935.1	23.6	2,092.2	0.0	13,389.4	0.3
15 Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	77,821.2	1.0	66,621.0	0.9	541,949.9	8.8	535,699.3	10.1
16 Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	34,643.8	0.5	31,103.6	0.4	1,240,678.8	20.2	1,060,598.5	20.0
17 Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	78,586.3	1.0	4,234.7	0.1	1,163,725.8	19.0	849,845.0	16.0
18 Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	1,253.0	0.0	1,408.4	0.0	89,804.0	1.5	103,842.1	2.0
20 Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	2,359.0	0.0	1,706.2	0.0	93,436.4	1.5	79,349.5	1.5
21 Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	57.7	0.0	5.7	0.0	168.8	0.0	48.8	0.0
Бүгд	7,619,632.9	100	7,576,310.9	100	6,127,515.9	100.0	5,298,913.5	100

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл
2005-2020 (ГЕГ, 2005-2020)

Хавсралт 3. Монгол Улсын гадаад худалдааны гүйцэтгэл
(сая ам. доллар)

Он	Экспорт	Импорт	Нийт
2005	1063,9	1177,3	2241,2
2006	1542,0	1435,0	2977,0
2007	1947,5	2061,8	4009,3
2008	2534,5	3244,5	5779,0
2009	1885,4	2137,7	4023,1
2010	2908,5	3200,1	6,108,6
2011	4817,5	6598,4	11415,9
2012	4384,7	6738,4	11123,1
2013	4269,1	6357,8	10626,9
2014	5774,3	5236,7	11011,0
2015	4669,3	3797,5	8466,8
2016	4916,3	3339,6	8255,9
2017	6200,6	4,337,3	10537,9
2018	7011,8	5874,8	12886,6
2019	7619,6	6127,5	13747,1
2020	7576,3	5298,9	12875,2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл
2005-2020.

Хавсралт 4. Монгол Улсын БНХАУ, ОХУ-тай хийсэн гадаад худалдааны гүйцэтгэл (2005-2020 он, сая ам. доллар)

Он	БНХАУ			ОХУ		
	Экспорт	Импорт	Нийт	Экспорт	Импорт	Нийт
2005	513,2	303,2	816,4	27,2	417,9	445,2
2006	1049,4	364,9	1414,4	45,1	547,8	592,9
2007	1411,3	568,9	1980,2	58,5	745,0	803,5
2008	1635,8	898,7	2534,6	86,3	1242,3	1328,6
2009	1393,9	538,5	1932,4	68,2	772,8	841,0
2010	2466,3	970,9	3437,3	82,7	1046,7	1129,4
2011	4439,8	2023,8	6463,7	96,3	1624,7	1721,0
2012	4,059,7	1873,4	5933,1	79,6	1847,4	1927,0
2013	3706,3	1822,6	5528,9	61,8	1561,9	1623,6
2014	5073,4	1767,9	6841,3	61,6	1549,3	1610,9
2015	3910,1	1389,9	5300,0	76,9	1021,0	1097,9
2016	3901,6	1061,1	4962,7	55,8	880,4	936,2
2017	5307,4	1429,6	6737,1	67,7	1217,3	1284,9
2018	6542,8	1994,8	8537,6	85,9	1710,3	1796,3
2019	6789,7	2060,7	8850,5	68,1	1729,9	1798,0
2020	5489,9	1892,7	7382,7	57,3	1400,0	1457,2
Дүн	57691,2	20962,4	78653,7	1079,0	19314,6	20393,6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдааны мэдээлэл 2005-2020.

Хавсралт 5. Монгол Улсын гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаанд мөрдөж буй олон улсын гэрээ, хэлэлцээр

No.	ГЭРЭЭНИЙ НЭР	Хүчин төгөлдөр болсон өдөр (Хэлэлцэн тохирогч Талын тоо)	Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон өдөр
ДЭЛХИЙН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД			
1.	Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (Дэлхийн гаалийн байгууллага байгуулах тухай Конвенц, 1950-12-15. Бельги Улсын Брюссель хот)	1952-11-04 (2009: 177) (2015: 180)	1991-09-17
2.	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын Конвенц (БТКУС-ийн Конвенц, 1983-06-14. Бельги Улсын Брюссель хот)	1988-01-01 (2018: 157)	1993-01-01
3.	Гаалийн горимыг хялбарчилах, уялдуулах тухай олон улсын Конвенц (Киотогийн Конвенц, 1973-05-18. Япон Улсын Киото хот)	1974-09-25 (2019: 120)	2006
4.	Түр хугацаагаар оруулах тухай Конвенц (Стамбулын Конвенц, 1990-06-26. Турк Улсын Стамбул)	1993-11-27 (2019: 71)	2003-09-05
ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД			
5.	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (Дэлхийн Худалдааны Байгууллагын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01 (2019: 164)	1997-01-29
6.	1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Демпингийн эсрэг татварын тухай Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01 (2019: 164)	1997-01-29
7.	1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Дэлхийн Худалдааны Байгууллагын Үнэлгээний Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01 (2019: 164)	1997-01-29
8.	Ачилтын өмнөх шалгалтын тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01 (2019: 164)	1997-01-29
9.	Гарал үүслийн дүрмийн тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01 (2019: 164)	1997-01-29
10.	Татаас болон нөхөн төлөөсийн/ саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот)	1995-01-01 (2019: 164)	1997-01-29
11.	Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр (Бали, Сайд нарын Бага хурал, 9 дүгээр хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 3-6)	2017-02-22 (2019: 146)	2016-11-24
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ТАВИН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД			

12.	Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын Конвенц (Парисын Конвенц) 1883-03-20. Франц Улсын Парис хот	1884-07-07	1985-04-21
13.	Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц 1980-4-11. Австри Улсын Вена хот	1988-01-01	1999-01-01
14.	Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (Женевийн Конвенц) 1982-10-21. Швейцарь Улсын Женев хот	1987-09-12	(УИХ: 2007-05-04)
15.	Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр	2016-04-23	2016-02-05
16.	ТИР карней ашиглан олон улсын хэмжээнд бараа тээвэрлэх тухай Конвенц (ТИР Конвенц) 1975-11-14. Швейцарь Улсын Женев хот	1978	2003-04-01

*Хавсралт 5. Б. Хөрш орнуудтай байгуулсан олон улсын хоёр талт гэрээ
(Гадаад худалдаа, хилийн боомттой холбоотой)*

№	Утга	Гэрээ байгуулсан огноо
I. Гаалийн хүрээнд хамтран ажиллах, харилцан туслах тухай асуудлаар		
1.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1993-01-20
2.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1993-09-07
II. Хил, хилийн боомтын асуудлаар		
1.	Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1994-08-10
2.	Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	2004-07-05
3.	Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ	2006-12-08
4.	Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ	2010-06-01
III. Бусад асуудлаар		
1.	БНМАУ, БНХАУ-ын хоорондын консулын Конвенц	1986-08-09
2.	Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	1992-10-19

Хавсралт 6. БНСУ-ын экспортын хориг тавьсан бараанууд¹¹⁶

HS	Бүтээгдэхүүний нэр	Шалтгаан
02	Мах, махан бүтээгдэхүүн	Далайн хөхтөн амьтны мах гаргахыг хориглоно
	Халим, далайн гахайн мах	
	Хөлдөөсөн, хатаасан, давсалсан, утсан мах	
	Бусад мах	
25	Давс; хүхэр; шороон эрдэс болон чулуу; шаваасны материал, шохой болон цемент	Байгалын чулуу гаргахыг хориглоно
43	Үслэг арьс болон хиймэл үслэг арьс; тэдгээрээр хийсэн эдлэл.	Амьтны гаралтай үслэг эдлэл гаргахыг хориглоно

¹¹⁶ БНСУ-ын эрх зүйн мэдээллийн төл-<https://www.law.go.kr/>

Хавсралт 7. БНСУ-ын экспортын хязгаарлалт тогтоосон бүтээгдэхүүн¹¹⁷

HS	Бүтээгдэхүүний нэр	Шалтгаан
25	Хайрга	Барилга, зам, гүүр, зуурмаг зэрэг бүтээн байгуулалтад хэрэглэгдэх түүхий эдийг Бетон зуурмагийн холбооны зөвшөөрлөөр экспортолж болно.
	Дайрга	
	Элс	
	Хүдэр	
72	Гулдмай, анхны хэлбэрээрээ байгаа төмөр ган, хайлшгүй ган	Ган төмрийн холбооны зөвшөөрлөөр экспортод гаргаж болно.

Хавсралт 8. БНСУ-ын импортын хязгаарлалт тогтоосон бүтээгдэхүүн¹¹⁸

HS	Бүтээгдэхүүний нэр	Шалтгаан
39	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	БНСУ-ын агаарын тээвэр, сансрын үйлдвэрлэлийг дэмжих холбооны зөвшөөрлөөр импортолж болно.
40	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	
70	Шил болон шилэн эдлэл.	
84	Цөмийн реактор, уурын тогоо, машин, тоног төхөөрөмж техник хэрэгсэл; тэдгээрийн эд анги.	
88	Агаарын хөлөг, сансрын хөлөг болон тэдгээрийн эд анги	
90	Агаарын тээврийн эд анги болон тоног хэрэгсэл.	
94	Агаарын тээвэр хэрэглэх сандал	

¹¹⁷ Мөн тэнд

¹¹⁸ Мөн тэнд

Хавсралт 9. БНСУ-ын гадаад худалдааг дэмжих эрх зүйн баримт бичгүүд

№	Хуулийн нэр	Төрөл	Харьяалал
1	Гадаад худалдааны хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
2	Гадаад худалдааны хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
3	Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагын тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
4	Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагын тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
5	Худалдааны суурь тавих тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
6	Худалдааны суурь тавих тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
7	Худалдааны даатгалын тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
8	Худалдааны даатгалын тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
9	Худалдааны даатгалын тухай хууль хэрэгжүүлэх дүрэм	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яамны тушаал	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
10	Худалдааны хорооны ажлын алба	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам, Төрийн захиргаа, аюулгүй байдлын яам
11	Шударга бус худалдааг судлах, аж үйлдвэрлэлийн хохирлыг арилгах тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
12	Шударга бус худалдааг судлах, аж үйлдвэрлэлийн хохирлыг арилгах тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
13	Шударга бус худалдааг судлах, аж үйлдвэрлэлийн хохирлыг арилгах тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
14	ДХБ-ын хэлэлцээр зэрэг хөнгөлөлттэй тарифын	Ерөнхийлөгчийн зарлиг	Төлөвлөгөө, сангийн яам

	зохицуулалт		
15	ДХБ-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
16	АНДХХ-ын гарал үүслийг батлах стандартын тухай дүрэм	Төлөвлөгөө, сангийн яамны тушаал	Төлөвлөгөө, сангийн яам
17	Чөлөөт худалдааны бүс тодорхойлох, ажиллуулах тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
18	Чөлөөт худалдааны бүс тодорхойлох, ажиллуулах тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
19	Чөлөөт худалдааны бүс тодорхойлох, ажиллуулах тухай хууль хэрэгжүүлэх дүрэм	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яамны тушаал	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
20	ЧХХ хэрэгжүүлэх гаалийн тарифын тусгай хэргийн тухай хууль	Хууль	Төлөвлөгөө, сангийн яам
22	ЧХХ хэрэгжүүлэх гаалийн тарифын тусгай хэргийн тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Төлөвлөгөө, сангийн яам
25	ЧХХ хэрэгжүүлэх гаалийн тарифын тусгай хэргийн тухай хууль хэрэгжүүлэх дүрэм	Төлөвлөгөө, сангийн яамны тушаал	Төлөвлөгөө, сангийн яам
26	ЧХХ байгуулсны дараах ХАА, загас агнуур зэргийг дэмжих тухай хууль	Хууль	Газар тариалан, ой, МАА, хүнсний яам, Далай, загасны аж ахуйн яам
27	ЧХХ байгуулсны дараах ХАА, загас агнуур зэргийг дэмжих тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Газар тариалан, ой, МАА, хүнсний яам, Далай, загасны аж ахуйн яам
28	ЧХХ байгуулсны дараах ХАА, загас агнуур зэргийг дэмжих тухай хууль Хэрэгжүүлэх дүрэм	Газар тариалан, ой, МАА, хүнсний яамны тушаал	Газар тариалан, ой, МАА, хүнсний яам, Далай, загасны аж ахуйн яам
29	ЧХХ байгуулсны дараа худалдааны зохицуулалтыг дэмжих тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам, Хөдөлмөрийн яам
30	ЧХХ байгуулсны дараа худалдааны зохицуулалтыг дэмжих тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам, Хөдөлмөрийн яам
31	ЧХХ байгуулсны дараа худалдааны зохицуулалтыг	Аж үйлдвэр, худалдаа,	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам

	дэмжих тухай дүрэм	нөөцийн яамны тушаал	яам, Хөдөлмөрийн яам
32	Цахим худалдааг дэмжих тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
33	Цахим худалдааг дэмжих тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
34	Цахим худалдааг дэмжих тухай хууль хэрэгжүүлэх дүрэм	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яамны тушаал	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам
35	Худалдааны гэрээ хийх дараалал ба хэрэгжүүлэх тухай хууль	Хууль	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам, Гадаад харилцааны яам
36	Худалдааны гэрээ хийх дараалал ба хэрэгжүүлэх тухай хууль хэрэгжүүлэх журам	Ерөнхийлөгчийн зарлиг	Аж үйлдвэр, худалдаа, нөөцийн яам, Гадаад харилцааны яам